



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХҮҮЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ЭНЭ ДУГААРТ:

- Үндсэн хуулийн цэц ба захиргааны хэргийн шүүх
- Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
- Баривчлах ялын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт
- Газрын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал
- Давж заалдах шатны шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх хэмжээ хязгаар
- Арбитрийн ажиллагааны олон улсын эрх зүйн зохицуулалт
- Өмгөөлөгч байна гэдэг миний бодлоор...
- Гэрээслэл

ЭНЭ ДУГААРТ:

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар

(Хууль зүйн үндэсний төвийн Секторын эрхлэгч С.Гэрэлмаа) 3-7

Гүрж улсын үндсэн хуулийн шүүх: Зохион байгуулалт, үйл ажиллагаа

(Үндсэн хуулийн цэцийн ажилтан Э.ЛХАГВАСҮРЭН) 8-12

Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнд хяналт тавих нь

(ИБМУТ-ийн Бүртгэл мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн Ц.ГАНЗОРИГ) 13-14



Шүүх эрх мэдэл

Үндсэн хуулийн цэц ба захиргааны хэргийн шүүх

(Үндсэн хуулийн цэцийн гишүүн, академич Ж.АМАРСАНАА) 15-19



Криминологи

Баривчлах ялын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт

(ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын ЭША Ц.ОДОНЧИМЭГ) 20-21

Гэмт хэргийн статистикт хийх регрессийн шинжилгээ

(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах Г.БАТЧИМЭГ) 22-24

Цагдаагийн ажилтны нэр хүнд

(ЦЕГ-ын тамгын газрын ажилтан З.БАТСҮХ) 25-27



Иргэний хууль тогтоомж

Газрын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал

(Удирдлагын академийн ахлах багш Х. ОЮУНЦЭЦЭГ) 28-31

Сервитут, түүний хөгжил

(МУИС-ийн ХЗС-ийн магистрант Б.ЭНХМАА) 32-37

ИХШХША дахь төлөөлөлтийн зарим асуудал

(ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах А.ТҮВШИНТУЛГА) 38-40

Барьцааны эрх – Эдийн эрх болох тухай асуудал

(ТЕГ-ын дээд сургуулийн багш, дэд профессор Д.БАТ-ӨЛЗИЙ) 41-44

Давж заалдах шатны шүүхээс иргэний хэргийг хянан шийдвэрлэх хэмжээ хязгаар

(МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант Д.ХУЯГ) 45-48

Хөөн хэлэлцэх хугацаа нь завсарлаагүй гэж үзсэн байна

(Японы шүүхийн шийдвэрийн "Цаг үе, мэдээлэл" сэтгүүлээс) 49-50



Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Иракийн дайн ба Олон улсын нийтийн эрх зүйн асуудал

(ХЗҮТ -ийн олон улсын эрх зүйн секторын ЭША Т.ЗАЯА) 51-53

Нийтийн ба хувийн эрх зүйн тухай

(МУИС-ийн докторант, "Хасагт хайрхан" дээд сургуулийн багш З.СҮХБААТАР) 54-56

Арбитрийн ажиллагааны олон улсын эрх зүйн зохицуулалт

("Отгонтэнгэр" их сургуулийн Эрх зүйн тэнхимийн багш Ч.САРАНГЭРЭЛ) 57-59

Худалдааны эрх зүй - "Lex mercatoria"-ийн тухай ойлголт, түүний үүсэл хөгжил

(ХЗҮТ-ийн Эрх зүйн албан бус сургалтын төвийн багш Б.ТАМИР) 60-61

Бернийн конвенцийн материаллаг хэм хэмжээ

(ХБНГУ-ын Фрайбургийн их сургуулийн докторант Д.УЯНГА) 62-66



Эрх зүйн үйлчилгээ

Өмгөөлөгч байна гэдэг миний бодлоор...

("Эрх" хууль зүйн товчооны захирал, өмгөөлөгч А.ЭНХБАТ) 67-69

Гэрээслэл

(Сүхбаатар дүүргийн нотариатч Р.ОНОНЧИМЭГ) 70-75



Мэдээ мэдээлэл

Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний (ALIN) үйл ажиллагаа

76-77

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2004 оны нийтлэлийн жагсаалт

78-81



ХАЯГ: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын гудамж

УТАС: 322094, ФАКС: 322094

Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн бүрэлдэхүүн:

Ц.Бат-Орших	- Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн ерөнхий эрхлэгч
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Н.Ганбаяр	- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Ж.Амарсанаа	- Хууль зүйн үндэсний төвийн захирал
Ж.Энхнасан	- Хууль зүйн үндэсний төвийн Захиргааны хэлтсийн дарга
Т.Мэндсайхан	- Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч
Я.Сайнжаргал	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын ажлын албаны дарга
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
П.Цэцгээ	- Улсын дээд шүүхийн судалгааны төвийн захирал
А.Энхжав	- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга
Ж.Сайнжаргал	- Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга
Б.Пүрэвням	- Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч
А.Оюунчимэг	- Монголын Нотариатчдын танхимын ерөнхийлөгч
С.Дэлгэрзаяа	- Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Дугаарыг эрхэлсэн: С.Дэлгэрзаяа

(Сэтгүүлийн хариуцлагатай
нарийн бичгийн дарга)

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР



Хууль зүйн үндэсний төвийн Секторын эрхлэгч С.Гэрэлмаа

Олон улсын практик, харьдуулсан судалгаа

1. Татвар ногдуулах объект

Энэ сэдвийг бичихийн тулд юуны өмнө Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гэсэн ухагдахууныг тодорхойлохыг зорьёо:

Сюзан Лайнзийн Олон улсын татварын тайлбар тольд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг "Компанийн орлогод ногдуулах татвар. Ихэнх оронд аж ахуйн нэгжийн ашигт энэ татварыг ногдуулдаг." гэж тодорхойлжээ. Татварын онолч, судлаачдын дунд аж ахуйн нэгжийн татварыг чухам юүнд ногдуулах вэ? гэдэгт гол анхаарлаа төвлөрүүлж байна. Тэдгээрийн нэг хэсэг нь албан татварыг орлогод ногдуулах нь зүйтэй гэж үздэг бол нөгөө хэсэг нь татвар ногдуулах объект нь зөвхөн ашиг байна гэж үздэг юм байна.

Орлогын концепцийг дэмжигчэд орлогод татвар ногдуулах нь :1/нийт орлогод хяналт тавих, 2/орлогын тогтвортой суурийг бүрдүүлэх ач холбогдолтой, гэжээ. Монголын

практикт онолын энэ концепцийг 1990 оноос нэвтрүүлж тодорхой хугацаанд хэрэглэсэн боловч бодитой үр дүнд хүрч чадаагүй гэж үзэж болно. 1990 оноос мөрдсөн албан татварын хуулиар татвар ногдуулах объект нь:

- ашиг
- цалингийн сан
- үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн нийлбэр байхаар тодорхойлж өгсөн байна.

Энэ нь зах зээлийн эдийн засгийн нийтлэг жишгээс гажиж хөдөлмөр зарцуулалт болон фонд багтаамж ихтэй салбаруудад татварын дарамт үүсгэж, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг бодитойгоор байгуулах сонирхолгүй болгож, технологийн шинэтгэлийн бодлогод гажуудал бий болгосон. Иймд 1993.01.01-нээс ашигт албан татвар ногдуулах журмыг мөрдөж эхэлсэн.

Энэ аргын давуу тал нь

1. ашиг нь бизнесийн байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дүнг илэрхийлж чадагт оршино;
2. ажиллах хүчний нөхөн үйлдвэрлэлийн зардлыг татвараас чөлөөлсөнөөр улс орны эдийн засгийн хөгжилд бодитой үр дүн өгдөг;
3. бүх зардлыг татвараас чөлөөлсөнөөр үйлдвэрлэгчийн хэвийн үйл ажиллагааг урамшуулдаг.¹

Монгол улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйл ёсоор нийт орлогоос:

- баримтаар нотлогдож буй шууд зардал /цалин хөлс, бүх төрлийн материалын зардал, эрчим хүч, түлш шатахуун, баглаа боодол г.м /;
- эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл;
- үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл;
- урсгал засварын болон түр барилгын зардал;
- гадаадын валютын арилжаанаас гарах алдагдал;
- бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс;
- түрээсийн төлбөр, зээлийн хүү;
- хөрөнгө эзэмшигчээс тогтоосон захиргааны зардал;
- автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;
- газар, байгалийн нөөц ашигласны хураамж, төлбөр;
- онцгой болон үл хөдлөх хөрөнгийн албан татвар хассан зөрүүгээр орлогыг тодорхойлж байна.

Дэлхий нийтэд аж ахуйн нэгжийн албан татварыг ашигт ногдуулах явдал давамгайлж байгаа энэ зарчмыг мөн манай хөрш ОХУ ч хуульдаа тусгаж "налог на доход" гэсэн нэр томъёоны оронд "налог на прибыль предприятий" гэсэн

¹ С.Баатар, Я.Пүрэв, В.Ганхүлэг "Татварын онол арга зүйн зарим асуудлууд", Улаанбаатар хот, 1997 он, 40-43 дахь тал.

нэр томьёог хэрэглэж байна.

Татварыг ашигт ногдуулах уу? эсхүл орлогод ногдуулах уу? гэсэн асуудлыг шийдвэрлэсний дараа чухам ямар ашигт татвар ногдуулах вэ? гэсэн асуудал зүй ёсоор тавигдана. Үүнд:

дотоодын аж ахуйн нэгжийн гадаадад олж байгаа ашигт татвар ногдуулах уу?

гадаадын аж ахуйн нэгжийн дотоодод олж байгаа ашигт татвар ногдуулах уу? гэсэн асуудалд хариулт өгөх ёстой болно.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд татвар ногдуулах үндсэн 3 зарчмыг авч үзэх шаардлагатай.

Нэгдүгээр зарчим нь дэлхий даяархи орлогод татвар ногдуулах зарчим /worldwide income principle of taxation/ - энэ зарчмын дагуу байнгын оршин байгаа компани нь өөрийн дэлхий даяар олсон орлогоос татвар төлдөг. Байнгын оршин суугч аж ахуйн нэгж гэдэгт тухайн оронд үүсгэн байгуулагдсан эсхүл үр ашгийг, удирдлага нь тухайн оронд байгаа аж ахуйн нэгжийг хэлнэ. Энэ зарчмыг Монгол, АНУ, Орос, Хятад, Япон улс баримтладаг.

Хоёрдугаар зарчим нь оршин байгаа статусаар татвар ногдуулах зарчим /residence principle of taxation/- энэ зарчмын дагуу байнгын оршин суугчийн илүү өргөн хүрээний орлогод, оршин суугч бус этгээдийн илүү явцуу хүрээний орлогод татвар ногдуулдаг. Энэ зарчмыг жишээ нь: Австрали улс хэрэгжүүлэхдээ байнгын оршин суугчийн дэлхий даяархи орлогод, оршин суугч бус этгээдийн Австралийн нутаг дэвсгэрт олсон орлогод татвар ногдуулдаг.

Гуравдугаар зарчим нь татвар ногдуулах нутаг дэвсгэрийн зарчим /territoriality

principle of taxation/-татварыг зөвхөн өөрийн эрх мэдлийн нутаг дэвсгэрт олсон орлогод ногдуулах зарчим. Бусад орны татварын байгууллагын эрх мэдлийг зөрчихгүйгээр өөрийн нутаг дэвсгэрээс гадна татвар ногдуулах боломжгүй гэж энэ зарчмыг баримтлагчид үздэг. Байнгын эсхүл түр оршин суугч эсэхээс хамаарахгүй тухайн аж ахуйн нэгж зөвхөн тухайн оронд олсон орлого, эд хөрөнгөнд татвар төлнө. Энэ зарчмыг Герман, Франц, Латин Америкийн орнууд, тухайлбал Перу, Боливи баримтладаг.

Дэлхийн бусад улс орны тухайд дэлхий даяар олсон орлогод татвар ногдуулах зарчмыг баримтлах чиг хандлага сүүлийн жилүүдэд давамгайлж байгаа бөгөөд ихэнх улс оронд нутаг дэвсгэрийн зарчмаар татвар ногдуулахаас татгалзах болжээ.

Нэгэнт бид татвар ногдуулах объектоо тодорхойлсон учраас одоо татвар төлөгч нь субъектийг буюу хэн энэ татварыг төлөх вэ гэдгийг тодруулах нь зүйтэй.

2. Татвар ногдуулах субъект

Дэлхийн улс орнууд татвар ногдуулахад дээрх 3 зарчмын алийг нь баримтлахаас хамаарч татвар төлөх субъектийг тодорхойлдог.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг Монгол Улсад дараахь этгээд төлөх үүрэгтэй:

Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа өмчийн бүх төрлийн компани, хоршоо, нөхөрлөл, гадаадын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж;

Монгол улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар; Арлжааны банк, зээл, даатгалын болон тэдгээртэй

адилтгах бусад байгууллага;

Төрийн бус байгууллага;

Шашны байгууллага;

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

Монгол улсад оршин суугч бус хуулийн этгээд;

Дээр зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд.

ОХУ-ын хуульд татвар төлөгчийг дараахь байдлаар тодорхойлсон:

ОХУ-ын байгууллагууд

ОХУ-д байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын байгууллага;

ОХУ-д байгаа эх үүсвэрээс орлого олж байгаа гадаадын байгууллага.

Австралийн хуулиар татвар төлөгчид нөхөрлөлөөс бусад байгууллага, холбоог хамруулсан. Нөхөрлөлийн хувьд татварын бие даасан хууль үйлчилдэг. Австралид оршин суугчийн статусаас хамаарч татвар ногдуулдаг учраас байнгын оршин суугчийг тодорхойлох шалгуурыг дараахь байдлаар баталсан:

1. Австралид үүсгэн байгуулагдсан байх,
2. Төв удирдлага нь Австралид байршилтай болон бизнесийн үндсэн үйл ажиллагаа нь Австралид явагддаг байх;
3. Бизнесийн үндсэн үйл ажиллагаа нь Австралид явагддаг болон дийлэнхи хувьцаа эзэмшигчид нь Австралид оршин суудаг байх.

3. Татварын хувь хэмжээ

Татварын шатлал, хувь хэмжээг зохистой тогтоох нь татвар төлөгчийг дампууруулахгүй байх, татвараас

зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх, төсвийн алдагдлаас урьдчилан сэргийлэх зэрэг олон ач холбогдолтой. Зарим орны хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татахын тулд татварын диваажин ч үүсгэж байна. Тухайлбал Кууккийн аралуудад компани байгуулахад хөрөнгийн доод хэмжээг 1 сая доллараар тогтоосон бөгөөд анх компанийг үүсгэн байгуулахдаа 1000 доллар төлнө. Цаашид жил тутам ямар орлого олж байгаагаас хамаарахгүй жилдээ 500 доллар Засгийн газарт төлнө. Өөр ямар нэгэн татвар байхгүй. Гонконг импортын хэмжээгээрээ дэлхийд 7-д, экспортын хэмжээгээрээ дэлхийд 8-д ордог. Монголоос 3 дахин их буюу 6 сая хүн амтай гэж бодоход хүрсэн амжилт нь бахархууштай. Гонконгийн татвар төлөгчийн хувьд оршин суугчийн статус ямар ч нөлөөгүй байдаг онцлогтой. Зөвхөн орлогын эх үүсвэрээс хамаарч татвар ногдуулдаг. Гадаадын компаниуд Гонконгд төвөө байршуулж, дансаа нээж ямар нэгэн татварын сүлжээнд орохгүй үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой. Гонконгд байгаа компаниуд 0,6 хувийн хөрөнгийн хураамж, жилийн 75 Гонконг доллар хураамж төлөх л үүрэг хүлээдэг.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухайд дэлхийн нийтийн сүүлчийн үеийн хандлагыг авч үзье.

Нэгдүгээрт, сүүлийн жилүүдэд даяарших үйл явцтай холбоотойгоор дотоодын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хэт өндөр хувь хэмжээгээр тогтоохгүй байх хандлага дэлхий нийтэд ажиглагдаж байна.

Хоёрдугаарт, улс орнуудын татварын хувь хэмжээ нилээд

ойртож хөнжингүй орнуудын аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ойролцоогоор 30 хувь болж байна.

Гуравдугаарт, татварын хувь хэмжээ жилээс жилд буурах хандлага ажиглагдаж байна.

Дөрөвдүгээрт, татварын шатлал мөн цөөрөх хандлага ажиглагдаж байна. Эдгээр хандлагатай бид ч хөл нийлүүлэн алхахаас өөр аргагүй.

Тухайлбал, 2003 оны байдлаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын /OECD/ гишүүн орнуудын татварын хувь хэмжээ дараахь төвшинд байсан байна:

Үүнээс үзэхэд аж ахуйн

нэгжийн орлогын хамгийн өндөр татвартай оронд Япон /40,9%/, Герман /40,2%/, АНУ /39,4% / хамрагдаж байгаа бол хамгийн бага татвартайд Ирланд /12,5%/, Исланд /18%/, Унгар /18% / орж байна.

Энэ хүснэгтээс харахад мөн нийт улс орны татварын дундаж хэмжээ 30 хувь нилээн ойртож байгаа нь тодорхой байна. Манай хоёр хөршийн тухайд ч мөн ойролцоо дүр зурагтай байгаа. Тухайлбал, Хятад улсад аж ахуйн нэгж нь Засгийн газартаа 30 хувийн албан татвар, орон нутгийн захиргаандаа 3 хүртэл хувийн татвар төлдөг бол ОХУ-д 24 хувийн албан татвартай байна.


№	Улс орон	Холбооны Засгийн газрын төлөх татварын хувь хэмжээ %/	Орон нутгийн татварыг багтаасан татварын хувь хэмжээ %/
1.	Австрали	30,0	30,0
2.	Австри	34,0	34,0
3.	Бельги	33,99	34,0
4.	Канада	24,1	36,6
5	Чех	31,0	31,0
6.	Дани	30,0	30,0
7.	Финланд	29,0	29,0
8.	Франц	35,43	35,4
9.	Герман	27,96	40,2
10.	Грек	35,0	35,0
11.	Унгар	18,0	18,0
12.	Исланд	18,0	18,0
13.	Ирланд	12,5	12,5
14.	Итали	34,0	34,0
15.	Япон	30,0	40,9
16.	Солонгос	27,0	29,7
17.	Люксембург	22,88	30,4
18.	Мексик	34,0	34,0
19.	Голланд	34,5	34,5
20.	Шинэ Зеланд	33,0	33,0
21.	Норвеги	28,0	28,0
22.	Польш	-	-
23.	Португаль	30,0	33,0
24.	Словак	25,0	25,0
25.	Испани	35,0	35,0
26.	Швед	28,0	28,0
27.	Швейцар	8,5	24,1
28.	Турк	33,0	33,0
29.	Их Британи	30,0	30,0
30.	АНУ	35,0	39,4

Монгол Улсад албан татвар ногдуулах жилийн орлогод дараахь хувь, хэмжээгээр татвар ногдуулж байна:

- 0-100 сая төгрөгийн албан татварт -15%,
- 100 саяаас дээш орлогод 15 сая төгрөг дээр нэмэх нь 100 саяаас дээшхи орлогын 30% /2004.01.01-нээс/

Үүнээс үзэхэд манай орны татварын төвшин хөгжилтэй орнуудын дундаж үзүүлэлттэй бараг адил, харин хөгжиж буй орнуудын дунджаас нилээн дээгүүр байна.

Дэлхийн улс орнуудад ерөнхийдөө татварын хувь хэмжээ буурах хандлага ажиглагдаж байгаагийн нэг жишээг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын /OECD/ гишүүн орнуудын 1996-2002 татварын хувь хэмжээний дундаж төвшингөөс харж болно.



Мөн дэлхийн улс орнуудад ажиглагдаж байгаа татварын шатлалыг цөөрүүлэх хандлага нь ялангуяа, хөгжиж байгаа орнуудад илүүтэй хэрэгжиж аж ахуйн нэгжийн орлогод шаталсан олон хувиар бус нэг хувиар татвар ногдуулж байна.

Харин АНУ хувьд татвар ногдуулахад дөрвөн шатлалтай тогтолцоог хэрэглэж байна:


- 0-50 мянган долларт-15%
- 50-75 мянган долларт -25%
- 75-100 мянган долларт -34%
- 100-аас дээш мянган долларт -39%.

Шатлал цөөрүүлэх хандлага


юутай холбоотой вэ гэвэл татварын олон шатлалтай хувь хэмжээ тогтоох нь гажуудуулах нөлөөллийг ихэсгэдэг. Олон шатлал нь аж ахуйн нэгж жижгэрэх, эсхүл хоршсон буюу салбарласан аж ахуйн нэгжүүд ашиг багатай буюу алдагдалтай хэсэгрүүгээ ашгаа шилжүүлэх зэрэг зохисгүй хандлагад татвар төлөгчдийг хөтөлдөг. Монгол Улсад ч энэ байдал өмнө нь ажиглагдаж байсан. /1/

Татварын хувь хэмжээний хувьд өөр нэгэн чухал асуудал бол Татварын нийт орлогын хэдэн хувийг аж ахуйн нэгжийн албан татвар бүрдүүлдэг вэ гэдэг асуудал юм. Үүнийг АНУ, Францын жишээн дээр авч үзье.


АНУ-ын Холбооны төсвийн орлогын бүтэц¹




АНУ-ын муж улсуудын татварын орлогын бүтэц²



Франц Улсын төсвийн бүтэц³




Монгол Улсын татварын бүтэц /2001 оны байдлаар/⁴



Энэ графикаас харахад Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар нийт татварын 6.4 % бүрдүүлж байгаа нь АНУ, Францтай /10% / харьцуулахад харьцангуй бага байна. Монгол улсын татварын бүтцэд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын эзлэх хувь байнга буурах хандлага ажиглагдаж байна.

Татварын бүтцэд аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын эзлэх хувь хэмжээний хувьсал



Энэ нь олон шалтгаанаас үүдэлтэй. Нэгдүгээрт, Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжих үед малын түүхий эд боловсруулж байсан олон үйлдвэр хаагдсан, гадаадын

¹ Б.Ганхуял. Татварын тогтолцоо, 1 дүгээр дэвтэр, Улаанбаатар хот 2002 он 59 дэх тал

² Брызгалин А.В Налоги и налоговое право, Москва, 1997 он, 64 тал.

³ Брызгалин А.В Налоги и налоговое право, Москва, 1997 он, 65 тал.

⁴ Хөгжлийн эдийн засгийн асуудлууд, 2003 он №1, 16 тал.

хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор томоохон хөрөнгө оруулагчдыг татвараас чөлөөлдөг, Монгол улсын эдийн засгийн хөгжлийн бууралт зэрэг үүнд хамаарна.

4. Татварын хөнгөлөлт

Татварын хөнгөлөлтийг дэлхийн улс орнуудад дараахь хэлбэрээр үзүүлдэг:

- ногдуулсан татварыг хорогдуулах
- татварын хувь хэмжээг бууруулах
- татвар төлөгчийг дэмжих, үйл ажиллагааг нь урамшуулах зорилгоор тодорхой зориулалт бүхий татварын хөнгөлөлт үзүүлэх тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, үйлчилгээг татвараас чөлөөлөх
- татвар төлөгчийг тавараас чөлөөлөх
- татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх

Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулиар 3 төрлийн субъектэд хөнгөлөлт үзүүлж байгаа:

- гадаадын хөрөнгө оруулагч; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага;
- хөдөө орон нутагт, үйлдвэрлэл үйлчилгээ шинээр эхлэгчид ;

Зориулалт бүхий татварын хөнгөлөлтийг:

- дэд бүтэцийн салбарт;
- үр тариа, төмс хүнсний ногооны үйлдвэрлэл;
- газрын тосны салбарт хөрөнгө оруулагчдад үзүүлж байна.

Манай улсын татварын хөнгөлөлт тухайн бизнес эрхлэгчийг татвараас хөнгөлөх

зорилтоо биелүүлэхгүй байгааг эргэж харах цаг нэгэнт болжээ. Учир нь Австралийн компанийг бид эхний 10 жил дэд бүтэцийн салбарт хөрөнгө оруулсаныг нь төлөө татвараас чөлөөлдөг. Гэтэл Австралийн хуулиар байнга оршин суутч компани нь дэлхийн даяар олсон орлогодоо татвар төлөх ёстой учраас Монгол улсын төсөвт төлөөгүй татвараа Австралийн төсөвт төлдөг. Ялангуяа, уул уурхайн салбарт хөнгөлөлт, чөлөөлөлтийг эргэж авч үзэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Бид бүхэн сүүлийн үед Айвенхоу Майнз компанид үүцээ задалж өгч байгаа тухай ихээхэн ярьж байгаа.

Гадаадын олон улс орнууд гадаадын хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлт тогтоодог боловч зарим улс орон эдгээр хөнгөлөлтөө эргэж авч үзэх, өөрчлөх хандлагатай болжээ. Тухайлбал, Хятад ард улс өөрийн аж ахуйн нэгжээс 33%, гадаадын хөрөнгө оруулагчдаас 20% татвар авч байгаагаа үр ашиг муутай нь дээр Дэлхийн Худалдааны байгууллагын дотоодын, гадаадын үйлдвэрлэгчид ижил нөхцөл тогтоох зарчимд харшлах учраас өөрчлөхөөр төлөвлөж байна.

Иймд Монгол улсад хамгийн их хөрөнгө оруулалт хийж байгаа Хятад Солонгос, Орос зэрэг үндсэн хөрөнгө оруулагчид болон дэд бүтэц, уул уурхай, газар тариалангийн салбарт хөрөнгө оруулагчдийнхаа татварын тогтолцоо, татварын хууль тогтоомжийг нарийвчлан судалсны үндсэн татварын хөнгөлөлтийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ингэхдээ нэг татвараар үзүүлсэн хөнгөлөлтийг нөгөө татвараар үгүйсгэж болохгүй. Тухайлбал, газар тариалангийн

салбарт хөрөнгө оруулах сонирхолтой ОХУ-ын компанийн төлөөлөгчид хэдийгээр газар тариалангийн салбарт татварын хөнгөлөлт байгаа ч Автобензин, дизелийн түлшний татвар хэт их учраас бид энэ салбарт ажиллах боломжгүй юм, гэж ярьж байсныг энд дурьдмаар байна.

5. Дүгнэлт

Нэгдүгээрт, Монгол улсын аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар хөгжинх буй орнуудын төвшинтэй харьцуулахад харьцангуй өндөр байгааг харгалзан энэ татварын хэмжээг бууруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Татварыг бууруулах нь татвараас зайлсхийх явдлыг багасгаж, шинээр аж ахуй эрхэлж байгаа хүмүүс хөл дээрээ тогтож, энэ татварын суурийг өргөтгөхөд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Хоёрдугаарт, татварын бүтэцэд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар харьцангуй бага хувь эзэлж байгааг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний тулд юуны өмнө хөнгөлөлт чөлөөлөлтийг нягтлан үзэж, энэ тогтолцоог боловсронгуй болгох, гадаадын хөрөнгө оруулагчдад татварын таатай орчинг өөрийн улсын төсөвт хохирол багатай бүрдүүлэхэд анхаарч ажиллах нь чухал юм.

* * *

ГҮРЖ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үндсэн хуулийн
цэцийн ажилтан
Э.ЛХАГВАСҮРЭН

Гүржийн Үндсэн хуулийн шүүх /ҮХШ/ нь Үндсэн хуулийг чандлан сахиулах шүүх эрх мэдлийн байгууллага бөгөөд хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулийн хүрээнд хамгаалах, шүүх бүрэн эрх нь Гүрж Улсын нийт нутаг дэвсгэрт үйлчлэх төдийгүй улс орны хэмжээнд Үндсэн хуульт ёсийг хангах үндсэн чиг үүрэгтэй.

Хууль дээдлэх, маргааныг хамтын зарчмаар олонхиороо шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх, талуудын тэгш эрхийг хангах, бие даасан хараат бус байх зэрэг үндсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно. Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны бүтэц, эрх хэмжээ, дэг нь Гүржийн Үндсэн хууль болон одоогийн хуулиар тодорхойлогдоно. Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь (бусад зохион байгуулалтын асуудлыг) тусгай батлагдсан дэгээр зохицуулагддаг.

Үндсэн хуулийн шүүхийн гишүүн өөрийн албан үүргээ гүйцэтгэх үедээ хараат бус халдашгүй дархан байх бөгөөд аливаа маргааныг хууль зүйн үүднээс Үндсэн хуулийн хүрээнд мөн бодит нөхцөл

байдалд уялдуулж шийдвэрлэх ёстой. Үндсэн хуулийн шүүхийн гишүүнд хөндлөнгөөс нөлөөлөх, нөлөөлөхийг оролдох аваас тэр хүнийг хуулийн дагуу залхаан цээрлүүлэх учиртай.

Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа болон зохион байгуулалттай төсвийг улсын төсвийн тусгай хэсгээс санхүүжүүлэх бөгөөд ҮХШ-ийн дарга хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд шаардагдах төсвийн төслийг гаргаж өгөх үүрэгтэй.

ҮХШ-ийн гишүүний хараат бус байдлыг хангах зорилгоор түүний ахуй амьдрал, үйл ажиллагаанд зохих нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Тухайлбал, Үндсэн хуулийн шүүхийн гишүүн, түүний гэр бүл, орон байр, унаа болон аюулгүй байдал нь хуулиар хамгаалагддаг.

Үндсэн хуулийн шүүхийн дарга, гишүүд тэдгээрийг томилох

Гүржийн ҮХШ нь 9 гишүүнээс бүрдэнэ. Гишүүд дотроосоо ҮХШ-ийн дарга, хоёр орлогч дарга болон ҮХШ-ийн нарийн бичгийн даргыг сонгоно. ҮХШ-ийн 3 гишүүнийг Гүржийн Ерөнхийлөгч, 3-ыг нь Парламент, 3-ыг нь Улсын дээд шүүхээс томилоно. ҮХШ-ийн гишүүнийг томилохоос өмнө тухайн хүнээс энэ албанд ажиллахыг зөвшөөрсөн тухай саналыг нь заавал бичгээр авсан байх шаардлагатай.

ҮХШ-ийн гишүүн нь хууль зүйн дээд боловсролтой, 35 нас хүрсэн Гүрж Улсын иргэн байна. ҮХШ-ийн гишүүнийг сонгохдоо Гүрж Улсын Ерөнхийлөгч, Парламент, Улсын

дээд шүүх нь нэр дэвшигчийн мэргэжлийн туршлага, мэргэшсэн байдал нь ҮХШ-ийн гишүүнийн статуст нийцэж байгаа эсэхийг нь харгалзан үздэг байна. ҮХШ-ийн гишүүнийг томилсон тухай Ерөнхийлөгч зарлиг гаргана. Парламентаас ҮХШ-ийн гишүүнийг томилох журмыг товчхон сонирхуулахад:

Юуны өмнө санал хураалт явуулахаас өмнө Парламентын дарга ҮХШ-ийн гишүүдэд сонгогдох нэр дэвшигчдийн нэрс, тэдгээрийн зөвшөөрлийн хамт хуралдаанд танилцуулна. Нэр дэвшигч бүр дээр шаардлагатай бол санал асуулга явуулж, үүний дараа саналыг нууцаар хураана. Санал хураалтаар нийт гишүүдийн тавны гурваас доошгүйн санал авсан хүнийг ҮХШ-ийн гишүүнээр томилно. Хэрвээ сонгуульд 3 нэр дэвшигч оролцоод хэн нэг нь олонхийн санал авч чадаагүй бол уг нэр дэвшигчийг нэрийг тухайн санал хураасан өдрөөс хойш 10 хоногийн дараа дахин нэр дэвшүүлэх боломжтой.

Анхны санал хураалт чуулганы сүүлчийн өдөр явагдсан бол эсхүл үлдэж буй хугацаанд дараагийн нэр дэвшигчийг сонгох боломжгүй бол дахин санал хураалтыг Парламентийн дараагийн чуулганы анхны хуралдаанаар хэлэлцэнэ. Мөн ҮХШ-ийн гишүүний сонгуульд 3-аас дээш нэр дэвшигч оролцсон хэдий ч аль нь ч олонхийн санал авч чадаагүй бол дахин санал хураалт явуулна. Энэ тохиолдолд эхний шатанд хамгийн олон санал авсан 3 нэр дэвшигчийн нэрийг дахин оруулдаг журамтай.

Гүрж Улсын дээд шүүх ҮХШ-ийн гишүүнээр томилогдох 3 нэр дэвшигчийг дээд шүүхийн бүгд хурлаар хэлэлцэх бөгөөд энэ хуралд Ерөнхий шүүгч нэр дэвшигчид болон тэдгээрийн зөвшөөрлийг танилцуулсны дараа санал хураалт явагдах ба нийт шүүгчдийн гуравны хоёрын санал авсан нэр дэвшигчийг томилогдсонд тооцно.

ҮХШ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь 10 жил. Дахин томилогдох эрхгүй. ҮХШ-ийн гишүүний бүрэн эрх нь Гүржийн Ерөнхийлөгч, Парламентын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн өмнө "Бурхан, ард түмнийхээ өмнө Үндсэн хуулийн шүүхийн гишүүний үүргээ үнэнч шударгаар биелүүлэхдээ зөвхөн Гүрж Улсын Үндсэн хуульд захирагдахаа тангараглаж байна" хэмээн тангараг өргөснөөр эхэлнэ. ҮХШ-ийн бүх гишүүн тангараг өргөснөөс хойш 10 хоногсоо хэтрэлгүй эсхүл даргын бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө бүх гишүүдийн хуралдаанаар ҮХШ-ийн даргыг 5 жилийн хугацаатай сонгоно. Мөн энэ зарчмаар 2 орлогч даргыг сонгоно.

ҮХШ-ийн даргад Гүрж улсын Ерөнхийлөгч, Парламентын дарга болон дээд шүүхийн даргатай зөвшилцсэний дагуу нэр дэвшүүлнэ. Харин орлогч дарга нарыг нэр дэвшүүлэх эрхийг ҮХШ-ийн дарга хэрэгжүүлнэ. Сонгуулийн хувьд тус бүрт нь нууцаар санал хураах бөгөөд ҮХШ-ийн гишүүдийн 5-аас доошгүйн саналыг авсан үед сонгогдсонд тооцно. Үндсэн хуулийн шүүхийн дарга, түүний орлогчоор нэр дэвшигч нь урьд нь энэ албан тушаалыг хашсан хүн байж болохгүй.

Үндсэн хуулийн шүүхийн бүтэц, ҮХШ-ийн дарга, орлогч дарга, НБД-ын эрх хэмжээ

Гүржийн Үндсэн хуулийн

шүүх нь бүгд хурал болон 2 коллегос бүрдэнэ. Бүгд хурлын бүрэлдэхүүнд ҮХШ-ийн 9 гишүүн орох бөгөөд хуралдааныг ҮХШ-ийн дарга удирдан явуулна. Коллеги тус бүрийн бүрэлдэхүүнд 4 гишүүн багтах ба мөн л хуралдааныг ҮХШ-ийн дарга удирдана. Коллегийн бүрэлдэхүүнийг ҮХШ-ийн даргын мэдүүлснээр Бүгд хурлаар батална. ҮХШ-ийн даргыг шинээр томилсноос хойш 10 хоногийн дотор коллегийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулна.

Үндсэн хуулийн шүүхийн даргын эрх хэмжээ

1. ҮХШ-ийн Бүгд хуралдаанд ҮХШ-ийн дэгийг батлуулах, /дэгд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ҮХШ-ийн гишүүн гаргах эрхтэй/;
2. ҮХШ-ийн дэгээр тогтоосон журмын дагуу ажил, хэргийг хуваарилах;
3. ҮХШ-ийн бүгд хуралдаанд даргын орлогч болон нарийн бичгийн даргад нэр дэвшигчийг танилцуулах;
4. ҮХШ-ийн бүгд хуралдааныг хуралдуулах, хуралдааныг даргалах, хурлаас гаргах шийдвэрт /магадлал, дүгнэлт/, хуралдааны протоколд гарын үсэг зурж баталгаажуулах;
5. ҮХШ-ийн аппаратын /ажлын албаны/ үйл ажиллагааг удирдах; /ажилтныг ажилд томилох болон халах бусад/;
6. ҮХШ-ийн төсөв хөрөнгийг төсөвлөх, захиран зарцуулах болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

ҮХШ-ийн дарга жилд 1 удаа Гүрж Улсын Ерөнхийлөгч, Парламент, Улсын дээд шүүхэд Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулах журамтай.

Орлогч дарга коллегийн

хуралдааныг эрхлэн явуулж, ҮХШ-ийн даргын даалгаснаар бусад тусгай албан үүргийг эрхлэн гүйцэтгэнэ. ҮХШ-ийн даргын эзгүйд эсхүл түүнийг албан үүргээ гүйцэтгэх боломжгүй үед нь түүний даалгаснаар орлогч дарга нарын аль нэг нь, харин тийм даалгавар өгөөгүй үед нь хамгийн ахмад нь ҮХШ-ийг удирдах, харин орлогч даргыг түр эзгүйд болон ҮХШ-ийн даргыг орлож байх үед коллегийн тухайн бүрэлдэхүүнээс хамгийн ахмад гишүүн нь даргалж ажил, үүргээ гүйцэтгэнэ.

ҮХШ-ийн нарийн бичгийн дарга Бүгд хуралдаанаас 5 жилийн хугацаатай сонгогдох бөгөөд тэрбээр ҮХШ-ийн гишүүний бүрэн эрхээс гадна:

1. Бүгд хуралдаан болон коллегийн хуралд бэлтгэх ажлыг зохион байгуулах;
2. Хуралдааны протокол хөтлөх, түүнийг албан ёсний болгох ажлыг зохион байгуулах;
3. ҮХШ-ийн дэгд заасан журмын дагуу ҮХШ-ээс гаргах актад гарын үсэг зурах;
4. ҮХШ-ийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
5. Байгууллагын дотоод техник хэрэгсэл, шаардлагатай бусад мэдээллийг бэлтгэх, байгууллагын бичиг баримтыг түгээн тараах ажлыг зохион байгуулах эрх хэмжээтэй.

ҮХШ-ийн гишүүн халдашгүй дархан байна. Түүнийг ҮХШ-ийн зөвшөөрөлгүйгээр гэмт хэрэг үйлдэж байгаад газар дээрээ баригдсанаас бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагад татах, саатуулах, хорих, биед нь үзлэг, нэгжлэг хийх, мөн түүний орон байр, унаа, ажлын байранд

нэгжлэг хийхийг хатуу хориглодог. Хэрвээ ҮХШ өөрийн гишүүнийг баривчлагдан хоригдсоныг үл зөвшөөрвөл түүнийг нэн даруй суллана.

Харин ҮХШ-ийн гишүүнийг эрүүгийн хариуцлагад татах тухай тогтоолыг ҮХШ зөвшөөрсөн тохиолдолд шүүхээс тухайн гишүүнтэй холбоотой хэргийг хянан хэлэлцэхээс өмнө түүний бүрэн эрхийг түтгэлзүүлнэ. Шүүхээс ҮХШ-ийн гишүүнийг цагаатгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох тухай тогтоолын аль нэгийг гаргасан үед гишүүний бүрэн эрхийг сэргээнэ. Энэ тухай ҮХШ-ийн Бүгд хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд нийт гишүүдийн олонхийн саналыг авсан байх шаардлагатай.

ҮХШ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө орны шинэ гишүүнийг томилоно. Дараах тохиолдолд ҮХШ-ийн гишүүний хугацаанаас нь өмнө ҮХШ-ийн шийдвэрээр чөлөөлнө. Үүнд:

1. өөрийн хүсэлтээр албан ажлаасаа чөлөөлөгдвөл;
2. ямар нэг шалтгаангүйгээр 6 сарын турш өөрийн албан үүргээ гүйцэтгээгүй бол;
3. эрүүгийн хариуцлагад татагдаж, шүүхээс гаргасан ялын тогтоол хүчин төгөлдөр байгаа бол;
4. албан үүргийн холбоотой болон байгууллагын / мэргэжлийн / нууцыг задруулсан тохиолдолд;
5. хуулиар хориглосон ажил, албан тушаал хавсарч эрхэлсэн бол;
6. Гүрж Улсын харьяатаас гарсан тохиолдолд;
7. Шүүхээс тухайн гишүүнийг хөдөлмөрлөх чадваргүйг хүлээн зөвшөөрсөн, энэ тухай шүүхээс шийдвэр гарсан бол;

8. Нас нөгчсөн тохиолдолд;

ҮХШ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх тухай асуудлыг Бүгд хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд нийт гишүүдийн олонхи нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тэрхүү шийдвэрийг хүчинтэйд тооцно. Энэ тухай шийдвэрийг Гүрж Улсын Ерөнхийлөгч, Парламент болон Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

ҮХШ-ийн гишүүний албан тушаалыг төрийн болон аж ахуйн ямар ч албан тушаалтай хавсарч хийж болохгүй бөгөөд гагцхүү шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх ажил давхар эрхэлж болно. Мөн улс төрийн намын гишүүн байх, эсхүл аливаа нэг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглодог. ҮХШ-ийн гишүүнээр томилогдохоос өмнө аль нэг намын харьяалалтай болон дээр дурдсан үйл ажиллагаа эрхэлдэг байсан бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уг намын харьяалал, үүрэгт ажлаасаа түдгэлзэх шаардлагатай, тийм ч үүрэгтэй.

Маргаан хянан шалгах хугацаанд ҮХШ-ийн гишүүний нь бүрэн эрх дуусгавар болох тохиолдолд тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэлт бүрэн эрхийг нь хэвээр хадгална.

Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ

Гүрж Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд зааснаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үндсэн хуульд хууль бусад дүрэм, Гүржийн парламентийн дэг, Абхаз, Ажарийн Засгийн газрын дээд байгууллагуудаас гаргасан акт нийцсэн эсэх;
2. Төрийн байгууллагуудын хооронд үүссэн эрх мэдлийн маргаан;
3. Иргэдийн улс төрийн эрхийн талаар гарсан маргаан;
4. Бүх нийтийн санал хураалт,

сонгуулийн талаар гарсан маргаан;

5. Гүржийн Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт заасан Үндсэн хуулийн хэм хэмжээтэй холбоотой маргаан;
6. Нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээртэй холбоотой маргаан;
7. Гүржийн Парламентын гишүүний бүрэн эрхийн талаархи асуудлыг / хугацаанаас нь өмнө чөлөөлөх/шийдвэрлэх;
8. Гүржийн Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн дарга, Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор, Төрийн хянан шалгах танхимын дарга, Үндэсний банкны зөвлөлийн гишүүд Гүржийн Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан зэргийг хянан хэлэлцэнэ.

Хууль болон бусад дүрэм Үндсэн хууль зөрчсөн нь ҮХШ-ээс тогтоогдвол шүүхээс урьд нь тухайн Үндсэн хуультай зөрчилдсөн хуулийг хэрэглэж маргаан шийдвэрлэсэн тогтоол, бусад шийдвэрүүд хүчингүй болохгүй, харин Үндсэн хууль зөрчсөнийг тогтоосноос хойш хуулийн холбогдох заалт хүчингүй болно.

Маргааныг хянан хэлэлцэж шийдвэр гаргах үед гишүүдийн санал тэнцвэл тухайн зөрчил бүхий маргаантай асуудал нь хангалтгүй байна гэсэн үг. Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд гишүүд санал өгөхөөс татгалзах эрхгүй.

Гүржийн ҮХШ-д маргаан хянан шийдвэрлэх хугацаа нь 30 хоног, онцгой тохиолдолд энэ хугацааг Бүгд хуралдаанаас 30 хүртэл хоногоор сунгаж болно. Төрийн нийт байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд маргаан хянан шалгаж буй ҮХШ-ийн гишүүний шаардсан бичиг баримт, тайлбар, мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх

үүрэгтэй. Тэдэнд энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Шаардлагатай бол маргаан хянан шалгах ажиллагааны явцад шинжээч томилогч, гэрч оролцуулах ч эрх УХШ-ийн гишүүнд нээлттэй.

Хэм хэмжээний актын талаархи маргааныг хянан шалгах явцад маргалдагч талуудын аль нэгэнд ноцтой үр дагаварт хүргэхээр байвал маргаан бүхий актын үйлчлэлийг эцэслэн шийдвэрлэхээс өмнө нь зогсоож болно.

Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх журм

УХШ-д ихэнх хэргийг нээлттэй хуралдаанаар авч хэлэлцэнэ. Зарим тохиолдолд тухайлбал, УХШ-ийн санаачилгаар, талууд хүсэлт гаргаснаар, төрийн нууцтай холбоотой асуудлыг хэлэлцэхдээ хаалттай хуралдаан хийдэг. Хаалттай хуралдаан хийх үед шаардлагатай тохиолдолд гэрч, шинжээч, орчуулагчийг оролцуулж болно. Мөн УХШ-ээс талуудын хүсэлт гаргаснаар холбогдох бусад этгээдүүдийг оролцуулах боломжийг бүрдүүлж өгнө.

УХШ-ийн хуралдаан болохоос өмнө түүнийг нээлттэй эсхүл хаалттай хийх эсэхийг бүх гишүүдийн хуралдаанаар хэлэлцэж магадлал гаргана. Гэрч л биш бол хуралдаанд 16 насанд хүрээгүй хүн, мөн хуралдааны дэг сахиулагчаас бусад этгээд галт зэвсэгтэй орж болохгүй.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг гарсан даруйд нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж нийтэлдэг. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг гүрж хэл дээр явуулна. УХШ-ээс гүрж хэл мэдэхгүй маргагч талуудад орчуулагч, хэлмэрч гаргаж өгөх үүрэгтэй.

Маргагч талууд хэргийн материалтай танилцах, түүнээс

хуулбар хийх, тэмдэглэл хөтлөх, нотлох баримтыг гаргаж өгөх, нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаанд оролцох, гэрч, шинжээчид асуулт тавих, УХШ-д хүсэлт гаргах, шүүх бүрэлдэхүүнээс татгалзах, бичгээр болон аман тайлбар гаргах, өөсдийн санаа бодол, дүгнэлтийг хэлэх эрхтэй.

Маргагч талууд хуралдааны бүрэлдэхүүнээс дараах тохиолдолд татгалзах эрхтэй. Бүрэлдэхүүнд орсон УХШ-ийн гишүүн ч энэ тохиолдолд татгалзан гаргах үүрэгтэй. Үүнд:

1. УХШ-ийн гишүүн нь маргагч талын ойрын төрөл садангийн хүн байвал;
2. УХШ-ийн гишүүн шууд болон хөндлөнгөөс хэргийн үр дагаварт нөлөөлөхөөр байвал;
3. Маргагч талын аль нэгийг өмгөөлөгчөөр урьд нь ажиллаж байсан бол.

Дээрх тохиолдолд гишүүнийг татгалзан гаргах асуудлыг УХШ-ийн хаалттай хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хэргийг хянан хэлэлцэх аль ч шатанд маргагч талууд хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлийн өмгөөлөгчөөр, эсхүл бусад этгээдээс хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлүүлэх, мөн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогч, түүнд өөрийн бүрэн эрхийг шилжүүлэх эрхтэй.

УХШ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг иргэдийн мэдүүлэг, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан өргөдөл, хүсэлт үндэслэн явуулна. Энэ үүднээс УХШ-ийн хуралдаан тэрхүү өргөдөл, хүсэлт, мэдүүлгийг /энэ нь хууль зүйн үндэслэлтэй байх, маргагч этгээдийн үзэл бодлоор үндэслэлийг заавал дурдсан байх ёстой/ илтгэснээр эхэлнэ. Хуралдаанд гэрч, шинжээч, орчуулагчийг оролцуулахдаа урьдаас эрх, үүрэг, хуралдааны дэг зөрчсөн тохиолдолд

хүлээлгэх хариуцлагыг танилцуулсан байна.

УХШ-д зарга гаргах эрхийг Гүржийн парламент болон парламентын гишүүдийн тавны нэгээс багагүй нь санал гаргаснаар хэрэгжүүлнэ. Гэхдээ зарим хязгаартайгаар тодруулбал, хууль, парламентын дэг, хэм хэмжээ тогтоосон акт, мөн Гүржийн Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан акт, Абхаз, Аджарийн төрийн байгууллагуудаас гаргасан актууд Гүржийн Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлаар Парламент түүний гишүүд УХШ-д хүсэлт гаргах эрхтэй.

Хариуцагчийн хувьд тухайн хэм хэмжээний актыг баталсан байгууллага, тэдгээрийн албан тушаалтан байх ба тэрхүү зөрчил бүхий акт нь Үндсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан байвал түүнийг баталсан байгууллага, албан тушаалтныг залгамжлах байгууллага, албан тушаалтан нь байна. Ийм байгууллага байхгүй /татан буугдсан г.м/ бол УХШ-ийн шийдвэрээр хариуцагч нь Гүржийн Ерөнхийлөгч, эсхүл Гүржийн парламент байна.

Төрийн байгууллагуудын хооронд үүссэн эрх мэдлийн маргааны талаарх хүсэлт УХШ-д Гүржийн Ерөнхийлөгч гаргах эрхтэй. Мөн тэрбээр Ерөнхийлөгчийн бүрэн эрх болон Үндсэн хуулиар олгогдсон төрийн байгууллагуудын бүрэн эрх зөрчигдсөн гэж үзвэл энэ талаар УХШ-д хүсэлт гаргах эрхтэй.

УХШ-д гаргасан мэдүүлэг болон хүсэлтийн нэг хувийг холбогдох байгууллага, албан тушаалтанд, мөн Гүржийн Ерөнхийлөгч, Парламентад, Абхаз болон Аджарийн төлөөлөгчдийн дээд байгууллагад хүргүүлнэ. Ийнхүү хүргүүлснээс хойш 15 хоногийн хугацаанд тухайн хүсэлт, мэдүүлэг нь тэдгээрийн бүрэн эрхэд халдсан байна гэж

үзвэл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдүүлэгчийн хувиар оролцуулах үүрэгтэй байдаг.

Иргэдийн улс төрийн нэгдэл, түүнийг үүсгэн байгуулах талаарх хүсэлтийг УХШ-д Гүржийн Ерөнхийлөгч, Парламент (тавны нэгээс багагүй саналаар), мөн Абхаз болон Аджарийн төлөөлөгчдийн дээд газраас оруулах эрхтэй. Энэ маргааны хариуцагч нь иргэдийн улс төрийн нэгдэл болоод тэдгээрт бүртгэгдсэн байгууллагууд байдаг. Парламент, Гүржийн Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар эсхүл сонгогчдын шаардлагаар, сонгогчдын шаардлагыг үл харгалзан бүх нийтийн санал хураалтыг хүчингүйд тооцвол Гүржийн ардын өмгөөлөгч Бүх нийтийн санал хураалтын талаарх хүсэлтийг гаргах эрхтэй.

Сонгуулийн талаар гарсан маргааны тухай хүсэлтийг Ерөнхийлөгч, Парламентийн гишүүдийн тавны нэгээс багагүй саналаар УХШ-д гаргана. Тухайлбал, Гүржийн Ерөнхийлөгчийн сонгууль Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн, Парламентын сонгууль Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 2; 50 дугаар зүйлийн 1-ийн 4 дэх хэсэгт заасан шаардлагыг зөрчсөн эсэх тухай асуудлаар хүсэлт гаргах бөгөөд энэ тохиолдолд хариуцагч нь Гүржийн Сонгуулийн төв комисс байна.

Олон улсын гэрээ хэлэлцээрийн тухай болон тэдгээрийн зарим заалтыг зөрчсөн тухай хүсэлтийг УХШ-д Гүржийн Ерөнхийлөгч, Парламент оруулна. Ингэхдээ тухайн олон улсын гэрээ хэлэлцээрийн зөрчил бүхий заалтыг батлагдсаны дараа болон батлагдахаас нь өмнө УХШ-д гаргаж болдог онцлогтой.

Үндсэн хуулийн хэм хэмжээний акт болон тэдгээрийн зарим заалтыг хүчингүй болгох тухай хүсэлтийг Гүржийн ардын өмгөөлөгч эдлэх бөгөөд

хариуцагч нь тэрхүү хэм хэмжээний актыг батлан гаргаж Үндсэн хуулиар олгогдсон хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэсэн, зөрчсөн байгууллага албан тушаалтан байна.

Парламентын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, хугацаанаас нь өмнө чөлөөх тухай шийдвэртэй холбоотой хүсэлтийг Гүржийн Ерөнхийлөгч, Парламентаас гадна тухайн асуудалд холбогдсон парламентын гишүүн дангаараа гаргах эрхтэй бөгөөд энэ тухай хүсэлтийг тухайн шийдвэр гарснаас хойш 14 хоногос хэтрэхгүйгээр УХШ-д гаргасан байх ёстой. Энэ тохиолдолд хариуцагч нь Гүржийн парламент байна.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр

УХШ-ийн шийдвэр нь магадлал, дүгнэлт гэсэн хэлбэртэй. Шийдвэрт тухайн маргааныг хэлэлцэхэд орсон бүрэлдэхүүн бүгд гарын үсэг зурна. УХШ-ийн бусад шийдвэртэй холбогдолгүй албан бичигт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. УХШ Үндсэн хуулийн холбогдолтой хүсэлт өргөдөл, болон мэдүүлгийг хянан шийдвэрлэж батлах асуудлыг магадлалын хэлбэрээр, харин Гүржийн Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Гүржийн Засгийн газрын гишүүн, Ерөнхий прокурор, Хянан шалгах танхимын дарга, Үндэсний банкны зөвлөлийн гишүүд Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг дүгнэлтийн хэлбэрээр шийдвэр гаргана.

УХШ-ийн шийдвэр нь гармагцаа хүчин төгөлдөр бөгөөд түүнийг давж заалдах, эсхүл дахин хянах тухай ойлголт байхгүй. УХШ аливаа шийдвэр гаргахдаа тухайн маргааны талаархи хууль зүйн үндэслэлийг маш нарийн хэн ч ойлгомжтой шинжлэх ухааны

үндэслэлтэй гаргах учиртай.

УХШ-ийн Бүгд хуралдааны ирц нь нийт гишүүдийн гуравны хоёр буюу 6 ба түүнээс дээш гишүүн байгаа тохиолдолд аливаа асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үздэг. УХШ-ийн коллегийн хуралд 3-аас доошгүй гишүүн байгаа үед хүсэлт өргөдөл, мэдүүлгийг шийдвэрлэж болно.

УХШ өөрийн албан ёсны хэвлэлтэй. Маргаан хянан шийдвэрлэх явцад УХШ-ийн гишүүн тухайн асуудлаар онцгой санал гаргах эрхтэй бөгөөд энэхүү онцгой саналыг хуралдааны протоколд хавсаргахын зэрэгцээ УХШ-ийн шийдвэрийн хамт хэвлэлд нийтэлнэ.

УХШ-ийн нарийн бичгийн дарга шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн талаар сард 1 удаа бүгд хуралдаанд танилцуулна. Хуралдаанд оролцох гишүүд тусгай өмсгөлтэй. Өмсгөл хэрэглэх журам, өмсгөлийн загварыг УХШ-ийн дэгээр тодорхойлдог байна.



ИРГЭНИЙ ШИЛЖИН СУУРЬШИХ ХӨДӨЛГӨӨН, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ

ИБМУТ-ийн Бүртгэл мэдээллийн
Хэлтсийн мэргэжилтэн
Ц.ГАНЗОРИГ

Монгол улс дэлхийд хүн амын нягтшил багатай буюу сийрэг суурьшилтай оронд багтдаг. 1ам/км нутагт улсын хэмжээнд 1.5 хүн ногдож байна. Нягтрал хамгийн ихтэй Улаанбаатар хотод 1ам/км-т 162 хүн, нягтрал хамгийн багатай Өмнөговь аймагт -0.3 хүн ногддог байна. 1918-2004 онд Монголын хүн ам 542.5 мянгаас 2503161 хүртэл 4.6 дахин өссөнөөр хүн амын нягтшил 1ам/км-т 0.33 хүн байснаа 1.44 болж өсчээ.

1918 онд хүн амын тооллогоор монголчуудын 15-20 хувь нь хот сууринд, 80 гаруй хувь нь хөдөөд оршин сууж байсан ба нийслэл хүрээнд 40 мянга гаруй, Ховд, Улиастай, Сан бэйсийн хүрээ, Хиагтад 2-3 мянган Монголчууд байжээ. Харин 1921 оноос хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн эхэлсэн тухай мэдээ байдаг. 1990 оноос хойш манай орны нийгэм, эдийн засгийн хүрээнд гарсан өөрчлөлтийн нөлөөгөөр хүн амын бүртгэлийн болон хүн ам зүйн үзүүлэлтэд ч олон өөрчлөлт оров.

Үүнтэй холбоотойгоор Монгол улсын иргэдийн дотоод гадаад шилжих хөдөлгөөн эрс ихэсч гадаад

орнуудад сурч, ажиллаж амьдрахаар зорчин явагсад олширч, хөдөөнөөс сумын төв рүү, сумын төвөөс аймгийн төв рүү, аймгийн төвөөс нийслэл, дархан, эрдэнэт зэрэг төвлөрсөн суурин газар руу чиглэсэн хөдөлгөөн ихээхэн нэмэгдсэн байна.

2004 оны байдлаар Улаанбаатар хотод 720009, Дархан-Уул аймагт 96888, Орхон аймагт 67983 хүн амьдарч байгаа нь зөвхөн эдгээр 3 хотод л гэхэд 884800 хүн буюу нийт хүн амын 35.3 хувь нь оршин сууж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18-д "улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй ..." гэж зааснаар шилжин суурьших нь иргэдийн сайн дурын асуудал мэт боловч "Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-ын 3.2-т заасан "Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар буюу бүрмөсөн шилжин ирсэн бол 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт оршин суугаа газрынхаа

хаягаар бүртгүүлж иргэний үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ" гэсэн заалтыг цөөнгүй иргэд биелүүлэхгүй байгаа ба иргэдээс иргэний баримт бичгийн зайлшгүй шаардлага гарахгүй л бол хаягийн хөдөлгөөний бүртгэлээ хийлгэх асуудалд туйлын хойрго ханддаг болсон байна.

Тухайлбал 2002 онд аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин явсан 26067 иргэн байгаагаас шилжин ирсэн тухай бүртгэлд хамрагдсан 25475 иргэн байна. Шилжин ирсэн тухай бүртгэлд хамрагдаагүй 592 иргэн байгаа нь 2.3 хувийг эзэлж байна.

Харин 2003 онд шилжин явсан 27724 иргэнээс шилжин ирсэн бүртгэлд бүртгүүлсэн 25599, түүнээс 2125 иргэн буюу 7.6 хувь нь бүртгэлд хамрагдаагүй байгаа нь урьд оныхтой харьцуулахад 5.6 хувиар өссөн байна.

Мөн засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд шилжин суурьшиж удаан хугацаагаар амьдарсан хэдий ч албан ёсны шилжүүлэг хийлгээгүй засаг захиргаа завсардсан иргэд болон айл өрхүүд олширсон байна.

2004 онд явуулсан иргэний баримт бичгийн улсын үзлэгээр Улаанбаатар хотод 4385 өрхийн 11529 иргэн, аймаг, орон нутагт 5683 өрхийн 18970 иргэн үндсэн засаг захиргааны нэгжээсээ хасалт хийлгэлгүйгээр шилжин суурьшиж шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдаагүй гэсэн дүн гарсан байна.

Иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнтэй холбогдсон харилцаа нь Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-аар зохицуулагддаг бол хүн амын анхан шатны бүртгэлд хамруулах, шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх мэдээлэх ажлыг "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-д бүх шатны засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд байхаар заасан байдаг.

Энэ тогтсон хяналтын систем тогтолцоог шат шатандаа бүрэн хангаж ажиллаж чадахгүй байгаагаас УИХ-ын буюу Ерөнхийлөгчийн сонгууль зэрэг компанит ажил явагдах үед аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодод сонгуулийн насны

иргэдийнхээ тоог бүрэн тогтоож чадахгүй будилж, энэ алдаа дутагдлаа бусад байгууллага албан тушаалтанд тохох гэсэн оролдлого ч ажиглагдах болов.

Иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл эмх замбараагүй байгаа байдалд дүгнэлт хийж үзвэл хууль тогтоомжийн дагуу иргэний шилжих хөдөлгөөн түүний бүртгэлийн ажлыг хариуцсан байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулж, хуульд заасан эрх үүргийнхээ хүрээнд хуулийн заалтыг ягштал биелүүлж ажиллаж чадахгүй байгаа болон нөгөө талаас иргэдийн хайхрамжгүй байдал, хуулийн мэдлэг дутмагаас шалтгаалж байна гэж үзэж болох юм.

Үүнтэй холбогдуулан дараах ажлуудыг нэг бүрчлэн хийж хэвших шаардлагатай байна. Үүнд:

1. Иргэдтэй илүү ойр ажиллаж байгаа баг, хорооны Засаг дарга нар хүн амын анхан шатны бүртгэл болох хүн амын өрхийн бүртгэлийн дэвтрийг нарийн хөтөлж, баг хорооныхоо нутаг дэвсгэрт иргэний баримт бичгийн үзлэг шалгалтыг тодорхой график, төлөвлөгөө гарган хийж хэвших,
2. Үзлэгээр илэрсэн хаягийн бүртгэлгүй иргэдийн асуудлыг тухай бүрд нь шийдвэрлүүлэх арга хэмжээ авч, иргэдээс

засаг захиргаа завсардан бүртгэлгүй оршин суух бололцоо нөхцөлийг бүрдүүлэхгүй байх,

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрууд, баг, хорооны Засаг дарга болон иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбогдуулан үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагуудаас иргэдэд үйлчлэх үйлчилгээг шуурхай болгож ямар нэгэн явцуу эрх ашгийн үүднээс иргэдийг чирэгдүүлж, дарамт учруулдаг байдлыг бүрэн арилгаж ажиллах,
4. Иргэддээ иргэний баримт бичгийн хууль зүйн ач холбогдлыг бүрэн ойлгуулж сурталчлах ажлыг зохион байгуулан хийж ажиллавал шилжилт хөдөлгөөнтэй холбогдон гарч байгаа зөрчил дутагдал, эмх журамгүй байдлыг засч бүрэн цэгцлэх боломжтой юм.

* * *

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ БА ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ



Үндсэн хуулийн цэцийн гишүүн,
Академик Ж.АМАРСАНАА

Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүх нь эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу шүүх эрх мэдлийн ангилалд багтана.

Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэг нь "Монгол Улсын төрийн байгуулал" нэртэй бөгөөд энэ нь дотроо:

1. Монгол Улсын Их Хурал;
2. Монгол Улсын Ерөнхийлөгч;
3. Монгол Улсын Засгийн газар;
4. Шүүх эрх мэдэл гэсэн дөрвөн хэсэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь бие даасан Тавдугаар бүлэгт багтсан байна. Үндсэн хуулийн цэц нь "Төрийн байгуулал" бүлэг болон "Шүүх эрх мэдэл" хэсэгт багтаагүй нь Үндсэн хуулийг батлах цаг үеийн улс төрийн мэтгэлцээний нэг "халил" байсан юм. "Үндсэн хуулийн цэц" гэсэн оноосон нэртэй "Үндсэн хуулийн шүүх" байгуулагдаад, үйл ажиллагаагаа явуулаад 12 жил өнгөрч байхад Цэц шүүх биш гэж "онолдох" нь нийцдэггүй гэхээсээ илүү эмгэнэлтэй юм. Өнөө хэр Цэц ямар байгууллага болохыг мэдэхгүй, Цэцийн

шийдвэрийг үгүйсгэдэг, биелүүлэхээс цааргалдаг, үндсэндээ Цэцийг шүүх биш гэж үздэг, Цэцийг үгүйсгэдэг бүлэг улс төрч Монголд байгааг нуугаад хэрэггүй юм.

Үндсэн хуулийн цэц бол төрөлжсөн шүүх юм. Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан Үндсэн хуулийн байгууллага мөн. Харин Захиргааны хэргийн шүүх нь дагвасан шүүх юм. Хэдийгээр захиргааны хэргийн шүүх нь заавал байгуулагдах ёстой биш боловч Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд ...эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болохоор нэр заагдсан шүүх юм.

Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1-д заасанчлан дагвасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын Дээд шүүхийн хяналтаас гадуур байж болохгүй. Хэрэв Үндсэн хуулийн цэцийг дагвасан шүүхэд хамааруулбал Улсын Дээд шүүхийн хяналтад ороход хүрнэ.

Үндсэн хуулийн цэцийн үүрэг нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хянах байдаг бол Захиргааны хэргийн шүүхийн үндсэн үүрэг нь гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг хянах явдал юм. Эндээс Үндсэн хуулийн цэц болон Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны нийцэл ба ялгарал харагдана.

Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүх нь хүний эрхийг хамгаалах, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хуваарилалтыг хянах, эрх мэдэл бүхий албан тушаалтныг шүүх эрх, үүрэгтэй. Гэхдээ Үндсэн хууль бусад хуулиар тэдгээрийн

хооронд ажлын нарийн хуваарь тогтоогдсон байна. Үндсэн хуулийн шүүх, захиргааны хэргийн шүүхийн харилцаанд цаашид үүсч болох нэг зүйл бол иргэд аль алинд нь өргөдөл өгч зэрэгцүүлэн шийдвэрлүүлэх гэсэн оролдлого гарч магадгүй. Иргэд Улсын Дээд шүүхэд өргөдөл өгөөд уг шүүхээс хэрэг шийдвэрлэсний дараа, эсвэл хэргийг хянан шийдвэрлэх явцад тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэж буйтай холбогдуулан Ерөнхий шүүгчийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж Цэцэд хандаж байна. Үндсэн хуулийн цэц байгуулагдсанаас хойш Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн тухай гомдол 8 удаа ирж, Цэц зохих шийдвэр гаргажээ. Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн гэж өнөө хэр тогтоогдоогүй байна. Иргэн гомдлоо шүүхээр эцэслэн шийдвэрлүүлээд, хамгийн сүүлд Цэцэд ханддаг байх, Цэц ч ийм чиглэлээр асуудалд ханддаг байх нь Үндсэн хуулийн шаардлага юм. Гэхдээ энэ нь Дээд шүүхийн дараах шат маягаар шийдвэрлэсэн хэргийг нь хянана гэсэн үг биш юм. Үндсэн хуулийн асуудал бий эсэхийг л тогтоох нь чухал юм.

Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүх нь нэгэн адил шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг боловч нэг нь Үндсэн хуулийн төвшинд, нөгөө нь ердийн хуулийн төвшинд хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг тул уг ажлыг эрхлэх хүнд тавигдах шаардлага өөр өөр гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн ондөр мэргэшилтэй, дөчин нас хүрсэн иргэнийг томилдог бол Захиргааны шүүхийн шүүгчээр

хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан (энд онцлон тэмдэглэхэд Улсын Дээд шүүхийн "мэргэжлээрээ ажилласан" гэдэг ойлголтыг тайлбарласан 1993 оны тогтоол, 1997 оны нэмэлтийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй юм) хорин таван насанд хүрсэн иргэнийг (Улсын Дээд шүүхийн шүүгчийн хувьд мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, гучин таван нас хүрсэн иргэнийг) томилогд.

Хууль зүйн дээд боловсрол, хууль зүйн өндөр мэргэшил өөр өөр ойлголт, төвшний хувьд ялгаатай зүйл юм. Хууль зүйн дээд боловсрол гэдэгт хууль зүйн дээд сургууль төгсч бакалаврын зэрэг авсан, мөн хуульчийн сонгон шалгаруулалтад оролцож хуульчийн гэрчилгээ авсан байхыг ойлгоно. Тэгвэл хууль зүйн өндөр мэргэшил гэдэгт эрх зүйн шинжлэх ухаан, ялангуяа эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүйн нарийсан дагнасан, гүнзгийрсэн дээд төвшний мэдлэгтэй байхыг ойлгоно. Хууль зүйн хувьд мэргэжил-мэргэшил-нарийн мэргэшил¹ (энэхүү нарийн мэргэшил гэдэг нь Үндсэн хуулийн 65.2-т заасан өндөр мэргэшил гэдэгтэй дүйж байгаа юм) гэсэн дээд түвшин рүү шилжсэн, гүнзгийрсэн агуулга бүхий ойлголтын дагуу үзвэл хуульч-шүүгч-захиргааны хэргийн шүүгч, хуульч-өмгөөлөгч-хөдөлмөрийн хэргийн өмгөөлөгч, хуульч-шүүгч-Үндсэн хуулийн цэцийн гишүүн гэсэн эрэмбэ байгааг дурдах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, эхний эрэмбийн шаардлагыг алгасч дараагийн шатанд нь харайж орж болохгүй юм. Энэ нь жишээлбэл Захиргааны хэргийн шүүгч болохын тулд ердийн шүүхэд ажилласан байх ёстой гэсэн үг биш. Харин хуульч хүн шүүгчийн

болзлыг хангах, тэгээд захиргааны хэргийн шүүгчээр ажиллана гэсэн санаа юм. Улсын Дээд шүүхийн нийт 17 шүүгчийн (удахгүй томилогдохоор нэр дэвшээд байгаа захиргааны хэргийн танхимын 6 шүүгчийг оролцуулаад) дотор доктор, профессор цолтой хүн байхгүй бол Үндсэн хуулийн цэцийн 9 гишүүний дотор академич 2, шинжлэх ухааны доктор 3, доктор 4, дэд профессор, профессор 6 байна. Ердийн шүүх нь харьцангуй ойлголтоор "ахуйн" шинжтэй шүүх бол Үндсэн хуулийн цэц оволын шүүх бөгөөд энэ нь ч онолын шүүхэд онолын бэлтгэлтэй хуульч ажиллаж байгаа одоогийн бүрэлдэхүүнээр бас нотлогдож байна. Чухам ийм ялгаатай учир Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 5-д Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Улсын Дээд шүүхийн шүүгч орж үл болно гэж заасан. Ингэхлээр энэ нь доод шатны бусад бүх шүүгчдэд ч хамааралтай нь тодорхой. Энэ талаар Германд Холбооны Бүгд Найрамдах Улсын зохион байгуулалтаас үүдэн өөр тогтолцоо байна. Холбооны Үндсэн хуулийн шүүгч дагнан ажилладаг. Муж улсад бол өөр. Жишээ нь Бавари муж улсын Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч нь Баварын Үндсэн хуулийн шүүхийн дэд Ерөнхийлөгч байдаг аж.

Захиргааны хэргийн шүүхийн шүүгчээс өндөр мэргэшил шаарддаггүй учир, ажиллах явцад нь мэргэжүүлэх, сургах шаардлага гарч байдаг.

Захиргааны хэргийн шүүх шинэ тутам бий болж байгаагай холбогдон Дэлхийн банк, Америкийн "Шүүх эрх мэдлийн шинэтгэл" хөтөлбөр, Ханнс-Зайделийн сангийн өргөн дэмжлэг, оролцоотойгоор шинэ шүүгчдийг

сургах сургалтыг амжилттай зохион байгуулсан юм.

Хууль зүйн үндэсний төв 2003 оны 8 дугаар сараас "Захиргааны хэргийн шүүх" сэдэвт сургалтыг бүх аймаг, хотод зохион байгуулав. Үүнд 190 шүүгч, 86 прокурор, 73 өмгөөлөгч, 575 бусад албан тушаалтан (орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч, байцаагч зэрэг) хамрагдлаа. Мөн Захиргааны хэргийн шүүх (эмхтгэл), Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн, Захиргааны хэргийн шүүх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг зэрэг ном хэвлэн гаргасны гадна захиргааны хэргийн шүүхийн талаар таниулах зорилго бүхий 20 орчим нугалбар хуудас бэлтгэв. Одоо захиргааны хэргийн шүүхтэй холбоотой 14 гарын авлагыг хэвлэн гаргахаар бэлтгэж байна.

Цаашид ч нэлээд урт хугацаанд Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийг сургах шаардлага бий. Зохих хууль өөрчлөлт оруулж Захиргааны хэргийн шүүгч (бусад шүүгч ч адил) жил бүр сургалтад хамрагдаж, тодорхой тооны кредит авдаг байх журам тогтоох хэрэгтээ гарч магадгүй.

Төрийн албаны тухай (2002) хуулийн 19 дүгээр зүйлд "мэргэшлийн төвшинг үнэлэх" тухай заасан байдаг бол Шүүхийн тухай (2002) хуулийн 30.3-д "шүүхийн мэргэшлийн хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хуулийн болон шүүн таслах ажлын дадлагатай шүүгч, хуульч, эрдэмтдээс бүрдэнэ", мөн хуулийн 72.2-д "Судалгааны төвийн судлаачид мэргэшсэн байна" гэх зэргээр заасан нь өндөр мэргэшил нь мэргэжлийн боловсролоос наад зах нь шат ахуу, нарийвчлалтай, гүнзгий хийгээд дагнан төрөлжсөн байхыг харуулж байна.

Бас нэг зайлшгүй хэлэх зүйл бол "Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшил" гэдгийг Үндсэн хуулийн анх батлахдаа нэгдмэл, хам

¹ Ромын эрх зүйд томъёологдсон, эдгээр латин үүсэлтэй үгийг оросоор специальность-квалификация-профессия; англиар specialization-qualification-profession; германаар spezialisierung-qualifizierung-profession гэдэг байна.

шаардлага гэж ойлгож байсан. Гэтэл үүнийг 1992, 1998 онд Ерөнхийлөгч, 2004 онд Улсын Их Хурал улс төрийн учир шалтгааны улмаас тус тусдаа шаардлага мэтээр "мэдэн будилж" Үндсэн хуулийн цэцийг хараат бус, бие даасан шүүх байх Үндсэн хуулийн болзлыг биелүүлэхгүй байна. Улс төрийн өндөр мэргэшил гэдэг нь улс төр судлалаар зэрэг хамгаалсан эрдэмтний алба уу?, эсвэл энэ чиглэлийн хичээл заадаг профессорын эрхэлж буй ажил уу? Улс төрийн өндөр мэргэшилээр ажиллаж байгаа хүн гэж хэвийг хэлэх вэ? Улсын Их Хуралд 8 жил ажилласан, 10 жил сумын Засаг даргаар ажиллаж байгаа, 12 жил багийн Засаг даргаар ажиллаж байгаа хүнийг (Төрийн албаны хуулийн дагуу сум, багийн Засаг дарга улс төрийн албан тушаалтанд хамаарч буй) улс төрөөр өндөр төвшинд мэргэшсэн гэх үү? Үндсэн хуулийн заалтын агуулгаас үзвэл эрх зүйтээр өндөр төвшинд нарийн мэргэшсэн, төрийн ажлын (төрийн байгууллага бол улс төрийн бүтэц мөн) арвин гуршлага, дадлага, чадвартай, улс төрийн өндөр мэдрэмжтэй, улс төрийн мэдлэгтэй, хууль зүйн шинжлэх ухааныг өндөр төвшинд эзэмшсэн, үгүйдээ л энэ чиглэлээр сургалт, судалгааны ажил хийж байсан буюу хийж буй хүнийг хамааруулж байгаа болов уу. Үндсэн хуулийн шаардлага бол ердийн төвшний хууль зүйн мэргэшил, ердийн төвшний улс төрийн мэргэшил бус өндөр төвшний хууль зүй, улс төрийн мэргэшлийн асуудлыг тавьж байгаа юм. Улс төрийн өндөр мэргэшил нь улс төрийн тодотголтой албан тушаалыг олон жилээр хааснаар илэрхийлэгдэхгүй. Өмнө дурдсанаар Цэц "оюуны" шүүх учир оюуны өндөр төвшинд бэлтгэгдсэн хүн энэ ажлыг хийх учиртай. Улс төрийн харилцаа, улс төрийн тогтолцоо, бүтэц, байгууллага, улс төрийн нам, улс төрийн манлайлал, улс төрийн ёс зүй, улс төрийн сэтгэл зүй зэрэг асуудлыг зөвхөн "гадарладаг" биш "доторлодог" хуульч улс төр-эрх

зүйн баримт бичиг болох Үндсэн хуулийг "манах" бололцоотой юм. Эрх зүйн сэтгэлгээ хөгжсөн төдийгүй, түүн дээр нэмээд улс төрийн сэтгэлгээ хөгжсөн, эрх зүйн "зүүн их тархи" нь улс төрийн "баруун их тархитай" эн тэнцүү ажилладаг хүн "Үндсэн хууль" гэдэг бүтэцийн манаачийн үүргийг гүйцэтгэх чадвартай.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Захиргааны хэргийн шүүхийн шүүгч нь мэргэшлийн хувьд ч, хувь хүний хувьд ч хараат бус байж, цэц, шүүх бие даасан байх нь Цэц, Захиргааны хэргийн шүүхэд хангалттай биш. Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь эрх зүйн хувьд үндэслэлтэй шийдвэр гаргах боломжоор хангагдсан байх учиртай.

Үүний тулд иргэд Цэц, шүүхэд хандах эрхээр хангагдсан байх ёстой. Түүнчлэн Цэц, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл ягштал дагаж мөрдөх шаардлагатай. Дагаж мөрдөхүйц, хүлээн зөвшөөрөхүйц шийдвэр гаргахад хараат бус байдал, төвийг сахисан байдал, ялангуяа хууль зүйн боловсрол, мэдлэг, туршлага яах аргагүй хэрэгтэй.

Хуулийг зөв хэрэглэж чадвал аливаа маргааныг зохицуулж чадна. Хоёр этгээд хоорондоо маргалдахад Гуравдагч этгээд зохицуулах шаардлага заавал гардаг нь энгийн ойлголт. Гэхдээ гуравдагч этгээдийг эрх зүйн хувьд зөв шийдвэр гаргаасай гэж хүсэх нь ойлгомжтой. Шийдвэр гаргах хүн нь хуулийг өөрөө зөв ойлгож, зөв хэрэглэж, зөв тайлбарлах шаардлагатай. Чухам үүнд мэргэшлийн, мэргэшсэн, өндөр мэргэшилтэй хүн байх хэрэгтэй болдог. Ийм ч учраас хууль зүйн боловсролыг, хууль зүйн мэргэшлийг, тэр тусмаа мэргэшлийг хуулиар тодорхой шаардлага болгон тавьж байгаа хэрэг.

Шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс

хараат бус байж чадах чухал болзол бол асуудлыг хууль зүйн мэргэжлийн дагуу шийдвэрлэж чаддаг байх явдал мөн.

Үндсэн хуулийн цэцэд нэгэнт хууль зүй, улс төрийн хос шаардлагыг хамтатган хангаан өндөр мэргэшлийн албан тушаалтан буюу шүүгч ажиллаж байх ёстой учир Цэцийн гишүүнийг дүгнэх, шалгах мэргэшлийн хороо, сахилгын хороо гэж байхгүй. Захиргааны хэргийн шүүхэд байх мэргэжлийн алдаа, мэргэшлийн хороо, сахилгын хороо, давтан (үргэлжилсэн буюу тасралтгүй) сургалт, мэргэшил дээшлүүлэх, шүүгчдийн зөвлөгөөн зэрэг асуудал хууль зүйн хувьд Цэцээс ангидаг гэсэн үг.

Гэхдээ Цэц, түүний гишүүн хараат бус байж, зөвхөн Үндсэн хуульд захирагдах, Цэцийн гишүүд төвийг сахих, хууль зүй, улс төрийн өндөр мэргэшлийн төвшинд шийдвэр гаргах талаар шийдвэрлээл зохих тулгамдсан асуудал чамгүй их байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Монгол Улсад хууль дээдлэх ёс хийгээд Үндсэн хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх үйл явц сүүлийн 12 жилд улс төрийн амбиц, нам, бүлэглэлийн явцуу эрх ашиг, мөнгийг шүтэх үзэлтэй харшилдан сөргөлдөж байна. Нэг баримт дурдъя. Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Үндсэн хуулийн цэц нь Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгааг эсэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд оруулах эрх, үүрэгтэй. Гэтэл 1998-2000 онд Улсын Их Хурал Ерөнхий сайд М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт нарыг дараалан огцруулахдаа Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргуулалгүй Үндсэн хуулиас гадуур үйл ажиллагаа явуулж, Үндсэн хууль дээдлэх ёсыг ноцтой зөрчиж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Ерөнхий сайдыг учир шалтгаангүй, ямар ч үндэслэлгүй огцруулж таархгүй байх. Хууль зөрчсөн нь Үндсэн хуулийн зохих заалтыг (тухайлбал Үндсэн

хуулийн Нэгдүгээр зүйл) зөрчсөн гэх үндэслэлээр эрх бүхий субъект Үндсэн хуулийн цэцэд ханддаг байх практикийг улс төр, эрх зүйн хүрээнд тогтоогоосой гэж бодож байна. Улсын Их Хурал итгэл хүлээлгээгүй, огцрох, чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг огцруулахаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан зэрэг асуудлын зааг ялгааг тогтоох шаардлагатай.

Өнөө хэр эрх зүй, улс төр хоёрын хоорондын харилцан хамаарал, уялдаа холбооны асуудлыг дутуу үнэлэх, үл ойшоох явдал гарсаар байгаагийн нэг ирлэл энэ юм.

Эрх зүйг давамгайлсан улс төр ба эрх зүйгээр хязгаарлагдсан улс төрийн харьцаа, харилцан хамаарлыг судлах тулгамдсан хэрэгцээ ч байна.

Бодит байдлыг авч үзвэл эрх зүй, улс төр хоёрын хоорондын харилцаанд улс төр нь ямагт давамгайлна гэсэн үзэлтэй маргагдах нь хүндрэлтэй. Энэ бол хамгийн энгийн томъёолд бөгөөд түүнийг эсэргүүцээд бодитой байхад бэрх. Гэхдээ үүнээс цааш харах хэрэгтэй. Эрх зүй бол улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх зэвсэг. Гэвч эрх зүйг давамгайлсан улс төр нь өөрийн хязгаартай байна. Тодорхой тохиолдолд улс төр нь эрх зүйгээр давамгайлдаг захиргааг буюу түүнээс хараат байх боломжтой бөгөөд шаардлагатай.

Үндсэн хуулийн цэцийн Захиргааны хэргийн шүүхээс яллагах нэг онцлог нь тэрээр улс төрд ойр байдагт оршино. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг улс төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас томилдог хийгээд Цэцийн шийдвэр нь улс төрийн агуулгатай гадна улс төрийн нөлөөтэй байдаг. Нөгөө талаар Цэц нь тухайн үеийн нөхцөл байдалд хөтөлгөж, маргаантай асуудлыг олонхийн ардчиллын улс төрийн шахалтад автан шийдвэрлэж болохгүй юм. Үндсэн хуулийн

нийтлэг, ерөнхий заалтад дулдуудан түүнийг онолын төвшинд тайлбарлах, шийдвэр гаргах орон зай, боломж их юм. Гэхдээ Цэц цаг үеийн нөхцөл байдал, үзэл бодол болон нийгэмд шинээр бий болж буй үзэлэмжийг хооронд нь ялган салгаж чадах, оюуны эрсдэлийг хүлээж чадах чадвартай байх учиртай.

Улсын Их Хурал, Үндсэн хуулийн цэцийн хоорондын эрх зүйн харилцаа нь уг чанараараа сөргөлдөөнт шивжийг агуулж байдаг. Энэхүү харилцаанд Цэц нь Улсын Их Хурлаас баталсан хуулийг хүчингүй болгох хүртэл түүний эрх мэдэлд нөлөөлөх олон хэлбэр бий.

Үүний нэг чухал хэлбэр нь Цэц Үндсэн хуулийг тайлбарласан шийдвэр гаргаж байгаа явдал юм. Нөгөө талаар Улсын Их Хурал ч Цэцийн гишүүдийг томилох зэргээр өөрийг нь хянаж Цэцэд нөлөөлөх боломж олон бий.

Цэцийн бүх шийдвэр биш, тодорхой асуудлаар Үндсэн хуулийн утга санааг задалж, гүнзгийрүүлэн логик утгаар тайлбарласан шийдвэр Үндсэн хуулийн тайлбар болж байдаг.

Нийгмийн бүлгийн тодорхой хэсгийг төлөөлж байдаг, тодорхой хугацаагаар бараг бүх бүрэлдэхүүн нь шинэчлэгдэн өөрчлөгддөг, дийлэнхи нь хууль зүйн мэргэжлийн бус хүмүүсээс бүрддэг, улс төрийн бүтэц болох парламент хууль тайлбарлах, тэр тусмаа Үндсэн хууль тайлбарлах ямар ч яриа байж таарахгүй.

Үндсэн хуулийг тайлбарлах нь хууль тогтоох үйл ажиллагаанаас агуулгын хувьд хальсан. Үндсэн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарч ирж буй, өөр субъектээс хэрэгжүүлэх, өөр хүрээний, өөр шатны ажил юм. Зарим хүн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж буй нь түүнийг тайлбарлаж буй явдал гэж бичиж байна. Асуудлыг нягтж бичүүвчилж ойлгож болохгүй юм. Вүхэл бүтэн хууль гаргасан ч бай, хэсэгчлэн “засварласан” ч бай

хууль тогтоож л буй хэрэг.

Социализмын үед Ардын Их Хурлын Тэргүүлэгчид Үндсэн хуулийг тайлбарлах эрхтэй байсан. Одоо ийм практик тоталитар дэглэмтэй, голдуу коммунист удирдлагатай, социализмыг үргэлжлүүлэн байгуулж байна гэгддэг орнуудад бий. Ийм орны тоонд ВНХАУ, ВНАСАУ, Куба, Вьетнам, Лаос, Этиоп зэрэг орон багтдаг. Бид хуучнаа сэргээх юм уу, иймэрхүү орны туршлагыг амьдралд хэрэгжүүлэх гэж оролдох ямар хэрэгцээ байна вэ?, Үндсэн хуулийн шүүхийг Монголд байгуулсны учир юу вэ?.

Үндсэн хуулийн цэц хууль тогтоогчоос гаргасан шийдвэр нь Үндсэн хуулийн үнэлэмж, үзэл баримтлал, зарчмыг зөрчсөн эсэх талаар л шийдвэр гаргах эрх хэмжээтэй. Иймээс Цэц ихэнх тохиолдолд Улсын Их Хурал эрх зүйн хувьд хамгийн оновчтой зөв, шударга шийдэл гаргасан эсэхийг хянах үүрэггүй. Үүгээрээ Цэцийн үүрэг Захиргааны хэргийн шүүхтэй адил.

Үндсэн хуулийн цэцийн “хариуцагч” нь үндсэндээ төрийн дээд ангиллын өндөр зэрэг дэвийн улс төрийн албан тушаалтнууд юм. Үүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүд, Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор гэсэн 97 албан тушаалтан, Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хороо гэсэн төрийн 4 институт хамаарагдаж байна. Захиргааны хэргийн шүүхийн “хариуцагч” нь үндсэндээ захиргааны дунд шатны буюу “конторын” гэдгэх олон мянган албан тушаалтан байна. Энэ хоёр шүүх дарга нарт зориулагдсан шүүх маягтны хувьд нийтлэг, адил төсөөтэй зүйл олон буйн зэрэгцээ ялгаатай тал ч мөн олон. Нэг жишээ хэлбэл Үндсэн хуулийн цэцийн оролцогчид өөрсдөө нотлох баримтаа гаргаж өгөх (Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянах шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18.2; 20.1.4) үүрэгтэй бол Захиргааны хэргийн шүүх нотлох

баримт цуглуулах, үнэлэх үүргийг өөрөө (Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1) хүлээгдгээрээ ялгаатай.

Захиргааны шүүх нь уг чанараараа ард түмэнд шууд хүрч үйлчилж байгаа албан хаагчдын хариуцлага, дэг журмын асуудлыг хариуцна. Энэ утгаар уг шүүхийг улс төрд хутгахгүй байх талаас нь бодолцох учиртай. Үүнээс үздэн Төрийн албаны тухай (2002) хуулийн 6 дугаар зүйл (төрийн улс төрийн албан тушаал)-д нэн даруй өөрчлөлт оруулах шаардлагатай. Тухайлбал 6.1.12-д "бүх шатны Засаг дарга", 6.2-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хот, тосгоны захирагч улс төрийн албан тушаалтан" байхаар заасныг хүчингүй болгох нь зүйтэй.

Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүхийн бас нэг хамаарлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан байгаа. Хэргийн харьяалал тогтоох тухай уг зүйлд: "Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ" гэж заасан. Үүний дагуу захиргааны хэргийн шүүхийн хүрээнд, эсвэл захиргааны хэргийн ба эрүү, иргэний шүүхийн хооронд хэргийн харьяалал тогтоож чадахгүй ахул Үндсэн хуулийн цэц зохицуулах боломжтой. Ийм байдал цаашид үүсч болохыг үгүйсгэж болохгүй. Ийм практик ч бий.

Үндэслэлгүйгээр үүсгэсэн сахилгын хэргийг шийдвэрлүүлэхээр нэг иргэн Улсын Дээд шүүх, Нийслэлийн шүүх, Баянзүрх дүүргийн шүүхэд өргөдөл гаргасан боловч дээрхи шүүхэд шийдвэрлэж өгөөгүй байна. Иймд харьяалал тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасны дагуу

Үндсэн хуулийн цэц 1997 онд хянан хэлэлцээд уг маргааныг Улсын Дээд шүүхээр харьяалуулан шийдвэрлүүлэхээр тогтоосон байна.

Үндсэн хуулийн цэц, Захиргааны хэргийн шүүх нь бие биедээ хэрэг шилжүүлэх зайлшгүй нөхцөл байдал бий болно. Энэ нь Цэцийн одоогийн практикаар ч нотлогдож байна. Үндсэн хуулийн цэцийн тухай (1992) хуульд (9.3; 9.4) заасанчлан Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан биш буюу Цэцэд харьяалагдахгүй байвал өргөдөл, мэдээллийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлэх, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай (1997) хуульд зааснаар Цэцэд ирүүлсэн маргааны шаардлагын зарим нь Цэцэд, зарим нь өөр шүүхэд харьяалалтай байвал Цэц зөвхөн өөрийн харьяалалтай маргааны шаардлагыг шийдвэрлээд шүүхийн харьяалах маргааны шаардлагыг шийдвэрлэхээс татгалзана. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.1.8-д зааснаар захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн маргаан бол захиргааны хэргийн шүүхийн шүүгч нэхэмжлэл хүлээн авахаас татгалзаж, Цэцэд нэхэмжлэлийг шилжүүлнэ. Энд анхаарах нэг зүйл бол шүүгч тухайн захиргааны акт чухамдаа Үндсэн хуулийг зөрчсөн гэдгийг тогтоох эрх зүйн өндөр мэдлэг, хууль зүйн нарийн мэдрэмжтэй, практикийн асар өргөн туршлагатай байх шаардлагатай. Энэ талаар Захиргааны хэргийн шүүхийн шүүгчид хуулиар маш өндөр шаардлага тавигдаж байгаа юм.

Хэрэг хянан шийдвэрлэхэд гарч болох нэг бэрхшээл бол хоёр шүүхийн зарим "хариуцагч" давхардаж байгаа явдал юм. Тухайлбал Үндсэн хуулийн цэцэд Засгийн газар, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Сонгуулийн ерөнхий хороо "хариуцагч" болдог бол дээрх

субъектүүд мөн захиргааны хэргийн шүүхийн хариуцагч болно. Чухам энэ давхардлаас "Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан" хийгээд "Захиргааны хэрэг"-ийн ялгаа, огтлолцлыг нарийн олж, шүүн тунгаах нь энэ хоёр шүүхийн ажлын зааг ялгааг зөв тогтоох чухал шалгуур мөн. Өөрөөр хэлбэл дээрхи субъектүүд Үндсэн хуулийг зөрчиж үү?, ердийн хуулийг зөрчиж үү?, тэрхүү зөрчил нь Үндсэн хуулийн төвшинд яригдах асуудал уу? гэдгийг тогтоох нь Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн ч, Үндсэн хуулийн цэцийн гишүүний ч чадвар, туршлага, мэдлэгийг сорьсон шинэ сорилт гарцаагүй мөн гэдгийг онцгойлон анхаарах хэрэгтэй юм.

* * *

БАРИВЧЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ



ХЗҮТ-ийн Криминологийн
судалгааны секторын эрдэм
шинжилгээний ажилтан
Ц.ОДОНЧИМЭГ

Монгол Улсын эрүүгийн эрх зүй нь хэд хэдэн үе шатыг дамжин хөгжиж ирсэн бөгөөд хөгжлийн үе шат бүрт гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг цээрлүүлэх ял шийтгэлийн төрөл өөрчлөгдсөөр байсан юм. Үүний нэг жишээ бол Монгол Улсад 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуульд 7 төрлийн үндсэн болон нэмэгдэл ялыг, тэр дундаа албадан ажил хийлгэх болон баривчлах ялыг шинээр хуульчилж өгсөн явдал юм. Үүнээс өмнө баривчлах гэдэг хуулийн хариуцлагын арга хэмжээ зөвхөн захиргааны эрх зүйн хариуцлагын нэг төрөл байсан бол шинэ эрүүгийн хуулиар "баривчлах"-ыг эрүүгийн үндсэн ялын нэг төрөл болгон хуульчилсан байна.

Ял бол эрүүгийн хариуцлагын нэг төрөл бөгөөд албадах, цээрлүүлэх хэр хэмжээгээрээ эрүүгийн хариуцлагын бусад төрлөөс төдийгүй төрийн албадлагын бүх төрлөөс хамгийн

хүнд нь юм. Ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэхэд оршино.

Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд "энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгахыг баривчлах ял гэх ба уг ялыг нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулна"¹ гэж заажээ.

Баривчлах ял нь хүнийг хүн болон нийгмээс тусгаарлан ганцаарчлан байлгаж, эрх чөлөөг нь хязгаарлах замаар цээрлүүлж, ганцаарчлан хорьж ялтны сэтгэл зүйд нөлөөлөх замаар хүмүүжүүлэх агуулгыг багтаасан ял болох нь хуулийн зохицуулалт, үзэл санаанаас харагдаж байна.

Хууль тогтоогч баривчлах ялын ялтныг нийгмээс богино хугацаанд тусгаарлан хүмүүжүүлдэг, ганцаарчлан хорьдог учир ялтны зан харьцаа бусдаас шалтгаалж эвдрэх явдал бага байдаг, сэтгэл зүйд нь тодорхой нөлөө үзүүлдэг гэх мэт ач холбогдолтой шинжийг харгалзан шинээр хуульчилсан биз.

Баривчлах ял хуульд тусгалаа олсоноос хойш 2 жил гаруй болж байгаа боловч ял эдлүүлэх байрны

стандарт жигд бус, уг ялыг эдлүүлэх нэгдсэн практик тогтоогүй, эрх зүйн зарим зохицуулалт учир дутагдалтай зэрэг шалтгааны улмаас жинхэнэ агуулгаараа хэрэгжихгүй байгаагаас хэр үр нөлөөтэй ял болох нь төдийлөн сайн ажилагдахгүй байна.

Үүнээс гадна хууль, эрх зүйн зохицуулалт зөрүүтэй буюу хуулиуд /Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай/-ын харилцан уялдаатай хэрэгжих ёстой хэм хэмжээнүүд утга, агуулгын хувьд хоорондоо зөрчилдөж байгаа явдал баривчлах ялын үр нөлөөтэй байх чанарт нөлөөлж буй эсэхийг авч үзье.

Монгол Улсын Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хорих ялын дэглэмийг

- Баривчлах;
- Жирийн;
- Чанга;
- Онцгой;
- Гяндан гэж ангилна.

Хорих ял эдлүүлэх дэглэм гэдэг нь ялан этгээдэд шүүхээс оногдуулсан хорих ялыг эдлүүлэх байгууллагад хоригдож буй этгээдийн ажиллах, амьдрах нөхцөл, журмыг хуульчилсан хэм хэмжээний нийлбэр цогц байдаг².

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын Эрүүгийн хуулийн товч тайлбар толь. Г.Совд. 2002 он.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "...баривчлах байранд ялтныг ганцаарчлан байлгаж баривчлах ял эдлүүлэх бөгөөд баривчлах байр нь жирийн дэглэмтэй хорих ангитай адил дэглэмтэй байна"¹ гэж заасан атал Эрүүгийн хуульд "тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгана..."² гэж заасан нь агуулгын хувьд жирийн дэглэмээс өөр дэглэм бүхий байр болохыг илэрхийлж байгаа юм. Иймээс дээрх үндэслэлүүдээс баривчлах байрны дэглэмийг хуулиар тусгайлан зааглаж тодорхойлох шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2002 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн А/158 тоот тушаалаар баталсан "Баривчлах ял эдлүүлэх байрны түр журам"³-ын 6.2-т заасан "түр уулзалтын тоог хязгаарлахгүй бөгөөд үргэлжлэх хугацаа 3 цагаас илүүгүй, удаан хугацааны уулзалтыг 2 сард нэг удаа хийх ба үргэлжлэх хугацаа 24 цагаас илүүгүй байна". 7.1-д заасан "Ялтныг өөрийн байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын ажилд хөдөлмөрлүүлж болно" гэсэн заалтууд нь баривчлах ялын агуулга, зорилгыг алдагдуулж байна гэлтэй. Жишээлбэл, 2003 онд жирийн дэглэмд ял эдэлж байсан Д гэгч эмэгтэй хорих ангид ирсний дараахь 3 сарын дотор ар гэрээсээ 27 удаа түр эргэлт авч 2580 минут буюу 43 цаг уулзалт хийж, мөн

хугацаанд хамтын уулзалтад хоёр ч удаа гараад амжжээ. Ийнхүү уулзсан хугацааг ажлын өдрийн үргэлжлэх цагт шилжүүлэн үзвэл 3 сар буюу 90 хоног ял эдэлсэн тэр эмэгтэй 17 өдөр нь ойрын садан төрлийн хүмүүс, найз нөхөдтэйгөө хоол цай идэж ууж, элдэв зүйл ярилцан ял эдлэх хугацаагаа өнгөрүүлсэн байна⁴. Мөн практикт дээрх журмын 7.1 дүгээр заалтыг үндэслэн баривчлах ял эдэлж буй ялтнуудаар тухайн ялыг эдлүүлж буй байгууллагын барилга, шорооны гэх мэт ажлыг хийлгэж, тэднийг бөөнд нь бие биетэйгээ харилцах боломж нөхцөлийн дор ял эдлүүлж буй тохиолдол ч мэр сэр байдаг ажээ.

Хууль тогтоогч нь баривчлах ялаар шийтгүүлсэн хүнийг хүн ба нийгмээс тусгаарлан ганцаарчлан байлгах шийжгийг харгадсан үзсэний үндсэн дээр уг хугацааг маш богино байхаар хуульчилж өгсөн нь дамжиггүй. Гэтэл энэ богино хугацаанд ялтны түр болон удаан хугацааны уулзалтыг хуульд зааснаар эдлүүлж, байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээ, тохижилтын ажилд хөдөлмөрлүүлэх юм бол ялтны ялыг ганцаарчлан эдлэх хугацаа, ял эдлэх нийт хугацааны харьцаа хэр тэнцвэртэй байх юм бол. Үүнээс үүдээд баривчлах ял нь ялтанд хүмүүжлийн үр нөлөө үзүүлж чадахуйц ял байж чадах болов уу гэх асуудал буюу баривчлах ялын үр нөлөөний асуудалд судлаачийн хувьд эмээглэж буйгаа нуух юун.

Нэгэнт хуульчилсан ялаа үр нөлөөтэй байлгах үүднээс зохих арга хэмжээг авах нь зүйн хэрэг.

Үүний тулд эхний ээлжинд хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай бөгөөд энэ хүрээнд дараахь арга хэмжээг авах нь зүйтэй юм. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн ... дүгээр зүйлд баривчлах байранд ялтныг ганцаарчлан байлгаж баривчлах ял эдлүүлэх бөгөөд баривчлах ялыг жирийн дэглэмд эдлүүлэхээр заасныг Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд "тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгана..." гэж заасантай нийцүүлэн өөрчлөх;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2002 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн А/158 тоот тушаалаар баталсан "Баривчлах ял эдлүүлэх байрны түр журам"-ыг хүчингүй болгон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд баривчлах ял эдлүүлэх дэглэм буюу баривчлах ял эдэлж буй этгээдийн ажиллах, амьдрах нөхцөл, журмыг жирийн дэглэмээс ялган хуульчилсан нэмэлт заалт оруулах шаардлагатай байна.



¹ Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2002 он/-ийн 107.1, 105.2 дугаар зүйл. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын Эрүүгийн хууль /2002 он/-ийн 51 дүгээр зүйл. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль, түүнд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. 2003 он. 349-354 дэх тал.

⁴ Р.Оюунбадам. "Илүү хөнгөлөлт ялтан гэдгээ мартахаа хүргэдэг" өгүүлэл. Хууль зүйн мэдээ сонин. 2004 он. №22(040). 4 дүгээр нүүр.

ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКТ ХИЙХ РЕГРЕССИЙН ШИНЖИЛГЭЭ



ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний
ажилтны туслах
Г.БАТЧИМЭГ

Нийгмийн үзэгдлүүд нь өөр хоорондоо хамааралтай байж харилцан нөлөөлдөг зүй тогтол нь гэмт явдалд ч мөн адил хамааралтай байдаг. Энэхүү хамаарлын зүй тогтлыг илрэх хэлбэрээс нь үндэслэн динамик болон статистик зүй тогтол гэж ангилдаг бөгөөд статистик зүй тогтол нь судлагдаж буй нийгмийн үзэгдлийн системийн тухайн үеийн болон түүнээс хойших бүх байдлыг тогтоохдоо өнгөрсөнд оршсон хувьсах хандлагуудынх нь цаашид хэрэгжих бололцооны объектив хэмжүүр болох магадлалтайгаар тодорхойлон тооцоолж болохуйц тийм шалтгаант холбоогоор илэрдэг. Энэ чанараас нь үзвэл гэмт явдлыг статистик зүй тогтолтой нийгмийн үзэгдэл гэж үзэх боломжтой. Статистик зүй тогтолтой нийгмийн үзэгдэл нь бусад нийгмийн үзэгдэл, үйл явцаас хамаарах төдийгүй өөртөө агуулсан олон тооны элементээс ихээхэн хамааралтай байдаг. Энэхүү статистик зүй тогтол бүхий үзэгдлүүдийн харилцан хамаарлыг статистик шинжилгээний төрөл бүрийн аргуудаар тодруулбал: бүлэглэл, товчоолол, динамик эгнээ, корреляцийн болон регрессийн шинжилгээ хийж судалж болно. Эдгээр аргуудаас бичигч би бээр корреляцийн болон

регрессийн арга дээр тогтож санаа бодлоо хуваалцахыг хүссэн бөгөөд уг аргаар хүчин зүйлийн хамаарлын хэлбэр, нөлөөллийн хүчийг тодорхойлох боломжтой байдаг учраас гэмт явдлын статистик үзүүлэлтийг ашиглан түүний хандлага, хөдөлгөөнийг тодорхойлохыг зорьсон болно¹.

Гэмт хэргийн гаралтын байдалд нийгмийн янз бүрийн хүчин зүйлс нөлөөлж байдаг бөгөөд тодорхой хүчин зүйл нь хүртэл цаг хугацаа, тоо хэмжээ, нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байна. Эдгээр хүчин зүйлийн хамаарлын хүчийг тус бүрт нь тооцоолж, үүнд үндэслэн урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээ боловсруулах явдал нь криминологийн судалгаан дахь корреляцийн шинжилгээний үндсэн зорилт юм. Корреляцийн хамаарал нь шинж чанараараа нэгдмэл хамаарлын үндсэн хэлбэр бөгөөд түүний онцлог нь хүчин зүйлийн хувьсан өөрчлөгдөж буй утга бүхэнд үр дүнгийн шинж тэмдгийн дундаж утга тохирч байдагт оршдог. Өөрөөр хэлбэл энэ нь гэмт хэргийн тоон үзүүлэлтийн өсөлт, бууралттай түүнд нөлөөлсөн нийгмийн үзэгдэл, үйл явцын дундаж утга тохирч байх хамаарлын хэлбэрийг агуулж байдгаараа ач холбогдолтой.

Корреляцийн шинжилгээний аргаар хүчин зүйлийн зүй тогтлыг

илрүүлснээр гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилсан ажиллагаануудыг илүү бодитой, мөн нөлөөлж байгаа объектоо зөв тодорхойлох боломжтой юм. Тэгэхлээр корреляцийн шинжилгээ гэдэг нь хүчин зүйлийн хамаарлын хүчийг тооцоолох арга болж байна. Харин регресс нь уг хамаарлын хүч нь хэр зэрэг нөлөөлж байгааг тодруулдаг арга юм. Корреляцийн шинжилгээний шатанд үр дүнгийн болон хүчин зүйлийн шинж тэмдгүүдийн хоорондын хамаарлын нягтралыг тооцоолох бөгөөд хамаарлын хүчийг хэмжих үзүүлэлтийг R буюу "Корреляцийн коэффициент" гэж нэрлэдэг ба коэффициентийн утга нь "-1"-ээс "+1"-ийн хооронд байна. Корреляцийн коэффициентийн утга "+1"-руу тэмүүлэх тусам хамаарал хүчтэй байна, "-1"-д ойртох тусам хамаарал сул байгааг илтгэдэг.

Гэмт хэргийн статистикт үндэслэн корреляцийн шинжилгээг бид хийснээр ирээдүйд гарах гэмт хэргийн тоог барагцаалах боломжтой. Түүнчлэн энэ аргыг ашиглан өнгөрсөн онуудад ямар төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн өсөлдөд нөлөөлж байсныг ч мөн мэдэх бололцоотой. Монгол улсад 1981-2000 онд бүртгэгдсэн тоон мэдээнд корреляцийн шинжилгээ хийж үзэхэд дараах дүр зураг харагдаж байна. (зураг 1).

¹ Корреляцийн шинжилгээ /correlation- хамаарал гэсэн утгатай англи үг/-ний аргыг шинжлэх ухаанд анх Францын биологич, палентологич Ж.Кюве, 1769-1811/ нээсэн байдаг.

Зураг 1 Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо



Зургаас (1) 1991 оноос 2000 он хүртлэх хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг нийгэм-эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор өмнөх /1981-1989/ онуудад бүртгэгдсэн гэмт хэргээс огцом (2-4 дахин) өссөн байгааг харж болно.

Гэмт хэргийн тоо хэмжээг хугацаанаас хамааруулж авч үзвэл дараах загвараар тодорхойлогдоно:

$$C_t = a + b \cdot T$$

C_t - тухайн t хугацаанд гарсан гэмт хэргийн тоо

a, b - параметр, T - хугацаа

Хүснэгт 1


	Coefficients	Standard Error	t Stat	R ²
Intercept	-2179525.621	213196.0161	-10.2231	0.85
он	1101.784211	107.1063157	10.28683	

$$C_t = -2179525.621 + 1101.78 \cdot T$$

Доорх графикаас гэмт хэргийн өсөлт, бууралтыг 95хувийн магадлалтайгаар таамаглаж болно. Өөрөөр хэлбэл түүвэрт авагдсан онууд болон энэ үед гарсан гэмт хэргийн үзүүлэлтээс дараах таамаглалыг дэвшүүлж болохоор байна. Зургаас (2) гэмт хэргийн өсөх

болон буурах хөдөлгөөн нь 7-8 жилийн давтамжтай байна гэсэн дүгнэлт хийв. Иймээс 2007-2008 онд гарах гэмт хэргийг дээрх давтамжид захируулан тоон үзүүлэлт нь буурах хандлагатай гэж таамаглаж болох юм. (Зураг 2-ыг үз)

Зураг 2 Нийт гэмт хэргийг хугацаанаас хамааруулж авч үзвэл



Харин нийт гэмт хэргийн өсөлтөд тодорхой төрлийн гэмт хэрэг нөлөөлсөн байдлыг судлаж үзэхэд судалгаанд хамрагдсан 20 жилийн хугацаанд хулгайн гэмт хэрэг нийт гэмт хэргийн өсөлтөд гол нөлөөлөл үзүүлсэн нь харагдаж байна (зураг 3).

Зураг 3. Хулгайлах




Зургаас (4) Танхайн гэмт хэрэг нь 1983 он хүртэл буурах хандлагатай байснаа 1984 онд өсөөд, эргээд 1988 он хүртэл буурсан байна. 1988 оноос 1990 он хүртэл өсөөд 1990-1993 он хүртэл ерөнхийдөө тогтвортой байснаа 1993-1994 онуудад өсөөд, 1994-1995 онуудад буураад 1995 оноос хойш 2000 он хойш өссөөр байна.

Эдгээр үзүүлэлтээс Монгол Улсад 1993 оноос хойш гэмт хэргийн өсөлтөд тогтмол өсөх шинжтэй хэмнэл байгаа, түүнчлэн энэхүү хэмнэлийг хулгайлах, дээрэмдэх, танхайрах гэмт хэрэг голчлон тодорхойлж байгаа нь харагдаж байна.

Гэмт хэргийн өсөлтийг тодорхойлоход нөлөөлж болох хүчин зүйлсийг тооцож үзэхгүйгээр хамааруулах явдал ажиглагддаг. Тухайлбал, сүүлийн жилүүдэд автомашины тоо эрс өссөн нь зам тээврийн гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлнэ гэж хууль сахиулах байгууллагын ажилтанууд, судлаачид үзэх хандлага байна

Зам тээврийн гэмт хэргийн гаралт нь автомашины тооноос хамааралтай явагддаг уу? Эсвэл өөр бусад хүчин зүйлээс хамаардаг уу? гэдгийг судлахын тулд статистикийн аргыг ашиглаж үзье.


Зураг 4. Зарим гэмт хэргийн мэдээлэл



Юуны өмнө хоёр хүчин зүйлийн хамаарлын хүчийг харуулдаг корреляцийн коэффициентийг бодож үзвэл дараах байдлаар гарч байна.

Энэ тохиолдолд корреляцийн коэффициент 0,97 буюу "+1" руу

тэмүүлж байгаа тул автомашины тоо нь зам тээврийн гэмт хэргийн гаралттай эерэг хүчтэй хамаарал байгаа харуулж байна. Тэгвэл яг ямар хэлбэрийн хамаарлын зүй тогтол байж болохыг регрессийн шинжилгээний аргаар үргэлжлүүлэн судлавал:



Дүгнэлт:

1. Гэмт хэргийн байдал, хөдөлгөөн, хандлагад дүн шинжилгээ хийхдээ тоон мэдээллийг боловсруулах статистикийн аргуудыг оновчтой ашиглаж, гэмт явдлын өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох боломжтой нь судалгаанаас харагдаж байна. Ялангуяа гэмт хэргийн өсөлтөд нөлөөлж буй зүйлийг олж тогтооход корреляцийн болон регрессийн аргыг ашиглах нь чухал ач холбогдолтой юм. Эдгээр аргуудыг ашигласнаар гэмт

хэргийн шалтгааныг тогтоох анхдагч мэдээллүүд статистик үзүүлэлтээс авах боломжтой болох юм. Улмаар гэмт хэргийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс, зүй тогтлыг зөв тодорхойлж илрүүлснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаануудыг илүү бодитой төлөвлөх боломжтой нь судалгаагаар нотлогдлоо гэж илтгэгч үзэв.

2. Корреляцийн судалгаа нь гэмт хэргийн прогноз хийх боломжийг олгодог. Бидний судалгаанд авагдсан тоон

мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийж үзэхэд 2005 онд ойролцоо 30000 гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай гэж үзлээ.

3. Монгол Улс дахь зам тээврийн гэмт хэргийн шалтгаан нь автомашины тоо мөн боловч энэхүү үзүүлэлтийн нөлөө нь 0.02 буюу маш бага байна. Өөрөөр хэлбэл автомашины тоо 100-гаар нэмэгдэх нь зам тээврийн гэмт хэргийг 2-оор өсгөдөг гэсэн дүгнэлтийг өгч байна. Энэ нь зам тээврийн гэмт хэргийн үндсэн шалтгаан бусад хүчин зүйлсүүдэд байдаг гэсэн үг. Тухайлбал, жолоочийн ур чадвар сул, Замын хөдөлгөөний дүрмийг барьдаггүй байх, замын зохион байгуулалт муу, замын цагдаагийн үр бүтэл муутай оролцоо зэргүүд байж болох юм.

Жич:

Графикуудад тусгагдсан мэдээллийг 1981-2000 онд Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон мэдээнд тулгуурлав.

(Цагдаагийн ерөнхий газрын дүн шинжилгээ мэдээллийн төв 2001 он)

★ ★ ★

ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ НЭР ХҮНД



ЦЕГ-ын Тамгын газрын ажилтан,
дэд хурандаа **З.БАТСҮХ**

1. Нэр хүнд гэж юу вэ ?

Энэ талаар эрдэмтэн мэргэд, ихэс дээдэс, суут хүмүүсийн хэлсэн үг эндөө бий. Гэхдээ тэр бүрийг уншиж дуулж байхад нэгэн санааг л янз янзаар тайлбарлаж олон талаас нь хэлсэн байдаг билээ.

Хүмүүс эрдэмтэй, эрдэмгүй, соёлтой, соёлгүй байлаа ч “нэр хүнд” гэдгийг нэгэн чигт ойлголтод хамааруулан авч үздэг гэж хэлж болно.

Манай Монголчууд дунд эрт цагаас нэр хүндээ өндөрт өргөж, эрхэмлэн нандигнаж явахыг ямагт туйлын чухалд үзэж, үр хүүхэд хойч удмаа энэ талын хүмүүжилд гаршуулан сургаж ирсэн, одоо ч энэ сайхан уламжлал үргэлжлэн дамжсаар байна. Үүний хамгийн ойрын жишээг ардын сургааль үгсээс харж болно.

Тухайлбал: “Хүн нэрээ, тогос өдөө”, “Нэр хугарахаар, яс хугар” гэсэн хоёрхон өгүүлбэрээс харахад монголчууд нэр хүндийг ямар их чухалчилж эрхэмлэж байдаг нь тодорхой юм.

Дуудах нэр дуурсах алдар гэдэг бол хувь хүнтэй шууд

холбоотой боловч гэр бүл, хамт олон, нийгэм хувь хүмүүсээс бүрддэг болохоор нэг хүний нэр төр бүгдтэйгээ нягт холбоотой байдаг. Тиймээс ч Монголчууд “Нэг үхрийн эвэр дэлсвэл мянган үхрийн эвэр доргидог” гэж хэлдэг билээ.

Аливаа хүн анх мэндлэхэд дуудах нэрийг нь эцэг эх нь түүнд хайрладаг бөгөөд харин ямархуу хүн болж нэр хүндтэй явах эсэх нь хувь хүнээс өөрөөс нь л шалтгаална.

Иймээс хүн шиг хүн байж, хүн шиг ажиллаж амьдарч чадваас тэр бол нэр хүнд билээ. Нэр хүнд гэдэг нь нийтлэг ойлголт бөгөөд харин алдар цуутай байна гэдэг хэн хүнд заяадаггүй нилээд өргөн, өндөр түвшингийн ойлголт юм. Суут ухаан, сод авьяас билэг, нөр их хөдөлмөрөөр алдар сууг олж нэрээ улс гүрэн, даян дэлхийд мандуулдаг.

Нэгэнт ийм болохоор хүн бүр алдар цуутай байх боломж хязгаарлагдмал, гагцхүү өөрийн ухаан, хичээл зүтгэлээр нэр хүндээ өргөж нэгэн насаа элээх нь хорвоод хүн болж төрсний үүрэг хариуцлага ч гэж хэлж болно.

Хүн болгон нэр нүүрээ хичээж, айж ичиж явдаг нь ухаант хүмүүсийн нэгэн ариун ёс билээ. Энэ ариун ёс жаягийг цаг ямагт эрхэмлэж явбаас нэр хүнд аяндаа өөрөө ирж, тэр хүний нэрийн өмнө бичигдэж, олны дунд сайн сайхнаар яригдаж, үеийн үед нутаг хошуундаа ч юмуу амьтан ах

дүүс, үр хүүхдүүддээ эсвэл бүр улс үндэстэндээ дурсагдаж байдаг жамтай. Нэр хүнд муутай явбал амьддаа адлагдаж, элдэв муу муухайгаар дуудуулахаас гадна үхсэний хойно түүнийг дурсах хүн ховор байдаг. “Дуудах нэрийг эцэг эх өгч, дуурсах алдрыг өөрөө олдог” гэдэг үгийн утга учир энэ болой.

2. Цагдаагийн албан хаагчийн нэр хүнд

Хүн төрөлхтний нийгмийн үе шат болгонд сайн сайхан үйлсийн зэрэгцээ саар муухай, бузар бусармаг, харш үйл явдал гарсаар ирсэн нь түүхээс тодорхой. Буруу муу үйлийг таслан зогсоох, ул үндсийг мэдэж арилган засах үүргийг тухайн улс нийгмийн эрх баригч нар нэгэн хэсэг хүмүүст үүрэг болгон даатгаж хариуцуулж иржээ. Ийм үүрэг гүйцэтгэдэг хүмүүсийн эрхлэх ажил цаг үед даган өөрчлөгдөж, арга ажиллагаа нь тухайн шаардлагаар зохицуулагдаж байсан бөгөөд төрт ёс үүссэн цагаас төрийн зүгээс тогтоосон хууль цаазыг амьдралд ёсоор болгох үүрэгтэй “Төрийн төмөр нударга” болж ирсэн байна.

Монгол улсын хувьд түүхэн үеүүдэд ийм үүрэгтэй алба ажилтан байсаар, үүргээ гүйцэтгэсээр ирсэн түүхтэй бөгөөд түүхийн баримт сэлтээс үзвэл богд хаант Монгол улсын үед “Арван тавны цагдаа” бий болж, энэ үүргийг 1921 онд ялсан ардын хувьсгалын үед “Сэргийлэх цагдаа” нэртэйгээр залгамжлан авсанаар манай өнөөгийн

цагдаагийн шинэ үеийн түүх эхэлсэн гэдэг. Төрийн цагдаа байна гэдэг нэр хүндтэй бөгөөд нэн хариуцлагатай үүрэг юм. Буруу үйл бүхэнтэй тэмцэж, ард түмнийхээ амар амгаланг сахиулна гэдэг тун чухал ажил тул ийм үүрэг гүйцэтгэдэг хүмүүс байх учиртай. Монголын цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсан цагаасаа өөрийн эгнээгээ эрдэм боловсрол эр чадалтай, үнэнч шударга ариун цагаан мөртэй хүмүүсээр бэхжүүлэхийг нэг гол зорилгоо болгож ирсэн. Үүний үрээр ч цагдаагийн байгууллагын салбарт алба хаагчдийн нэр хүнд ард түмнийхээ дунд жилээс жилд өсч, ажил үйлс нь өөдлөн дэвжсээр ирсэн, одоо ч энэ уламжлал хэвээр байна.

Цагдаагийн ажилтан нэр хүндтэй байх нь өөрийн ажил үйлс бүтэмжтэй байхын нэгэн эх сурвалж бөгөөд ингэснээр байгууллага, хамт олон, улмаар Монголын цагдаагийн байгууллагын нэр хүндийг өргөнө гэсэн үг.

Цагдаагийн ажилтан, алба хаагчид нэр хүндтэй байх үндэслэлүүдийг олон зүйлээр тайлбарлаж болох боловч гол хэдэн зүйлийг энд дурдъя.

1. Цагдаагийн албан хаагчийн хийх ажил, хэлэх үг, өмсөх хувцас, харьцах харьцаа зэрэг бүхий л үйл ажиллагаа нь дүрэм журмаар зохицуулагдсан байдаг тул алхам тутамдаа хуулийн заалтыг хатуу чанд баримталж, ажил үүргээ хуулийн хүрээнд явуулж байх.
2. Үнэнч шударгыг цаг ямагт туйлаас эрхэмлэж, гуйвж дайвахгүй, цэгц шулуун, төв түвшин ноён нуруутай байх.

Энэ талаар шинэ цагийн цагдаагийн байгууллагыг санаачлан байгуулсан жанжин Сүхбаатар 1921 онд цэрэг, цагдаа нарт хандаж хэлсэн сургаал үг өнөөдөр ч санамж сургаалтай тул энд зориуд оруулж бичив.

Тэрээр хэлэхдээ: "Олон түшмэд, цагдаа цэргүүд өөрийн албан хэргээр нийслэлийн хороо зээлийн газар явах ба хөдөө газар албан зарлагаар гарваас тус тус номхон шударгаар төв ёсыг сахиж, зөвхөн ажил үүргээ гүйцэтгэхийг туйл болговоос зохино. Харин дэмий нэр, зэвсэг дор эрдэж, омгорхон бардамнаж, ойворгон загнаж хяхан сүрдүүлж явах зэрэг муу гэмийг бүрнээ гээгтүн" гэж сургамжилжээ.

3. Даруу төлөв байж, үг хэл, үйл явдалдаа анхаарал болгоомжтой, өөртөө хянамгай хандаж, дүрмт хувцсаа цэвэр нямбай заавар журмын дагуу хэрэглэж байх нь өөрийн чинь нэр хүндийг өргөнө гэдгийг санаж явах.

Хайш яаш хувцасласан, хамаа намаагүй үг яриатай, анхаарал болгоомжгүй салан задгайдуу хунийг хүмүүс өнгөн дээрээ албан тушаал, цол формьг нь бодон аятайхан харьцах боловч цаагуураа үл тоомсорлож, тэгснээрээ таны нэр хүндэд сөв сууж байдгийг мартаж болохгүй.

4. Та бусдыг хүндэтгэж байж л өөрийгөө хүндлүүлж нэр төртэй байна. Хэдийгээр хууль зөрчсөн гэмт хэрэгтэн, танхай этгээд байлаа ч хунийг нь хувьд хүндэтгэж хүнлэг энэрэнгүй, тусч сэтгэлээр хандаж байвал

таны ажил үйлс бүтэж, нэр хүнд дээшилнэ.

5. Өөрөө хууль бус буруу муу үйлдлээс ангид байж, дутагдал доголдол гаргахгүй байх нь чухал. Дутагдал гаргасан хүн бие амар, нүүр бардам байж чаддаггүй учир ажил үйлс нь муудаж, тойруу замаар нэр хүндээ муутгах аюултай гэдгийг мартахгүй байх.
6. Өөрийн ажил үйлс, зан чанартаа шүүмжлэлтэй хандаж, сул тал, муу дадал зуршлаа гээх, бусдын сайн сайхан, өөдрөг зан байдал, ажилсаг хичээнгүй идэвхтэй дайчин чанарааас өөртөө шингээж авахыг хичээн зүтгэж байвал өөрт үл мэдэгдэм атлаа бусдад анзаарагдам сайн чанар хэвшин тогтож нэр хүндэд чинь алхам алхамаар сайн нөлөө үзүүлнэ.

Өөрийн сул тал, дутагдлаа анзаардаггүй, ойлгодоггүй, энэ талаар эргэцүүлэн боддоггүй хүн бусдын сайн талыг олж хардаггүй, ойлгож үздэггүй явдал ч бас байдаг. Энэ бол нэр хүндэд халгаатай гэдгийг санаж явах.

7. Хуудуутгүй үнэн үг яриатай, хэлсэн үгэндээ эзэн байх явдал туйлаас чухал. Яарч сандрах, уурлах уцаарлах юм таарсан ч бие сэтгэлээрээ тэвчээртэй байж, намуун аядуу эвлэлгэн ярьдаг байвал та бусдад аятайхан сэтгэгдэл төрүүлнэ. Үнэн үгийг ийнхүү өгүүлж бусдын үгийг тэвчээртэй сонсож, санал сэтгэгдэл хүсэл бодлыг нь ойлгож харьцвал таны нэр хүнд өндөр байхад нөлөөлнө.

8. Эрхэлсэн ажилдаа бүрэн дүүрэн эзэн байж үүрэг гүйцэтгэхдээ хуулийн мэдлэгтэй, дадлага чадвартай, авхаалж самбаатай, эгзэгтэй үе тохиолдолд ч тэдгэж мунгиналгүй зөв шийдвэр гаргаж чаддаг болохыг ажилтан бүр санан мэрийж, ийм түвшинд хүрч чадвал ажил үйлс тань ямагт өөдрөг бүтэмжтэй нэр хүнд чинь өндөр байх болно.

Цагдаагийн ажил гэдэг байнга тасралтгүй явагдаж, олон түмний нүдэн дээр ил цагаан хийгдэж, өдөр тутам янз бүрийн ажил мэргэжил, ааш араншинтай хүмүүстэй уулзаж учирч байдаг учир иргэдийн нүдний өмнө тэдний хараа хяналт дор байнга байдаг гэсэн үг. Ийм болохоор буруу ажиллах, хазгай гишгэхийг тэд андахгүй. Учир иймийн тул цагдаагийн аль ч шатны алба хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ хууль журмаа баримтлан хийвэл зохих ажил үүргийг цаг хугацаанд нь дайчин шуурхай чадварлаг гүйцэтгэж байх нь цагдаагийн нэр хүндэд туйлын их нөлөөтэй.

9. Өнөө үед цагдаагийн алба хаагчдын ажил үйлс нэр хүндэд туйлын муугаар нөлөөлж байгаа зүйл бол архидан согтуурах явдал байна гэдгийг хүн бүхэн мэддэг, ярьдаг, арга хэмжээ, зэмлэл шийтгэл оногдуулдаг боловч төдөрхөй үр дүн харагдахгүй байна. Архины улмаас зарим ажилтан гэмт хэрэгт орох, хууль ёс зөрчих, хариуцлага алдах, улмаар зальтай муу хүмүүст ашиглуулж өөрийнхөө ажил амьдралыг баллаад зогсохгүй байгууллага, хамт

олон цагдаагийн нэр сүрийг муутгаж, ард олны дунд алдар хүндийг нь унагаж байна.

10. Замбараагүй, дэг журамгүй байдал газар авсан зах зээлийн өнөө үед цагдаагийн ажилтны үүрэг хариуцлага нэмэгдэхийн хэрээр тэдний хэр зэрэг үнэнч шударга, хууль ёсоор ажилладгийг шалгах шалгуур өндөрсөж байна. Овсгоо самбаатай, овжин зальхай, эгтгээдүүд хүсэл зориггоо биелүүлэхэд нь "саад" болж, хууль бус үйл явдлыг нь илрүүлж, хянаж шалгадаг цагдаагийн ажилтнуудыг өөртөө татах гэж элдвээр оролдох явдал алхам тутамд гарах болов. Бэлэг шаң, архи тамхинаас авахуулаад мөнгө валют, эд зүйлээр хахуульдахыг оролдох, хууль бус ажиллагаа явуулахад түлхэж турхирах, танил тал, ах дүүс найз нөхдөөр нь ятгуулах, шууд ба шууд бусаар дарамт шахалт үзүүлэх явдал үзэгдсээр байна Энэ мэт бусармаг нөлөөнд их багаар автаж, бусдаас мөнгө төгрөг авсан, архидан согтуурсан, ажлын хариуцлага алдсан, хууль ёс зөрчсөн, тэр байтугай эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдол цагдаагийн ажилтнууд дотор мэр сэр гарч, олон сайхан залуу чадварлаг ажилтан цагдаагийн эгнээнээс зайлуулалдаж байна. Энэ бол цагдаагийн нэр хүндэд харшилсан ноцтой хэрэг юм. Залуу ажилтнууд энэ бүхнээс сургамж авч ажил үүрэг гүйцэтгэхдээ бусдын

нөлөөнд автахгүй, гагцхүү хууль дүрмээ чанд баримтлан ажиллах нь чухал байна.

3. Төгсгөл

"Нэгэнт олсон нэр хүндийг алдахад ганцхан буруу алхам л хангалттай гэдгийг санаж явах нь чухал" гэж нэгэн суут ухаантан хойч үедээ сургамжлан захисан байдаг. Үүнээс үзвэл нэр хүнд гэдэг маш нарийн эмзэг зүйл бөгөөд цэвэр ариун авч явбал эзэндээ алдар хүнд, аз жаргал, баяр баясгалан авчирч байдаг бөгөөд өчүүхэн төдий хайнга салан хандваас дорхноо сэвтэж арилдаг ажээ. Үүнтэй холбогдуулж манай Монголчууд "Сайн нэрийг хүсэвч үл олдоно. Муу нэрийг хусавч үл арилгана" гэсэн гүн утгатай үгээр залгамж үеийнхнийг сурган хүмүүжүүлж ирсэн ухаалаг сайхан уламжлалтай ард түмэн юм.

Цагдаагийн алба хаагчийн нэр хүнд гэдэг бол Монголын цагдаагийн байгууллагын нэр хүнд бөгөөд цаашилбал төр засаг, улсын маань нэр нүүр гэдгийг бид мартаx ёсгүй.



ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Удирдлагын академийн ахлах багш Х. ОЮУНЦЭЦЭГ

Өнөөгийн байдлаар газрын харилцааг зохицуулж буй дараах гол хуулиуд үйлчилж байна:

Иргэний хууль, 2002 он

Газрын тухай хууль, 2002 он

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, 2002 он

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, 2003 он

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, 1999 он

Социализмыг бүтээн байгуулж байх үед эрдэм шинжилгээний ажил, өгүүллийг Авторын буудлагаас эхлэн өгүүлдэг байсантай адил орчин цагийн эрх зүйн асуудлыг судлахдаа шинэ Үндсэн хуулийг баталсан цаг мөчийг дурьддаг заншлийг би ч эвдэлгүй газрын шинэчлэлийн асуудлыг уг цаг мөчөөс эхлэн ярих болсон билээ.

Монгол улсын иргэнд газар өмчлөх эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсантай холбогдуулан газрыг эдийн засгийн гүйлгээний чухал бүрэлдэхүүн болгох төрийн бодлогын эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил

сүүлийн жилүүдэд эрчимжиж байна. Энэ талаар эрх зүй судлаачид ч газрыг байгалийн баялаг гэдэг уламжлалт ойлголт талаас нь бус өмчлөлийн объект болохынх нь хувьд судлах хандлага давамгайлж байна.

Дээр дурьдсан хуулиудын зохицуулалтыг өөр хооронд нь харьцуулж, уялдуулж авч үзэхэд газрын харилцаа болон эд юмсын /манай Иргэний хуульд томъёолсноор “Эдийн баялгийн эрх”/ эрх зүйн үндсэн хэсэг болсон үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт нь манай улсын нийгэм - эдийн засаг түүхэн уламжлал дээр суурилан шат дараалсан зохицуулалт хийсэн нь харагдаж байгаа ба цаашид газрын харилцааны зохицуулалтыг Иргэний хуулийн суурь зарчмуудтай нийцүүлэн шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна.

“Газар өнөөг хүртэл түүхийн бүх үед улсын мэдэлд байж эдийн засгийн утгаар бүрэн эргэлтэнд орж, чухал нөөц хэрэгсэл гэж ойлгогдож байгаагүйг тэмдэглэх хэрэгтэй. Энэ утгаараа саяхан болтол газар дээрх барилга байшин үл хөдлөх эд хөрөнгө гэж ойлгогдож, газар өөрөө энэ утгын агуулгагүй явж ирсэн” гэсэнтэй санал нэг байна.

Энэ өгүүллийн сэдвийг ч

мөн газрын эрх зүйн гэх бус үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалатыг боловсронгуй болгох нь гэж томъёолсон бол илүү оновчтой байсан болов уу? Их, бага хувьчлалаар эдийн засгийн объектуудыг болон газар, орон сууцаа ч үнэ төлбөргүй хувьчилж авах аз завшаан тэр болгон хуучин социалист гэгдэх зүүн европын орнуудын ард түмэнд оногдоогүй юм.

Орон сууцыг болон газрын иргэдэд өөр өөр цаг хугацаанд хувьчилсаны улмаас 2002 оноос хэрэгжиж буй Иргэний хуулийн эдийн баялгийг өмчлөх эрхийн болон газрыг харилцааны зохицуулалт хооронд нэр томъёоны зөрөлдөөн байхаас гадна зарчмын хувьд өөр хоорондоо зөрчилтэй зүйл анги байгаа ба Иргэний хуулинд орсон шинэ институтыг Газрын тухай хууль болон ЭХӨЭТҮБХ-д нарийвчлан зохицуулахыг амьдрал шаардаж байна. Түүнчлэн хот суурингийн газрын харилцаа нь Хот барилга байгуулалт, хот төлөвлөлт, нийтийн эрүүл ахуйн харилцаатай нягт холбоотой тул эдгээр асуудлыг ч мөн шинэчлэн зохицуулах шаардлагатай.

Ер нь газар олгох, барилгын зөвшөөрөл олгох асуудалд мэргэжлийн хяналт тавих үүрэгтэй аймаг нийслэлийн улсын мэргэжлийн хяналтын газрын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилох нь чонноор хонь

¹ Ш. Батсүх, Монгол улс дахь газрын эрх зүйн тулгамдсан асуудал, МУ дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил, УБ хот, 2004, 121 дэх тал

мануулахтай адил юм.

Өөрөөр хэлбэл Засаг даргын зүгээс газрын хууль тогтоомжийг зөв хэрэгжүүлж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавих үүрэгтэй байгууллагын дарга нь Засаг даргаасаа томилогдох, түүнээс хараат байгаа өнөөгийн практикийг үтэр түргэн халах хэрэгтэй байна. Газар олгох талаар Нийслэлийн хэмжээнд гарч буй маргааныг судлахад төрийн байгууллагын чиг үүрэг, эрх мэдлийн оновчтой хуваарилалт чухал байгааг харуулж байна.

"Ихэнх эрдэмтдийн үзэж байгаагаар хууль дээдлэх ёс нь төр болон засгийн эрх бүхий элитийн эрх мэдлийг хуулиар үндэслэлтэй, оновчтой хязгаарласан нийгэмд хэрэгждэг. Өмчийн эрх бодитойгоор хэрэгждэг, өрсөлдөөний шудрага дүрэм үйлчилдэг нөхцөлд бизнес эрхлэгчид хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж, өмчийг нийгэмчлэх төрийн эрх мэдлийг хязгаарладаг.

Өмчийн эрх болон бизнесийн орчны бусад бодлогуудад байнга өөрчлөлт орж, шийдвэрийг нууцаар гаргаж буй тохиолдолд бизнесийн ур чадвартай нь бус харин эрх баригчтай холбоотой нь давуу эрх эдлэдэг. Иймээс өмчийн эрхийг хэрэгжүүлэх институтын чадавхгүй байдал нь хөгжиж буй орнуудыг даяаршлын олгож байгаа өсөлтийн боломжийг эдлэж чадахгүйд хүргэдэг" гэж ноён Донгсун Сим /БНСУ/ эрдэмтэн онцлон тэмдэглэсэнийг ч бид ухаарах хэрэгтэй.² Фернандо Де Сотогийн "Капиталын нууц"

номны гол утга санаа ч мөн үүнд чиглэсэн байна.

Газрын кадастрыг шинэчлэх төслийн хүрээнд хийсэн судалгааны талаарх санал бодлоо Та бүгдтэй хуваалцахад таатай байна.

Газрын харилцааны шинэт-гэлийн асуудал нь бидний төсөөлснөөс их өргөн хүрээтэй асуудал юм. Юуны өмнө газар, хот байгуулалт, газрын кадастрын асуудал нь Засгийн газрын бие даасан тусдаа байгууллагуудад харьяалагдаж байсан ба тэдгээр байгууллагуудын явцуу эрх ашигт нийцсэн хууль тогтоомжтоор зохицуулагдаж байсныг халах зорилгоор одоогийн ГХГЗЗ Агентлаг байгуулагдан нэгдмэл бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг бид мэднэ. Энэ ч утгаараа Засгийн газар болон тус агентлагаас 40 гаруй эрхийн акт батлагдан гарсан байна. Гэсэн хэдий ч хууль хоорондын хийдэл, зөрчлөөс гадна газрын бүртгэл, менежментын нэгдсэн бодлого байхгүй байна.

Газрын кадастрын үйл ажиллагааны тулгамдсан асуудлын нэг бол хот руу чиглэсэн их нүүдлийн илрэл болох зөвшөөрөлгүй газар эзэмших явдал юм. Үүнээс гадна, нэг талаасаа амьдрал ахуйн эрхшээлд өндөр хүчдлийн шугамын зурвас, үерийн далан дээр айл буух явдал ихэссээр байгаа ба нөгөө талаас хүч түрэмгийлэн усан сан, ойн зурвас газар зуслан нэртэй орд харш барих явдал газар авч байгааг хэрхэн

зохицуулах талаар бодох хэрэгтэй байна.

Түүнчлэн зөвшөөрөлгүй газар эзэмших /гол нь Аж ахуйн нэгж байгууллагын зүгээс гардаг нийтлэг асуудал/ явдлын шалтгаан нь нэг талаас дээр заасан агентлагын хүчин чадал, газар хувьчлал ид өрнөж буйгаас үүсч буй хүндрэлүүд байхад нөгөө талаас орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллагын хүнд суртал, авилгалын дарамт асуудал байна. Бидний хийсэн тооцоогоор газрын зөвшөөрөл авч, барилга барихад /барилга барих зөвшөөрөл авах нь барих хугацаанаас 3 дахин урт байгаа тухай баримт байна /давхардсан тоогоор 60 гаруй албан тушаалтны гарын үсэг шаардлагтай байдаг тул зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн амнистийн асуудлыг хэлэлцэх хэрэгтэй мэт санагдаж байна. Өөрөөр хэлбэл өнөөгийн хэмжээнд иргэд байгууллагын зүгээс хөрөнгө оруулалт хийж баригдсан, холбооны, дулааны болон бусад шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн хувьд зөрчилгүй баригдсан барилгад газрын төлбөрөө хийх болзолтойгоор хялбаршуулсан журмаар газрын зөвшөрөл болон ҮХЭХБүртгэлийн гэрчилгээг олгож болох юм.

Ингэснээр тэдгээр этгээд ч өөрийн хөрөнгийг баталгаажуулах, түүнийгээ зээлийн барьцаанд тавьж цаашид хөдлөх зэргээр алдагдсан боломжоо нөхөж болно. Энэ ч зарчмыг удирдлага болгон хувь хүмүүсийн барьсан ойн болон гол усны зурваст нэгэнт баригдсан зуслангийн зориулалтай барилга байгууламжийг /түр зөвшөөрөлтэй/

² Донгсун Сим /БНСУ/. Даяаршлын нөхцөл дэх эдийн засгийн хөгжил ба хууль ёс. Монгол улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил. УБ хот, 2004, 43 дахь тал

галын аюулгүй байдлын болон байгаль орчны нөлөөлөл талаас нь тодорхой болзол тавьж, газрыг харьцангуй өндөр татвартайгаар хувьчлах нь зөв мэт.

Ингэснээр төрийн өмчлөлийн газрыг худалдах нууц арилжааг /газар эзэмшлийн эрхийг шилжүүлэх нэрээр хийдэг буй худалдаа/ төрд ашигтайгаар илрүүлэх, зохицуулах нь зүйтэй болуу. Учир нь илт хууль зөрчиж л бариагүй хашаа байшин, “зуслангийн” харшуудыг албадан буулгах, нүүлгэхэд олгоход төрөөс олгох нөхөн олговрын эх үүсвэрийг хаанаас олох нь өнөөг хүртэл ойлгомжгүй байгаа тул уг асуудлыг эцэслэн шийдвэрлэж чадахгүй байгаа билээ.

Газрын кадастрын /үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэл гэдэг утгаар нь/ өөр нэгэн чухал асуудал бол Газрын үндэсний нэгдсэн сан бий болгох явдал юм. Газрын кадастрын тодорхойлолтыг холбогдох хуулиас авч үзвэл энэ нь газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, газрын улсын бүртгэлээс бүрдэнэ гэж заасан байдаг /Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 9-р зүйл/. Мөн зүйлд газрын улсын бүртгэл нь газрын кадастрын зураглал, газар ашиглах, эзэмших эрхийн бүртгэл гэж заасан. Өөрөөр хэлбэл газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээг авах үйл ажиллагаа нь барилга байшин зэрэг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээс тусдаа явагдаж байна. Энэ утгаараа иргэн хүн хашаа байшингаа өмчлөх эрхээ баталгаажуулахын төлөө Газрын алба болон ЭХӨТХЭХБЭ-ийн улсын бүртгэлийн албанд давхардсан

процессыг туулж ҮХЭХ татвар болон газрын татвар, төлбөрийг мөн давхардуулан төлж байна. ААНБ-ын хувьд ч ялгаагүй Газрын албанаас газар эзэмших эрхийн гэрчилгээ аваад түүн дээр баригдсан барилгадаа үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг мөн аргаар давхардсан татвар, төлбөр төлж авч байна.

Газрын кадастрын тухай ойлголт нь манай улсын хувьд зах зээл хөгжсөн улс орнуудын хууль тогтоомжтой харьцуулбал илүү өргөн хүрээтэй байна. Нэгж талбар дээр үндэслэгдсэн газрын кадастр нь өмчлөгчийн эрхийн баталгааг хийж, нэгэн гол ҮХЭХ-ийн өмчлөх эрхийн хөдөлгөөнийг бүртгэх зорилготой байдаг. Харин манай улсын хувьд газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийг оруулж байгаа нь хэт нүсэр, төрд ашиг орлого өгөх бус мэдээллийг агуулдаг. Өөрөөр хэлбэл газрын тухай тоо бүртгэл /аль аймгийн хэдийн хэмжээний газар нь цөлжсөн, бэлчээр нь устсан г.м газрын нэгдмэл сангийн бүртгэлийн тухай мэдээллийг иргэн, ААНБ, банк, татварын байгууллага тэр болгон ашиглахгүй, зөвхөн төрийн болон судалгаа шинжилгээний байгууллага л уг мэдээллийн хэрэглэгч байна. Эдгээр мэдээлэл нь эдийн засгийн хувьд төсөвт нөхөн төлөгдөхгүй зардал л болно. Иймд дээр заасан 2 хуулийг нэгтгэх эсхүл шинэчлэх шаардлага үүдэн гарч байна.

Дээр заасан нөхцөл байдал нь юунаас үүдэлтэй вэ? Хууль зүйн талаас нь тайлбарлахыг хичээе.

1. Дээр хэлсэнчлэн газрын хуулийг Иргэний хуулийн өмчийн /туйлын/ эрхийн

зарчимд нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй байна. Газар эзэмших, ашиглах тухай Газрын тухай хуулийн тодорхойлолт нь үеэ өнгөрөөсөн гэдэгтэй хэн ч маргахгүй байх.

2. Газар эзэмших, өмчлөх эрхийн цар хүрээ /60 жилийн эзэмших эрхээ 40 жилээр сунгуулах, өвлүүлэх, барьцаалах, бусад шилжүүлэх??? г.м/ нэн хязгаарлагдмал байна. Мэдээж хэрэг өөрийн нэр дээр л бүртгүүлэхээс бусад захиран зарцуулах эрхийг эзэмшлийн эрх хамарч байна. Гэтэл энэхүү эрхэд хязгаарлалт байгаа. Тухайлбал, газрыг эзэмших эрхээ гагцхүү монгол газар нутаг дээрх банк, монгол ААНБ, иргэдийн хооронд л барьцаална гэсэн байдаг. /Газрын тухай хуулийн 38.1-р зүйл/

3. Газар өмчлөх эрхийн талаар дахин харах үзэх чухал асуудлууд байна:

Газар өмчлөх гагцхүү монгол хүний онцгой эрхийг бид баталгаажуулсан мэт хөөрдөг.

Гэтэл Иргэний хуулийн 150 дугаар зүйлд заасан бусдын газар дээр барилга байгууламж барих 99 жилийн эрхийг хэн ч өөрөөр хэлбэл гадаадын иргэн, компани ч эдлэх эрхтэй. Энэхүү эрх эзэмшигч нь түүнийгээ гадаадын банкинд ч өвлүүлэх, барьцаалах гээд бүрэн захиран зарцуулах эрхтэй байна. Гэтэл ашигт малтмалыг олборлох, ашиглах лицензийг гадаадынх нь ямар ч хязгаарлалтгүй өмчлөх эрхтэй л байна. Өөрөөр хэлбэл газар өмчлөгч монгол иргэний эрх нь уг эрхээс хяз-

гаарлагдмал хүрээнд үйлчилж байна. Мэдээж хэрэг би аливаа улс гүрэн газрыг өмчлөх харилцааг тусгаар тогтнол, үндсэний аюулгүй байдалтай уялдуулан өөр зохицуулалт хийдэг жам ёсыг үгүйсгэж байгаа юм биш.

Газрын өмчлөх эрхийг хуулийн этгээд бус зөвхөн иргэн эдлэхээр заасан байна.

Үүний гол санаа нь Үндсэн хуулинд тусгагдсан ба зөвхөн иргэн хүнд л өмчлүүлнэ гэж тайлбарладаг. Гэтэл нөгөө л Үндсэн хуулинд иргэн эд баялгийг өмчлөх эрхийг л баталгаажуулсан болохоос биш эрхээ хэрэгжүүлэх хэлбэрийг заагаагүй байдаг. Монгол улсын иргэд газраа өмчлөөд түүнийгээ компанид /гадаад хөрөнгө оруулалтгүй компанид ч хамаагүй/ хувь нийлүүлэх хөрөнгө болгон оруулж болохгүй байгааг ойлгоход хүнд байхна. Өнөөгийн байдлаар монгол иргэд ГХХО-д ашигт малтмал ашиглах лицензээ хувь нийлүүлсэн хөрөнгө болгон оруулж л байгаа шүү дээ. Иймд яагаад бид эрсдэлтэй бизнес эрхлэхдээ хариуцлагаа хязгаарлах үүднээс өмчилсөн газраараа хувь нийлүүлж болохгүй байгаа юм бэ. Хуулийн этгээдэд, нэн ялангуяа банк, даатгалын байгууллагад газар өмчлөх эрхийг олгосноор авах нэг давуу тал бол дампуурсан тохиолдолд нэхэмжлэгчид уг этгээдийн газрыг эзэмших, өмчлөх эрхийг өр төлбөртөө суутган авч болно. Гэтэл өнөөгийн байдлаар төр газраа буцааж авна гээд хуульчлан байна. Яах вэ? Энэ шударга ёсонд нийцэж байна уу?

Дээр заасан барилга барих

эрх, узуфрукт, сервитутийн шинэ эрхийн асуудлыг Газрын тухай хуулинд буй өнөөгийн холилдсон зохицуулалтыг шинэчлэх, эрхээ хэрэгжүүлэх механизмыг бий болгох замаар бүртгэлийн болон газрын хуулинд өөрчлөлт оруулах цаг болжээ.

Газар дээрх объект өмчлөгчийнх болно гэсэн заалт өнөөг хүртэл үйлчилж байна.

Түүнчлэн дундын орон сууцны байрны доорх газар нь нийтийн буюу нийслэл, аймгийн/сум/ хөрөнгө байгаа өнөөгийн зохицуулалт хотын Засаг даргын үзэгний үзүүрээр олон хүний амьдрал ахуйг шийдэх өргөн эрх мэдлийг олгож байгаагаас /цэцэрлэгийн талбайд байшин барих эрх олгож байна. Жишээ нь Сансар хорооллын түннел дээр 8 хүнд барилга барих газар олгосон/ гадна цаашид маш том асуудлыг бий болгоно. 50-60 онд баригдсан барилгууд удахгүй нурж унах гамшгийг өөртөө агуулах магадлал ихсэнэ.

Ингээд хотын төвийн нурсан орон сууцны өмчлөгчид газраа өмчлөгч биш тул хаашаа очих вэ? Түргэний гол, Эмээлтийн хөндий руу юу? Зардлыг төр хариуцах уу? Хот уг газрыг өөр этгээдэд эзэмшүүлэх эрхтэй юу?

Ул хөдлөх эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөгчдийн асуудал:

Өнөөгийн байдлаар дундаа хэсгээр өмчилж байгаа барилгыг анх барилга бариулсан этгээд эзэмшиж буюу өмчилж байна. Шинэ өмчлөгчид уг газрыг дундаа хэсгээр өмчлөх эрхийг нарийвчлан зааж өгөх шаардлагатай байна.

Байршлын онцлогоос харгалзан ялгавартай татварын тогтолцоог бий болгох хэрэгтэй.

Хэдий хүртэл Гачуурт тосгоны харш өмчлөгч Хайлаастын гэр хорооллын оршин суугч газрын адил хэмжээтэй төлбөр төлөх вэ?

Газрын төлбөрийг газрын алба, үл хөдлөх эд хөрөнгийн татварыг татварын алба тус тусдаа авч буй өнөөгийн тогтолцоо шаардлага хангах-гүй байна.

Иймд татварын албанд энэхүү төлбөрийг авах эрх мэдлийг шилжүүлэх нь илүү зохимжтой юм. Үл хөдлөх эд хөрөнгийн үнийг гэрчилгээнд тусгахаа больсон тул татварыг хэн хэдий хэмжээтэй төлж байгаа нь зөвхөн татварын байцагчийг та таньдаг эсэхээс л хамаарч байгаа мэт санагдаж байна. Өөрөөр хэлбэл үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний шинэ тогтолцоо, бүтэц хэрэгтэй байгааг харуулж байна.

* * *

СЕРВИТУТ, ТҮҮНИЙ ХӨГЖИЛ



МУИС-ийн Хууль Зүйн
сургуулийн магистрант
Б.ЭНХМАА

1992 онд баталсан Монгол Улсын дөрөвдөх Үндсэн хуулийн үзэл баримтлалын нэг чиглэл нь иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулах язгуур үндэс нь хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авч эзэмших, өмчлөх эрхтэй, төр түүнийг хүлээн зөвшөөрч хамгаалах үүрэгтэй болохыг хуульчлан баталгаажуулсан явдал болно.

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу 2002 онд “Монгол Улсын Иргэний хууль”, “Орон сууц хувьчлах болон дундын өмчлөлийн орон сууцны тухай хууль”, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” зэрэг хуулиудад батлагдаж, иргэд хувьдаа өмчтэй болох, түүнийгээ хуулиар хориглоогүй арга хэлбэрээр өөрөө мэдэж ашиглах, захиран зарцуулах эрхтэй болсон нь зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, нийгэм эрх зүйн таатай нөхцөл бүрдсэнтэй холбоотой юм.

Иргэд өөрөө өмчөө бие даан чөлөөтэй өмчилж, захиран зарцуулах олон тал, чиглэлтэй болсны нэг баталгаа нь “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн

эрхийг хязгаарлах эрх” /сервитут/, “Бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмшиж ашиглах эрх” /узуфрукт/ гэсэн шинэлэг нэр томъёо, ойлголтууд бий болсон.

Сервитут гэдэг нь засаглах, үүрэг болгох, боолчлох гэсэн утгыг илэрхийлсэн латин үг бөгөөд анх эрх зүйн хөгжлийн дараах үе буюу Юстинианы үед гүйцэтгэлийг хангах арга хэмээн үзэж хуульчилсан байна. 1804 онд Напелионы хууль гэж алдаршсан Францын Иргэний хууль, 1896 оны Германы Иргэний хууль болон Европын ихэнх улсын хуульд бүлэг заалт болж байсан, 2002 онд Монгол Улсын Иргэний хуулийн 150, 151, 152 дугаар зүйлүүдэд шинээр тусгаж өгсөн.

Эдийн баялгийн хязгаарлагдмал эрх гэдэг бол өмчлөх эрхээс үүдэлтэй, түүнд үндэслэгдсэн, өмчлөлийн зүйлийн талаар өмчлөгч бус этгээдийн эдлэх эрх юм. Энэхүү эрхийн сонгодог жишээ болгож сервитут буюу үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг нэрлэж болно. Эд баялгийн хязгаарлагдмал эрхээр олгогдож байгаа боломж нь агуулгын хувьд үргэлж хязгаарлагдмал байх ба өмчлөгчийн бүрэн эрхээс үргэлж явцуу байдаг.

Өмчлөгч этгээдийн эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийн объект болж байгаа өмчлөлийн зүйл, эд юмсыг бусдад шилжүүлсэн тохиолдолд, өөрөөр хэлбэл өмчлөгч этгээд өөрчлөгдөж байхад ч уг эд юмсын талаарх өмчлөгч бус этгээдүүдийн эдийн баялгийн хязгаарлагдмал эрх нь хэвээр хадгалагдаж, үргэлжилсээр

байдаг нь уг эрхийн нэгэн онцлог юм.

Тодруулбал эдийн баялгийн хязгаарлагдмал эрх нь өмчлөгчийг дагаж бус харин эрхийн объект болох эд юмсыг дагадаг. Энэ эрх нь эдийн баялгийн бүрэн эрх болох өмчлөх эрхийн хамгаалалтын аргын нэг негатор нэхэмжлэлээр хамгаалагдах боломжтой. Эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийн агуулга, шинж байдал нь гэрээ, хэлцлийн үндсэн бус харин шууд хуулиар тодорхойлогдох бөгөөд өмчлөгчийн хүсэл зоригтоос гадуур уг эрхийг тогтоох, үүсэх явдал цөөн бус удаа гардаг. Тиймээс хуулиар эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийн бүх төрлүүдийг тогтоож, тухайн эрх нэг бүрийн агуулгыг өөрөөр хэлбэл тухайн нэг эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийг эдлэгчийн эрх болоод үүргийг нь нарийвчлан тогтоох шаардлагатай.

Онолын хувьд эдийн баялгийн хязгаарлагдмал эрхэд бусдын эд юмсын талаарх эдийн баялгийн эрх хамаарах бөгөөд үүнд сервитут түүний бүх төрлүүд, суперфизий, эмфитевзис болон барьцааны эрх хамаарна.

Сервитутын харилцааг бүрэн төгс зохицуулсан эрх зүйн зохицуулалт Ромын эрх зүйн хөгжлийн сонгодогийн дараах үед буюу Юстинианы үед бий болсон гэж үздэг.

Тодорхой газрыг ашиглах үед ашиг шим бий болгох зорилгоор эсхүл тодорхой этгээдийн тусын тулд тогтоосон бусдын эд юмсыг ашиглах эрхийг сервитут хэмээн нэрлэж байжээ.¹

¹ Римское право: Учебник под ред. И. Б. Новицкого и проф. И. С. Перетевского. Москва, Юрист 2001. с. 204

“Сервитут гэдэг нь ямар нэг эд юмсыг бүхэлд нь буюу хэсэгчлэн ашиглах сервитутын эрхийг эзэмшигчийг сөрж, эсэргүүцэх бүрэн эрх нь хасагдсан эсхүл тухайн нэг эд юмсыг өмчлөгч этгээд нь сервитут тогтоогдохоос өмнө боломжтой байсан тодорхой арга замаар цаашид дахин ашиглахгүй байх үүрэг хүлээсэн өмчлөгч этгээдийн гарцаагүй, идэвхгүй, үнэ төлбөргүй үүрэг, эдийн баялгийн эрхийн бие даасан байнгын эрх юм” хэмээн тодорхойлсон байна. Сервитутын тухай энэхүү тодорхойлолт нь өмчлөгч этгээдийн байр сууринаас түүнд өгсөн тодорхойлолт юм.

Харин сервитут бүхий этгээдийн байр сууринаас бол уг эрхийг өмчлөгч этгээд нь өөрөөр хэлбэл сервитут бүхий этгээд нь үнэ төлбөргүйгээр, хугацаагүйгээр, тэр ч байтугай өв залгамжлуулах эрхтэйгээр бусдын эд юмсыг ашиглах буюу өмчлөгчөөс түүнийг тодорхой байдлаар ашиглахгүй байхыг шаардах бүрэн эрхийг эзэмшигч эдэлж байдаг эдийн баялгийн эрхийн харилцааг сервитут гэнэ. Дээрхи тодорхойлолтуудыг Ромын хуульчид өгсөн хэрэг биш, зөвхөн тэр үеийн эрх зүйн зохицуулалтыг шинжлэн судалсны үндсэн дээр хийж байгаа тодорхойлолт юм. Ромын хуульчид бүтээлдээ энэхүү ойлголтыг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай элементүүдийг л дурьдаж тайлбарласан байдаг.

Ромын хуульчид сервитутын нийтлэг шинжийг 2 бүлэгт хувааж үзсэн байдаг.

Сервитутын эрхийг тогтооход зайлшгүй шаардлагатай урьдчилсан нөхцөл байдлууд,

Энэхүү эрхийн агуулгын хязгаарлалт зэрэг шинжүүд болно.

Сервитутын эрхийг тогтооход зайлшгүй шаардлагатай урьдчилсан нөхцөл байдлууд гэдэгт:

Сервитутын эрх байнгын шинжтэй байх,

Сервитут тогтоогдож байгаа байнгын эд юмсын эзэн нь идэвхгүй байр суурьтай байх, өөрөөр хэлбэл сервитутаар эрх нь хязгаарлагдсан этгээд сервитут бүхий этгээдийн төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж, үйлдэл хийх шаардлагагүй.

Сервитутын эрх нь эдийн баялгийн эрхийн шинжтэй бөгөөд бусад бүх гуравдагч этгээдэд ач холбогдолтойгоор үйлчилнэ. Сервитут нэг өмчлөгчийн эзэмшил газрыг өөр этгээдийн эзэмшил газрын тусын тулд хугацаагүйгээр хязгаарлалт тогтоох харилцаа юм.

Хязгаарлалт тогтоогдож байгаа өмчлөгчийн газрыг үйлчлэгч газар, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд бусдын газарт сервитут тогтоох шаардлагатай тэрхүү газрыг ноёлогч газар гэнэ. Сервитутын харилцаанд сервитутаар эрх нь хязгаарлагдаж байгаа өмчлөгч нь сервитут бүхий ноёлогч газрыг эзний зүгээс явуулах үйл ажиллагаа, тодорхой үйлдлийг хүлцэн тэвчих гэнэ.

Түүнээс бус сервитут нь эрх нь хязгаарлагдаж байгаа өмчлөгчид тодорхой үйлдэл хийх үүргийг бий болгодоггүй, харин зөвхөн түүний өмчлөгчийн хувиар хэрэгжүүлэх тодорхой хэмжээгээр хязгаарлалт тогтоогдох буюу тодорхой үйлдлийг түүний зүгээс өөрийн газарт эсхүл сервитут бүхий этгээдийн эзэмшил газарт нөлөөлөл нь чиглэх тодорхой үйл ажиллагаа явуулахаас татгалзах пассив үүргийг бий болгодог.

Ромд сервитутыг Юстинианы үеэс системчлэн төстэй шинж байдлаар нь 2 бүлэгт хуваан ангилж эхэлсэн байна. Үүнд:

1. Газрын сервитут нь:

Хөдөө аж ахуйн зориулалтаар тогтоох газрын сервитут

Хотын сервитут

2. Хувийн сервитут нь:

- Уузфрукт буюу үр шимийг хүртэх, ашиглах эрх,
- Усус буюу ашиглах эрх
- Байнга оршин суух эрх
- Бусдын мал, амьтан, боолыг байнга ашиглах эрх

Газрын сервитут

Газрын сервитут нь ноёлогч газартай салшгүй холбоотой байдаг. Сервитутын харилцаанд “нэг газар нөгөө газарт үйлчлэх” гэсэн зарчим үйлчилнэ. Газрын сервитут нь дараах үндсэн шинжүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

1. Сервитут нь ноёлогч газар буюу сервитут бүхий этгээдийн ашиг сонирхлыг хангах буюу түүнд ашиг тустай байх ёстой, гэхдээ сервитут нь ноёлогч газрын үнэ өртөг, түүнийг эзэмшигч этгээдийн ашиг орлогыг шууд нэмэгдүүлж байхыг шаарддаггүй. Талуудын эзэмшил газар нь зайлшгүй хөрш газрууд байх ёстой.
2. Сервитут нь тохиолдоор буюу хэн нэгний дур зоргоор бус харин зайлшгүй шаардлагын улмаас ноёлогч газрын буюу сервитутын эрх бүхий өмчлөгчийн эрх, ашиг сонирхол, хэрэгцээг үйлчлэгч газар буюу сервитут тогтоогдсон газрын байгалийн нөөцөөр байнга ханган үйлчлэхийн тулд тогтоогдох ёстой.

Энэхүү байнгын зорилго нь хэрэгжих хүртэл сервитут үргэлжилсээр байх бөгөөд сервитутын эрх бүхий этгээдүүд солигдож байлаа ч гэсэн уг эрх хэвээр хадгалагдана. Үүнийг дагалдаж үргэлжлэх эрх гэнэ.

Газрын сервитутын төрлүүд

Хөдөө аж ахуйн газрын эрх ашгийн үүднээс тогтоож байгаа сервитутыг хөдөө аж ахуйн сервитут гэнэ. Энэхүү сервитутад усны, замын сервитут хамаарна.

Ромын эрт үеийн хувийн эрх зүйд:

Бусдын газрыг явганаар буюу мориор нэвтрэн гарах.

Бусдын газраар мал тууж гарах ба бэлчээрлүүлэх,

Бусдын газраар дамжин ачаа зөөх,

Бусдын газраар урсаж байгаа усыг ашиглах эрх зэрэг сервитутын төрлүүдийг хуульчилсан байна.

Харин хожим сонгодог эрх зүйн үед:

Бусдын эзэмшил газраас ус татах эрх,

Урсгал устай газар малаа бэлчээх эрх,

Бусдын эзэмшил газар мал бэлчээх, хариулах зэрэг сервитутын төрлүүд бий болсон байна.

Эдгээр сервитутыг нийтлэг төстэй шинжээр нь :

Замын сервитут/ бусдын газрыг мориор буюу явганаар нэвтрэн гарах, бусдын газраар мал тууж гарах ба бэлчээрлүүлэх, бусдын газраар дамжин ачаа зөөх/

Усны сервитут/ бусдын газраар урсаж байгаа усыг ашиглах эрх, бусдын эзэмшил газраас ус татах эрх/

өөр бусад сервитут/ бусдын эзэмшил газар мал бэлчээх гэх мэт/

Хот газрын сервитут

Барилгажсан газар тогтоож буй сервитутыг хот газрын сервитут гэнэ. Энэ сервитутын гол төрлүүд нь:

Бусдын агаарын орон зайд нэвтэрч дээвэр, сүүдрэвч барих эрх,

Бусдын хана хэрэмд түшиглэн хөндлөвч, дам нуруу тавих эрх,

Бусдын сууринд тулгуурлах буюу бусдын ханыг ашиглан байшин барилга барих эрх зэрэг болно.

Ромын эрх зүйн хөгжлийн явцад:

Борооны усыг урсгах эрх,

Ус урсгах эрх,

Бохирын суваг тавих, дамжин өнгөрүүлэх эрх,

Цонх халхлахгүй байхыг шаардах эрх,

Барилгыг тодорхой хэмжээнээс өндөргүй барихыг шаардах эрх зэрэг сервитутын эрх шинээр үүссэн гэж үздэг.

Хувийн сервитут /Servitus personarum/

Хувийн сервитут гэдэг нь бусдын эд юмсыг ашиглах байнгын эрх юм. Хувийн сервитут бусдын эд юмсын үр шим, ашгийг ашиглах эрх буюу узуфрукт, ашиглах эрх-усус, байнга оршин суух эрх, бусдын боол мал амьтныг ашиглах байнгын эрх зэрэг төрлүүдтэй.

Хувийн сервитут ба газрын сервитутын хоорондын ялгаа юунд орших вэ? Газрын сервитутыг ноёлогч газрын өмчлөгч буюу эзэмшигчийн тусын тулд, уг газрыг ашиглах зайлшгүй шаардлагад үндэслэн тогтоодог бол хувийн сервитут буюу узуфруктыг газрын тусын тулд бус харин тодорхой этгээдийн тусын тулд тогтоогддог.

Тухайн тодорхой эд хөрөнгө болон эрхийн эзэмшигч нь гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс тодруулж хэлбэл гуравдагч этгээд түүний эрх болон эд хөрөнгөөс үр шимийг хүртэх болон ашиг олох зорилгоор бусдын эд хөрөнгө, эрхийг эзэмшиж ашиглахад узуфруктын зорилго оршино.

Сервитутын эрх зүйн хамгаалалт

Ромд сервитутыг онцгой төрлийн нэхэмжлэлүүдээр болон интердиктээр хамгаалдаг байжээ. Сервитут бүхий этгээд нь эрхийг нь зөрчиж байгаа аливаа үйл ажиллагааг таслан зогсоох эрхийг өмчлөгчийн нэгэн адил эдэлдэг. Сервитутын эрхийг хамгаалах хамгийн анхдагч арга нь сервитутыг сэргээн тогтоохыг шаардах эрх юм.

Энэ нэхэмжлэлийн шаардлага нь түүний сервитутын эрхийг хүлээн зөвшөөрөх, энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд учрах саадыг арилгах төдийгүй сервитутыг сэргээн тогтоох явдал болдог байжээ. Энэхүү нэхэмжлэлээ хангуулахын тулд сервитут бүхий этгээдэд сервитутын эрх байгаа эсэх, түүнд үндэслэсэн шаардах эрхээ гаргах үндэслэлтэй эсэхээ нотлох шаардлага нэн тэргүүнд тавигддаг байсан¹ гэж зарим сурах бичигт бичсэн байдаг.

Хожим Юстинианы кодекс гарснаар энэхүү нэхэмжлэлийн оронд actio confessoria гэх нэхэмжлэл гаргах замаар сервитутын нэхэмжлэлийг хамгаалах болсон. Энэхүү нэхэмжлэлийг сервитутын эрх зөрчигч этгээдэд сервитутаар хязгаарлагдсан үл хөдлөх эд хөрөнгө байгаа эсэхээс үл хамааран эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа этгээдийн эсрэг гаргана. Энэхүү нэхэмжлэлийн зорилго нь түүнийг өмчлөгч этгээдийн негатор нэхэмжлэлтэй ойролцоо болгодог байна.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 6 дугаар зүйлийн 2-д "Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, үүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн." мөн зүйлийн 3-д "Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэргэцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.

¹ Пузанк Иво, Поленак-Аккомская марияна. Римское право. Базовый учебник. Перевод с македонского языка. Док.юрид.наук проф. В.А.Томсинова, Ю.В. Филиппова. Изд-Зерцало, 2000с.185

Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхээ газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно." мөн зүйлийн 4-д "Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүний эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно." 5 дахь хэсэгт "Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол журмын дагуу ашиглуулж болно." гэж заасан нь газар өмчлөлийн харилцаа түүний үндсэн үүсэх сервитут болон бусад төрлийн эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийн харилцааны хууль зүйн үндсийг тавьсан зохицуулалт болсон.

Үндсэн хуулийн энэхүү зүйл заалтын дагуу 1994 оны Иргэний хуулийн Өмчийн эрх зүй гэх II хэсэг, Долдугаар бүлэгт "Газар өмчлөх болон газартай холбогдсон эд хөрөнгийн бусад эрх" зохицуулалтыг хийсэн байна. Иргэний хууль батлагдсанаас яг 10 хоногийн дараа буюу 1994 оны 11 дүгээр сарын 11-нд Монгол Улсын Их Хурлаас Газрын тухай хуулийг батлан гаргасан. Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх боломж нээгдсэн боловч 1994 оны Иргэний хууль, Газрын тухай хуулиудаар иргэд газар өмчлөх харилцааг зохицуулаагүй, Үндсэн хуулийн заалт амьдралд хэрэгжих хууль эрх зүйн орчин бүрдээгүй байсан цаг үе юм. Энэ үед газрыг өмчлөгч нь гагцхүү төр байсан бөгөөд газрыг өмчлөх болон эзэмших ашиглах харилцааны нэг тал нь ямагт

төр байж, үүний дагуу газрын талаарх эд хөрөнгийн хязгаарлагдмал эрхүүд нь төрийн оролцоотойгоор хэрэгжиж байсан.

Иргэний хууль болон газрын тухай хуулиудаар газрыг иргэд, хуулийн этгээд эзэмших, ашиглахтай холбоотой харилцаа буюу газар өмчлөгч биш этгээдийн эрх, уг эрхээ өвлүүлэх харилцаа, газрыг тодорхой бус хугацаагаар ашиглах эрх, бусдын газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч дэвсгэр газрыг ашиглах эрх, газар болон барилгаа байгууламж, бусад үл хөдлөх эд хөрөнгийг хязгаартайгаар ашиглах эрх буюу сервитут, бусдын эзэмшил, ашиглалтанд байгаа газрыг бусад тусгай хэрэгцээнд ашиглах буюу нийтийн сервитут, бусдын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөх сервитут, бусдын эзэмшил, ашиглалтанд байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах зэрэг эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг тогтоосон. Эдгээр зохицуулалтууд нь Монгол Улс хүн төрөлхтөний хөгжлийн түгээмэл зүй тогтлын дагуу зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн хууль зүйн баталгаа, илэрхийлэл болсон анхдагч зохицуулалт болсон. Цоо шинэ харилцааг хуульчилсан эдгээр хуулиудын амьдрал дээрх биелэлт, хэрэгжилт, ололт, амжилт, зөрчил дутагдлыг нь дүгнэж цэгнээд дахин шинэчилж холбогдох хуулиудыг батлан гаргаснаар эрх зүйн шинэтгэлийн 2 дахь үе эхэлсэн бөгөөд энэ үед батлагдан гарсан 2002 оны Иргэний хууль, 2003 оны Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудад газрыг иргэдэд өмчлүүлж, газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой харилцааг олон улсын жишигт нийцсэн байдлаар илүү нарийвчлан зохицуулсан.

Иргэний хуулийн зохицуулалтаас харах ахул үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх буюу эрхээ хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөх эрхийг хязгаарлах гэх бүлэг харилцаанд оруулжээ. Уг бүлэг харилцаа нь уг чанартаа бол бусдын эд юмсын талаарх өмчлөгч бус этгээдийн эдийн баялгийн эрх, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулагч Иргэний эрх зүйн нэгэн институт юм гэж дүгнэж болох юм.

Иргэний хууль болон Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг шинжлэн судалж үзвэл уг хуулиудад хувийн сервитут ба нийтийн сервитут гэх нэр томъёог хэрэглэсэн байна. Гэвч эдгээр хуулиудад дээрх ойлголтуудыг авч хэрэглэхдээ хувийн сервитут гэдэг нь (бусдын эд юмсыг ашиглах байнгын эрх) Эртний Ромд болон Роман-Германы эрх зүйн тогтолцоот улсуудад хэрэглэж заншсан *servitus personarum* гэдэг утгаар бус харин хувийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн үүсэгч, уг хэм хэмжээгээр зохицуулагдах байдлаар нь өөрөөр хэлбэл иргэний хуулийн дагуу үүсч байгаа харилцааг нь хувийн сервитут хэмээн нэрлэж, харин улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагын улмаас нийтийн захираганы байгууллага буюу сум дүүргийн засаг дарга сервитут тогтоох үйл ажиллагааг нийтийн сервитут хэмээн нэрлэж байна. Өөрөөр хэлбэл нийтийн эрх зүйн хүрээнд, нийтийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн тогтоогдож байгаа сервитут хэмээх утгаар нь түүнийг нийтийн сервитут хэмээн нэрлэжээ. Нийтийн сервитут гэх хуулийн энэхүү томъёолол нь зайлшгүй хэрэгцээгдэх томъёолол мөн хэдий боловч түүнтэй зэрэгцүүлэн хувийн сервитут гэх томъёолол нь оновчтой, үг томъёололын хууль агуулгатай

харшилсан хэрэг болсон гэж үзэх үндэстэй. Нийтийн эрх зүй гэдэгтэй дүйцэх ойлголт нь хувийн эрх зүйн сервитут хэмээн нэр томъёо юм.

Мөн түүнчлэн Иргэний хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд сервитутыг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх гэж томъёолсон бол Газрын тухай хуульд сервитутыг газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах хэмээн томъёолсон байна.

Ижил төрлийн харилцааг зохицуулсан хуулиудад хэрэглэсэн нэр томъёо нь ингэж зөрүүтэй, өөр өөр байгаа нь иргэдэд хуулийн зохицуулалтыг таньж мэдэх, ойлгох, түүнчлэн түүнийг амьдралдаа ашиглах, дагаж мөрдөхөд хүндрэл учруулж болохыг үгүйсгэхгүй.

Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудад зааснаар дараах төрлийн нийтийн сервитутуудыг хуульчилсан.

Бусдын эзэмшил ашиглалтад байгаа газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах, Тухайлбал: Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч нь эд хөрөнгөө ашиглах, хамгаалах зорилгоор бусдын газраар дайран өнгөрөх зам, цахилгаан холбооны болон инженерийн шугам татах, гарц гаргах гэх мэт,

Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт нэвтрэх, дайран өнгөрөх,

Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт газрын заагийн болон геодезийн байнгын цэг, тэмдэг тавих, Намагжилтыг багасгах ажил гүйцэтгэх,

Газар зохион байгуулалтын бусад арга хэмжээ хэрэгжүүлэх гэх мэт сервитутууд байж болно.

Иргэний хуульд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах дараах арга

замуудыг хуульчилсан.

Хууль буюу гэрээнд заасан тохиолдолд бусдын үл хөдлөх эд хөрөнгийг тэргүүн ээлжинд хязгаартайгаар ашиглах,

Өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг бусад өмчлөгчдөд даалгах, өөрөөр хэлбэл сервитутаар эрх нь хязгаарлагдсан тал сервитут бүхий талын тусын тулд өөрийн газар дээр ямар нэгэн үйлдэл хийх буюу үйл ажиллагаа явуулахгүй байх үүргийг хүлээдэг.

Жишээ нь: өөрийн газар дээр тодорхой өндрөөс давсан барилга барихгүй байх, тодорхой хэмжээнээс хэтэрсэн дуу чимээ гаргахгүй байх, тоос, хог шороо гадагш гаргахгүй зэрэг болно.

Сервитутаар эрх нь хязгаарлагдсан өмчлөгчөөс сервитут бүхий талын үл хөдлөх эд хөрөнгийн хувьд зарим эрх хэрэгжүүлэхийг хязгаарлах,

Өөрөөр хэлбэл эрх хязгаарлагдсан өмчлөгч нь өмчлөгчийн хувьд эдлэх эрхээ ямар нэг хэмжээгээр хасуулдаг. Жишээ нь: хөршийн эрхийн харилцаанд хэмжээнээс хэтэрсэн нөлөөллийн нөхөн төлбөрийг шаардах эрхээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл өмчлөх эрх нь зөрчигдсөн гэж үзвэл зөрчсөн үйлдлийг зогсоохыг шаардах эрхээ хэрэгжүүлэхгүй байх зэрэг болно.

Сервитутын эрх нь Иргэний хуульд заагдсан иргэний эрх зүйн хамгаалалтын аргаар хамгаалагдана. Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэх бөгөөд сервитут бүхий этгээд өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр эрх зүйн хамгаалалтын боломжит арга хэрэгслүүдийг сонгон авч хамгаалах боломжтой.

Гэхдээ сервитутын эрх нь эдийн баягийн эрхийн нэг төрөл болох учраас эдийн баялгийн эрхийн хамгаалалтын арга хэрэгслээр хамгаалагдах учиртай. Ингэж хэлж байгаа нь сервитут бүхий этгээд өөрийн эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа этгээдийн үйлдлийг таслан зогсоох буюу саадыг арилгахын тулд "өөртөө туслах" "аргагүй хамгаалалт" болон "гарцаагүй байдлын" нөхцөлд тодорхой үйл ажиллагаа явуулах боломжийг нь үгүйсгэсэн утга агуулаагүй юм.

Орчин үед Өрнөдийн, Ром-Германы эрх зүйн тогтолцоот орнуудын сервитутын эрхийн зохицуулалтыг ХБНГУ-ын жишээн дээр авч үзье.

Германы Иргэний хуулийн зохицуулалтаас судлан үзвэл хуульд маш олон тооны эдийн баялгийн хязгаарлагдмал эрхийг хуульчилсан байх ба тэдгээрийг бүхэлд нь дараах бүлгүүдэд хувааж болно. Үүнд:

1. Бусдын эд юмсыг ашиглах эрх. Энэ нь үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэх зорилгоор өөр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах зорилгоор газарт нь тогтоож байгаа сервитутууд, газар өмчлөгчийн эрхийг тодорхой этгээдийн тусын тулд хязгаарлах буюу газарт нь хязгаарлалт тогтоох хувийн сервитутууд, узуфрукт, суперфизий зэрэг багтаадаг.
2. Бусдын эд юмсаас ашиг хүртэх эрх: Энэ нь барьцаа, үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа, эд юмс шилжүүлэх, эд юмсын үүрэг, рентийн үүрэг зэргийг ойлгодог.
3. Ямар нэг эд юмсыг олж авах эрх: Үүнд худалдан авах давуу эрх, ан агнуур хийх загас барих эрх, ашигт малтмал боловсруулах эрх зэрэг багтана.

Эдгээрээс бусдын эд юмсыг

ашиглах эрхэд сервитут багтдаг байна. Сервитутын үндсэн 2 хэлбэрийг хуульчилсан.

Бодит сервитут: газар өмчлөгчид хамааралтайгаар тогтоож байгаа сервитут.

Германы Иргэний хуулийн 1018дугаар зүйлд “Газрыг өөр газар өмчлөгчийн тусын тулд уг этгээд нь ямар нэгэн тодорхой тохиолдолд газрыг ашиглах эрхтэй байхаар, эсхүл уг газарт тогтоогдсон газрын өмчлөх эрхээс үүсэн гарах тэрхүү нөгөө газарт холбогдуулан ямар нэгэн эрхийг хэрэгжүүлэхийг хориглох замаар хязгаарлалт тогтоож болно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл газрыг өөр газар өмчлөгчийн тусын тулд түүнд бусдын газрыг ашиглах эрх олгох замаар хязгаарлалт тогтоохыг хэлнэ. Газрын сервитутыг хэрэгжүүлэх үед сервитут бүхий этгээд нь сервитутаар эрх нь хязгаарлагдаж, газарт нь хязгаарлалт тогтоогдсон өмчлөгчийн ашиг сонирхлыг боломжоороо хүндэтгэх үүрэг хүлээнэ.

Мөн сервитутын зүйл нь газар төдийгүй байшин барилга байгууламж байж болохыг хуульчилсан. Тиймээс уг газрын өмчлөгч нь сервитут бүхий этгээдийн ашиг сонирхол нь бодитойгоор шаардаж байвал түүний дээр байгаа байшин барилга, байгууламжийг зохих ёсоор хадгалж хамгаалж арчлах үүрэг хүлээнэ. Хуулийн 1023 дугаар зүйлд газрыг хэсэгчлэн болон бүхэлд нь сервитут тогтоож болохоор заасан. Хэд хэдэн газрын сервитут дуусгавар болох эсхүл тасалдах тохиолдолд уг газрын өмчлөгчөөс бусад энэхүү харилцааны оролцогчид нь бүх эрх бүхий этгээдүүдийн ашиг сонирхлыг хангах замаар түүнийг хэрэгжүүлэн биелүүлэхийг шаардаж болно.

Ноёлогч газар буюу сервитут бүхий этгээдийн эзэмшил газар,

бусад үл хөдлөх эд хөрөнгө нь хуваагдах тохиолдолд хуваагдсан газар бүрт өөрөөр хэлбэл уг газрыг өмчлөгч, эзэмшигч тус бүрт сервитут хэвээр хадгалагдана. Гэхдээ энэ бүгд нь сервитутаар эрх нь хязгаарлагдсан өмчлөгчид ноцтой хохирол учруулахааргүй байх нөхцөлд л хэрэгжинэ.

Үйлчлэгч газар буюу сервитутаар эрх нь хязгаарлагдсан өмчлөгчийн эзэмшил газар нь хуваагдан хэд хэдэн этгээдэд шилжсэн тохиолдолд өмнө нь сервитутаар хязгаарлагдаж байгаагаас бусад газар эрхийн хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

Хувийн сервитут: хязгаарлалт тогтоогдсон эд юмсын шинж чанарыг өөрчлөхгүйгээр түүнээс гарах үр шимийг ууфрукт эзэмшигч өөрийн болгохтой холбоотой бусдын эд юмсын талаарх эдийн баялгийн эрхийн нэг төрөл.

ОХУ-ын хувьд тус улсын Иргэний хуулийн “Өмчлөгч бус этгээдийн эд юмсын эрх” гэх 216 дугаар зүйлээс харах ахул өмчлөх эрхтэйгээс гадна газрыг өв залгамжлуулах эрхтэйгээр бүх насаараа эзэмших эрх, газрыг байнга ашиглах эрх, сервитутууд, эд хөрөнгийг аж ахуйн хувьд эрхлэн хөтлөх эрх, эд хөрөнгийн шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх эрх зэргийг хуульчилсан байх ба эдгээрээс эхний 3 нь эдийн баялгийн хязгаарлагдмал эрх болно.

1. МУ-ын Иргэний хууль, Газрын тухай хууль болон Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн зохицуулалтыг судалснаар хувьдаа нэгэн дүгнэлтэд хүрээд байгаа болно. Иргэний хууль болон Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг шинжлэн судалж үзвэл уг хуулиудад хувийн сервитут ба нийтийн

сервитут гэх нэр томъёог хэрэглэсэн байна.

2. Сервитутыг үл хөдлөх эд хөрөнгөөс газарт холбон ярихдаа сервитут бүхий этгээдийг ноёлогч газар, сервитутаар эрх нь хязгаарлагдсан этгээдийг үйлчлэгч газар гэсэн нэр томъёогоор хэрэглэж заншжээ. Энэ нь өөрөө МУ-ын Иргэний Хуулийн 151 дүгээр зүйлд заасан нэр томъёотой харьцуулахад

шууд ойлгогдохоор энгийн

Сервитут тогтоогдож буй зүйлийн тодорхой шинж чанараас хамаарсан ангилалт хийх боломжийг олгож байна.

3. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрхийн талаар ард түмэн нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Иргэдийн эрх зүйн мэдлэг дутмагаас энэхүү эрхээ хэрэгжүүлж чадахгүйд хүрч, маргаан гарсан тохиолдолд хэнд, хэрхэн хандаж, яаж шийдвэрлэхээ мэдэхгүй мухардалд хүрдэг. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд сумд газрын даамал, дүүрэгт газрын албаны ажилтнуудад хөршийн эрх, сервитутын эрхийн талаарх ойлголтуудыг ул суурьтай бий болгох шаардлагатай байна. Мөн сервитуттай холбоотой хэрэг маргаан шийдвэрлэсэн шүүхийн практик бараг үгүй байгаа нь шүүгчдийн сервитутын талаарх эрх зүйн мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна.

* * *

¹ Германское гражданское уложение. В. редакции от 25 июля 1991 года.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ТӨЛӨӨЛӨЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

ХЗҮТ-ийн Эрдэм шинжилгээний ажилтны туслах А.ТҮВШИНТУЛГА

Иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах хангах шүүхийн үйл ажиллагааны нэгэн төрөл бол иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа юм.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол улсын олон хууль тогтоомжид дорвитой өөрчлөлт орж, шинээр батлагдан өөрчлөгдөж байгаа билээ.

Түүний нэгээхэн хэсэг бол Улсын Их Хурлаас "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх" тухай Монгол улсын хууль шинэчлэн батлагдаж 2002 оны 9-р сарын 1-нээс эхлэн мөрдүүлээд багагүй хугацаа өнгөрлөө. Шинэ хуулийн зохицуулалт нь сайн тал нэлээд байгааг үгүйсгэх аргагүй ч цаашид анхааран дахин нягтлан үзвэл зохистой нилээдгүй зохицуулалт байгаагийн нэг нь Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд бусдаар өөрийгөө төлөөлүүлэх тухай ойлголт юм. Тус зохицуулалт нь хуучин хуулинд /1994 он/ тус хуулийн 30.1.2-д тусгагдсан тэр хэвээрээ байгаа бөгөөд цаашид анхааран эргэж харах шаардлага байна.

Энэхүү шүүхэд төлөөлүүлэх гэдэг ойлголт нь практикт нилээд гардаг, хэнд ч тохиолдож болох практик чухал ач холбогдолтой нарийвчилсан зохицуулалт шаардагдах ойлголт. Тийм учир энэ ойлголтын онолын үндэслэгээ, эрх зүйн зохицуулалт болоод практикт гарч болох зарим бэрхшээлтэй асуудал, хууль түүнтэй хэрхэн уялдаж буй, цаашид юун дээр нь анхаарвал зохистой зэрэг цомхон асуудлыг дэвшүүлэхийг зорьсон болно.

Онолын үндэслэл

Иргэн, хуулийн этгээд нь өөрөөр хэлбэл зохигчид нь иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо өөрийн эдэлбэл зохих эрх үүргээ өөрөө хэрэгжүүлэх буюу төлөөлөгчөөрөө дамжуулан гүйцэтгүүлж болно.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөл гэдэг нь: Зохигчдын нэрийн өмнөөс тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж эрх зүйн чадвар, чадамж бүхий субъектүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөн оролцох үйл ажиллагаа юм.

Төлөөлөлт нь тодорхой этгээдийн нэрийн өмнөөс явагддаг

Төлөөлөлт нь төлөөлөгч, төлөөлүүлэгчийн хоорондын тохиролцоо буюу тэдгээрийн хүсэл зоригоор тодорхойлогдоно. Өөрийн ашиг сонирхлоо хамгаалуулахын тулд өөрийгөө бусдаар төлөөлүүлэн шүүхэд оролцуулж байгаа талыг "Төлөөлүүлэгч" гэнэ. Харин хэрэг хэлэлцэх үйл ажиллагаанд /төлөөлүүлэгчийн/ буюу бусдын нэрийн өмнөөс оролцож байгаа этгээдийг "Төлөөлөгч" хэмээн тодорхойлсон байна.¹

Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх чөлөө хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулна.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь төлөөллийн харилцаанд төлөөлөгч - төлөөлүүлэгч, төлөөлөгч - шүүхийн хооронд үүсэх харилцаа байдаг.

Төлөөлүүлэгч өөрийн гүйцэтгэх эрх үүргээ төлөөлөгчид шилжүүлж төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүрэн эрхтэйгээр оролцдог. /Төлөөлөгч төлөөлүүлэгч нь иргэн, хуулийн этгээд байдаг/. Төлөөлөгчдөөс явуулах үйл ажиллагаанд төлөөлүүлэгчид эрх зүйн тусалцаа үзүүлэх, тодорхой зөвлөгөө өгөх, түүний нэрийн өмнөөс процессийн баримт бичиг боловсруулах, хэргийг шүүхээр хянан хэлэлцэхэд хуульд заасан бүрэн эрхийг эдэлж хэрэгжүүлэх зэрэг өргөн ойлголт хамаарна.

Төлөөлөлтийн зорилго, ач холбогдол

- Хэрэг хэлэлцэх ажиллагаа сунжирч удаашрахаас сэргийлэх
- Хэрэг хэлэлцэх ажиллагаанд биечлэн оролцох боломжийг тохиолдолд талуудыг төлөөлөх /сайн дурын төлөөлөл/
- Зохигчдын албан ёсны ашиг сонирхлыг мэргэжлийн үүднээс хамгаалах өмгөөлөх боломжоор хангах /гэрээгээр төлөөлөл/
- Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд биечлэн оролцох боломжоор хязгаарлагдсан. Тухайлбал: Хэсэгчлэн эсхүл эрх зүйн чадамжгүй этгээдүүдийн эрхийг хамгаалж тусалцаа үзүүлэх /хууль ёсны төлөөлөл/

Төлөөлөлтийн онцлог нь:

Төлөөлөгч ИХШХША-нд оролцохдоо зөвхөн хуулиар зөвшөөрсөн бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Төлөөлөгч нь бүрэн эрхийг нотлох баримт бичгийг шүүхэд үзүүлэх буюу итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлнө.

Төлөөлөгчийн бүрэн эрхийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлүүлэгч ямар байр суурь эзлэн оролцож байгаагаас шалтгаалан төлөөлөгч нь зохигчдын эрх үүргүүдийг эдэлдэг онцлогтой.

¹ Т.Монхжаргал "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" 2004 он 93-98 дахь тал

² Ж.Наранцацрал "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй" /тайлбар схем /2004 он 56-58 дахь тал

Төлөөлөгчийн бүрэн эрх

Төлөөлүүлэгчийн хууль ёсны төлөөлөгчийн хувьд: иргэний үнэмлэх, гэрлэлтийн баталгаа, төрсний гэрчилгээ, асран хамгаалах байгууллагын шийдвэрээр олгогдсон баримт бичиг гэх мэт.

Сайн дурын төлөөллийн хувьд: төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлд тусгасан эрхээр;

Гэрээгээр төлөөлүүлэгчийн хувьд: төлөөлөгч төлөөлүүлэгчийн хооронд хийгдсэн бичгэн гэрээгээр тус тус тодорхойлогддог.

Жишээ нь: өмгөөлөгч эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг төлөөлүүлэгчтэй байгуулах гэх мэт. Ингэхдээ итгэмжлэл болон гэрээнд төлөөлүүлэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийн заримыг төлөөлөгч этгээд эдлэхгүй байхаар зааж болно.

ИХШХША-д төлөөлөн оролцох эрхтэй субъект:

Юуны өмнө өмгөөлөгч гэрээний үндсэн дээр эрх зүйн бүрэн чадамжгүй болов зарим буюу хэсэгчилсэн чадамжтай хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг түүний хууль ёсны төлөөлөгч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, шүүхийн зөвшөөрснөөр эрх зүйн чадамжтай иргэн, гэр бүлийн гишүүд, төрөл садангаараа хуулийн этгээдийн хувьд бүрэн эрхийг нотолсон баримт бичгийн үндсэн дээр хэн ч байж болохоор гол төлөөлөх эрх бүхий субъектүүд байна.

Түүнчлэн хуульд заасан төлөөллийн харилцаанд төлөөлөгчөөр сонгож болохгүй хоригдосон субъектүүд бий. /ИХШХШ тухай хуулийн 36.5.1, 36.5.2, 36.5.3/

- 18 насанд хүрээгүй этгээд /тодорхой тохиолдолд/

Энэ нь харьцангуй зохицуулалт бөгөөд дотроо зарчмын хоёр ялгаатай. Үүнд:

- а. 14-18 хүртэлх насны хүнээр төлөөлүүлэхийг үү этгээдийн эцэг эх, харгалзан дэмжигч нь

зөвшөөрөөгүй бол түүгээр төлөөлүүлж болдоггүй. /төлөөллийн ерөнхий харилцаанд/

- б. 14-18 нас хүрээгүй хүнээр /шүүхээс эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцогдсоноос бусад тохиолдолд/ шүүхэд төлөөлүүлж болдоггүй.

- Шүүхээс зарим эрхээ хязгаарлуулсан этгээд /тодорхой тохиолдолд/

Өөрөөр хэлбэл эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, чадамжгүй иргэн. Үүнд: мансууруулах болон сэтгэцэд нөлөөлж бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсны улмаас эрх зүйн зарим чадамжаа шүүхээр хязгаарлуулж энэ чадамжийнхаа хүрээнд шүүхээс харгалзан дэмжигчийг томилуулсан насанд хүрсэн хүн.

- Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч /тодорхой тохиолдолд/

Хэрэв тухайн албан тушаалтнууд өөрөө иргэнийхээ хувьд түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд төлөөлөгчөөр оролцож болохгүй юм.

- Төлөөлөлтийг хэлбэрийн хувьд гурав ангилсан байдаг:

- Хууль ёсны
- Сайн дурын
- Гэрээгээр

Нийтлэлд энэхүү сайн дурын төлөөллийн онолын үндэслэлийг хуулийн хүрээнд хязгаарласан зэрэг асуудалд түлхүү анхаарсан юм. Ерөнхий онолын үндэслэлийн хувьд төлөөлөлтийн ойлголт нь ниймэрхүү байна.

Эрх зүйн зохицуулалт

Эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэхэд юун түрүүнд үндсэн эх сурвалж болох Үндсэн хуулиасаа эхлэх нь зүйд нийцэх билээ.

“Монгол Улсын Үндсэн Хуулийн 2дугаар бүлгийн 16.14-т зааснаар” “...өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрхтэй...” гэж заасан ба эрх зүйн туслалцаа авч шүүхэд бусдаар өөрийгөө төлөөлүүлэх эрх нь Үндсэн хуульд заасан дээрх эрхийн агуулгад багтах ойлголт, түүнчлэн Үндсэн хуулийн 19.1 “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”.

Цаашлаад ИХШХШ тухай хуульд хэрхэн тусгагдсан тус хуулийн зохицуулалт /сайн дурын төлөөлөлтэй холбоотой/ Үндсэн хуультайгаа хэрхэн уялдаж байгааг авч үзвэл:

ИХШХШ тухай хуулийн 32.4-т “Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн төрөл садангаараа эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэж заасан нь сайн дурын төлөөллийн онолын үндэслэлээг явцууруулж хязгаарласан төдийгүй Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16.14 дэх хэсгийн заалтын агуулгаас харахад эрх зүйн туслалцааг хэн нэгнээс авах эрхтэйг заасан байхад ИХШХШ тухай хуульд эрх зүйн бүрэн чадамжтай иргэн нь:

1. Гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа
2. Гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр л төлөөлүүлж шүүхэд эрх ашгаа хамгаалуулах болж байгаа бөгөөд дээрх хоёр арга замаас өөр боломжийг олгоогүй байгаа юм.

Яг энэ асуудлаар иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн цэцэд хандан маргаан үүсгэж Үндсэн хуулийн цэцээс маргааныг хянан хэлэлцээд ИХШХША-ны төлөөллийн хэлбэрийг тоочихдоо төлөөлтийн зарим боломж хэлбэрийг орхигдуулж явцуурсан тал харагдаж байна!... гэсэн нь цаашид хууль тогтоомжийнхоо зохицуулалтыг оновчтой

нарийвчлан зохицуулахыг

шаардсан агуулгатай шийдвэр юм.

Цаашилбал эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг төлөөлөх дээрх зохицуулалт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулийн /2002/ 25.3-т “Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэний гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садангийн хүн эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэхэе сайн дураараар сонгох эрхтэй” гэж бас л явцууруулж тусгасан байна.

Гэхдээ манай зарим судлаач эрдэмтдийн тайлбар¹ болоод эрх зүйн онолын үүднээс үзвэл ИХШХШ тухай хуулийн “эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно” гэсэн заалт нь эрх олгосон, зөвшөөрсөн шинжтэй хэм хэмжээ бөгөөд энэ нь бусад хөндлөнгийн этгээдээр төлөөлүүлж болохгүй гэсэн хориглосон хэм хэмжээ биш гэж үзэх нь байдаг.

Гэвч практикт хуулийн албан ёсны тайлбар дэлгэрэнгүй тодорхойлон гаргахгүй бол шүүгчид хуулийн нэр томъёог нэг мөр ойлгон шууд агуулгаар нь хэрэглэх юм.

Түүнчлэн гол нь жирийн иргэд хуулийн зүйл заалтыг шууд утгаар л ойлгохоос биш түүнийг эрх зүйн онолын үүднээс тэгж нарийвчлан ялгаж салган ойлгож чадахгүй юм.

Ингэж ИХШХША-нд иргэн эрх зүйн туслалцаа авч бусдаар өөрийгөө төлөөлүүлэх эрхийг хязгаарласан хэрнээ ИХШХШ тухай хуулийн 35.2 “хуулийн этгээдийг төлөөлж буй этгээд өөрийн албан тушаал эсхүл төлөөлөх эрх олгосныг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлээд төлөөлж болохоор өөрөөр хэлбэл дээрх шаардлагыг хангасан л бол хэн ч төлөөлж болохоор заан өргөн эрх олгосон нь нэг талдаа шардга

ёсны зарчим эрх тэгш байдлыг алдагдуулсан шинжтэй гэж үзэж ч болохоор юм.Зүй нь бол хуулийн этгээдийг зөвхөн эрх бүхий албан тушаалтан л төлөөлөх, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан гэсэн ойлголтыг “Компаний тухай хуульд” /1999 он/ дараах агуулгаар тодорхойлсон байдаг. Тодруулбал эрх бүхий албан тушаалтан гэдэг нь уг хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг байх тухай заасан байдаг. Гэхдээ голчлон тухайн хуулийн этгээдийг шууд төлөөлөх харилцаанд оролцох этгээд нь ихэнх тохиолдолд хуулийн этгээдийн удирдлага буюу гүйцэтгэх захирал нь байх ёстой юмуу хуулийн зөвлөх нь байх ёстой байтал ИХШХШ тухай хуулинд эрх бүхий албан тушаалтан гэсэн нэр томъёог оруулаагүй байгаа бөгөөд оруулах шаардлага бий. Хуулийн этгээдийг болохоор төлөөлөх эрх олгогдсоныг гэрчилсэн баримт бичиг үзүүлээд хэн ч төлөөлж болохоор байтал иргэнийг болохоор дээр дурдсан хоёр боломжоор хуульд хязгаарласан нь төдийлөн зүйд нийцэхгүй юм уу гэж санагдана.

Өмнө дурдсан зохицуулалттай холбоотойгоор практикт гарч ирэх зарим хүндрэл бэрхшээлтэй тохиолдлуудыг хийсвэр жишээн дээр авч үзье.

Жишээ нь: Иргэн Б бусдын компьютерыг түр ашиглаж байх үед цахилгаан тасарч, түүний улмаас тухайн ашиглагдаж байсан компьютер нь эвдэрсэн байна. Уг компьютерыг өмчлөгч А нь Б-ээс хохирлоо буюу компьютерын үнийг нэхэмжилж шүүхэд хандсан шүүх хурал болох өдөр иргэн Б хөдөө явах зайлшгүй шаардлагатай болсон. Энэ тохиолдолд иргэн Б-д өөрийгөө буруугүй гэж батлах боломж ИХШХШ тухай хуулийн

32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу түүнд Нэгдүгээрт: өөрийгөө гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа; Хоёрдугаарт: гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлэх гэсэн хоёрхон боломж байна. Гэвч түүний гэр бүлийн гишүүн, төрөл саданд өөрийнх нь эрх ашгийг шүүхэд төлөөлөөд хамгаалахаар хэмжээний компьютерын мэдлэгтэй хүн байхгүй /төрөл садан муутай ч хүн байж болно/ мөн компьютерын талаар сайн мэдлэгтэй санаанд нь нийцсэн өмгөөлөгч олдохгүй, олдсон ч өмгөөллийн хөлс өндөр, тэрээр төлөх боломжгүй байж болно. Тэр мөн шинжээч томилуулж болох байлаа. Харин манай жишээнд гардаг иргэн Б өөрийн компьютерын сайн мэдлэгтэй компьютерын техник хангамжийн инженер найзаараа шүүхэд төлөөлүүлэхээ итгэмж-лэл олгох гэтэл иргэн Б-д хуулийн тийм боломж алга байна.

Амьдралд ийнхүү энгийн хэрнээ ярьвгатай нарийвчилсан зохицуулалт шаардсан тохиолдол нилээдгүй гарах учир цаашид ИХШХШ тухай хуулийн дээрхи зохицуулалтыг илүү боловсрон-гүй нарийвчлан зохицуулах УДШ-ээс албан ёсны тайлбар гаргаж тодосгох, цаашилбал Үндсэн хуулийн үзэл агуулгад нийцүүлэх зүй ёсны шаардлага урган гарч ирж байна.



¹ 2004.04.21-ны өдөр 12.01 тоот Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт. Төрийн мэдээлэл сэтгүүл 2004.05.04 №7

² Эрх зүйн шинэтгэлийн түүхийн нэгэн бүлэг /илтгэл зөвлөмжүүдийн эхтгэл/ 2003 он “Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн зарим асуудал 132 дахь тал А.Доржготов

БАРЬЦААНЫ ЭРХ-ЭДИЙН ЭРХ БОЛОХ ТУХАЙ АСУУДАЛД

ТЕГ-ын Дээд сургуулийн эрх зүйн тэнхимийн багш,
дэд профессор Д.БАТ-ӨЛЗИЙ

Иргэний болон худалдааны эрх зүй дэх хамгийн эртний институтын нэг болох барьцааны эрх нь гол төлөв зээлийн хэрэгсэл болж төрөл бүрийн гүйлгээний харилцаанд хэрэглэгддэг зах зээлийн эдийн засгийн харилцаанд чухал ач холбогдолтой эдийн засаг-эрх зүйн хэрэгсэл юм.

Түүний анхны хэлбэр фидуциэр эд хөрөнгийн өмчлөх эрхийг өмчлөгчид ямар нэг хариу нэхэмжлэл гаргах эрх олголгүйгээр үүрэг гүйцэт-гүүлэгч өөртөө шилжүүлэн авч байснаараа үүрэг гүйцэтгэгчийг туйлын ашиггүй байдалд оруулж байсан тул хожим түүний энэхүү дутагдалтай тал нь эд хөрөнгийг үүрэг гүйцэтгэж дуусах хүртэл үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд саатуулан барих эрхтэйгээр шилжүүлэх замаар үүргийн гүйцэтгэлийг хангадаг барьцааны эрхийг бий болгоход хүргэжээ.

Барьцаалагчид барьцааны зүйлийг захиран зарцуулах эрх, сүүлд түүнийг эдийн эрхэд тооцох болсон үеэс олгогдсон бөгөөд чухам энэ үеэс барьцаалагчийн үндсэн эрх нь үүрэг гүйцэтгэгч үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд барьцаалсан эд хөрөнгийг

худалдан борлуулах эрх /ius distrahendi/ байсаар ирсэн юм.

Эдийн засгийн гүйлгээний хөгжил нь үүрэг гүйцэтгэгч барьцааны зүйлийг эзэмших, ашиглах эрхтэй байхад хүргэсэн бөгөөд энэ нь ялангуяа зээлдэгч зээлийн хөрөнгийг тухайн эд хөрөнгийнхөө ашигдалтыг нэмэгдүүлэхэд ихэвчлэн зориулдаг үл хөдлөх хөрөнгийн барьцаанд илүү хамааралтай байв. Учир нь үл хөдлөх хөрөнгө барьцаалагчийн ашиг сонирхол нь барьцааны зүйлийг өөрийн эзэмшилд авахаасаа илүүтэйгээр уг зүйлээс үүргийг гүйцэтгүүлэх шаардах эрхийг олж авснаар хангагдах юм. Орчин үеийн эх газрын болон англо-америкийн эрх зүйд барьцааны эрхийн эртний хэлбэрүүдийн аль аль нь байгаа бөгөөд тэдгээрийн онцлогийг таньж мэдэх нь Монгол Улсын иргэний эрх зүй дэх барьцааны эрхийн мөн чанар, агуулга, түүнчлэн үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах журмын талаарх хэм хэмжээг зөв тайлбарлан, хэрэглэхэд дөхөм болох билээ.

Монгол Улсын шинэ Иргэний хуульд урьд нь зөвхөн үүргийн гүйцэтгэлийг хангах аргад тооцогдож байсан уг институтыг эдийн ба эдийн бус эрхэд хамааруулж, түүний нэг төрөл болохынх нь хувьд тусгаж өгсөн нь эх газрын эрх зүй болон иргэний гүйлгээний өнөөгийн шаардлагад нийцсэн чухал зохицуулалт болсон билээ. Гэвч манай судлаачид барьцааг үүргийн гүйцэтгэлийг хангах арга болох талаас нь илүүтэй авч үзсээр байна.¹

Барьцаа нь үүргийн гүйцэтгэлийг хангах нэг арга мөн боловч түүнийг юуны өмнө эдийн ба эдийн бус баялгийн эрхийн нэг төрөл болохынх нь хувьд авч үзэх нь зүйтэй юм. Хууль тогтоомжийн тогтолцоо болон түүгээр зохицуулагдаж байгаа харилцааны шаардлага ч ийм байгаа билээ. Судлаач Н.Баярмаа нь Вишиневский.А.А. зэрэг эрдэмтдийн хийсэн "Барьцаа нь бусад үүргийн гүйцэтгэлийг хангах аргатай харьцуулбал эд юмсын эрхэд үндэслэх шинжтэйгээрээ онцлог бөгөөд өөрөөр хэлбэл барьцааны үед үүрэг гүйцэтгүүлэгчид үүрэг гүйцэтгэгч болох этгээдэд итгэх итгэлээс эд юмсад итгэх итгэл илүүтэй байдаг² гэсэн дүгнэлтийн учир шалтгааныг эрэлхийлж улмаар барьцааны зүйлийг өмчлөх эрх бусдад шилжсэн тохиолдолд барьцааны эрх хэвээр

¹ Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт. УБ. 2004. 75 дахь тал

Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт. УБ. 2004. 59 дахь тал

² "Вишиневский А.А. Залоговое право 1995 М. с. 3

хадгалагдаж үлддэг онцлог нь түүгээр хангагдаж байгаа үндсэн үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгэгч тодорхой этгээд бус харин барьцааны зүйл хангаж байх ба үүрэг гүйцэтгэгч нь үүргийн гүйцэтгэлийг хангах бусад аргын үүрэг гүйцэтгэгчтэй харьцуулбал ач холбогдлоор бага юм гэсэн дүгнэлтийг хийсэн байна.¹

Барьцааны эрх зүйн хэм хэмжээнүүдийн агуулгаас үзэхэд барьцааны эрх нь эрх бүхий этгээдийн ашиг сонирхлыг үүрэг хүлээгч өөрийн тодорхой үйлдлээр хангадаг үүргийн эрхэд бус харин барьцаалагч тодорхой эд хөрөнгөтэй харьцах замаар буюу түүнийг худалдан борлуулснаар ашиг сонирхлоо хангадаг эдийн эрхэд илүүтэй хамаарах болох нь харагдана. Тиймээс ч барьцаалагчийн шаардлага нь үүрэг гүйцэтгэгчийн эсрэг чиглэгдэхээсээ илүүтэй барьцааны зүйлд буюу түүнийг худалдан борлуулах эрхээ хэрэгжүүлэхэд чиглэгддэг онцлогтой. Энэ утгаараа барьцааны эрхийн мөн чанар нь үүрэг гүйцэтгэгч барьцаагаар хангагдсан үүргийг хууль буюу гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол барьцаалагч үүрэг гүйцэтгүүлэгч нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд барьцаалсан эд хөрөнгийн үнээс хохирлоо арилгуулах боломж олж авдагт оршино гэж үзэх нь зүйтэй.

Энэ утгаар нь барьцаа бол бусдын эд юмс дахь эрх юм гэж эрдэмтэд үзсээр ирсэн² бөгөөд эдийн бусад эрхүүдээс ялгаатай нь барьцааны эрх нь үүргийн эрх зүйн харилцаанаас салгаж үл болох эрх болохыг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн эдийн бусад эрхүүдийн агуулга нь эд хөрөнгийг ямар нэг хэмжээгээр ашиглах эрхээр тодорхойлогдож байдаг бол барьцааны эрх нь барьцаалагчид барьцааны зүйл болох хөрөнгийг эзэмших болон ашиглах эрхийн аль алиныг нь шууд олгодоггүй байна /зарим орны эрх зүйд хөдлөх хөрөнгийг барьцаалагчид шилжүүлснээр уг эрх үүсдэг байна/. Гэвч барьцааны эрх нь эрх бүхий этгээдэд эдийн бусад эрхүүдтэй харьцуулшгүй илүү өргөн эрх болох өмчлөгчийг өмчлөх эрхээс нь салгахад хүргэх эрх олгодог юм.³

Барьцааны гэрээний нэг тал болох барьцаалагч нь үндсэн гэрээний үүргээ хангуулах зорилгоор тодорхой хөрөнгийг барьцаанд авах, нөгөө тал болох барьцаалуулагч нь гэрээний үүргээ биелүүлэх нотолгоо болгон хөрөнгөө барьцаалах, үндсэн үүргээ биелүүлсний дараа буцаан авах эрх бүхий хэлцэл юм⁴ гэж зарим зохиогч үзсэнтэй санал бүрэн нийлэхгүй байгаа бөгөөд энэ нь барьцааны эрхийн анхны хэлбэрт илүү хамааралтай юм. Харин барьцааны эрх үүсэх, дуусгавар болох ба үүнтэй

холбоотойгоор барьцааны зүйл болох хөрөнгө барьцаалагчийн эзэмшилд шилжих, эсхүл барьцаалуулагчийн эзэмшилдээ үлдэх, түүнчлэн түүнийг барьцаанаас чөлөөлүүлэх тухай ойлголтуудыг авч үзэх нь арга зүйн хувьд зөв байх болно.

Барьцааны эрх зүйн харилцаа үүссэнээр барьцааны зүйлийг барьцаалагчид шилжүүлж, мөн барьцаалуулагчийн эзэмшилд үлдээж болох юм. Учир нь барьцааны агуулга нь захиран зарцуулах эрхээр тодорхойлогдож байгаа болохыг дурьдсан билээ. Барьцааны зүйлийг барьцаа баригчид шилжүүлсэн тохиолдолд барьцаалуулагчид барьцааны зүйлийг захиран зарцуулах эрх хязгаарлагдмал байх боловч барьцаалагчийн зөвшөөрлөөр түүнийг худалдах, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлэх эрх эдлэх ба энэ тохиолдолд барьцааны эрх хүчин төгөлдөр хэвээр байхаар байгаа нь түүнийг эд юмсаа дагалдах шинжтэй эдийн эрхийн нэгэн төрөл болохыг нь илтгэж байна.

Ийнхүү барьцааны эрхийн ойлголтыг эдийн эрх болохынх нь хувьд дээрх байдлаар тодорхойлж авч үзэхийн зэрэгцээ ипотекийн шаардлагыг хангах журмын талаарх зарим хэм хэмжээг зөв тайлбарлан хэрэглэх шаардлагатай байгаа юм. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн барьцааны зүйлээс үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах эрх үүсэх зарим, тодруулбал нь Иргэний хуулийн 169.1-д заасан үүрэг гүйцэтгэгч үүргийг гүйцэтгэх эрхтэй болсон гэсэн нөхцөл

¹ Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт. УБ. 2004. 78 дахь тал

² М. Н. Брагинский, В. В. Витрянский. Договорное право. М. 1998. с. 396.

³ Щершеневич, Г. Ф. Курс торгового права. 1908. с. 240. /Договорное право М. 1993./

⁴ Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт. УБ. 2004. 60 дахь тал

үндэслэлтэй эсэх талаар зарим зохиогч тэмдэглээд “үүрэг” нь түүнийг заавал биелүүлэх, гүйцэтгэх ёстой гэсэн утга агуулгыг илэрхийлдэг бөгөөд үүрэг гүйцэтгэгч этгээдийн хувьд “эрх” нь үүрэг гэсэн уг агуулгатай зөрчилдөн эдгээр ухагдахуунуудыг ялгаагүй мэт болгох билээ гээд энэ нь ипотекийн шаардлагыг хангах үеийг тодорхойлох нөхцөл хэрхэн болох талаар эргэлзсэн байна.¹

Үүнээс иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын субъектив эрх нь үүрэг болох тохиолдол байж болохоос үүрэг нь шууд агуулгаараа эрх болж хувирах нь үгүй юм. Гэхдээ дээрх тохиолдолд үүрэг гүйцэтгэгч нь хууль, гэрээнд заасан хугацаа болохоос өмнө үүргийг гүйцэтгэх эрхгүй байх журамтай хууль тогтоогч тухайн нөхцлийг холбож үзсэн гэж үзэхээр байна. Мөн үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөр дээрх хугацаанаас өмнө үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгэх эрх олж авдаг билээ.

Мөн тэрчлэн ипотекийн шаардлага хангах үндсэн арга болох үл хөдлөх эд хөрөнгийг албадан худалдах шийдвэрийг барьцааны зүйлийг худалдан борлуулах шаардлагыг үүрэг гүйцэтгэгч /барьцааны эрхийн/ гүйцэтгээгүй тохиолдолд шүүх үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг үндэслэн гаргах журмын талаар Н.Баярмаа “үл хөдлөх эд хөрөнгийг гагцхүү шүүхийн шийдвэрээр худалдана гэсэн үзэл баримтлалаар боловсруулагдсан ипотекийн

зохицуулалтын хувьд ийнхүү худалдах шаардлагыг үүрэг гүйцэтгэгчид тавих нь дээрх үзэл баримтлалд эргэлзээ төрүүлж байгаа юм”² гэж үзжээ.

Эрх бүхий этгээд аливаа субъектив эрхийн шаардлагыг үүрэг хүлээсэн этгээдэд гаргах нь эрх зүйн харилцааны нийтлэг журам гэдэг талаас нь авч үзвэл дээрх зохицуулалтад эргэлзэх шаардлагагүй бөгөөд барьцаалагчийн шаардлагын дагуу үүрэг гүйцэтгэгч барьцааны зүйлийг худалдан борлуулах үүргээ өөрийн хүсэл зоригийн дагуу гүйцэтгэх нь эрх бүхий этгээдийн эрх, ашиг сонирхолд бүрэн нийцнэ. Хууль тогтоогч энэ талаас нь ч хандсан бизээ.

Гэтэл бодит амьдрал дээр үүрэг гүйцэтгүүлэгч ипотекийн зүйлийг худалдан борлуулах шаардлагыг барьцаалуулагчид тэр бүр гаргадаггүй, нөгөө талаар үүрэг гүйцэтгэгч нь нь шаардлагыг биелүлдэггүйтэй холбоотойгоор ипотекийн зүйлийг гагцхүү шүүхийн журмаар худалдан борлуулах журамтай гэсэн өрөөсгөл ойлголт бий болсон гэж үзэхээр байна. Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүргийг албадлагын журмаар гүйцэтгүүлдэг эрх зүйн нийтлэг журмаас гадуур зохицуулалт үүнд байхгүй болох нь хууль тогтоомжийн агуулгаас харагдаж байгаа бөгөөд гагцхүү худалдан борлуулах хэлбэрийг нь хуульчилж өгчээ.

Харин хөдлөх хөрөнгийн, түүний дотор барьцаалан зээл олгох гэрээний хувьд барьцаалагч шүүхийн шийдвэр, нөгөө талын зөвшөөрөлгүйгээр барьцааны зүйлийг худалдан борлуулах эрхээ өөрөө албадан хэрэгжүүлэх журам тогтоосон нь эртний иргэний эрх зүйн фидуцийн эрхтэй төсөөтэй зохицуулалт юм. Иймд эдгээр зохицуулалтын ялгаатай болон ижил талуудыг барьцааны эрхийн хүрээнд зөв тайлбарлах нь тухайн эрхийн агуулга, мөн чанарыг зөв тодорхойлох ач холбогдолтой билээ. Одоогоор онол, судлагааны болон эрх зүйн практик хэрэглээний түвшинд ч энэ талаар буруу ойлголт тогтох хандлага ажиглагдаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Эцэст нь банкны зээлийн барьцааны практикт Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх үед хэм хэмжээний зөрчилдөөн байгаа эсэх талаар авч үзье. Судлаач Н.Баярмаа энэ талаар дараах үндэслэлүүдийг гаргаж тавьсан байна. Үүнд, “Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 2-ыг анхааралтай уншвал банк зээлийн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс захиран зарцуулах эрхтэй байхаар заажээ. Учир нь тэнд барьцааны зүйлийг “худалдах эрхтэй” гэсэн бус харин “захиран зарцуулах эрхтэй” гэж заасан.

Гэтэл 174-ын 2-ын дагуу үл хөдлөх эд хөрөнгө “худалдах” тохиолдолд л мөн хуулийн 175-180 дугаар зүйл нь нарийвчилсан зохицуулалт байж түүнийг баримтлах ёстой

¹ Н.Баярмаа. Ипотек, түүний шаардлагыг хангах арга. /Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт. 78 дахь тал.

² Иргэний хууль. Шинэлэг зохицуулалт. УБ. 2004. 79 дэх тал

болох юм. Өөрөөр хэлбэл, банк үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулахдаа “худалдах”-аас өөр хэлбэрийг сонговол дээрх нарийвчилсан зохицуулалт нь үйлчлэх боломжгүй болох юм. Хоёрдугаарт, үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд үл хөдлөх эд хөрөнгийг худалдах харилцааны нарийвчилсан зохицуулалт нь болж буй Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 174 дүгээр зүйлд заасны дагуу шаардлага гаргасан боловч үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүү-лэгчийн хүсэлтийг үндэслэн ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан хураана” гэсэн тодотгол нь мөн л үл ойлголцлыг үүсгэх нэг хүчин зүйл болох юм. Өөрөөр хэлбэл 453 дугаар зүйлийн 2-нь ийнхүү “хуульд өөрөөр заасан” явдал бөгөөд ийм учраас банк барьцааны хөрөнгийг захиран зарцуулахдаа 175 дугаар зүйлийг баримтлахгүй байж болох юм гэсэн ойлголтыг төрүүлж байгаа юм.

Гэвч Иргэний шинэ хуулийн үзэл баримтлалын үүднээс авч үзвэл үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа буюу ипотекийн харилцаанд Иргэний хуулийн 165-181 дүгээр зүйлийг баримтлах нь зүйтэй бөгөөд уг зохицуулалт нь ипотекийн хувьд бүхэлдээ нарийвчилсан эрх зүйн зохицуулалт юм.”¹ гэжээ.

Иргэний хуулийн 453.2 нь барьцааны зүйлийг худалдах харилцааг зохицуулаагүй тул уг хэм хэмжээ нь мөн хуулийн 174.2-т заасан үл хөдлөх хөрөнгийн барьцааны зүйлийг худалдахад иргэний хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан гэж үзэх заалттай бүрэн зөрчилдөөгүй байгаа нь үнэн юм. Үүний дээр үл хөдлөх хөрөнгийн барьцааны зүйлийг худалдах талаарх иргэний хуульд заасан нийтлэг журам нь шүүхийн шийдвэрээр албадан дуудлага худалдаа явуулах, худалдах өөр хэлбэр гэсэн хэлбэрүүдтэй байгаа бол мөн хуулийн 453.2-оор банкны зээлийн гэрээний барьцааны зүйлийг шүүхийн шийдвэргүйгээр захиран зарцуулах боломжийг зээлдүүлэгчид олгосон байгаагаас үзвэл эдгээр нь өөр өөр харилцааны эрх зүйн зохицуулалт болох нь харагдаж байна.

Нөгөө талаар хэдийгээр Иргэний хуулийн 171.3-т заасан үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг бүрэн буюу хэсэгчлэн хангаагүй бол барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх үүрэг гүйцэтгүүлэгч-барьцаалагчид шилжинэ гэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх заалттай банкны зээлийн барьцааны зүйлийн өмчлөх эрх зээлдүүлэгчид шилжиж болох талаарх мөн хуулийн 453.2-ын заалт зөрчилдөж байгаа мэт харагдаж байгаа боловч сүүлдний хэм хэмжээ нь тусгай буюу нарийвчилсан зохицуулалт болох тул

нийтлэг болон тусгай хэм хэмжээнүүд хоорондоо зөрчилдөн өрсөлдөх тохиолдолд тусгай зохицуулалтын хэм хэмжээг баримтлах зарчмын үүднээс Иргэний хуулийн 453.2-т заасан хэм хэмжээг мөн хуулийн ерөнхий ангид заасан хэм хэмжээтэй зөрчилдөөгүй гэж үзэх үндэслэлтэй юм.

Нөгөө талаар Иргэний хуулийн 171.3 ба 453.2-д заасан журмын аль нь эрх зүйн нийтлэг зарчимд илүү нийцсэн хэм хэмжээ болохыг харгалзан үзэх учиртай бөгөөд тодорхой нөхцөл бүрдсэн тохиолдолд эрх, үүргийг шүүхийн шийдвэргүйгээр албадан хэрэгжүүлэхийг талууд зөвшөөрч гэрээнд тусгаж байгаа нь эрх зүйн харилцаанд оролцогч нь эрх, үүргийг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлэх зарчимтай нийцэж байгаа болно. Гагцхүү барьцааны эрхийн талаарх хэм хэмжээг зөв оновчтой тайлбарлах нь шүүхийн нэгдмэл практик тогтох, түүнчлэн хууль тогтоомжийн болон эрх зүйн номлолын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход зохих нөлөө үзүүлэх ач холбогдолтой билээ.

★ ★ ★

¹ Н.Баярмаа.Ипотек, түүний шаардлагыг хангах арга, Иргэний хууль.Шинэлэг зохицуулалт.УБ.2004.81дах тал/

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭС ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХЭМЖЭЭ ХЯЗГААР



МҮИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант **Д.ХУЯГ**

Давж заалдах шатны шүүх иргэний хэргийг хянах хэмжээ хязгаар гэдэгт уг шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хянаж байгаа цар хүрээг хэлэх ба давж заалдах шатны шүүх хэргийг "бүхэлд нь" буюу эсвэл "давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хянадаг" үзэл баримтлал байдаг байна. 2002 онд батлагдсан ИХШХШ тухай хуулийн 161дүгээр зүйлийн 3-т "Зохигч талын нэг нь давж заалдах, эсрэг тал нь хяналтын журмаар гомдол гаргасан бол давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хэргийг бүхэлд нь хянана." Мөн хуулийн 166.4-д "Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ "гэж тус тус заажээ.

Би урьд нь бичсэн өгүүлэлдээ¹ дээрх 166 дугаар зүйлд дурдсан "хэргийг бүхэлд нь хянах" гэдэг нэр томъёог анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны болсон /эрх зүйн үндэслэл талаас нь/, ба шийдвэр үндэслэлтэй болсон /маргааны үйл баримтын/ эсэх талаас нь хянах гэдэг утгаар нь авч үзсэн билээ. Тэгээд ч миний энэ байр суурь Дээд шүүхийн 2002 оны 263 дугаар тогтоолын /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол улсын хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай/ заалттай агуулга нэг байгаа ба уг тогтоолын 24дүгээр заалтад "хуулийн 161.3 заалтын ... "хэргийг бүхэлд нь хянана" гэдэг нь зохигч талын нэг нь давж заалдсан, мэтгэлцэж байгаа нөгөө тал нь хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд давж заалдах журмаар хянан шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ уг хэргийн нотлох баримт хийгээд үйл баримт, түүнд үнэлэлт дүгнэлт өгсөн байдал, шүүхийн шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг бүхэлд нь хянан шийдвэрлэхийг хэлнэ"² гэжээ. Ингэж шүүхийн шийдвэрийг "бүхэлд нь хянана" гэдгийг шүүхийн шийдвэрийг хууль ёсны ба үндэслэлтэй болсон

эсэхийг хянахын зэрэгцээ гомдолд дурдсан үндэслэлээс гадна гомдол гаргаагүй хэргийн оролцогчийн хувьд хянана гэж ойлгож болно.

Гэтэл хэргийг хянах энэ үзэл баримтлал нь диспозитив³ ба мэтгэлцэх зарчимтай зөрчилдөж, зах зээлийн эдийн засгийн харилцаа, зүй тогтол, өмчлөгчдийн чөлөөт сэтгэлгээ, бүрэн эрхт байдал, үйл ажиллагаатай зарим талаар нийцэхгүй байна гэж үзэж байна. Тухайлбал давж заалдах шатаар "иргэний хэргийг бүхэлд нь хянана" гэдэг үзэл баримтлал нь давж заалдах шатны шүүх хэргийг хянахдаа социалист нийгмийн үед төрийн эрх ашгийг хамгаалахад голлон анхаарч, "хувийн шинжтэй харилцаа" буюу "хувийн ашиг сонирхолыг" хамгаалах асуудалд бага анхаардаг байсан явдалтай холбоотой гэж үзнэ. Энэ нь зөвхөн онолын шинжтэй асуудал байсан бөгөөд учир нь тэр үед хувийн өмч гэж байгаагүй, тухайн нийгмийн байгуулалд зөвхөн төрийн өмч голлох үүрэгтэй байсан учир "хувийн шинжтэй ашиг сонирхлоос" төрийн ашиг сонирхол нь ямагт дээгүүр тавигдаж давамгайл байдалтай байснаас давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлахгүйгээр төрийн ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор хэргийг бүхэлд нь хянадаг байсан гэж үзэж болно. Энэ нь давж заалдах шатны шүүх гомдол гаргагчийн

¹ Д.Хуяг, Иргэний хэргийг давж заалдах шатаар хянах ажиллагаа "Хууль дээдлэх ёс" 2004.№4. 28-32 дахь тал.

² Төрийн мэдээлэл. 2002.9-28. №36. /273/ 1175 дахь тал

³ "Диспозитив" зарчим гэдэг нь ИХШХШ эрх зүйл хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зохигчийн санаачилга буюу хүсэлтийг үндсэн дээр явагдана гэсэн агуулгыг илэрхийлдэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. /Ерөнхий анги/ УБ.2004.Ред. Т.Мөнхжаргал. 38-39 дэх тал.

гомдолдоо дурдсан хүсэлтэнд бага ач холбогдол өгч, гомдолд дурдаагүй зүйлийг авч хэлэлцэж, зарим талаар зохигчдод өөрт нь ашиггүй байдалд анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгоно гэсэн утгыг бас давхар агуулдаг байна.

Тэгээд ч доктор профессор Т.Мөнхжаргал хуучин социалист нийгмийн үеийн ба одоогийн зах зээлийн харилцааны онцлог шинжийг "Эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалт" номондоо ... 1960 оны Үндсэн хууль, 1963 оны Иргэний хуульд: өмчийн төрлийг социалист өмч, амины өмч гэж ялгана.

Социалист өмч нь:

Улсын өмч /бүх ард түмний хөрөнгө/, Хоршооллын өмч /Хөдөө аж ахуй, нэгдэл, хоршооллын бусад байгууллагын өмч/, Үйлдвэрчний эвлэл, олон нийтийн бусад байгууллагын өмчөөс бүрдэнэ. Иргэдийн амины өмчид тэдгээрийн материалын ба оюуны хэрэгцээнд зориулагдсан эд хөрөнгө байж болно. Иргэн бүхэн аминыхаа өмчид хөдөлмөрийн орлого, хуримтлал, орон сууц, мал, амины туслах аж ахуй, хэрэгцээний зүйл, гэрийн эд хогшилтой байна гэж хуульчилж байв. 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжиж, өмчийн харилцаа, өмчлөгчдийн чөлөөт сэтгэлгээ, үйл ажиллагаанд цоо шинэ чанарын өөрчлөлт орсон нөхцөлд урьд социалист системийн аж ахуй, үйлдвэрлэлийн хэрэгслэлийг өмчлөх социалист өмч Монголын эдийн засгийг тодорхойлж байсан бол 1992 оны Үндсэн хуульд: Монгол улс

дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчдийн эрхийг хуулиар хамгаална гэж хуульчилсан¹ гэжээ.

Энэхүү хэргийг бүхэлд нь хянадаг явдлыг Оросын эрдэмтэн В.К.Пучинский ямар ч иргэний хэргийг шийдвэрлэх явцад бодит үнэнийг тогтоох явдал байдаг гэдэгтэй холбон авч үзсэн байна².

Гэтэл барууны ихэнх оронд давж заалдах шатаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд³ эртний Ромд үйлчилж байсан латинаар "tantum devolutum quantum appellatum", оросоор "сколько жалобы столько решения" гэсэн нэр томъёо буюу зарчим үйлчилдэг ба үүнийг утгачлан орчуулбал "гомдолд үндэслэн хэргийг хянана" гэсэн дээрх орнуудын иргэний хэргийг хянах ажиллагаанд энэ үзэл баримтлалыг удирдлага болгодог байна. Энэ үзэл баримтлалын дагуу гадаад орнуудын иргэний байцаан шийтгэх хууль тогтоомж нь давж заалдах /айлтган заалдах/ шатны шүүхүүдийн хэрэг хянах эрх хэмжээг зөвхөн давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хэргийг хянана гэж зааж, энэ тухай тэдгээр улсуудын ИБШ хуулинд тусгасан байдаг

Жишээ нь: Австрийн ИБШ хуулийн 462 дугаар зүйл, Словак улсын ИБШ хуулийн 212 дугаар зүйл, Францын ИБШ хуулийн 562 дугаар зүйл.

Эстонийн ИБШ хуулийн 301 дүгээр зүйл, Литов улсын ИБШ хуулийн 332 дугаар зүйл, ХБНГУ-ын ИБШ хуулийн 525, 521, 536 дугаар зүйлүүдэд дээрх үндэслэлээр хэргийг хянахаар дурджээ. ХБНГУ-ын ИБШ хуулийн 525 дугаар зүйлд "Айлтган заалдах шатны шүүх хэргийг талуудын хүсэлт гаргасан хүрээнд хянаж үзнэ", 536 дугаар зүйлд "Анхан шатны шүүхийн шийдвэрт зөвхөн гомдолд дурдсан үндэслэлийн хүрээнд өөрчлөлт оруулна" гэж заасан. Дээр дурдсан улсуудад хэргийг давж заалдах шатаар хянах ажиллагаа нь давж заалдах шатны шүүх хэргийг зөвхөн давж заалдах гомдол гаргасан этгээд ба түүнд гаргасан тайлбарын хүрээнд хэргийг хянах асуудлыг анхаарна гэсэн утгыг агуулдаг байна. Үүнийг жишээ болгон үзүүлбэл:

Сүхбаатар дүүргийн шүүхэд нэхэмжлэгч Дугар хариуцагч Галтад зээлдүүлсэн 300000 төгрөгөө буцаан авахаар нэхэмжлэл гаргасанд шүүх хариуцагчаас 200000 төгрөг гаргуулахаар болж, үлдэх 100000 төгрөгийг хэрэгсэхгүй болгожээ.

Нэхэмжлэгч Дугар Сүхбаатар дүүргийн шүүхээс хэрэгсэхгүй болгосон 100000 төгрөгөө гаргуулахаар нийслэлийн шүүхэд гомдол гаргасан бол нийслэлийн шүүх зөвхөн дээрх 100000 төгрөгийг нэмж гаргуулах эсэхийг хянаж үзэх ёстой /хариуцагч гомдолд ямар нэг тайлбар гаргаагүй тохиолдолд/ болохоос биш, урьд нь Сүхбаатар дүүргийн шүүх 200000 төгрөг гаргуулахаар заасан асуудал нь давж заалдах шатны шүүхийн хянаж үзэх асуудал биш байна. Хариуцагч Галт давж заалдах гомдолд гаргасан хариу тайлбартаа нэмж 100000 төгрөг

¹ Т.Мөнхжаргал, "Эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалт" 56 дэх тал.

² В.К.Пучинский, Кассационное производство в Советском гражданском процессе. М. 1973.с.11.

³ Эгээр улсын хэрэг хянах ажиллагаа нь манай давж заалдах шаттай төсөөтэй апелляция буюу айлтган заалдах шат юм.

гаргуулахаар болсныг зөвшөөрөхгүй гээд Сүхбаатар дүүргийн шүүхийн шийдвэрээр төлөх болсон 200000 төгрөгийн талаар юу ч дурдаагүй бол нийслэлийн шүүх зөвхөн 100000 төгрөгийг хариуцагч Галтаас нэмж гаргуулах нь үндэслэлтэй эсэхийг хянаж үзэх ёстой байна. Мөн хэрэг хянах дээрх үзэл баримтлалтай холбогдуулж ОХУ-ын ИВШ хуулийг харьцуулан судлаж үзвэл 1964 онд батлагдсан Иргэний байцаан шийтгэх хуулинд хэргийг давж заалдах шатаар бүхэлд нь хянахаар заасан байсан бол 2002-11-14-нд батлагдсан Иргэний байцаан шийтгэх хууль¹ -ийн 347-р зүйлийн (Давж заалдах шатны шүүх хэргийг хянах хязгаар)

1. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль ёсны ба үндэслэлтэй эсэхийг хянахдаа давж заалдах гомдол ба татгалзалд дурдсан учир байдлыг үндэслэн хэргийг хянана.

2. Давж заалдах шатны шүүх нь хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хянах эрхтэй гэж заажээ. Энэ нь давж заалдах шатны шүүхүүд давж заалдах гомдолд дурдагдаагүй боловч материаллаг ба процессийн хуулийн заалтуудыг зөв хэрэглэсэн эсэхийг хянах тухай заалт ба тухайлбал: Хэргийн ба шүүхийн харьяалал зөв эсэх, төлөөлөгчийн итгэмжлэл хуулийн шаардлага хангасан эсэх, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг төлөөгүй буюу дутуу төлсөн эсэх, хуваагдахгүй эд хөрөнгөтэй холбогдсон маргааны хамтран хариуцагчдад хариуцлага хүлээлгэх тухай, хэргийг шийдвэрлэсэн шүүх бүрэл-дэхүүн хуулийн заалтад

нийцэж байгаа эсэх зэрэг асуудлыг хамаарна. Жишээ нь:

Баянзүрх дүүргийн шүүхийн 2002-11-12 өдрийн 392-А дугаартай шийдвэртэй хэргийг /нэхэмжлэгч нь Франц улсын иргэн Жак Болэг төлөөлж өмгөөлөгч Д.Дашцэдэн, хариуцагч нь "Говийн өглөө" ХХК/ хариуцагчийн өмгөөлөгчийн давж заалдах гомдлоор нийслэлийн шүүхийн 2002-12-18-ны 1024-р магадлал гаргаж, хариуцагчийн өмгөөлөгчийн давж заалдах гомдолд дурдаагүй "нэхэмжлэгч Жак Болэгийн Д.Дашцэдэнд олгосон итгэмжлэлийн хугацаа" /хэргийн 11-р хуудас/ иргэний зүйлийн /1996 оны/ 63-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дууссан байгааг анхаарч тодруулаагүй байна гэж заагаад 392-А дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр мөн шүүхэд нь буцаажээ.

Чингэлтэй дүүргийн шүүхийн 2002-09-06 ны өдрийн 762 дугаар шийдвэртэй Б.Ватхүүгийн нэхэмжлэлтэй Зоос гоёл ХХК-д холбогдох хэргийг нийслэлийн шүүх хариуцагчийн давж заалдах гомдлоор хянаад 2002-10-21-ны өдрийн 380 дугаар магадлалдаа "Зоос гоёл ХК нь шүүхэд нэхэмжлэл гаргаагүй, улсын тэмдэгтийн хураамж бүрэн төлөөгүй байхад шүүх оюуны өмчийн газраас шилжүүлсэн материалаар хэрэг шийдвэрлэж ИХШХШ тухай хуулийн 61.1, 67.1 ыйдүгээр зүйлүүдийг зөрчсөн байна" гээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр мөн шүүхэд нь буцаажээ.

Мөн давж заалдах шатны шүүх хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс анхан шатны шүүхийн шийдвэрийг "бүхэлд

нь хянах" гэдгийг процессийн хуулийн хэм хэмжээг ноцтойгоор зөрчсөн, нийтийн буюу төр нийгмийн ашиг сонирхолыг хамгаалах шаардлага гарч байгаа тохиолдлыг ойлгоно.

Давж заалдах шатны шүүх "хувийн ашиг сонирхол" хөндөгдөж байгаа хэргийн хувьд давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хэргийг хянах ба энэ нь Иргэний процессийн эрх зүйн диспозитив зарчмын агуулгатай тохирч байна гэж үзэж байна. Давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянана гэдэг бол талуудын хувийн бүрэн эрхт байдалтай холбоотой ба давж заалдах шатны шүүх гомдлын хүрэнээс хэтэрч, өөрийн санаачлагаар маргалдаж байгаа талуудын шүүхэд хандаж хянуулахаар хүсэлт тавиагүй асуудлыг хөндөж, үүнийгээ үндэслэл болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгож байгаа нь мэтгэлзэх зарчимд харшилж байна гэж үзэх үндэстэй. Бидний урьд нь авч үзсэн "Давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хэргийг хянах тухай" үзэл баримтлал нь мөн латинаар "non reformatio in peius" гэсэн үзэл баримтлалтай салшгүй холбоотой ба энэ нэр томъёо нь оросоор "Запрет поворота к худшему" гэж орчуулагдах ба үүнийг утгачлан орчуулбал "Гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох" гэсэн үзэл баримтлал юм. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолын үзэл баримтлалаар дээд шатны шүүх гомдлоор хэргийг хянахдаа "шүүгдэгчийн хувийн байдлыг дордуулахыг хориглоно" гэсэн үзэл баримтлал байдаг ба энэ нь тухайн хэрэгт шийтгэх тогтоол гарсны дараа эрүүгийн хэргийг

шүүгдэгч, цагаатгагдсан этгээд ба тэдний өмгөөлөгчийн гомдлоор хянаж байгаа тохиолдолд давж заалдах шатны шүүх шүүгдэгчийн эрх зүйн /хувийн/ байдлыг дордуулахыг хориглоно гэсэн утгыг илэрхийлдэг гэж судлаач К.Ф. Гуценко¹ үзсэн байна. Судлаач С.Батдэлгэр монгол улсын ЭБШ хуулийн 321 дүгээр зүйлийг (Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх) тайлбарлахдаа:

“Давж заалдах шатны шүүхэд шүүгдэгчийг шийтгэсэн, эсхүл цагаатгасан хэргийн хэмжээний дотор хэргийг хянан шийдвэрлэнэ. Давж заалдах шатны шүүхээс ялыг өөрчлөсөн нь шүүгдэгчийн байдлыг дээрдүүлсэн бөгөөд түүний өмгөөлүүлэх эрхийг зөрчөөгүй байх ёстой. Давж заалдах шатны шүүх шүүгдэгчийн ялыг хүндрүүлэх, түүний эрх зүйн байдлыг дордуулах эрхгүй”² гэжээ. Үүнээс улбаалан иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйд “Давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглоно” гэдэгт давж заалдах шатны шүүх хэргийг хянахдаа гомдол гаргагчийн хувьд урьд нь анхан шатны шүүхээс гарсан шийдвэрийг өөрт нь ашигтай бус байдлаар өөрчлөхийг хориглох гэсэн үзэл баримтлалыг тухай яригдаж байгаа юм.

Оросын судлаач Н.И. Авдеенко давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, шинэ шийдвэр гаргахдаа давж заалдах гомдол гаргасан этгээдийн эрх зүйн байдлыг дордуулж болохгүй.

ингэвэл уг этгээдийн давж заалдах эрхээ хэрэгжүүлэх баталгааг зөрчсөн явдал болно³ гэж үзсэн бол түүний энэ үзэл бодлыг судлаач И.Юхо, С.Курылев, А.Т.Боннер⁴ нарын зэрэг эрдэмтэд дэмжиж энэ тухай өөрсдийн бүтээлдээ авч үзсэн байна.

Гэтэл Оросын судлаач зарим эрдэмтэд дээрхээс огт өөр саналтай байгаа ба В.К.Пучинский 1973 онд “Зөвлөлтийн иргэний байцаан шийтгэх эрх зүйд гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох тухай журам үйлчилдэггүй, тухайлбал нэхэмжлэгч давж заалдах шатанд гомдол гаргаж анхан шатны шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг нэмүүлэх тухай санал гаргахад давж заалдах шатны шүүх авах төлбөрийг нэмэгдүүлэхийн оронд бүрэн хэмжээгээр хэрэгсэхгүй болдох эрхтэй, учир нь энэ шатанд бодит үнэнийг тогтоох зарчим ямар ч хязгаарлалтгүйгээр бүрэн хэмжээгээр үйлчилдэг”⁵ гэж үзсэн ба түүний энэ үзэл бодлыг В.Г.Тихиня⁶, И.Н.Зайцев⁷ нарын зэрэг судлаач эрдэмтэд дэмжиж санал бодлоо илэрхийлжээ.

Дээрх И.В.Авдеенко, В.К.Пучинский нарын үзэл баримтлалыг гүнзгийрүүлэн судлан үзэх нь зүйтэй гэж үзнэ.

Монгол улсын шүүхээс 2000-2004 оныг дуустал анхан шатны шүүхээр шийдсэн ба давж заалдах шатны шүүхээр хянагдсан иргэний хэргийн тоо бүртгэлийн мэдээнээс үзвэл:

он	Нийт шийдсэн хэргийн тоо	Давж заалдсан хэргийн тоо		Хэвээр үлдсэн хэргийн тоо		Өөрчлөлт орсон хэргийн тоо		Хүчингүй болсон хэргийн тоо	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
2000	21717	2035	9.3%	990	48.6%	542	26.6%	503	24.7%
2001	23252	2144	9.2%	1120	52.2%	519	24.2%	505	23.5%
2002	24100	2038	8.4%	1070	52.5%	446	21.9%	522	25.6%
2003	23407	1539	6.5%	732	47.6%	400	26%	407	36.4%
2004	23290	1324	5.7%	562	42.4%	315	23.8%	447	33.8%

Энэ судалгаанаас үзэхэд давж заалдах шатаар хянагдсан анхан шатны шүүхийн шийдвэр өөрчлөгдөж хүчингүй болох явдал жил ирэх тутам өсөж байгаа нь анхан шатны шүүхийн шүүгчдийн хариуцлага, мэдлэг, чадварын түвшин, давж заалдах шатанд “хэргийг бүхэлд нь хянана” гэдэг ойлголт хэт ерөнхий утгаар ойлгогдож байгаатай холбоотой гэж үзнэ. Иймд давж заалдах шатаар иргэний хэргийг “бүхэлд нь хянадаг” үзэл баримтлыг өөрчилж “давж заалдах шатаар хэргийг гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлан хянадаг” үзэл баримтлалд шилжих, энэ талаар ИХШХШ тухай хуульд өөрчлөлт оруулах, мөн давж заалдах шүүх хэргийг хянахдаа давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх тухай үзэл баримтлалыг судлан үзэх нь ач холбогдолтой юм.



¹ Уголовный процесс. Под ред. К.Ф. Гуценко М., 1998 с. 404

² Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар Ж.Бямба нар УБ. 2003 он 460-461 дэх тал

³ Гражданский процесс. Под ред. Н.А.Чечина, Д.М.Чечот, М., 1968 с. 316

⁴ Законность и справедливость в правоприменительной деятельности А.Т.Боннер М., 1992 с. 73-74

⁵ В.К.Пучинский. Кассационное производство в Советском гражданском процессе. М.1973 с.12-13

⁶ Гражданский процесс БССР под ред. В.Г.Тихиня. Минск.1981.4-3. с. 101

⁷ И.М.Зайцев. Устранение судебных ошибок в гражданском процессе. Саратов. 1985.с.112.

ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА НЬ ЗАВСАРЛААГҮЙ ГЭЖ ҮЭСЭН БАЙНА

Японы шүүхийн шийдвэрийн "Цаг үе, мэдээлэл" сэтгүүлээс
(1996 оны 5 сарын дугаар)

Иргэний арбитрын хуулийн дагуу арбитрын тухай өргөдөл гаргах болон Иргэний хуулийн 151 дүгээр зүйлийн хөөн хэлэлцэх хугацаа завсарлах (зогсох) тухай

Нэг. Хэргийн товч агуулга

- 1 Нэхэмжлэгч (давж заалдуулагч) нь хариуцагч (давж заалдагч)-ийн ажилтнаар олон жил ажилласан байна. Хариуцагчийн удирдлагын эрх мэдлийн төлөө маргалдааны улмаас 1982 оны 1 сард удирдах ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд жирийн ажилтны хувьд авч байсан үндсэн цалинг нь хасч 1982 оны 4 сард үндсэн цалинг нь дахин бууруулсан байна.
- 2 Нэхэмжлэгч нь 1989 оны 2 сарын 22-нд тухайн мөнгийг төлүүлэх, цалинг бууруулахаас өмнө авч байсан үндсэн цалин нь 194000 иенээс дээш болохыг тогтоохыг шаардан арбитрын өргөдөл (цаашид уг хэргийн арбитражын өргөдөл гэнэ) гаргасан байна. 1989 оны 10 сарын 18-ны өдөр арбитрын хуралдаан болж тохиролцоонд хүрсэнгүй.
- 3 Нэхэмжлэгч 1989 оны 11 сарын 16-ны өдөр 1986 оны 1 сараас хойшхи хугацааны цалингийн зөрүүг төлөхийг шаардаж уг нэхэмжлэлийг гаргасан байна.

Хоёр. Нэхэмжлэгчийн үндсэн цалинг өөрчлөх тухай хариуцагчийн гаргасан шийдвэр нь хүчин төгөлдөр бус гэдэг нь тодорхой бөгөөд маргааны гол нь нэхэмжлэгчийн зөрүү цалинг олгохыг шаардсан шаардлагын хөөн хэлэлцэх хугацаа хэзээ дууссан бэ өөрөөр хэлбэл хэзээ хүртэлх цалингийн зөрүүг нэхэмжлэх эрх нь дуусгавар болсон бэ гэдэгт оршино.

Энэ маргааны хувьд урьдчилсан шүүхийн шийдвэр (Осака хотын дээд шүүхийн 1991 оны 12 сарын 25-ны өдрийн 786/195 тоот шийдвэр) нь арбитражаар тохиролцоонд хүрээгүй ч байсан түүнээс хойш 6 сарын дотор гомдол гаргаж арбитражын өргөдөлд дурьдсан эрхээ эдлэх бодол санаа нь хариуцагчид хүрсэн өдөр 1991 оны 2 сарын 22-ны өдөр цалингийн зөрүүг нэхэмжлэх эрхийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзжээ.

Хариуцагч нь урьдчилсан шүүхийн шийдвэрийн хуулийн тайлбар алдаатай гэж үзэн хяналтын шүүхэд давж заалдсан байна.

Гурав. Шүүхийн энэ шийдвэр нь иргэний арбитрын хуулийн дагуу гаргасан өргөдөл нь өөрийн эрхэд хамаарах маргааныг шүүхийн оролцоотойгоор шийдвэрлэж эрхээ тогтоолгох зорилготой байдаг тул иргэний хуулийн 151 дүгээр зүйлийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа завсарлах үндэслэл болж байна гэж тайлбарлах нь зохимжтой. Тохиролцоонд хүрээгүй өдрөөс хойш 1 сарын дотор гомдол гаргасан энэ хэргийн хувьд арбитрын өргөдөл гаргах үед цалингийн зөрүүг нэхэмжлэх эрхийн хөөн хэлэлцэх хугацаа завсарласан (зогссон) гэж үзсэн.

Дөрөв. Арбитрын өргөдөлд Иргэний хуулийн 151 дүгээр зүйлийг тохируулан хэрэглэхэд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэх нь хүчин төгөлдөр байх уу үгүй юу гэдэг тал дээр хуулинд өөрийн түр тохиролцооны өргөдлийн тухай дээрх зүйлийг тохируулан хэрэглэхийг зөвшөөрнө. Гэвч үүний дараа Иргэний арбитрын хууль гарч

түүний 19 дүгээр зүйлд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд 2 долоо хоногийн дотор гомдол гаргавал Иргэний хуулийн 151 дүгээр заалтыг тохируулан хэрэглэх арбитрын өргөдөлд хөөн хэлэлцэх хугацаа завсарласан нь хүчинтэй байхыг хүлээн зөвшөөрсөн, үгүйсгэсэн гэсэн хэсэгт хуваагджээ.

Энэ шүүхийн шийдвэр нь арбитрын өргөдөл боловч эвлэрлийн өргөдлийн адил төстэй байдлыг анхаарч тохируулан хэрэглэхийг зөвшөөрсөн хамгийн анхны дээд шүүхийн шийдвэр болно.

Уг шүүхийн шийдвэр нь Иргэний хуулийн 151 дүгээр зүйл болон Иргэний арбитрын 19 дүгээр зүйлийн харилцааны тухай нэгдүгээрт Иргэний арбитрын хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу арбитрын өргөдлийг давж заалдах үр дүн нь үгүйсгэгдэх (fiction) бол Иргэний хуулийн 147 дугаар зүйл, 149 дүгээр зүйлд үндэслэн хөөн хэлэлцэх хугацаа завсарлана, арбитрын өргөдөл нь эвлэрлийн өргөдөлтэй адил хүчин чадал, тодорхой эрхийг эдлэх хэлбэртэй учраас Иргэний хуулийн 147 дугаар зүйл, 151 дүгээр зүйлийн дагуу эвлэрлийн өргөдөлтэй адилхан хөөн хэлэлцэх хугацаа завсарлахыг хүлээн зөвшөөрнө гэсэн нь хуулийн логиктай зөрчилдөхгүй, хоёрдугаарт Иргэний арбитрын хуулийн 19 дүгээр зүйл нь арбитрын журмыг хэрэглэгчдийг хамгаалахыг зорилго болгосон зэргээс урьд хүлээн зөвшөөрөгдөд байсан арбитрын өргөдлийн хөөн хэлэлцэх хугацаа завсарлахыг үгүйсгэж арбитрын журмыг хэрэглэгчдэд сөргөөр нөлөөлөх болсон заалт гэж үзэхэд хэцүү, гуравдугаарт Иргэний хуулийн 151 дүгээр зүйлийн тохируулан хэрэглэхийг үгүйсгэх үзэл бодол нь Иргэний арбитрын хуулийн 19 дүгээр зүйлийг Иргэний хуулийн 151 дүгээр зүйлийн тусгай заалт гэж үзэх нь хууль тогтоох аргын хувьд ч ховор тохиолдол юм гэж хэлэх хэрэгтэй.

Тав. Шүүхийн энэ шийдвэр нь

Иргэний хуулийн 151 дүгээр зүйлийг тохируулан хэрэглэхийг зөвшөөрсөн тохиолдолд арбитрын өргөдөл гаргах үед хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болох нь завсарласан гэж үзсэн. Шүүхийн нэхэмжлэл гаргах тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа завсарлах тухайд бол шүүхийн шийдвэр, нийтлэг тайлбар нь шүүх ажиллагаа хоцорсны улмаас эрх бүхий этгээдийн хохирол учруулж болохгүй гэдгийг үндэслэл болгон гомдол гаргасан цагийг үндэс болгон хөөн хэлэлцэх хугацааг завсарлах нөхцөл үүснэ гэж тайлбарлаж байгаа бөгөөд Иргэний хуульд заасан эвлэрүүлэхийн тулд дуудах үеийн хөөн хэлэлцэх хугацааг завсарлах тухайд үүнтэй нэгэн адилаар тайлбарлаж байна.

Хэрэглэсэн хууль:

Иргэний хуулийн 147 дугаар зүйл, 151 дүгээр зүйл

Холбогдогчид:

Давж заалдах Киотогийн зар сурталчилгааны ХК

Хариуцагч:

Имаи

Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг

Давж заалдсаныг хэрэгсэхгүй болгох.

Давж заалдах зардлыг давж заалдагчаар гаргуулах

Үндэслэл

Давж заалдагчийн төлөөний этгээдийн гаргаж буй давж заалдах үндэслэлийн тухай

Иргэний арбитрын хуулинд үндэслэн арбитрын өргөдөл нь өөрийн эрхтэй холбоотой маргааныг шүүхээр шийдвэрлүүлж түүний эрхийг тогтоох тухайд

Шүүхийн эвлэрлийн өргөдөлтэй ялгарах зүйл байхгүй учраас арбитрын өргөдөлд Иргэний хуулийн 151 дүгээр зүйлийг тохируулан хэрэглэж хөөн хэлэлцэх хугацааг завсарлуулах үндэслэл болно гэж тайлбарлах нь зохимжтой. Тиймээс тохиролцоонд хүрээгүй бол арбитрын өргөдлийн үед хөөн хэлэлцэх хугацаа

завсарласныг хүчинтэй гэж үзнэ. Давж заалдах хэргийн хариуцагч нь 1989 оны 2 сарын 22-ны өдөр хариуцагчид давж заалдагчаас олгох ёстой үндсэн цалин сард 194000 иен байх ёстой гэдгийг тогтоохыг шаардахын хамт 194000 иен болон давж заалдагчийн төлсөн мөнгөний зөрүүг төлөхийг шаардаж Киото хотын шүүхэд арбитрын өргөдөл гаргасан байна.

Арбитраж нь тухайн оны 10 сарын 18-ны өдөр тохиролцоонд хүрэлгүй дууссан тул давж заалдах хэргийн хариуцагч нь 11 сарын 16-ны өдөр дээр дурдсан мөнгийг төлүүлэхээр гомдол гаргасан. Бодит байдалд үндэслэн цалингийн зөрүүг олгохыг шаардах эрх арбитрын өргөдөл гаргасан 1989 оны 2 сарын 22-ны өдөр хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж үзэх ёстой учраас 1987 оны 02 сарын хойшхи цалингийн зөрүүг олгохыг шаардах эрхийн хувьд хөөн хэлэлцэх хугацааг завсарласан гэсэн урьдчилсан шүүхийн шийдвэрийг зөв гэж үзэн хүлээн зөвшөөрч болно.

Давж заалдах бусад үндэслэл

Урьдчилсан шүүхийн дүгнэлтийг нотлох баримтад үндэслэн зөв гэж хүлээн зөвшөөрч болно. Гомдлыг хүлээж авах үндэслэл байхгүй. Иргэний гомдол шийдвэрлэх хуулийн 401 дүгээр зүйл, 95 дугаар зүйл, 8 дүгээр зүйлийн дагуу шүүгчид санал нэгтгэгийг дүгнэлтийн хэсгийн дагуу шийдвэрлэнэ.

Шүүгчид давж заалдагчийн төлөөний этгээдийн давж заалдах үндэслэл

Хуулийн тайлбарыг буруу хэрэглэсэн. Нэгд урьдчилсан шүүхийн шийдвэр нь эвлэрлийн өргөдөл, түүний эрхээ эдлэх бодол санаа нь хүрснээр шаардлага нь хүчин төгөлдөр болно. Шүүх үүнийг 1989 оны 2 сарын 22 гэж үзэж байгаа нь буруу учраас хөөн хэлэлцэх хугацааг завсарласан гэдэг нь хуулийг буруу хэрэглэснээс болсон алдаа.

Гомдол, арбитраж хөөн хэлэлцэх хугацааг завсарлах явдлыг хүчинтэй гэж үзэх тохиолдолд

гомдлын нийт хугацааны туршид хамаарах нь мэдээж бөгөөд шаардлагын үргэлжлэх хугацааг зэрэг ойлголтыг хэрэглэхийг хүлээн зөвшөөрөх нь буруу.

Өргөдлийн хуулбарыг илгээх асуудалд шаардлагын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа нь шаардлагад бодол санаагаа илэрхийлсэн байгаа учраас юм.

Энэ хэрэгт шаардлагын хуулбарыг илгээгээгүй байна. Хэрэгт өргөдлийн хуулбарыг илгээгээгүй байна. Өдөр болгон нэхэмжлэх явуулж эсвэл нэг сарын дотор төл гэж бичсэн шаардлагыг илгээгээд байвал энэ нь бас шаардлага үргэлжлээд байна гэсэн үг үү.

Урьдчилсан шүүхийн шийдвэрт ямар ч нотлоогүйгээр 1989 оны 2 сарын 22-нд бодол санаагаа хүргэсэн гэж байгаа нь бодит байдлыг буруугаар ойлгосон явдал болно. Нэг сарын зөрүү 672000 иен гэдэг нь тодорхой байгаа учраас шүүхийн шийдвэрт нөлөөлөх учраас урьдчилсан шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгох ёстой.

1989 оны 2 сарын 22-ны өдөр нь Арбитрын өргөдөл өгсөн өдөр бөгөөд тэр өдөрт нь өргөдөл гаргагчийн бодол санаа нөгөө этгээдэд хүрэх боломжгүй юм. Үнэн хэрэг дээрээ тухайн оны 03 сарын 01-ний өдөр зарлан дуудах хуудсыг /шаардлагын хуулбар бус/ шуудангаар явуулсан ба 7 хоногийн дотор хүрч прэзгүй. 1989 оны 2 сарын 22 нь Лхагва гариг байсан ба сарын эцэс хүртэлх 6 хоног дотор Бямба, Ням гариг байгааг бодолцвол 3 сар гарах нь тодорхой. Эхний хугацаа нь 1989 оны 3 сарын 27 байсан боловч давж заалдах нь очоогүй, дараагийн сарын 21-ны өдөр болж өөрчлөгдсөн боловч давж заалдах 1989 оны 6 дугаар сарын 9-ний өдөр л хүрэлцэн очсон. Тиймээс шаардлагад дурьдсан бодол санаа хүрсэн хугацаа гэвэл 6 сарын 9 юм.

★ ★ ★

ИРАКИЙН ДАЙН БА ОЛОН УЛСЫН НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ



ХЗҮТ-ийн олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Т.ЗАЯА

Том, жижиг бүх улсыг адилхан хамарч байгаа, дэлхий дахины шинжтэй асуудлын нэг бол олон улсын терроризмтэй тэмцэх явдал мөн. Террористуудаас 2001 оны 9 дүгээр сарын 11-нд АНУ-д үйлдсэн аймшигт халдлага нь терроризмын эсрэг хийх тэмцэл болон дэлхий нийтийн шинж чанартай, ноцтой асуудал гэдгийг харуулав. Энэ нь терроризмын эсрэг дэлхийн том, жижиг улс орнууд хамтран тэмцэх ёстой, энэ аюулыг зайлуулахад улс гүрэн бүр оролцох ёстой гэдгийг нотолсон билээ.

Иракийг террорист үйл ажиллагааг өөгшүүлэн дэмжигч гэж АНУ-ын удирдлага үзэж, НУБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоолуудын заалтуудыг нэг бүрчлэн биелүүлж, цөмийн болоод үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгээ устгах, олон улсын конвенцээр хориглосон цэрэг зэвсгийн бусад хөтөлбөрөө зогсоохгүй бол Садам Хуссейны дэглэмийг түлхэн унагаах үүднээс АНУ цэргийн хүч хэрэглэхээ мэдэгдэж өөрийн засаг захиргаанаас 2003 оны 3 дугаар

сарын 18-нд Садам Хуссейнд хандаж 48 цагийн дотор Иракийг орхиж явахыг тулган шаардсан хугацаа дууссанаар 3 дугаар сарын 20-ны өдөр АНУ-ын толгойлсон олон улсын эвслийн хүчин Иракийн эсрэг дайны ажиллагаагаа эхэлсэн. Тухайн үйл явдлаас хойш хоёр жил шахам өнгөрсний эцэст энэ оны 1 дүгээр сарын 30-нд Иракт Үндэсний Ассамблейн хүсэн хүлээж байсан сонгууль болж өнгөрсөн бөгөөд 2006 он гэхэд Иракийн шинэ засгийн газар үүрэгт ажилдаа орохоор төлөвлөж байна.


Иракт явуулсан АНУ-ын байдлааны ажиллагааны талаар судлаачид, улс төрчид өөр өөрийн байр сууринаас ханддаг. Тухайлбал:

зарим нэг нь АНУ-г олон улсын эрх зүй дэх дотоод хэрэгт үл оролцох, улс гүрний бүрэн эрхийн, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй байх, хүч үл хэрэглэх, хүчээр заналхийлэх болон маргааныг эв зүйгээр шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоогүй учир олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн цагаа олоогүй буруу дайн гэж үздэг. Жишээлбэл, өнгөрсөн онд болж өнгөрсөн АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан намаас нэр дэвшигчийн өгсөн арилцлагаас Аль-Каида, түүний толгойлогч Осам бин Ладен болон Садам Хусейны дэглэмийн хооронд ямар нэгэн холбоо байгаагүй, тэр ч байтугай тэр хоёр Америкийг үзэн яддагаасаа илүү бие биенээ үзэн яддаг

байсан гэх зүйл ажиглагдсан болно. Хэрэв тийм бол АНУ-д Ирак дахь дайны үйл ажиллагааг эхлүүлэх ямар нэгэн өөр шалтгаан байсан байх болох юм. Ирак бол нефтийн асар том баялагтай орны нэг. Хүн төрөлхтөн нефть гээч зүйлийг илрүүлснийхээ дараа дэлхийн хоёр том дайнд татагдан орж, дайнаас хойш ч нефтийн төлөө олон арван дайнууд болж өнгөрсөн байдаг. /Ж: Ирак өөрөө ч Ирантай 1980-аад онд 8 жил үргэлжилсэн 250 тэрбум долларын алдагдалтай дайныг хийж байсан түүхтэй. Үүний дараагаар мөн Кувейттэй дайтсан байдаг/ Хэрэв АНУ гагцхуу нефтийн ашиг сонирхолтой байсан бол олон улсын эрх зүйн зарчмуудыг зөрчсөн нь тодорхой болох юм. Үүнээс гадна олон улсын эрх зүйд дайны эрх зүй, дайтах эрх зүй гэсэн хоёр ойлголт бий. Дайны эрх зүй /ius in bello/ гэдэг нь зэвсэгт мөргөлдөөний үед баримтлавал зохих хэм хэмжээний нийлбэр цогц юм. Харин дайтах эрх зүй /ius belli/ нь ямар үед улс, үндэстний дайн хийх эрх хэзээ үүсэх вэ гэдгийг тодорхойлсон байдаг. Дайны эрх зүйгээр зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талуудын хүч хэрэгсэл, байдлааны ажиллагаа явуулах нөхцөл зэргийг мөн зохицуулдаг. Тухайн эрх зүйг "дайны хууль" гэж нэрлэдэг бөгөөд "олон улсын зэвсэгт мөргөлдөөний эрх зүй", "хүмүүнлэгийн эрх зүй" гэсэн

хоёр үндсэн ангид хуваагддаг.¹
/схем 1/ АНУ-гийн хувьд
тухайн "дайны хууль"-ийг

Схем 1



дагаж мөрдөж байгаа нь зарим хүмүүсийн хувьд эргэлзээ төрүүлдэг. Тухайлбал, сүүлийн үед мэдээллийн хэрэгслээр америкийн цэргийнхэ дайны оллоог-содтой ёс бус харьцсан тухай мэдээллийг тараах болсон. Тухайн мэдээлэл нь албан ёсоор нотлогдох бол АНУ олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээг мөн зөрчсөн болно. Ингэснээр олон улсын эрх зүйн хариуцлагын тухай ойлголт гарч ирнэ. ОУЭЗ-н хариуцлага үүсэх үндэслэлийн нэг бол үйлдэл хийсэн буюу хийгээгүй явдал нь олон улсын өмнө хүлээсэн үүргийг зөрчсөн байх явдал юм.² АНУ НҮБ-ын гишүүн улсынхаа хувьд НҮБ-ын дүрмээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй болно. Олон улсын эрх зүйн хариуцлагын олон хэлбэр, хариуцлагыг хүлээлгэх олон арга замууд байдаг.

өөр нэгэн судлаачид АНУ-г НҮБ-ын дүрмийн дагуу эдлэх "өөрийгөө хамгаалах эрх"-ээ хэрэгжүүлж байгаа явдал гэж

үздэг байна. Тухайлбал, Америкийн судлаач Уйтон үзэхдээ, "өөрийгөө хамгаалах эрх" бол төр улсын аливаа бүх эрхээс абсолют суурь эрх мөн гэжээ.

Ер нь аливаа улс өөрийгөө хамгаалах дархан эрхтэй байдаг ба олон улсын эрх зүйд улс орны бүрэн эрхт байдал аюул тулгарвал зэвсэг хэрэглэн няцаах эрхтэйг хүлээн зөвшөөрсөн байдаг. НҮБ-ын дүрмийн 51 дүгээр зүйлд:

Байгууллагын гишүүн улс зэвсэгт довтолгоонд өртвөл олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахилах хэрэгтэй арга хэмжээг Аюулгүйн зөвлөлөөс авах хүртэл ганцаараа буюу хамтран хамгаалах хөдлөшгүй эрхийг энэхүү дүрэм хэрхэвч үл хөндөнө. Өөрийгөө хамгаалах энэ эрхээ биелүүлэх талаар байгууллагын гишүүдийн авах арга хэмжээг нэн даруй Аюулгүйн Зөвлөлд мэдэгдсэн байх ёстой бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиж буюу сэргээхэд хэрэгтэй гэж үзэж байгаа арга хэмжээг ямар ч үед авах талаар энэхүү дүрэм ёсоор Аюулгүйн Зөвлөлийн бүрэн эрх ба хариуцлагыг хэрхэвч хөндөх ёсгүй гэж заасан байдаг.³

НҮБ-ын дүрмийн 51дүгээр зүйлд заасан "ганцаараа болон хамтран хамгаалах" гэдгээс цэргийн эвсэл холбоонд элсэх замаар өөрийгөө хамгаалах эрхээ хэрэгжүүлэх бололцоо нээлттэй байгаа нь тодорхой харагдаж байгаа юм. Цэргийн эвсэл холбоог дотор нь цэргийн эвсэл ба холбоо гэж ангилдаг бөгөөд эдгээр нь өөр хоорондоо ялгаатай ойлголтууд юм.

Alliance /альянс/ - гэдэг нь хоёр буюу түүнээс дээш орон тодорхой зорилтыг хэрэгжүүлэх үүднээс тусгай гэрээ хэлэлцээр байгуулан нэгдэхийг хэлдэг байна. Энэ нь голдуу удаан хугацаагаар байгуулагддаг. Alliance гэдгийн тод жишээ бол цэргийн эвсэл НАТО болно.⁴

Coalition /коалиция/ - гэдэг нь хоёр буюу түүнээс дээш орон тусгай зорилтыг хамтран хэрэгжүүлэх үүднээс түр хугацаагаар нэгдэхийг хэлнэ. Энэ нь түр хугацаагаар байгуулагдах бөгөөд зорилтоо хэрэгжүүлж дууссаны дараа татан буугддаг. Coalition гэдгийн сонгодог жишээ бол 2001 онд байгуулагдсан терроризмын эсрэг олон улсын эвсэл, мөн энэ удаад Иракийг үй олноор хөнөөх зэвсгээс ангижруулах зорилгоор байгуулагдсан эвсэл зэрэг болно.⁵

Монгол Улсын хувьд дэлхий дахинд энх тайвныг бэхжүүлэх, үй олноор хөнөөх зэвсгээс ангид байх талаар тууштай бодлого баримталсаар ирсэн. "Иракийг үй олноор хөнөөх зэвсгээс ангижруулах эвсэл"-д нэгдсэн нь Монгол Улсын үндэсний эрх ашиг, гадаад бодлогын үндсэн зарчимд бүрэн нийцэж байгаа бөгөөд гадаад бодлогын залгамж чанараас урган гарч байгаа юм. Монгол Улсын Засгийн газар төрийн гадаад бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх бүрэн эрхийнхэ дагуу асуудалд хандаж, авах арга хэмжээний талаар зохистой шийдвэрийг гаргасан. Мөн тухайн эвсэлд нэгдэн орсоноор манай улс АНУ болон дэлхийн хамтын нийгэмлэгийн бусад гишүүний "газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнол"-ыг "хамтран хамгаалж" байгаа олон улсын эрх зүйн субъект болсон.

"Иракийн эрх чөлөө ажиллагаа"-нд манай цэргийн

¹ О.Машбат."Олон улсын эрх зүй дэх өөрийгөө хамгаалах зарчим, түүнийг бүрдүүлэгч хүчин зүйл". Стратеги судлал сэтгүүл.2004/3.

² Международное публичное право. Под редакцией К.А.Бекяшева. Москва:1999. с. 614

³ НҮБ-ын дүрэм ба Олон улсын шүүхийн дүрэм. 1970.УБ

⁴ Юридическая энциклопедия.Москва.2001.с. 38

⁵ Мөн тэнд. с. 407

багийг оролцуулах тухай АНУ-ын Засгийн газрын хүсэлтийг хүлээн авсанаар 2003 оны 8 дугаар сараас эдүгээ хүртэл Зэвсэгт хүчний энхийг сахиулах гурван баг үүрэг гүйцэтгээд улмаар дөрөв дэх баг Иракт 2005 оны 8 дугаар сарыг дуустал үүрэг гүйцэтгэх болсон. Монгол Улсын Үндсэн Хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т "Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна" гэсэн заалт болон Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааны дагуу гарсан "Батлан хамгаалах", "Дайн бүхий байдлын тухай" хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Төрийн цэргийн бодлогын үндэс" зэрэг хууль, эрх зүйн баримт бичгүүдийн заалтууд нь олон улсын дайн, байлдааны ажиллагаанд манай зэвсэгт хүчин шууд оролцох эрх зүйн үндэслэл байхгүйг нотолдог.

Харин манай улс олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд оролцох эрх зүйн орчин нь "Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" Монгол Улсын хуулийн 3.1.2.-д "олон улсын бусад ажиллагаа" гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачлагаар зохион байгуулж байгаа энхийг сахиулах төрөл бүрийн сургалт, дадлага, цэргийн хэргийн сургууль; гамшиг, ослын хор уршгийг арилгах, авран хамгаалах болон хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагааг; 3.1.3. "НҮБ-ын энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох" гэж цэрэг, цагдаагийн албан хаагч сайн дурын үндсэн дээр томилогдон хилийн чанадад үүрэг гүйцэтгэж; гэсэн заалтуудад үндэслэгдсэн.

Түүнчлэн АНУ-ын талаас манай зэвсэгт хүчнийг дайн байлдааны ажиллагаанд бус харин хүмүүнлэгийн чиглэлээр

оролцуулах санал тавьж байгааг үндэслэн Иракийн дайны төгсгөлд болох энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд өөрийн цэрэг, цагдаагийн албан хаагчдыг оролцуулах бололцоотой гэсэн зөвлөмжийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасныг үндэслэн Засгийн газар шийдвэрлэсэн болно. Өнөөдрийн байдлаар "Иракийн эрх чөлөө" цэргийн ажиллагаанд АНУ-ыг тооцогчгүйгээр 28 улсын 24 мянга гаруй цэргийн албан хаагчид үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улс явуулсан цэргийн тоогоор эдгээр улсуудын дотор 14 дүгээр байранд орж байна. Манай цэргийн багийн Иракт байх хугацааг сунгах, эсэх тухай асуудлыг Засгийн газраар орсны дараа УИХ-аар оруулж, парламентын зөвшөөрлийг авсан.

Дурдахгүйгээр өнгөрөөж болохгүй бас нэгэн зүйл бол АНУ Иракийн асуудлаар Олон улсын байгууллага, ялангуяа НҮБ-ын саналыг чухалчилж үзэх тухай АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Кондолеза Райс Европын холбооны улсуудад албан ёсны айлчлал хийх үедээ гаргасан мэдэгдэл юм. Үүнээс гадна НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс Иракт шууд ардчилсан сонгуулийг явуулах талаар гаргасан 1546-р тогтоолын талаар 2004 оны 11 дүгээр сарын 23-нд Шам Ел Шайх /Египет/ хотноо Олон улсын сайд нарын хэмжээний хурал зохион байгуулагдсан. Энэ хуралд Ирактай хөрш зэргэлдээ орших Египет, Йордан, Иран, Саудын Араб, Ирак, Турк, Сири, Кувейт, "G8" бүлэг болох Канад, Франц, Итали, Герман, Япон, Орос, Англи, Америк болон НҮБ-ын Аюулгүй зөвлөлийн байнгын гишүүн болох Хятад, Тунис, Алжир, Бахрейн, Малайз, Нидерланд зэрэг улсуудын төлөөлөгчид, мөн түүнчлэн НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга, Арабын улсуудын холбооны

ерөнхий нарийн бичгийн дарга, Европын холбооны төлөөлөгчид оролцсон болно. Тухайн хурлаар НҮБ-ын Ирак дахь улс төрийн үйл ялцад гүйцэтгэх чухал үүргийг авч хэлэлцсэн бөгөөд оролцогч улсуудын сайд нар Иракт шууд ардчилсан сонгуулийг явуулахад НҮБ-ын талаас зөвлөлтөө өгч, дэмжлэг үзүүлэх нь чухал гэдгийг тэмдэглэсэн байна.¹

Үүнээс үзэхэд НҮБ-ын болон Олон улсын эрх зүй, тэр дотроо Олон улсын нийтийн эрх зүйн үүрэг, ач холбогдол цаашид улам өсөн нэмэгдэх нь тодорхой харагдаж байна.

Ашигласан ном, хэвлэл:

- Монгол Улсын Үндсэн Хууль /1992/
- Батлан хамгаалах тухай хууль /1993/
- Дайн бүхий байдлын тухай хууль /1998/
- Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль /2002/
- НҮБ-ын дүрэм ба Олон улсын шүүхийн дүрэм. УБ /1970/
- О.Машбат. Стратеги судлал сэтгүүл /2004/3/
- Юридическая энциклопедия. Москва /2001/
- Международное право, особенная часть И.И. Лукашук, Мәсква /1999/
- Международное публичное право. Под редакцией К.А.Бекяшева. Москва /1999/
- Materials of International Ministerial Meeting of the Neighboring Countries of Iraq /The G8 and China/ 2004

¹ Materials of International Ministerial Meeting of the Neighboring Countries of Iraq, The G8 and China.Sharm El Sheikh, Egypt. 23th of November 2004.

НИЙТИЙН БА ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ТУХАЙД

“Хасагт Хайрхан” дээд сургуулийн багш, МУИС-ийн докторант **З.СҮХБААТАР**

Эрх зүйн тогтолцоог нийтийн эрх зүй (*Jus publicum*) хувийн эрх зүй (*Jus privatum*) гэж ангилах хандлага эртний Ромоос уламжлалтай эх газрын эрх зүйн системт улсуудад төлөвшсөн ухагдахуун юм.

Эрх зүйн тогтолцоог нийтийн болон хувийн эрх зүйд хуваарилах хандлага нь нийтийн болон хувийн ашиг сонирхлыг гол болгосонтой холбоотой.

Эртний Ромын хуульч Ульпиан “эрх зүйг судлахдаа нийтийн болон хувийн эрх зүй гэсэн хоёр чиглэлд хуваана”¹. Хувийн эрх зүй нь тодорхой этгээдүүдийн тусын тулд үйлчилдэг бол нийтийн эрх зүй нь Ромын төрийн эрх зүйн байдлыг тодорхойлох гэж үзэж байсан.

Нийтийн болон хувийн эрх зүйг нарийн зааглан ялгахад зарим нэг хүндрэл, бэрхшээл тулгарч байна. Энэ нь нэг талаас манай улсад эрх зүйн тогтолцоог ийнхүү ангилах хандлага шалгуур шинжийнхээ түвшинд сайтар төлөвшөөгүйтэй, нөгөө талаас

хувийн эрх зүйд төрийн оролцоо өргөн, нийтийн эрх зүйд иргэдийн хувийн ашиг сонирхол илрэн гарч ирж байдагтай холбоотой юм. Гэвч эдгээр эрх зүйг нийгмийн харилцааг зохицуулахад илрэх эрх зүйн үйлчлэлийн арга болон шинжээр нь тодорхой ялган зааглаж болно. Нийтийн эрх зүйн хүрээнд хуулиар зөвшөөрөн тогтоосноос бусад харилцаа хориглогддог бол хувийн эрх зүйд хуулиар хориглон хязгаарласнаас бусад харилцаа хүлээн зөвшөөрөгдөнө.

Эдүгээ нийтийн болон хувийн эрх зүйн талаар нийтийн сайн сайхан байдал, нийтийн ашиг сонирхлын төлөө үйлчилж буй бүх зүйлийг нийтийн эрх зүйд хамааруулдаг гэж үзэх ашиг сонирхлын онол, субъектуудын хоорондын харилцаа нь талуудын эрх тэгш байдалд үндэслэж байвал хувийн эрх зүй, харин төр түүний байгууллагаас бусад субъекттэй захирах захирагдах зарчмын дагуу ажиллаж байвал нийтийн эрх зүй болно гэх субъектын онол, тухайн үүсэн бий болсон нөхцөл байдлыг зохицуулахад нэг талд нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх

олгож, үүрэг хүлээлгэсэн хэм хэмжээ үндэс нь болж байвал нийтийн эрх зүй мөн гэх субординацийн онол бий.

“Хувийн эрх зүй бол эрх тэгш талуудын хоорондын гэрээний үндсэн дээр тодорхой бие хүн, хүмүүсийн, хамт олны ашиг сонирхлыг хангаж, иргэн, тэдгээрийн нэгдэл, үйлдвэр, компани, аж ахуйн бусад бүтцийн харилцааг зохицуулдаг, дагаж мөрдөж буй эрх зүйн тогтолцооны хэсэг мөн”². Хувийн эрх зүйн дэд тогтолцоог зохиостой бүрдүүлж, хөгжүүлэх нь нийгэм эдийн засгийн харилцаанд гүнзгий нөлөө үзүүлдэг. Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хувийн эрх зүйн хүрээнд эрх зүйн харилцааны субъект байж болох боловч төрийн засаглах бүрэн эрхийг хэрэгжүүлэхгүй. Харин бусад субьектийн /иргэд, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага/ нэгэн адил эрх тэгш байдалтайгаар оролцоно.

Хувийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараахь онцлог шинж ажиглагддаг байна. Үүнд:

1. Диспозитив хэм хэмжээ голлодог;
2. Эрх зүйн харилцааны субьектүүд эрх тэгш байдаг;
3. Субьектүүд эрхээ хэрэгжүүлэхдээ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлдэг;
4. Субьектүүд хүлээсэн үүрэг, хийсэн үйлдлийнхээ төлөө хувийн хариуцлага хүлээдэг;

¹ Л.Өлзийсайхан. Дээж бичиг (эрх зүйн түүх) УБ., 2004. 232 дахь тал.

² С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 84 дэх тал.

5. Гэрээний зохицуулалтын хэлбэрийг өргөн ашигладаг;

6. Шүүхийн хамгаалалтаар баталгаажсан байдаг;

7. Амины, хувийн, явцуу бүлгийн ашиг сонирхлыг түлхүү хангах чиг баримжаатай байдаг¹.

Хувийн эрх зүйд иргэний эрх зүй, гэр бүлийн эрх зүй, олон улсын хувийн эрх зүй, худалдааны эрх зүй хамаарагдана.

Нийтийн эрх зүй нь “нийтийн сайн сайхныг хамгаалахад чиглэгдсэн нийгмийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, төрийн бүрэн эрх, зохион байгуулалт, засаглах үйл ажиллагаатай холбогдсон дагаж мөрдөж буй эрх зүйн тогтолцооны нэг хэсэг мөн”². Нийтийн эрх зүй нь төр, төрийн байгууллага ба иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн бүтцийн хоорондын харилцаа, төрийн байгууллагуудын хоорондын харилцааг зохицуулна. Төр, түүний байгууллага нийгэм, улс орны нийтлэг ашиг сонирхлын үүднээс эрх мэдлийг хэрэгжүүлж байдаг. Нийтийн эрх зүйд императив буюу “захирамжлан чиглүүлэх”³ хэм хэмжээ хэрэглэгдэх бөгөөд түүний харилцаанд оролцогчид санаачлан өөрчилж үл болно.

Нийтийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараахь онцлог шинж ажиглагддаг байна.

1. Нийтийн ашиг сонирхлыг хангах чиг баримжаа түлхүү байдаг;
2. Эрх зүйн субъектийн нэг талын хүсэл зориг илрэн гардаг;
3. Үзэмжээрээ шийдвэрлэх хүрээ өргөн байна;
4. У д и р д а м ж - з а а в а л биелүүлэх хэм хэмжээ голлосон;
5. Субъектүүдийн шаталсан харилцаа ба эрх зүйн акт, хэм хэмжээ зохих дэг журамд орсон;
6. Санкцийг шууд хэрэглэх⁴ зэрэг байна.

Нийтийн эрх зүйд үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Санхүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүй, Экологийн эрх зүй, Олон улсын нийтийн эрх зүй хамаарагдана. Эрх зүйн тогтолцоог нийтийн болон хувийн гэсэн “хоёр дэд тогтолоцоонд хуваарилан ангилах, судлах, эрэмбэжүүлэх нь барилгыг дэвэрээс нь биш сууриас нь эхлэлтэй нэгэн адил ерөнхий

асуудлын дараа нь тусгаар асуудлаа шийдэх зарчимд нийцэх болно”⁵.

Товчхондоо төр түүний байгууллагуудын ажил хэрэг үйл ажиллагаа бол нийтийн эрх зүйн зохицуулалтынх, харин хувь хүн, хуулийн этгээдийн ажил хэрэг, үйл ажиллагаа нь хувийн эрх зүйн зохицуулалтад хамаарах юм. Гэхдээ өнөөгийн эрх зүйн зохицуулалтын нягтрал, нийлэгжилтэй холбоотойгоор нийтийн болон хувийн эрх зүйн дэд тогтолцооны аль алинд хамаарах холимог эрх зүй бий. Тухайлбал: бизнесийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй.

Манай улсад эрх зүйн тогтолцоог нийтийн ба хувийн эрх зүй гэж дэд тогтолцоонд ангилах уламжлал огт байгаагүй бөгөөд энэ нь нэг талаас хувийн өмчийн төрлийг хууль зүйн хувьд үгүйсгэж байсантай, нөгөө талаас зөвлөлт маягийн эрх зүйг баримжаа болгосонтой холбоотой. Ер нь эрх зүйн тогтолцоог нийтийн, хувийн гэж ангилах хандлагыг социалист систем үгүйсгэж байсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Ийнхүү үгүйсгэх үзэл санааны язгуурыг В.И.Ленинээс 1922 онд зөвлөлт оросын иргэний хуулийн төсөл бэлтгэхтэй холбогдуулан Д.Н.Курскийд бичсэн захидалд өгүүлсэн байдаг. Уул захидал: Бид хувийн юуг ч хүлээн

¹ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн тогтолцоо, УБ, 2004, 84 дэх тал

² С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн тогтолцоо УБ, 2004, 86 дахь тал

³ Императив арга гэдгийг Д.Баярсайхан “Эрх зүйн онол” УБ., 1996 номондоо захирамжлан чиглүүлэх гэжээ, 137 дахь тал.

⁴ С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, УБ., 2001, 86-87 дахь тал.

⁵ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал. Нэгдүгээр дэвтэр, УБ., 2004, 314 дэх тал.

зөвшөөрөхгүй. Бидний хувьд аж ахуйн талаархи бүх зүйл хувийн биш, нийтийн эрх зүйн байна. Хувийн эрх зүйн харилцаанд төрийн оролцоог өргөнөөр хэрэглэж хувийн гэрээг хэрэгсэхгүй болгох талаар төрийн эрхийг өргөтгөх, иргэний эрх зүйн харилцаанд манай хувьсгалт эрх зүйн ухамсрыг хэрэглэх, энэ бүхнийг яаж хийхийг харуулсан нэлээд шүүх ажиллагааг тогтмол, шургуу, тууштай явуулан үзүүлэх хэрэгтэй. Үүнд суралцахгүй, үүнийг ойлгохыг хүсэхгүй байгаа хувьсгалт тусгай шүүхийн гишүүд, ардын шүүгчдийг намаар дамжуулан дуулгаж, хөөн зайлуулах”¹ гэхчлэн бичсэн байна. Манай улсад хувийн өмчийг үгүйсгэх, устгах үзэл санаа үүнээс ч эрт илэрч байсан байна. Тухайлбал: 1921 оны 5 дугаар сарын 21-нд ардын засгийн газраас “Газрыг хувийн өмч болгохыг устгах тухай”² тогтоол гаргаж байсан бол “1958 онд хувиараа аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний худалдаа эрхлэхийг хориглож”³, 1960 оны үндсэн хуулиар “хувийн өмчийг үүрд устгасан”⁴ гэж заан хуульчилснаар хувийн өмчийн үзэл сэтгэлгээ

үгүйсгэгджээ. Эл үзэл санаа олон арван жилийн турш хууль зүйн шинжлэх ухааны онол, практикт үндсэн чиглэл болж ирсэн.

1990 оны ардчилсан өөрчлөлтийн нөлөөгөөр 1963 оны иргэний хуулийн 59 дүгээр зүйлд “өмчийн төрлийг социалист өмч, амины өмч гэж ялгана” гэж зааж байсныг халж “БНМАУ-д хувийн, нийтийн өмч байна” хэмээн хувийн өмчийн төрлийг хүлээн зөвшөөрсөн⁵. Улмаар 1992 оны Үндсэн хуулиар нийтийн болон хувийн өмчийн төрлийг баталгаажуулсан нь эрх зүйн тогтолцоог нийтийн, хувийн эрх зүй гэж ангилах онолын үндсийг баталгаажуулсан. Энэ талаар Академич Ж.Амарсанаа “Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлд нийтийн ба хувийн өмч байна гэснийг шалгуур болгож нийтийн эрх зүй, хувийн эрх зүй гэж бичиж, ярьж, сургаж хэвшвэл илүү оновчтой, үнэнд дөт байж болох юм”⁶ гэж бичжээ.

Хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, зах зээлийн эдийн засгийн харилцаа гүнзгийрч байгаа өнөөгийн нөхцөлд эрх зүйн тогтолцоог нийтийн эрх

зүй, хувийн эрх зүй гэж дэд тогтолцоонд ангилах нь онол, практикийн өндөр ач холбогдолтой болж байна.

“Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо” сэдэвт олон улсын симпозиумын төгсгөлийн баримт бичигт үндэсний эрх зүйн тогтолцооны үндсэн шалгуур нь Монгол Улсын үндсэн хуулийн нэгдүгээр зүйлд заасан хууль дээдлэх ёс байна. Тус улсын эрх зүйн тогтолцоо нь иргэншсэн эрх зүйн бүл /Civil law/-ийг баримжаалан хөгжинө” гэж АНУ, Монгол Улс, ОХУ, ХВНГУ-ын эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрсөнийг тусгажээ.

Эрх зүйн тогтолцоог нийтийн болон хувийн гэж ангилах дэд тогтолцоо нь эл бүлийг баримжаалдаг улс орнуудад нэгэнт тогтсон талаар өгүүллийн эхэнд дурьдсан билээ. Цаашид эрх зүйн тогтолцоог нийтийн болон хувийн гэж дэд тогтолцоонд ангилах талаар хүрсэн түвшнийг илүү ахиулж, онолын үндсийг төлөвшүүлэх, практик үйл явц болгох шаардлага тулгамдсан асуудал болжээ.



¹ Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал. нэгдүгээр дэвтэр УБ. 2004. 312 дахь тал

² Уг тогтоолд “Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино” гэж заасан. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актыг эмхтгэл. Нэгдүгээр боть. УБ., 1972. 18 дахь тал.

³ ХЗҮТ. Бизнесийн эрх зүй. Хуульчдад зориулсан гарын авлага. УБ., 2003. 7 дахь тал.

⁴ БНМАУ-ын Үндсэн хууль. УБ., 1960. 8 дугаар зүйлд.

⁵ Эмхтгэсэн. З.Сүхбаатар, П.Оюундэлгэр. Иргэний хуулиуд /1926, 1952, 1963, 1994, 2002/, нэмэлт, өөрчлөлтүүд. II боть. УБ., 2002. 164, 315 дахь тал.

⁶ Ж.Амарсанаа. Эрх зүйн аймаг, түүний Монгол дахь тусгал. “Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо”. Эмхтгэн хэвлүүлсэн Ханс-Зайделийн сан. УБ., 2000. 56 дахь тал.

⁷ Эмхтгэн хэвлүүлсэн Ханс-Зайделийн сан. “Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо” УБ., 2000.188 дахь тал.

АРБИТРЫН АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

“Отгонтэнгэр” Их Сургуулийн Эрх зүйн тэнхимийн багш Ч.САРАНГЭРЭЛ

Зах зээлийн эдийн засгийн тогтолцооны үед иргэд, хуулийн этгээдийн аж ахуйн үр ашигтай үйл ажиллагаа төдний олон улсын иргэний гүйлгээнд хэрхэн оролцох чадвартай шууд хамааралтай байдаг. Зохих судалгаа хийж үзвэл ийм аж ахуйн харилцааны зарим оролцогчид маргаанаас урьдчилан сэргийлэх, үүссэн маргаанаа зөвхөн хоорондын байгуулсан гэрээний хүрээнд шийдвэрлэж чадахгүй мухардах нь олонтаа байдаг.

Орчин үед аж ахуйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх зуучлал, эвлэрэл, шүүх зэрэг олон аргуудаас, маргааны талууд ихэвчлэн арбитрыг сонгож байгаа явдал нь нэг талаас авч үзвэл улсуудын арбитрар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтын үндэсний эрх зүй дэх ялгааг арилгах, нөгөө талаас олон улсын хэмжээнд энэхүү процессыг ижилтгэх буюу жигдрүүлэх бодит шаардлага үүсгэж байгаа юм.

Олон улсын шинжтэй худалдааны харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхэд олон улсын эрх зүйн гүйцэтгэх үүрэг үндсэн 3 чиглэлд хуваагддаг гэж үзэж болох юм.

1. улсуудын арбитрарт олон улсын арилжааны маргааныг хянан шийдвэрлэх нэг ижил журам бий болгох зорилгоор процессын хэм хэмжээг ижилтгэх буюу жигдрүүлэх,
2. нэг улсад гарсан арбитрын шийдвэрийг, нөгөө улсын нутаг дэвсгэр дээр хүлээн зөвшөөрөх, биелүүлэх олон улсын эрх зүйн үндсийг бий болгох,
3. арилжааны маргааны тодорхой төрлийг хянан шийдвэрлэх тусгай олон улсын байгуул-

лагыг байгуулах, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгох,

1. Олон улсын хамтын нийгэмлэг арбитрын процессын эрх зүйн ижилтгэлд онцгой анхаарал хандуулсаар ирсэн бөгөөд энэ салбарт хэд хэдэн олон улсын баримт бичиг байдгийн ихэнхи нь НҮБ-ын хүрээнд боловсруулагдсан байдаг. НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс боловсруулж, 1961 оны 4 дүгээр сарын 21-нд Женев хотод батлан, 1964 оны 1 дүгээр сарын 7-ноос хүчин төгөлдөр болсон Олон улсын арилжааны арбитрын тухай Европын конвенцийг юуны өмнө дурдаж болно. Маргаанаа арбитрарт шилжүүлж байгаа талууд Конвенцийн гишүүн өөр өөр улсуудын нутаг дэвсгэрт оршин байх тохиолдолд Конвенцийг байнгын болон түр арбитрыг байгуулан ажиллуулахад хэрэглэнэ. Конвенц арбитраг байгуулах, хэрэг маргаан хянан хэлэлцэх, шийдвэр гаргах, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох нөхцлүүд, үүлэх үр дагаварыг тогтоосон журмыг агуулснаас гадна дараах шинэ зохицуулалтуудыг тусгасан. Үүнд:

- A. Зөвхөн маргаан шийдвэрлэж байгаа улсын иргэнээс гадна гадаадын иргэд арбитраг байж болно,
- B. Ихэнхдээ нийтийн эрх зүйн хуулийн этгээд өөрийн үндэсний эрх зүйд зааснаар зөвхөн улсын шүүхэд хандах эрхтэй байсан бол уг Конвенцоор маргаанаа арбитрарт шилжүүлэх боломжтой болсон,
- B. Арбитрын ажиллагаанд хэрэглэх эрх зүйн сонголтонд талуудын хязгааргүй хүсэл зоригын зарчим тогтоосон. Хэрвээ талууд эрх зүйгээ

сонгоогүй бол арбитрын бүрэлдэхүүн зөрчилдөөний хэм хэмжээний тусламжтайгаар арбитрын ажиллагаанд хэрэглэх эрх зүйгээ сонгохоор заасан,

G. Талууд тохиролцсон тохиолдолд арбитраг зуучлалын ажиллагаа явуулж болно. Мавай улсад 2003 оноос энэ журмыг нэвтрүүлж, МҮХАУТ-ын Зөвлөл 2003 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хурлаараа Монголын Үндэсний Арбитраг зуучлалын ажиллагаа явуулдаг баримтлах дүрмийг баталсан.

Конвенц улсын шүүх болон арбитрын харилцан уялдааны талаар талууд хооронд арбитрын хэлэлцээр байгаа тохиолдолд улсын шүүх тухайн маргааныг хянан хэлэлцэхээс татгалзах үүрэгтэй гэсэн үндсэн зарчмыг тусгасан. Их Британи зэрэг Европын зарим улс өнөөг хүртэл дээрхи Конвенцид нэгдэн ороогүй, мөн уг Конвенц бүс нутгийн шинжтэй учир олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн арбитрын процессын хууль болж чадаагүй бөгөөд арбитрын процессын эрх зүйг ижилтгэх өөр арга замыг ашиглах шаардлага гарсан.

Олон улсын худалдааны арбитрын тухай хуулийг НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комиссоос боловсруулж 1985 оны 12 дугаар сарын 11-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей батлан, улсуудад зохих үндэсний хууль тогтоомжийг гаргахдаа загвар болгож хэрэглэхийг зөвлөсөн. Загвар хууль нь олон улсын гэрээ хэлэлцээр биш бөгөөд заавал биелүүлэх хууль зүйн хүчин төгөлдөр бүхий акт биш юм. Гэхдээ энэхүү актыг үндэслэж улсуудын арбитрын процессын эрх зүйд

ижилтгэлийн процесс тодорхой хэмжээнд явагдсан гэж үзэж болно. Тухайлбал: 1990 оноос эхлэн АНУ, Канад улсын ихэнх мужууд, Болгар, Финланд, Унгар, ОХУ, Украин, Герман зэрэг дэлхийн 30 гаруй улс тус загвар хуулийг удирдлага болгон өөр өөрсдийн онцлогт тохируулан арбитрын хуулиа шинэчлэн гаргасан байна.

Мөн олон улсын арилжааны практикт НҮБ-ын хүрээнд боловсруулагдсан дараах актуудыг дурьдаж болно. Үүнд:

- А. НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комиссын 1966 оны Европын Арбитрын дүрэм,
- Б. НҮБ-ын Ази болон Алс дорнодын Эдийн Засгийн Комиссын 1966 оны Арбитрын дүрэм,
- В. ЮНСИТРАЛ-ын Олон Улсын Арилжааны Арбитрын Загвар Хууль,
- Г. ЮНСИТРАЛ-ын 1976 оны Арбитрын дүрэм зэрэг байна.

Дээрх актуудаас 1976 оны 12 дугаар сарын 15-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан зөвлөмжийн чанартай ЮНСИТРАЛ-ын дүрмийг талууд гэрээндээ шууд тайлбар хийх замаар олон улсын худалдааны практикт хэрэглэж байна. Энэхүү актыг байнгын арбитрауд өөрсдийн дүрэмдээ нэмэлт болгон хэрэглэдэг нь түүний ач холбогдлыг харуулж байна. Тус дүрэмд арбитрын ажиллагаа явуулах хэл, газар, нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хэрэг маргаанаар нотлох баримт гаргах, арбитрын шийдвэрийн төрөл, шийдвэр гаргах зэрэг асуудал уян хатнаар зохицуулагдсан байдаг.

Тухайлбал: талууд арбитрын ажиллагаа явуулах газрыг тохиролцоогүй тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн хэргийн нөхцөл байдлыг харгалзан тогтооно. Мөн талууд арбитрын тоо, тэдэнд тавих шаардлага, арбитрын ажиллагаа явуулах журам зэргийг харилцан тохиролцоо бүрэн эрхтэй. Энэ арбитрыг улсын шүүхээс давуу гэж үздэгтэй шалгуур бөгөөд 2003 оны

Арбитрын тухай Монгол улсын хуулинд дээрх зохицуулалтуудыг тусгасан нь олон улсын жишигт хүрсэн гэж үзэх нэг үндэслэл болж болох юм.

Маргааны аль нэг тал нөгөө талаас арбитрийг томилох тухай саналыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн арбитрийг томилоогүй эсвэл талууд арбитрийн бүрэлдэхүүний тухай тохиролцоонд хүрээгүй бол үүнийг талуудын тохиролцсон эрх бүхий байгууллага, хэрвээ уг байгууллага ямар нэг шалтгаанаар арбитрийг томилоогүй эсвэл талууд санал хүлээж авснаас хойш 60 хоногийн дотор эрх бүхий байгууллагын тухай тохиролцоогүй тохиолдолд аль нэг тал Гаагын Байнгын Арбитрын Ерөнхий нарийн бичгийн даргад арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх эрх бүхий байгууллагыг томилуулах хүсэлт гаргаж болно. Дүрмийн ийм уян хатан зохицуулалтууд хэрэг маргааныг түргэн, үр дүнтэй шийдвэрлэх нөхцлийг бий болгоход чиглэгдсэн.

ЮНСИТРАЛ-ын Арбитрын дүрэмдс гадна 1980 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей эвлэрүүлэх ажиллагааны дүрмийг баталсан. Энэ ажиллагааны онцлог нь талуудад эрх зүйн үр дагавар бүхий шийдвэр гаргадаггүй, харин маргааны аль аль талын ашиг сонирхлыг хангаж, тэдгээрийг эвлэрүүлэхэд чиглэгдсэн байна.

Монголын Үндэсний Арбитрын дүрэмд, Монголын Үндэсний Арбитрын нэг зорилго нь Монгол улсад маргаан шийдвэрлэх арбитра болон зуучлалын ажиллагааг хөгжүүлэх, хөгжүүлэх гэж тодорхойлсон бөгөөд талууд тохиролцсон тохиолдолд Монголын Үндэсний Арбитр зохих журмын дагуу эвлэрүүлэх ажиллагаа явуулж болно. Дээрх дүрэм болон загвар хууль олон улсын гэрээ биш, тухайн талууд гэрээндээ шууд заасан тохиолдолд хэрэглэгдэх зөвлөмжийн шинжтэй олон улсын хэм хэмжээ болно.

Олон улсын худалдааны салбарт арбитрагтэй холбоотой хэд хэдэн бүс нутгийн шинжтэй гэрээнүүд бий. Тухайлбал:

Социалист орнуудын эдийн засгийн харилцан тусалдах зөвлөл /СЭВ/-ийн гишүүн улсууд эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны харилцаанаас үүссэн иргэний эрх зүйн маргааныг арбитраар хянан шийдвэрлэх тухай конвенцийг 1972 оны 5 дугаар сарын 26-нд Москва хотноо батласан. Москвагийн конвенцийн онцлогийг маргааныг заавал арбитра хянан шийдвэрлэх болон маргааны харьяалалын тухай харилцан холбоотой хоёр журамд харж болно. Конвенцийн 1 дүгээр зүйлд: Конвенцийн гишүүн улсуудын аж ахуйн байгууллага хоорондын маргааныг улсын шүүхэд харьяалагдахаас бусад тохиолдолд заавал арбитраар хянан шийдвэрлүүлэх тухай журмыг тусгасан. Конвенцийн 2 дугаар зүйлд: эрх бүхий арбитраар хариуцагчийн харьяалагдах улсын худалдааны танхимийн дэргэдэх арбитра байна гэж заасан. Эдгээр заалтууд маргаанаа арбитрагт шилжүүлэх, арбитра талууд чөлөөтэй сонгох нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын практиктэй үл нийцэж, арбитрын ажиллагааны сайн дурын зарчимтай харшилдаж байна. Конвенцэд талууд үндсэн журмаас хазайж маргаанаа гуравдагч орны худалдааны танхимийн дэргэдэх арбитрагт шилжүүлж болох тайлбар хийх нь Конвенцийн заавал биелэгдэх шинжийг зөвлрүүлж буй мэт боловч мөн чанар нь хэвээрээ байгаа юм.

Дээрх заалтуудаас үзэхэд арбитрагт олон улсын арилжааны маргааны талууд хоорондоо хэлэлцээгүй мөн арбитраг сонгоогүй байсан ч маргааныг арбитрагт шийдвэрлэх боломжтой болж байгаа юм. Үүнийг арбитрын мөн чанарыг алдагдуулсан зохицуулалт болжээ гэж үзэж болох юм. Социализмын үед Москвагийн конвенцийг өргөн хэрэглэж байсан ба СЭВ-ийн гишүүн орнуудын байгууллагууд хоорондын бүх гадаад эдийн засгийн маргаан шийдвэрлэгддэг байсан. Орчин үед Конвенцийн дээр дурдсан онцлогууд олон улсын арилжааны арбитрын үндсэн зарчмуудтай харшилдаж байна.

1992 оны Здугаар сарын 20-нд Киев хотод Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн гишүүн улсуудын хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой гарсан маргааныг шийдвэрлэх тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан. Уг баримт бичиг олон улсын арбитражын процессын эрх зүйг пжилтгэхэд чиглэгдээгүй бөгөөд хэлэлцээрээр ямар ч аж ахуйн харилцаанаас үүссэн маргааныг зөвхөн арбитраж бус, шүүхээр шийдвэрлэх боломжтой юм.

Арбитражын салбарт 1975 оны 1 дүгээр сарын 30-нд Панам хотноо Америк тивийн олон улсын арилжааны арбитражын тухай конвенцийг баталсан. Конвенцид нэгдэн орсон улсуудад гарсан арбитражын шийдвэрийг биелүүлэх зорилгоор тухайн арбитражын шийдвэр эцсийн шатны шүүхийн шийдвэртэй адил хүчинтэй байна гэсэн зарчмыг тусгасан. Конвенцид заасны дагуу маргааны талууд хооронд арбитражын хэлэлцээр байхгүй тохиолдолд Худалдааны арбитражын Америк хоорондын комисс маргаан шийдвэрлэх бүрэн эрхтэй байдаг. 1987 оны Арабын олон улсын худалдааны арбитражын тухай конвенц нь бүс нутгийн шинжтэй гэрээнд хамаарна.

2. Арбитражын процессын олон улсын эрх зүйн зохицуулалтын нэг үндсэн чиглэл нь нэг улсын нутаг дэвсгэр дээр гарсан арбитражын шийдвэрийг, нөгөө улсын нутаг дэвсгэр дээр хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх олон улсын эрх зүйн үндсийг биелэлж явдал юм. Олон улсын иргэний гүйлгээнд оролцогчид хоорондын маргаанаар гарсан арбитражын шийдвэрийг талууд сайн дураар биелүүлээгүй нөхцөлд олон улсын эрх зүйн тусламжтайгаар шийдвэрлэх асуудал гарч ирнэ. Энэ асуудлаар тусгайлан олон улсын гэрээ байдагас гадна, арбитражт холбоотой бүх олон улсын баримт бичиг гадаадын арбитражын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой заалтыг агуулсан байдаг. Энэ бол 1958 оны 7 дугаар сарын 10-нд баталсан Гадаадын арбитражын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай

Нью-Йоркийн конвенц юм. Эдүгээ уг конвенцид дэлхийн 130 гаруй улс нэгдэж орсны дотор Монгол улс 1995 онд нэгдэж орсон юм. Конвенцид нэгдэж орсон улсууд өөрийн улсын нутаг дэвсгэр дээр гадаадын арбитражын шийдвэрийг өөрийн улсын арбитражын шийдвэрийн адилаар хүлээн зөвшөөрч, өөрийн процессын хэм хэмжээний дагуу биелүүлэх үүрэг хүлээдэг. Конвенцид хэрэв талуудын аль нэг нь эрх зүйн чадамжгүй, арбитражын хэлэлцээр байгуулсан улсын хуулиар тухайн хэлэлцээр хүчин төгөлдөр бусад тооцогдсон, шийдвэр эсрэг гарсан талын процессын эрхийг бүрэн хангаагүй, талуудын тохиролцсон арбитражын ажиллагааны тухай журмыг арбитражын бүрэлдэхүүн нэцтэй зөрчсөн, шийдвэр гарсан улсдаа хүчин төгөлдөр болоогүй буюу түдгэлзүүлсэн тохиолдлуудад хариуцагчийн гаргасан нотлох баримтыг үндэслэж арбитражын шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж болно. Харин гадаадын арбитражын шийдвэрийг биелүүлэх нь тухайн улсын нийтийн дэг журамд харшлахаар бол тухайн улс өөрөө конвенцид заасны дагуу бие дааж татгалзаж болно.

3. Арбитражын процессын олон улсын эрх зүйн зохицуулалтын 3 дахь чиглэл нь аж ахуйн харилцааны тодорхой төрлөөс үүссэн маргааныг өөрийн харьяалалдаа авч хянан шийдвэрлэх олон улсын төрөлжсөн байгууллагыг байгуулахад оршино. Энэ хүрээнд нэг улс ба бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын талаар үүссэн иргааганы шийдвэрлэх тухай Вашингтоны конвенц 1965 оны 3 дугаар сарын 18-нд батлагдаж, 1966 оны 10 дугаар сарын 14-өөс хүчин төгөлдөр болсон. ы Конвенцид үндэслэж байнгын арбитраж болон олон улсын эрх зүйн бие даасан субъектийн статустай хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийг байгуулсан. Төв доорх гурван нөхцлийг зэрэг хангасан маргааныг өөрийн харьяалалд авч шийдвэрлэнэ:

1. зөвхөн конвенцид нэгдэн орсон улсад харьяалагдах иргэд, хуулийн этгээдийн хооронд

үүссэн,

2. маргаан зөвхөн хөрөнгө оруулалтын маргаанаас үүссэн байх,
3. талууд хооронд бичгээр хийсэн маргаанаа төвд шилжүүлэх тухай гэрээ байх

Вашингтоны конвенц хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх арбитражын болон эвлэрлийн гэсэн 2 механизмыг тусгасан. Конвенц тодорхой маргааныг шийдвэрлэх арбитражын бүрэлдэхүүнийг байгуулах, түүний эрх хэмжээг тогтоосон, үндэсний шүүхийн харилцаа, маргаанд хэрэглэх эрх зүйг сонгох, конвенцтой нийцүүлэн гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх журмыг тогтоосон хэм хэмжээг агуулсан байдаг.

Өмнө дурдснаас гадна арбитражын ажиллагаатай холбоотой асуудлууд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны болон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай хоёр талт болон олон талт гэрээнүүдээр зохицуулагддаг байна.

Өнөө үед олон улсын худалдааны харилцаанаас үүссэн маргааныг арбитражын журмаар шийдвэрлэхтэй холбоотой ажиллагааг зохицуулсан олон улсын эрх зүйн болон бүс нутгийн бүхэл бүтэн цогц орчин бүрэлдэж, худалдааны арбитраж үйл ажиллагааны ижилтгэх, улсуудын арбитражын хууль тогтоомжийг харилцан уялдуулах процесс ид явагдаж байна гэж дүгнэж болох юм.

Олон улсын арилжааны маргааны талууд маргаан шийдвэрлэх шүүхэд хянах болон бусад альтернатив аргуудаас арбитражыг онцгойлон сонгох болсон хөшүүрэг нь арбитражаас гарах шийдвэр гадаад улсын нутаг дэвсгэрт хүчинтэй байх эрх зүйн орчныг 1958 оны Гадаадын арбитражын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай Нью-Йоркийн конвенц зохих түвшинд хангаж байдагт оршино.

* * *

ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙ - "LEX MERCATORIA"-ИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ҮҮСЭЛ ХӨГЖИЛ



ХЗҮТ-ийн
Эрх зүйн албан бус сургалтын
төвийн багш **Б.ТАМИР**

Lex mercatoria нь олон улсын хувийн эрх зүйд ихээхэн ач холбогдолтой зүйл болоод байна. Учир нь гадаад эдийн засгийн үйл ажиллагааг эрх зүйгээр зохицуулахад зөрчилдөөний альтернатив аргыг бий болгосон.

Lex mercatoria-г тодорхойлсон нэгдсэн ойлголт байхгүй юм. Учир нь энэ нь нийгмийн амьдралд шинээр бий болсон үзэгдэл төдийгүй эдийн засгийн хөгжлийн хурдцаас хамааран байнга өөрчлөгдөж байдаг.

"Lex mercatoria" (латин үг) нь худалдааны эрх зүй гэсэн утгатай. Үүнийг олон улсын эрх зүйн үзэл баримтлал, сургаалиудад янз бүрээр томъёолдог. Тухайлбал, "Транснациональное право"-үндэс-тэн дамнасан эрх зүй "Право международной торговли" – Олон улсын худалдааны эрх зүй гэдэг.

Мөн Францын эрдэмтэн болох Ж.Шапира "международное право предпринимательской деятельности" – "Аж үйлдвэрийн олон улсын эрх зүй, Б.Гольдман – "Международное купеческое право" – олон улсын худалдааны эрх зүй хэмээн томъёолдог. Хэдийгээр янз бүрээр томъёолдог ч гэсэн эдгээрийн агуулга нь нэг ижил юм.

Уг ойлголтод худалдааны төрөл бүрийн үйл ажиллагааг хамруул-

даг. Тухайлбал, бараа худалдах, худалдан авах, түрээс, техникийг шилжүүлэх, төлөөлөл, тээвэр, даатгал, төлбөр тооцоо, зээлийн харилцаа зэргийг багтаадаг. Lex mercatoria-ийн хэд хэдэн онцлог шинжийг дурдаж болно. Үүнд:

1. Lex mercatoria- Олон Улсын худалдаанд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулдаг.
2. Lex mercatoria- Үндэсний эрх зүйгээс үл хамааран Олон улсын худалдааны харилцаанд оролцогчдын шударга, төгш эрхийн Үндсэн дээр өөрсдийн хэм хэмжээ бий болгох боломж олгодог.
3. Lex mercatoria- худалдаачдаар бүтээгдсэн харилцаа байдаг.
4. Lex mercatoria-н зарчим, хэм хэмжээ нь түгээмэл шинжтэй.
5. Lex mercatoria- маргааныг олон улсын худалдааны арбитрт хамруулан шийддэг.
6. Lex mercatoria-д олон улсын худалдааны бараа худалдах, худалдан авах гэрээ гол байр суурь эзэлдэг.
7. Lex mercatoria- заншил дээр үндэслэгддэг. Түүний хөгжил нь Олон улсын эрх зүйн хөгжилтэй холбоотой.
8. Lex mercatoria нь гэрээний эрх зүйн бүх хүрээг зохицуулахгүй. Тухайлбал, субъектуудын гэрээний эрх зүйн чадамж, /үүнийг үндэсний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг./ татвар ногдуулалт, шударга бус өрсөлдөөн, байгаль орчныг хамгаалах гэх мэт. Эдгээр асуудлыг үндэсний хууль тогтоомжоор, өөрөөр хэлбэл тухайн шүүхийн үндэсний хуулиар зохицуулдаг. lex fori

Lex mercatoria-г товчоор

тодорхойлбол: олон улсын худалдааны харилцааг зохицуулах хэм хэмжээ юм.

Lex mercatoria-гийн үүсэл хөгжил

Lex mercatoria-ийн түүхэн хөгжил нь 3 үе шаттай.

Эхний үе.

Эртний Ромын jus gentium-тэй холбогдон үүссэн. МЭӨ III зууны үед дундад төнгисийн сав орчим газар гэсэн хэлбэрээр Олон Улсын худалдааны заншил үүссэн гэж зарим эрдэмтэд үздэг.¹

Jus gentium нь гадаадын иргэнтэй холбоотой харилцааг зохицуулдаггүй, зөвхөн ромын иргэдийн харилцааг зохицуулдаг үндэсний шинжтэй явцуу хүрээнд зохицуулдаг эрх зүй байсан. Jus gentium бий болсны дараагаар Ром нь дэлхийн худалдааны төв газар болсон.

Jus gentium-ын үндсийг "преторское право буюу преторын эрх зүй"² бүрдүүлдэг байсан. Преторын шийдвэр нь тодорхой хэрэг маргаан дээр ex aequo et bono /по справедливости, шударга ёсны дагуу/ зарчим дээр үндэслэгдэж гардаг. Jus gentium-ыг бүрэлдэн бий болоход хуульчдийн тайлбар их нөлөө үзүүлсэн. Эртний Ромд зөрчилдөөний хэм хэмжээ байгаагүй. Тиймээс нэгдсэн нэг эрх зүйн хэм хэмжээний систем болсон jus gentium-ээр зохицуулж байсан юм. Энэ нь эртний дээр дурьдсан jus gentium, одоогийн Lex mercatoria хоёрын ижил төстэй байдал харагдаж байна.

Эртний ромын хуульч нарын бүтээлд Гая, Цицерон, Ульпиан олон улсын худалдааны харилцааг нэгдсэн нэг эрх зүйгээр зохицуулах

¹ А.А.Мережко. Lex mercatoria. Теория и принципы транснационального торгового права. Киев 1999 с.121

² претор- Эртний Ромын цэргийн удирдлага (захирагч)

шаардлагатай гэсэн үзэл баримтлалыг санал болгож байсан.

Jus gentium-ын даруу иргэний бусад гэрээнээс онцлогтойгоор гэрээний шинэ төрөл үүсч энэхүү гэрээ нь зөвхөн талуудын сайн дурын, зөвшилцлийн үндсэн дээр байгуулагдаж байсан.

Харин 212 онд Каракаллын эдикт¹ гарснаас хойш jus gentium нь ач холбогдлоо алдсан. Гэсэн хэдий ч доорх зүйлүүдийг бий болгож, таниулсан юм. Үүнд:

Олон улсын худалдааны харилцаанд оролцож байгаа этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулах зарчим, хэм хэмжээ байдаг гэдгийг; Худалдааны харилцааг нэгдсэн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах нь зөрчилдөөний хэм хэмжээний аргаар зохицуулахаас илүү үр дүнтэй гэдгийг харуулсан юм.

Хоёр дахь үе – Дундад зууны худалдааны эрх зүй

XI-XII зууны зааг үе дээр Баруун Европт далайн худалдаа хөгжиж эхэлсэн. Харин зүүн хэсэгт цэмбэ үйлдвэрлэж эхэлсэн. Энэ үеэс олон улсын худалдаа идэвхитэй хөгжиж Lex mercatoria-гийн нэгэн үе эхэлсэн. Энэ түүхэн үед худалдаа нь голдуу арилжааны газар буюу зах дээр явагддаг байсан. Эдгээр захууд Итали, Фландрийн хоорондох зам дагуу үүссэн. Үүнтэй холбоотойгоор худалдаачдын хооронд үүссэн маргааныг түргэн шийдэх шаардлага гарсан. Иймээс тухайн улсын шүүхээс үл хамаарах худалдааны тусгай шүүх бий болгосон. Худалдааны шүүх нь бие даасан. Гэхдээ худалдааны эрх зүй нь феодализм илүү ноёлсон газар хязгаарлалт тогтоодог байсан тул хөгжих боломжгүй байлаа. Бусад хотуудын шүүх худалдааны хүрээнд заншил, шударга ёсон дээр үндэслэхийг шаардаж байсан. Энэхүү худалдааны шүүхийн бүрэлдэхүүн худалдааны туршлага, мэдлэгтэй нэр хүндтэй худалдаачид өөрсдөө ордог байв.

Өмнөх үеийн Lex mercatoria-аас ялгагдах онцлог нь:

1. Lex mercatoria-гийн хэм хэмжээ төрөөс тогтоогдоогүй. Харин худалдаачдаар өөрсдөөр нь тогтоогдсон.
2. Lex mercatoria-г тусгай худалдааны шүүхэд хэрэглэдэг. /Societas mercatorium/
3. Lex mercatoria уян хатан, нарийвчилсан эрх зүй байсан.

Lex mercatoria-ийн хөгжил XIII-XIV зууны үед цэцэглэн гарч байсан боловч эдийн засаг, улс төрийн хүчин зүйлээс болж унасан. Үүний үр дүнд Lex mercatoria өөрийн шинж чанараа алдаж хэлбэрийн төдий болсон. XIX зууны үед Lex mercatoria үндсэндээ ач холбогдлоо алдсан бөгөөд харин үүний оронд зөрчилдөөний хэм хэмжээ гадаад худалдааг зохицуулах болсон байлаа.

Гурав дахь үе – Орчин үеийн худалдааны эрх зүй

XIX зууны үед улс төр, нийгмийн байдлаас хамааран худалдааны харилцаа үндсэндээ шинжтэй болсон. Гэсэн хэдий ч энэхүү байдал нь дэлхийн худалдааг зогсоож чадсангүй. Тэр тусмаа эрх зүйн хүрээнд. Иймээс олон улсын худалдааны нийгэмлэг худалдааг түргэн үр дүнтэйгээр явуулах үүднээс түгээмэл шинжтэй хэм хэмжээ бий болгох шийдэлд хүрч байлаа. Үүний үр дүнд Lex mercatoria дахин сэргэсэн юм. Францын хуульч Ж.Шапира Lex mercatoria-гийн гол шаардлагыг тодорхойлсон.

Худалдааны эрх зүйн хэм хэмжээ бий болгохын гол зорилго нь төрийн оролцоог бууруулах. Өмнө нь төрийн хүсэл зоригийн үндсэн дээр явагдаж шударга явдал зөрчилдөж байсан гэжээ.

Зарим эрдэмтэд шинэ Lex mercatoria-аг постиндустриализмтэй холбон тайлбарладаг. Гэрээ дээр худалдааны эрх зүйн харилцаа тулгуурлах бөгөөд мөн түүнчлэн зөвхөн бараа солилцохоос гадна энэхүү харилцаанд оролцогчдийн

эрхийг хамгаалах асуудлууд гарч ирсэн. Тухайлбал, барааны тэмдэг, зохиогчийн эрх г.м.

Lex mercatoria нь Сорбонны Их сургуулийн профессор нарын зохиосон байж боломгүй зохиомол "домог" гэж XIX зууны үед англи-америкийн позитивист төлөөлөгчид үздэг байсан. Өөрөөр хэлбэл Lex mercatoria гэсэн ойлголт байхгүй гэсэн байна.²

1920-д оны эхээр Оросын эрдэмтэн В.М.Корецкий Lex mercatoria-ийн зарчим, эх сурвалж, зохицуулах зүйлийг тодорхойлж өгснөөрөө дээрх үзлийг өөрчилж, түүний хөгжилд ихээхэн нөлөө үзүүлсэн юм.³

Өөрийн онцлог шинжээрээ Lex mercatoria 1960-аад оны эхээр бүрэн бүрэлдэн үүсч бий болсон. Үүний гол төлөөлөгчид нь Францын хууль зүйн шинжлэх ухааны эрдэмтэд: Б.Гольдман, Ф.Кав, Ф.Фушар нар болон бусад орны төлөөлөгчид гарч ирсэн. Английн К.Шмиттгофф, Швейцарийн Л.Копельманас, П.Лалив, Югославын Л.Голштен нар юм.⁴

Худалдааны эрх зүйн үндсэн эх сурвалж:

1. Олон улсын худалдааны заншил
2. Олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээ
3. Олон улсын худалдааны харилцаанд оролцогч улсуудын бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим
4. Загвар хууль
5. Олон улсын арбитрайн шийдвэр
6. Загвар гэрээ

Дээрхээс гадна дараах туслах шинжтэй эх сурвалж:

- 1 Ажил хэргийн практик
- 2 Олон улсын байгууллагын зөвлөмж
- 3 Хуульчдын санал, зөвлөмж
- 4 Гэрээ.

Lex mercatoria-ийн хүрээнд загвар хуулийг талууд өргөнөөр хэрэглэж байна.

¹ Каракал хааны хил дамнасан худалдаа хийхийг хориглосон зарлиг

² А.А.Мережко. Lex mercatoria. Теория и принципы транснационального торгового права. Киев 1999 с. 122

³ Мөн бүтээл с. 114

⁴ Мөн бүтээл с. 121

БЕРНИЙН КОНВЕНЦИЙН МАТЕРИАЛЛАГ ХЭМ ХЭМЖЭЭ

ХБНГУ-ын Фрайбургийн Их сургуулийн Хууль зүйн факультетийн Эдийн засгийн эрх зүйн институтын докторант Д. УЯНГА

A. Өмнөх үг

1971 онд Парист хянан баталсан Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах Бернийн 1886 оны конвенц (цаашид Бернийн конвенц гэх) материаллаг болон зохион байгуулалтын гэсэн хоёр бүлэг зохицуулалтыг агуулдаг. Материаллаг эрхийн хэм хэмжээ нь зохиогчийн эдлэх эрхийг, зохион байгуулалтын бүлэг нь Бернийн холбооны гишүүн улсуудын хамтын ажиллагааны хэлбэр, хүрээг тус тус тодорхойлсон. Гишүүн улс бүрийн оюуны өмчийн эрхийн салбарт ажилладаг хууль хэрэглэгчид буюу хэрэгжүүлэгчид материаллаг эрхийн хэм хэмжээтэй танилцаж, суралцсан байх шаардлагатай байдаг. Учир нь оюуны өмчийн эрх зүй зах зээл хөгжсөн орнуудад ч зохиогчийн эрхийг хамгаалахад чиглэдэг боловч энэ нь эдийн засгийн утгаараа утга зохиол урлагийн салбар дахь зах зээлийг хамгаалах чухал хэрэгсэл юм.

Манай Улс олон улсын зохиогчийн эрх зүйн салбарт Бернийн конвенц болон Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах тухай 1994 оны Марракешийн хэлэлцээний салшгүй хэсэг болсон Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай 1994 оны хэлэлцээр (ТРИПС)-т нэгдэн орсон. ТРИПС-ийн 9дүгээр зүйлийн дагуу Монгол Улс Бернийн конвенцын материаллаг хэм хэмжээг даган мөрдөх үүргийг хүлээсэн. Ингэхээр манай улс Бернийн конвенцийн материаллаг хэм хэмжээнүүдийг мөн ТРИПС-ийн дагуу дагаж мөрдөх үүрэгтэй. ТРИПС Бернийн конвенцийн

материаллаг хэм хэмжээнүүдээр баталгаажуулсан заавал биелүүлэх эрхээс гадна цахим тооцоолуурын хөтөлбөр болон мэдээллийн санг заавал хамгаалах ёстой бүтээл хэмээн зарлаж, үүний дээр бүтээлийн зүйлийг хөслөх буюу түрээслэх эрхийг баталгаажуулдаг.

Энэ удаагийн нийтлэлээр Бернийн конвенцийн материаллаг хэм хэмжээнүүдийн ерөнхий агуулга, конвенцийн үндсэн зарчмуудын талаар авч үзье.

B. Ерөнхий зүйл: системчлэл, агуулга

Бернийн конвенцийн анхдугаар хувилбар 1886 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш нийт зургаан удаа шинэчлэгдэн өөрчлөгдсөн билээ. Шинэтгэлүүд нь анхны хувилбарын ерөнхий бүтцийг нэг их хөндөөгүй учир конвенцийн системчлэл орчин үеийн зохиогчийн эрхийн хуулиудтай харьцуулашгүй юм. Тухайлбал:

Зохиогчийн эрх нь хэвлэгдчихсэн байгаа, бодтойгоор баригдах эд зүйлс болох номын хувьд биш, харин тэр номонд илэрхийлэлээ олсноор бусдад хүртэгдэх боломжтой болсон оюун санааны үйл ажиллагааны үр дүнгийн хувьд үүсдэг. Бернийн конвенцийн анхны хувилбаруудыг баталж байх үед энэ ойлголт одоогийн шиг мэдээжийн хэрэг байсангүй.¹ Иймээс ч аливаа бүтээлийг орчуулах, дахин найруулан өөрчлөх хоёр үнэн хэрэгтээ оюуны ойролцоо үйл ажиллагаа бөгөөд нэг талаас эх бүтээлийн зохиогч ба орчуулагч нөгөө талаас эх бүтээлийн зохиогч ба өөрчлөн найруулагч нарын

хоорондох эрхийн харилцаа үнэндээ нэг л жил шинж чанартай болохыг хараахан таниагүй байсан учир орчуулах эрх конвенцын 8 дугаар зүйлд, өөрчлөн найруулах эрх 12дугаар зүйлд тусдаа баталгаажсан байдаг.

Бернийн конвенцийн материаллаг хэм хэмжээнүүд нь конвенцоор хамгаалагдах бүтээл, бүтээл хамгаалахад тавигдах шаардлагууд, конвенцийн үндсэн зарчмууд болон конвенцоор хамгаалагдах этгээдүүд болон тэдгээрийн эдлэх эрхийг тодорхойлдог. Эдгээр хэм хэмжээнүүд нь конвенцын эхний хорин нэгэн зүйлд агуулагдана. Конвенцын хавсралт буюу хөгжиж буй орнуудад зориулсан тусгай зохицуулалт нь 21дугаар зүйлийн дагуу материаллаг хэм хэмжээний нэгэн салшгүй хэсэг юм.

Конвенцоор шууд баталгаажуулсан зохиогчийн амины болон бүтээл ашиглах бүрэн эрхүүдийг зохиогч нь 2-р зүйлийн каталогид заасан бүтээлүүдийн хувьд заавал эдлэнэ. Зохиогчийн амины эрх нь нэрээ хэрэглэх, дуудуулах эрх, мөн бүтээл халдашгүй байх эрх юм. Бүтээл ашиглах бүрэн эрх нь бүтээлийг орчуулах, хуулбарлах, нийтэл үзүүлэх, телевиз, радиогаар нэвтрүүлэх, өөрчлөн найруулах, кино бүтээл хийхэд ашиглахад чиглэнэ. Мөн түүнчлэн харилцан эрх тэгш байх зарчмын үндсэн дээр уран зургийн болон дүрслэх урлагийн эх бүтээл, эх гар бичвэрийг бусдын өмчлөлд шилжүүлэхтэй холбогдсон шимтгэлийн эрхийг конвенцоор баталгаажуулсан байдаг. Конвенцийн хамгаалалт зөвхөн заавал биелүүлэх ёстой эрхүүдээр хязгаарлагдахгүй. Үүний дээр үндэсний нөхцөл үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, гишүүн улс дотоодын хуулиараа өөрийн

¹ Энэ талаарх нотолсон өгүүлэлгүйг: Ikle, G., Zum sachlichen Geltungsbereich der Berner Uebereinkunft, UFITA 14 (1941) 365-384;

улсын иргэнд олгосон аливаа эрхийг конвенцоор хамгаалагдсан этгээдэд эдлүүлэх үүргийг хүлэсэн байдаг.

B. Үндсэн зарчим

Заавал биелүүлэх эрхийн зарчим, үндэсний нөхцөл, хэлбэрийн шаардлага тавихгүй байх зарчим нь Бернийн конвенцийн үндсэн зарчмууд юм. Үүний дээр холбооны харилцан эрх тэгш байх зарчим үйлчилдэг.

1. Холбооны зарчим

Бернийн конвенцийн анхны хувилбар 1886 онд батлагдсан гэж дурдсан. Энэ хувилбар буюу түүний дараагийн хувилбарууд бие даасан гэрээний хэлбэртэй үйлчилж байдаг. Монгол улсын нэгдэн орсон Парисын хувилбар нь конвенцийн хамгийн сүүлийн зөвшилцөөний үр дүн юм. Үүнээс өмнө Парисын 1896 оны, Берлиний 1908 оны, Бернийн 1914 оны, Ромын 1928 оны, Брюсселийн 1948 оны, Стокгольмын 1967 оны хувилбарууд Бернийн холбооны хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдаж байжээ.¹

Бернийн конвенцийн хүчин төгөлдөр болсон хувилбаруудад нэгдэн орсон улсууд конвенцийн 1 дүгээр зүйлд зааснаар “Бернийн холбоо” гэгчийг бүрдүүлнэ. “Холбооны зарчмын” материаллаг ач холбогдол нь конвенцийн сүүлийн хувилбарт нэгдэн орсон гишүүн улс энэ хувилбарт нэгдэн ороогүй өөр нэг гишүүн улсын өмнө түрүүчийн хувилбарын дагуу хүлэсэн үүргээ биелүүлсээр байх

зарчим үйлчилдэгт оршино.² Жишээ нь: Мадкаскар улс Брюсселийн 1948 оны хувилбарын гишүүн.³ Франц улс Брюсселийн хувилбарын гишүүн байсан боловч 1971 оны Парисын хувилбарт нэгдэн орсон. Франц Улс ийнхүү Парисын хувилбарын гишүүн болсон явдал нь түүний Брюсселийн хувилбараар Мадкаскар улсын өмнө хүлэсэн үүргийг хүчингүй болгохгүй буюу өөрчлөхгүй.

2. Үндэсний нөхцөл

Утга зохиол, урлагийн бүтээлийг бүтээх зардал өндөр байж болох боловч, түүнийг хуулбарлаж, тараах нь маш хялбар аргаар, хямдаар хийгдэж байна. Зохиолч хүн өөрийн хоёр, гурван жилийн турш хичээнгүйлэн судалснаа нэгтгэн ном болгон гаргахдаа өөрийн олон жилийн хөдөлмөрийг тооцож, ном өндөр шан хараж авч байж хэвлүүлэх сонирхолтой байдаг. Харин номыг нь хэвлэн, борлуулах хэвлэлийн байгууллага⁴ зохиогчид аль болох бага хөлс өгч, их ашиг олохыг эрмэлзэнэ. Сонирхолын энэ зөрчилдөөнийг улс орны хүрээнд аваад үзвэл, улс төрчид дотоодын зохиогчдын эрхийг хуулиар баталгаажуулж өгөхийг эрмэлзэх бөгөөд харин гадаадын зохиогчдын эрх ашгийг дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдээс доогуурт үзжээ, тэдэнд дотоодын зохиогчдод олгосон эрхийг тийм ч амар өгөхгүй.

Улс орон бүрийн дээрх бодлогыг баримтлах үед соёл, хэл нь олон улсад ойлгогдох хүчирхэг

гүрнүүдийн хувьд, нэн ялангуяа тэдний утга зохиол, урлагийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагуудад гадаад зах зээл дээр ашиг олох боломж хаалттай байсан байх болно. Учир нь эдгээр бизнесийн байгууллагууд зохиогчийн эрхийн хамгаалалт үгүйгээс болж гадаад зах зээлд өөрсдийн санхүүжүүлж, бүтээсэн ном, кино бүтээл, цахим тооцоолуурын хөтөлбөр зэргийг худалдаалж, нийтэд үзүүлж ашиг, орлого олж чадахгүй байсаар байна. Хөгжингүй орнууд өөрийн улсын зохиогчдыг гадаадад алгаварлан гадаргуулахгүй байх, улмаар өөрийн бизнесийн байгууллагад гадаад улсад өрсөлдөөний ижилхэн гарааг бий болгох талаар шахалт үзүүлэх нь тэдэнд эдийн засгийн үр дүнгээ шууд өгөх учиртай.

XIX зууны эхэн ба дунд үе гэхэд зохиогчийн эрхийн эрх зүйн салбарт үндэсний нөхцөлийг олгох тухай маш олон тооны хоёр талын гэрээнүүд байгуулагдсан. Ийм гэрээг эдийн засгийн хувьд хүчирхэг нэг улс хүл сул өөр нэг улсад худалдааны гэрээ байгуулахыг үндсэн нөхцөл болгож тулган, хүлээн зөвшөөрүүлж байжээ (жишээ нь: Англи Америкийг, Франц Бельгийг гэх мэт).⁵ Үүний үр дүнд XIX зууны сүүл үе гэхэд европын бүх улсууд зохиогчийн эрхийн салбарт үйлчлэх олон арван тооны хоёр талын гэрээнүүдэд нэгдэн орсон байсан. Эцэстээ энэ нь аалзны тор мэт хэлхэлдсэн олон арван хоёр талын гэрээг халж, олон талын

¹ Нэгэнт хэлэлцэн батлагдсан конвенцийн төсөлд Бернийн холбооны хуучин гишүүд болон шинээр гишүүн болон орохыг эрмэлзэх улс орнууд нэгдэн орох шаардлагатай. Конвенцийн үндсэн нөхцөлд заасан улсууд нэгдэн орсноор төсөл хүчин төгөлдөр болно. Бернийн холбооны хэлэлцүүлсэн конвенцийн хувилбар бүр хүчин төгөлдөр болж байсангүй. Жишээ нь: Стокгольмын 1967 оны хувилбарыг хөгжиж байгаа орнуудын шаардлагаар хэлэлцсэн. Стокгольмын хувилбар нь тухайн үед хөгжсөн орнуудын утга зохиол урлагийн салбарт үйл ажиллагаа явуулагч бизнесийн байгууллагуудын эсэргүүцэлтэй тулгарч байсан тул их шуугин, дуулиан дунд батлагдсан боловч эцэстээ энэ хувилбарт хөгжиж буй орнууд өөрсдөө ч идэвхитэйгээр нэгдэн ороогүй байна. Стокгольмын 1967 оны хувилбар Бернийн конвенцийн хэзээ ч хүчин төгөлдөр болоогүй нэг хувилбар юм.

² Парисын хувилбарын 32 дугаар зүйл.

³ www.wipo.int/treaties/en/ip/berne/index.html

⁴ Өрнөдийн орнуудын хэвлэлийн зах зээлийн дотоод зохион байгуулалт монголын зах зээлийн өнөөгийн түншинээс ихээхэн алгаатай байсаар ирсэн. Төнд хэвлэлийн байгууллагууд зохиогчдын гэрээ байгуулсны үндсэн дээр зохиогчийн эрхийг тодорхой хугацаатайгаар өөрт шилжүүлэн авдаг. Хэвлэлийн байгууллагууд зохиогчийн бүтээлийг хэвлээд зогсохгүй, нийтэд тарааж, худалдаалахыг эрх шилжүүлэн авсан хугацааныхаа дотор зохион байгуулж байсан. Энд хэвлэлийн байгууллага болон зохиогчийн хоорондох сонирхолын зөрчилдөөнийг өрнөдийн орнуудад хэвшсэн зах зээлийн үүднээс авч үзвэл.

⁵ Бернийн конвенцыг байгуулах түүхэн нөхцөл байдлын талаар: Boytha, Fragen der Entstehung des internationalen Urheberrechts, S. 182 ff. In: Dittrich Robert, (Hrsg.) Woher kommt das Urheberrecht und wohin geht es?, Wien 1989.

гэрээ байгуулж, олон улсын эрх зүйд ойлгомжтой байдлыг бий болгох түүхэн нөхцөлийг бий болгожээ. Ийнхүү хүчин төгөлдөр болсон анхны олон талын гэрээ бол Утга зохиол урлагийн бүтээлийг хамгаалах Бернийн конвенц бөгөөд түүний үндсэн зарчим нь мэдээжээр үндэсний нөхцөл байсан юм.

Үндэсний нөхцөл нь Бернийн конвенцийн Парисын хувилбарын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3 дахь хэсгийн 2 дахь заалтад баталгаажсан: 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу зохиогчид нь конвенцоор хамгаалагдсан бүтээлийнхээ төлөө "эх улсаас" бусад бүх Бернийн холбооны улсад хуулийн дагуу дотоодын зохиогчдын эдлэх байгаа эсвэл ирээдүйд эдлэх эрхийг эдлэнэ. "Эх улс" гэдгийг 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсон. Бүтээл анх нийтийн хүртээл болсон гишүүн улс, бүтээл нийтийн хүртээл болоогүй бол бүтээлийн зохиогч харьяалагдах гишүүн улс "эх улс" байх зарчим үйлчилдэг. Хэрэв зохиогч бүтээлээ анх нийтийн хүртээл болгосон улс буюу "эх улсад" харьяалагдахгүй бол тэрээр 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу үндэсний нөхцлийг эдлэх эрхийг эдлэхгүй. Энэ тохиолдолд 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр нэмэлт болон үйлчилнэ: "Эх улсад" харьяалагдахгүй зохиогчид ч гэсэн үндэсний нөхцлөөр хамгаалалт эдлэнэ.

Үндэсний нөхцлийн агуулгыг Бернийн конвенцийн зохиогчийн эрхийг хамгаалах зорилгыг харгалзан өргөнөөр тайлбарлах жишиг олон улсад тогтсон байдаг. Үндэсний нөхцлийн агуулгыг 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь

хэсгийн 2 дахь өгүүлбэр ерөнхийд нь тодорхойлж өгдөг. 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зохиогч "өөрийн бүтээлийнхээ төлөө" эдлэх эрхийн тухай дурьджээ. Иймээс үндэсний нөхцөл нь зохиогчийн төрөлжсөн эрх буюу тодорхой нэг бүтээлийн хувьд эдлэх эрхийг тодорхойлж өгсөн болон энэ эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон гишүүн улсын дотоодын хуулийн хэм хэмжээний хувьд үйлчилнэ.¹

3. Харилцан эрх тэгш байх зарчим²

Олон улсын зохиогчийн эрх зүйн хувьд харилцан эрх тэгш байх зарчим нь хэрэв А улс Б улсын иргэнд бүтээл олшруулах эрх олговол Б улс А улсын иргэнд мөн адил бүтээл олшруулах эрх олгоно гэсэн нөхцөлтэйгөөр материаллаг байдлаар хэрэгждэг. Харилцан эрх тэгш байх зарчим ийнхүү материаллаг байдлаар үйлчлэх тохиолдолд үндэсний нөхцөл шууд хэрэгжих боломж байхгүй. Иймээс Бернийн конвенцийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...энэхүү [эрхийг] эдлэх болон хэрэгжүүлэх нь бүтээлийн "эх улсад" хамгаалалт үүсэхээс эс хамаарна. Үүний дагуу хэрэв энэхүү конвенцд өөрөөр заагаагүй бол хамгаалалтын агуулга болон зохиогчийн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн арга зам нь зохиогч хамгаалалт хүсч буй улсын хуулиар тодорхойлогдоно." гэж заажээ. Энэ заалт үндэсний нөхцөл зөвхөн конвенцд заасан онцгой тохиолдолд л харилцан эрх тэгш байх зарчмаар хязгаарлагдана гэж тунхаглажээ.

Парисын хувилбарт харилцан эрх тэгш байх зарчмыг баримтлан 14 дэх зүйлийн "шимтгэлийн эрх"-ийг баталгаажуулдаг. Шимтгэлийн эрх нь уран зураач, уран

барималчдад өөрийн бүтээлийн эх хувийг, утга зохиолын зохиолчид өөрийн эх гар бичмэлийг, мөн хөгжмийн зохиолчид өөрийн гараар бичсэн нотыг бусдын өмчлөлд шилжүүлэн худалдаалсан орлогоос тодорхой хувиар бодож шимтгэл шаардан авах боломжийг олгодог. Хэрэв зохиогчийн эх улс шимтгэлийн эрхийг дотоодын хуулиараа баталгаажуулсан бол 14 дэх зүйлийн 2 дахь хэсгийн дагуу зохиогч гишүүн улсын иргэдийн нэг адил шимтгэлийн эрхийг эдлүүлэх шаардах эрхтэй.

4. "Заавал эдлэх" эрхийн зарчим

Үндэсний нөхцлийг тэгш эрхийн зарчмыг үл харгалзан баталгаажуулснаар зохиогчийн эрхийг өндөр түвшинд хамгаалж буй нэг улс конвенцоор хамгаалагдсан гадаадын иргэдийг өөрийн иргэдийн нэгэн адил үзэх, хамгаалах үүрэг хүлээдэг. Ийнхүү хамгаалалтыг тухайн хамгаалалтын өндөр түвшин бүхий улсын иргэд гадаад улсад дотоодод эдэлдэг шигээ эрхийг эдлэх эсэхээс үл харгалзан эдлүүлэх нь олон улсын түвшинд эрх тэгш бус байдлыг бий болгоно. Жижээ нь: ХБНГУ-ын Зохиогчийн эрхийн тухай хууль зураачдад өөрийн бүтээлийг анх удаа үзэсгэлэнд тавихыг зөвшөөрөх буюу хориглох эрхийг олгодог. Иймээс Монгол Улсын иргэн зураач Бернийн конвенцийн үндэсний нөхцлийг баримтлан ХБНГУ-д тус улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн дагуу бүтээлээ анх удаа үзэсгэлэнд тавьж, олонд таниулахыг хориглох бүрэн эрхийг эдлэнэ. Монгол зураач Монгол Улсад, тус улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу бүтээлээ анх удаа үзэсгэлэнд гаргах эрх эдлэхгүй байхаас үл

¹ Masouye, Kommentar zur Berner Uebereinkunft, Muenchen 1981, Aum. 5.6; Bappert/Wagner, Internationales Urheberrecht, Muenchen und Berlin 1956, Art. 4 RBUE Rn. 26; Bergstroem, Schutzprinzipien der Berner Uebereinkunft nach der Stockholm-Pariser Fassung, GRUR Int. 1973, 238, 242; S. 69; Nordemann/Vinck/Hertin, Internationales Urheberrecht und Leistungsschutzrecht der deutschsprachigen Laender unter Beruecksichtigung auch der Staaten der Europaeischen Gemeinschaft, Duesseldorf 1977, Art. 5 RBUE, Rn. 2; Wyler, Die Gleichbehandlung in- und auslaendischer Urheber in der Schweiz, in: Schweizer Festschrift zum hundertjaehrigen Bestehen der Berner Uebereinkunft, Die Berner Uebereinkunft und die Schweiz, Bern 1986, S. 219, 227.

² Эрх тэгш байх зарчим нь олон улсын нийтийн эрх зүйд хэлбэрийн хувьд эсвэл материаллаг байдлаар хэрэгждэг. Үндэсний нөхцөл нь эрх тэгш байдлыг хэлбэрийн хувьд хангасан байдаг. Нэг улс өөрийн улсын иргэнийг гадаад улсад ялгаварлан гадуурхахгүй гэж үзээд гадаад улсын иргэнд өөрийн иргэнд олгож буй таатай нөхцлийг олгоно. Ингэснээр эрх тэгш байдал хэлбэрийн хувьд буюу хийсвэр байдлаар хэрэгждэг. Өгүүлчдийн "Эрх тэгш байдлын зарчмын" тухай энэ хэсэгт материаллаг байдлаар буюу бодьтойгоор хэрэгжих ёстой тэгш байдлын талаар яригдаж байна.

хамааран ХБНГУ-д герман зураачдын нэгэн адилаар тус эрхийг эдлэнэ. Харин герман зураач манай улсад монголын зураачдын нэгэн адил эрх эдлэх тул бүтээлээ анх удаа үзэсгэлэнд тавьж, нийтэд танилцуулах онцгой эрхийг эдлэхгүй.¹

Ийнхүү олон улсын түвшинд бодит байдал дээр гарч буй эрх тэгш бус байдлыг үндэсний нөхцлийг хөндөхгүйгээр даван туулах нэг арга зам бол “заавал эдлэх” эрхийг баталгаажуулах явдал юм. Заавал эдлэх эрхийг конвенцоор хамгаалагдсан этгээдүүд шууд эдлэх зарчимтай бөгөөд, ингэснээр олон улсын түвшинд материаллаг эрхийн нэгдсэн систем бий болдог. Бернийн конвенцийн нэг онцлог заавал эдлэх эрх үндэсний нөхцлийн нэгэн адил “эх улсад” үйлчилдэггүйд оршино. Эх улс нь зарчмын хувьд бүтээл анх нийтийн хүртээл болсон улс буюу хэрэв бүтээл нийтийн хүртээл болоогүй бол бүтээлийн зохиогчийн харьяалагдаж буй улс байдаг. Иймээс ихэнхи тохиолдолд гишүүн улсын харъяат иргэд өөрийн улсдаа Бернийн конвенцийн заавал эдлэх эрхийг эдлэхгүй. Дүгнэвэл, заавал эдлэх эрх нь гадаад этгээдийн материаллаг эрхийн хамгаалалтын олон улсын түвшинг тогтоож өгдөг.

Парисын хувилбарт зохиогчийн нэрээ хэрэглэх буюу дуудуулах эрх, бүтээл халдашгүй байх эрх гэсэн амины эрхийг заавал эдлэх эрх хэмээн тунхагласан. Бүтээл ашиглалтын хувьд эдлэх зохиогчийн заавал эдлэх эрх нь бүтээлийг орчуулах, хуулбарлах, нийтэд үзүүлэх, телевиз, радиогоор нэвтрүүлэх, өөрчлөн найруулах, кино бүтээл хийхэд ашиглахад чиглэнэ.

Заавал эдлэх эрхийн зарчим нь үндэсний нөхцөлийг хөндөхгүйгээр үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, заавал эдлэх эрхийг баталгаажуулснаар зохиогч холбооны нэг улсад конвенцоос гадуур олгож буй эрхийг эдлэхгүй гэсэн үг биш юм. Хэрэв гишүүн улс дотоодын хууль тогтоомжоороо “заавал эдлэх” эрхээс гадна өөр ямар нэг эрхийг өөрийн улсын иргэн зохиогчид олгосон байвал Бернийн конвенцоор хамгаалагдсан “гадаадын зохиогч” түүнийг үндэсний зарчмын дагуу эдлэх эрхтэй. Жишээ нь: дээр дурдсан зургийн урлагийн бүтээлийг анх удаа үзэсгэлэнд тавьж, олонд таниулах эрх нь Бернийн конвенцоор заавал эдлэх эрхийн хэлбэрээр баталгаажаагүй. Гэсэн хэдий боловч Монгол Улсын иргэн зураач ХБНГУ-д өөрийн бүтээлийг анх үзэсгэлэнд гаргах эрхийг Бернийн конвенцийн үндэсний нөхцлийн дагуу эдлэнэ. Дүгнэвэл, заавал эдлэх эрх бол конвенцоор хамгаалагдсан этгээдүүд “дор хаяж” эдлэх ёстой эрх юм. ² Үүнийг Бернийн конвенцийн 19 дүгээр зүйл эргэлзээгүйгээр баталгаажуулсан бөгөөд тэнд гишүүн улсын дотоодын хуулиар олгосон илүү өргөн хамгаалалтыг эдлэхэд конвенцийн материаллаг хэм хэмжээнүүд саад болохгүй гэж заасан байдаг.

5. Хэлбэрийн шаардлага тавихгүй байх зарчим

5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрт конвенцоор олгосон эрхийг эдлэх болон хэрэгжүүлэхэд аливаа нэг хэлбэрийн шаардлага тавигдах ёсгүй гэж заажээ. Хэлбэрийн шаардлага гэдэгт бүтээл, бүтээл ашиглах эрх шилжсэн тухай гэрээг улсын бүртгэлд бүртгүүлж,

зохиогчийн буюу эрх эзэмшигчийн гэрчилгээ авах шаардлага тавих асуудал зүй ёсоор хамаарагдана. Хэлбэрийн шаардлага тавихгүй байх зарчмын үйлчлэл нь заавал эдлэх эрхийн нэгэн адил гадаад этгээдийн эрхийн хамгаалалтын олон улсын түвшинг тогтоодог: Гишүүн нэг улсын харъяат иргэд зохиогчийн эрхийн гэрчилгээ авснаар эрх эдлэх ёстой байж болно. Ийм тохиолдолд Бернийн конвенцоор хамгаалагдсан гадаад иргэд энэ улсад үндэсний нөхцлийн дагуу олгох дотоодын хуулиар баталгаажуулсан эсвэл конвенцоор шууд баталгаажуулсан зохиогчийн аливаа эрхийг ийм гэрчилгээ авсан эсэхээс үл хамааран эдлэх ёстой.

Утга зохиол, урлагийн салбарт явагдаж буй аливаа бизнесийн үйл ажиллагаа буюу зохиогчийн эрх үүсэх, шилжүүлэх, дуусгавар болох явдал төрийн эрх бүхий байгууллагын аливаа нэг зөвшөөрлөөс хамаарах, ингэснээр түүний хяналтанд байх нь хэлбэрийн шаардлагад хамаарна. Харин процессийн нотолгоо болгох үүднээс бүтээлийг материаллаг эд юмсад буулгасан байх шаардлага тавих явдал хэлбэрийн шаардлагад тооцогдохгүй.

Бүтээлийг материаллаг эд юмсад буулгах шаардлага тавих бүрэн эрхийг гишүүн улсын хууль тогтоогчдад Бернийн конвенцийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг олгосон. Өөрөөр хэлбэл, нэгэн бүжгэн жүжгийн зохиолыг видео cassette дээр буулгаж, зохиогч өөртөө хадгалсан үлдээх шаардлагыг гишүүн улсын дотоодын хуулиар тавьсан байна гэж үзье. Энэ шаардлагыг дотоодын иргэд төдийгүй конвенцоор хамгаалагдсан гадаадын иргэд биелүүлж байж, өөрийн бүжгэн жүжгийн бүтээлийн зохиогчийн эрх зөрчигдсөн байна гэдгийг нотлох боломжтой болно. ³ Харин касетийг төрийн эрх бүхий байгууллагад тусгайлан хадгалуулах ёстой гэх мэтийн шаардлага нь дээр дурдсан тодорхойлолтын дагуу хэлбэрийн шаардлага болох учир энэ нь конвенцоор хамгаалалт эдлэх этгээдүүд эрхээ эдлэх, хэрэгжүүлэхэд үйлчлэхгүй.

¹ Энэ талаар Д. Уянгын “Зохиогчийн бүтээлийнхээ төлөө эдлэх эрх” номын Зохиогчийн эрхийн тухай хуулийн 9дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн № 3 ба 4-ийн тайлбарыг харьцуулан үзнэ үү.

² Nordemann, Vinc, Hertin, Internationales Urheberrecht und Leistungsschutzrecht der deutschsprachigen Laender unter Beruecksichtigung auch der Staaten der Europaeischen Gemeinschaft, Duesseldorf 1977, Art. 5 RBUE, Rn. 3.

³ Хэрэв дотоодын хууль тогтоогч энэ эрхийг хэрэглэгчгүй бол үндэсний нөхцөл үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, гадаадын зохиогчид дотоодын зохиогчдын нэгэн адил бүтээлээ касетанд буулгасан эсэхээс үл хамааран зохиогчийн эрх зөрчсөн талаар өөр нотлох баримтуудыг үндэслэн шүүхийн өмнө нэхэмжлэл буюу шаардлага тавих бүрэн эрхтэй.

Г. Дүгнэлт

Хавсралт

Бернийн конвенцийн үндсэн зарчим бол үндэсний нөхцөл юм. Хамгаалалт хүсч буй гадаадын зохиогч өөрийн харьлт улсдаа хамгаалалт эдлэх эсэхээс үл хамааран үндэсний нөхцлийн дагуу дотоодын иргэн зохиогчийн нэгэн адил эрх эдлэнэ. Үүний дээр тэрээр конвенцоор түүнд шууд баталгаажуулж өгсөн заавал эдлэх эрхийг эдлэнэ. Заавал эдлэх эрх нь дотоодод гадаадын этгээдийн сонирхолыг хамгаалахад чиглэдэг. Иймээс дотоодын хуулиар олгосон зохиогчийн эрх, хэмжээ Бернийн конвенцийн заавал эдлэх эрхийн түвшинд хүрэхгүй байвал дотоодын зохиогчид өөрийн улсдаа гадаадын зохиогчдоос бага эрх эдлэх үр дагавартай. Үүнээс дотоодын хуулийн хамгаалалтын түвшинг конвенцийнхтой дүйцүүлэх шаардлага урган гардаг.

Заавал эдлэх эрхтэй адил үр дагаварыг хэлбэрийн шаардлага тавихгүй байх зарчим бий болгоно: Зохиогчийн эрхийн эрх зүйн салбар дахь аливаа хүнд суртал, төрийн байгууллагын явцуу эрх ашиг нь зөвхөн дотоодын иргэдийн хувьд үйлчлэх зарчимтай. Энэ нь эцсийн дүндээ утга зохиол урлагийн бүтээлийн дотоодын зах зээлийн чөлөөт байдлыг алдагдуулах сөрөг талтай учир зохиогчийн эрх үүсэх, хэрэгжүүлэх, дуусгавар болгохтой холбогдон зохиогч, эрх эзэмшигчийн гэрчилгээ олгох, бүртгэл хийх зэрэг хэлбэрийн шаардлагыг тавихгүй байх ёстой.

Энэхүү өгүүлэлтэй холбогдсон Бернийн конвенцийн заалтуудыг хавсралтаас үзнэ үү.

**УТГА ЗОХИОЛ,
УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ
ХАМГААЛАХ БЕРНИЙН
КОНВЕНЦООС**

1 дүгээр зүйл Энэхүү конвенцийг хэрэглэж байгаа улсууд нь утга зохиол урлагийн бүтээлд холбогдох зохиогчийн эрхийг хамгаалах холбоог бүрдүүлнэ. ...

5 дугаар зүйл 1. Зохиогчид н-энэхүү конвенцоор хамгаалагдсан бүтээлийнхээ төлөө бүтээлийн эх улсаас бусад холбооны бүх улсад дотоодын зохиогчдод холбогдох хуулиар олгож байгаа эсвэл ирээдүйд олгох эрхүүдийг мөн түүнчлэн энэхүү конвенцоор тусгайлан олгосон эрхүүдийг эдлэнэ. **2.** Энэхүү эрхүүдийг эдлэх болон хэрэгжүүлэхэд аливаа нэг хэлбэрийн шаардлага тавигдахгүй: эрх эдлэх, хэрэгжүүлэх явдал нь бүтээлийн эх улсад хамгаалалт үүсч байгаагаас үл хамаарна. Үүний дагуу хэрэв энэхүү конвенцод өөрөөр заагаагүй бол хамгаалалтын агуулга болон зохиогчийн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн арга зам нь зохиогч хамгаалалт хүсч буй улсын хуулиар тодорхойлогдоно. **3.** Эх улс дахь хамгаалалт түүний дотоодын хуулиар тодорхойлогддог. Энэхүү конвенцоор бүтээл нь хамгаалагдах зохиолчид эх улсад хамгаалагдахгүй тохиолдолд дотоодын зохиогчдын эрхийг мөн эдэлнэ. **4.** Эх улс гэдэг нь: (a) бүтээл анх нийтийн хүртээл болсон холбооны улсын хувьд энэ улс; хэрэв хамгаалалтын ялгаатай хугацаатай хэд хэдэн холбооны улсад бүтээл нийтийн хүртээл болсон бол дотоодын эрх зүй нь хамгийн богино хамгаалалтын хугацаа тогтоосон улс; (b) холбооны бус болон холбооны улсад нэгэн зэрэг анх нийтийн хүртээл болгосон бүтээлийн хувьд сүүлчийн улс; (v) нийтийн хүртээл болоогүй болон холбооны улсад нэгэн зэрэг нийтийн хүртээл бололгүйгээр холбооны бус улсад анх нийтийн хүртээл болсон бүтээлийн хувьд зохиогчид харъяалагдаж байгаа холбооны улс; мөн түүнчлэн эх улс гэдэг нь: (i) кино урлагийн бүтээлийн хувьд түүнийг үйлдвэрлэгч оршин байгаа буюу байнга оршин суугаа холбооны улс; (ii) ...

**FROM THE BERNE
CONVENTION FOR THE
PROTECTION OF LITERARY
AND ARTISTIC WORKS**

Article 1 The countries to which this Convention applies constitute a Union for the protection of the rights of authors in their literary and artistic works.

Article 51. Authors shall enjoy, in respect of works for which they are protected under this Convention, in countries of the Union other than the country of origin, the rights which their respective laws do now or may hereafter grant to their nationals, as well as the rights specially granted by this Convention. **2.** The enjoyment and the exercise of these rights shall not be subject to any formality; such enjoyment and such exercise shall be independent of the existence of protection in the country of origin of the work. Consequently, apart from the provisions of this Convention, the extent of protection, as well as the means of redress afforded to the author to protect his rights, shall be governed exclusively by the laws of the country where protection is claimed. **3.** Protection in the country of origin is governed by domestic law. However, when the author is not a national of the country of origin of the work for which he is protected under this Convention, he shall enjoy in that country the same rights as national authors. **4.** The country of origin shall be considered to be: (a) in the case of works first published in a country of the Union, that country; in the case of works published simultaneously in several countries of the Union which grant different terms of protection, the country whose legislation grants the shortest term of protection; (b) in the case of works published simultaneously in a country outside the Union and in a country of the Union, the latter country; (c) in the case of unpublished works or of works first published in a country outside the Union, without simultaneous publication in a country of the Union, the country of the Union of which the author is a national, provided that: (i) when these are cinematographic works the maker of which has his headquarters or his habitual residence in a country of the Union, the country of origin shall be that country, (ii) ...

ӨМГӨӨЛӨГЧ БАЙНА ГЭДЭГ МИНИЙ БОДЛООР

«Эрх» хууль зүйн товчооны
захирал, өмгөөлөгч А.ЭНХБАТ

Нийгмийн амьдралын амин чухал асуудлууд хуулиар зохицуулагддаг тогтолцоонд Монгол улс эргэлт буцалтгүйгээр шилжин орсныг өнөөгийн амьдрал нотолно. Дэлхий нийтийн жишигт хүрэлцэхүйцээр хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулж, тэр нь бодит амьдралд хэрэгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх нь энэ нийгмийн нэн тулгамдсан чухал асуудал болж байна. Хүний эрх бол хүн төрөлхтний үнэт зүйл бөгөөд иргэний ардчилсан нийгэмд иргэн төрийн тэгш байдлыг хангах, шүүхийн өмнө тэдгээр нь эрх тэгш байх явдлыг хангах зорилт тавигддаг. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн өмгөөлөгчдийн хууль зүйн туслалцаа зайлшгүй шаардлагатай бөгөөд түүний нийгмийн үүрэг, хариуцлага холбогдох учиртай.

Өмгөөлөгч бол үйлчлүүлэгчийн итгэмжит төлөөлөгч төдийгүй шүүн таслах ажиллагааны үр нөлөөний төлөө онцгой хариуцлага хүлээсэн албан ёсны этгээд юм. Ийм учраас өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой зарим нэг асуудлаар санал бодлоо хуваалцахыг зорив.

1. Үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үүрэгтэйн хувьд өмгөөлөгч нь мэтгэлзэх зарчмын хүрээнд үйлчлүүлэгчийн байр суурийг тууштай илэрхийлэх үүрэгтэй Ингэхдээ хэргийг шударгаар эрхлэн явуулах журмыг чанд сахиж үйлчлүүлэгчид таатай үр дүн бий болгохыг аль болох эрмэлзэнэ. Өмгөөлөгч мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өндөр ур чадвар, ёс зүйтэй шүүрхай ажиллах ёстой. Мөн үйлчлүүлэгчидтэй түүний ашиг сонирхлыг төлөөлөхтэй холбогдсон бүхийл асуудлыг зөвлөлдөх бөгөөд хуулиар зөвшөөрсөнөөс бусад мэдээллийн нууцыг чанд хадгалах нь өмгөөллийн тулгуур зарчим мөн. Энэ талаар тодорхой тусгагдсан байдаг. Тухайлбал : Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлд “өмгөөлөгчөөс туслалцаа хүссэн тодорхой асуудал, үйл баримт, өмгөөлөгчийн өгсөн зөвлөгөө, тайлбар түүнчлэн өмгөөлөгч туслалцаа авагч хоёрын хооронд аминчлан ярьсан ярианд холбогдох мэдээ болон бусад баримт бичиг сэлт нь өмгөөллийн нууцад хамаарна” гэж заажээ. Мөн өмгөөлөгч өмгөөллийн нууцыг задруулах, эсвэл

амин хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хуулиар хориглосон байдаг.

Үүний зэрэгцээ үйлчлүүлэгч нь өмгөөллийн хөлс, өмгөөллийн үйл ажиллагааны арга барил, бусад холбогдох нууцыг чанд хадгалж, өмгөөлөгчийн боловсруулж өгсөн бичиг баримт, хэрэгт ач холбогдолтой нотлох баримт мэдээ, мэдээллийг бусад дамжуулах, ашиглуулах, хувилж тараах зэргээр бусдын хүртээл болгохыг хориглох, хууль зүйн хүрээнд өмгөөлөгчийн өгсөн зөвлөгөөг зөрчсөнөөс гарсан хохиролтой үр дагаварыг өөрөө бүрэн хариуцах зэрэг асуудлыг холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлагатай байгаа юм. Энд зориуд нэг жишээг дурдъя.

ИХШХШ тухай хуульд өмгөөлөгч нь гэрээний үндсэн дээр өмгөөллийн үйл ажиллагаа явуулах утга бүхий залбыг Эрдэнэтийн шүүх “өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээг ойлгоно” гэж тайлбарлан гэрээ шаардаж буй нь буруу практик тогтож байгаад бусдыг өмгөөлж хамгаалдаг мэргэжлийн хүний хувьд эмзэглэх сэтгэл төрж байна.

2. Өмгөөлөгч бол нэхэмжлэгч ба хариуцагчийг сөргөлдүүлэгч биш харин тэдний хэн алины хууль ёсны эрх

ашгийг хохироохгүйгээр ашиг сонирхолын элдэв зөрөлдөөнийг зохицуулан эвлэрүүлдэг зуучлагч байх нь нилээд оновчтой байж болох талтайг анхаарах учиртай. Энэ нь Эрүүгийн хэргийн тухайд ч хамааралтай. Жишээ нь: АНУ-д нийт эрүүгийн хэргийн 97-98 хувь нь талууд /яллагч, өмгөөлөгч/-ын ял шийтгэл наймаалцлын үр дүнг шүүхээр батлуулсанаар дуусгавар болдог. Энэ нь нэг ёсондоо мэтгэлцэгч талууд зөвшилцөлд хүрч, талуудын хэн аль нь ч эцсийн шийдвэрт сэтгэл ханамжтай үлдэж, хэргцангуй сөргөлдөөн маргаантай байдлаас зайлсхийж буй, асуудлыг шийдвэрлэх оновчтой арга зам болдог л гол агуулга нь оршино. Тэгээд ч шүүн таслах ажиллагааны нүсэр зардал, чирэгдэл, ачааллыг багасгахад чиглэсэн оновчтой шийдэл бэлддэг утгаараа талууд /прокурор, өмгөөлөгч, хариуцагч, нэхэмжлэгч г.м/-ын төдийгүй хөндлөнгийн субъект, шүүгчдийн хувьд тал бүрийн "ашигтай" байдал үүсгэдэг.

3. Өнөө үед өмгөөлөгчийн тоо эрс олширч байна. Үүнтэй холбоотойгоор зарим өмгөөлөгчийн хувьд үйлчлүүлэгч бараг олдохгүй болжээ. Тохиолдлын чанартай хэрэгт оролцсоноос болж өмгөөлөгчийн мэргэшлийн ур чадвар тэр бүр дээшилж чадахгүй байгаа мэт бодогдоно. Өмгөөлөгч эрх зүйн бүхий л төрлийн асуудлыг шийдвэрлэх тусгай бэлтгэл буюу ажлын

туршлагатай байх албагүй юм. Учир нь өмгөөллийн үйл ажиллагаа нь салбар эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байхыг өмгөөлөгчдөөс шаарддагтай холбоотой гэж үздэг.

Өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дөнгөж саяхан олж авсан шинэ өмгөөлөгч өмгөөллийн ажлын олон жилийн туршлагатай өмгөөлөгчийн хэмжээнд хүрсэн мэдлэгтэй байж болно. Гэхдээ шүүхийн практикийн мэдлэг, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх шинжлэн судлах дадлага болон хууль зүйн баримт бичгийн төсөл зохиох зэрэг нь эрх зүйн бүхий л төрлийн асуудлыг шийдвэрлэхэд туршлага дутах нь бий.

Бий болсон үйл баримт, хэрэг маргааны хуулийн дагуу зөв хэлбэршилд оруулах нь өмгөөлөгчдөөс мэргэжлийн өндөр мэдлэг боловсрол шаарддаг бол нотлох баримт бүрдүүлэх, бүрдүүлэхэд оролцох түүнийг үнэлэх нь өмгөөлөгчдөөс мэргэшлийн өндөр ур чадвар, дадлага, туршлагыг шаарддаг гэж боддог. "Англо-Саксоны" эрх зүйн бүлд багтдаг орнуудын хууль зүйн практикт "Хэргийн онол гаргах" гэж ярьж хэвшжээ.

Тухайн өмгөөлөгчийн хувьд эрх зүйн цоо шинэ салбарт үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалж буй тохиолдолд асуудлаа нарийн нягт судлах шаардлагатай болдог. Үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг мэргэжлийн өндөр түвшинд төлөөлөхийн тулд тухайн асуудлын талаар мэргэшсэн нэр хүндтэй хуульч өмгөөлөгчидтэй хэргийн талаар зөвлөлдөх явдал илүүдэхгүй. Энэ нь болсон хэрэг

явдлын эрх зүйн үндсийг судлах, задлан шинжилгээ хийх түүнчлэн хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд өмгөөллийн арга хэрэглүүрийг ашиглахыг ойлгоно.

4. Өмгөөллийг хөгжүүлэх түүний мэргэжлийн дархлааг нийгэмд төлөвшүүлэхэд онцгой хүчин зүйл бол өмгөөлөгчийн ёс зүй юм. Өмгөөлөгч хэрэв ёс зүйгээ умартах аваас тухайн мэргэжлийн үнэ цэнэ, үйл ажиллагааны утга учир алдагдахад хүрнэ.

Өмгөөлөгч нь хүн төрөлхтний эртний мэргэжил учраас урт удаан хугацааны туршид энэ мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ төлөвшиж бүрэлдсэн талаар судлаачид олонтаа тэмдэглэсэн байдаг байна.

Өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлах нь хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг тогтоох, өмгөөллийн үйл ажиллагааг үр нөлөөтэй болгох, энэ мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэхэд нэн чухал урьдач нөхцөл болдог. Ийм учраас өөрийгөө хуулийн хүрээнд ажиллаж байгаа эсэхээ хянах, бусдын эрх ашгийг зөрчихгүй байх, хүндэтгэх, хариуцлагатай байх үндэс нь ёс зүйн хэм хэмжээг сайтар судлаж мөрдлөг болгон ажиллах явдал юм.

Өмгөөлөгчийн мэргэжлийн мөн чанартай холбогдох ёс зүйн хэм хэмжээ нь өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны мөн чанарыг алдуулахгүй байлгахад чухал ач холбогдолтой билээ.

Энэ төрлийн ангилалд багтах ёс зүйн хэм хэмжээг

дараах байдлаар тоймлон авч үзье:

- Хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх зорилтыг хангахын тулд өмгөөлөгч бүр хүч чадвараа дайчлан ажиллах ёстой.

Үнэнч шударга байж, хэргийн бодит үнэнийг тогтооход анхаарал тавина.

Мэдсээр байж хуурамч мэдүүлэг, нотлох баримт ашиглан өмгөөлөл явуулж хэрхэвч болохгүй.

- Хуулийг зориуд буруу хэрэглэхийг хориглоно.

Өмгөөлөл хийхийг зөвшөөрч хэрэг хүлээн авсанаас хойш цаг алдалгүй түүнийг эцэслэн шийдвэрлүүлэх талаар бүх талын арга хэмжээ авна гэсэн үг юм.

Өмгөөлөгч хуулиа хүндлэн сахиу үүрэгтэй бөгөөд түүний зан үйл нь өмгөөлөгч үнэнч шударга байж хүмүүсийн итгэх итгэлийг бэхжүүлэхэд чиглэгдэх учиртай.

Өмгөөлөгчийн мэргэжил нь өөрийгөө удирдах ёсны зарчимд үлэмж хэмжээгээр тулгуурладаг. Өөрөөр хэлбэл өмгөөллийн үйл ажиллагаа явуулахдаа хараат бус байхыг эрхэмлэх нь чухал.

Амьдралд өмгөөлөгчийн ёс зүйн тулгамдсан асуудлын нэг нь өмгөөлөгч эсрэг талын өмгөөлөгч болон түүний үйлчлүүлэгчтэй харьцах явдал юм. Миний бодлоор өмгөөлөгч эсрэг талын үйлчлүүлэгчтэй харьцахдаа түүний өмгөөлөгчөөс зөвшөөрөл заавал авах эсхүл түүний оролцоотойгоор уулзалт ярилцлагыг зохион байгуулах нь зохимжтой мэт

санагддаг. Энэ талаар өмгөөллийн тухай хууль болон бусад баримт бичгүүдэд огт тусгагдаагүй бөгөөд амьдралд ихээхэн тохиолддог. Энэ нь барууны өмгөөллийн практикт нэгэнт хэвмэл болсон ойлголт бөгөөд бидэнд ч мэргэжлийн үүднээс хэрэг маргааныг оновчтой зөв, үр нөлөөтэй байх арга замыг сонгоход үгүйлэгдэж байна.

5. Байцаан шийтгэх ажиллагаанд мэтгэлцээний үр нөлөөг дээшлүүлэх, өмгөөлөгчийн үүрэг, ролийг нэмэгдүүлэхэд зарим нэг өөрчлөлт оруулмаар санагдаж байна.

Тухайлбал: Одоогийн мөрдөж буй хуулиар зөвхөн шүүх хуралдаанд санал, хүсэлт, нэмэлт нотлох баримт гаргах эрхтэй байгаа нь учир дутагдалтай мэт санагддаг.

Өмгөөлөгч нь баримт сэлтийг гаргаж түүнийгээ нотлох баримтад тооцуулах хүсэлт шүүхэд тавих эрхтэй байх шаардлагатай байна. Хэрэв шүүх хуралдааны явцад өмгөөлөгчийн гаргасан баримт сэлтийг яллагч /прокурор/-ын зүгээс няцааж чадаагүй буюу хүлээн зөвшөөрвөл /энэ нь иргэний болон бусад маргааны хувьд хамааралтай/ шүүх түүнийг нотлох баримтын хэмжээнд шууд үнэлж болохыг заана гэсэн үг юм. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд уг баримт сэлтийг нотолгооны чадамж, ач холбогдлыг тогтоолгох талаар шүүхээс шийдвэр гаргаж болох юм.

Жишээлбэл: Казиногийн хэмээх дуулиант хэргийн явцад гаргаж өгсөн зарим баримт сэлтүүдийг шүүх хэрхэж буй нь

тодорхой бус үлдэж байсан хэдий ч шүүх хуралдааны явцад тэдгээрийг шүүх хүлээн авч байсан нь дэвшил байсан гэж боддог.

Ийнхүү олныг нуршин өгүүлэхийн учир бол өмгөөлөгч байхын хариуцлагыг даана гэдэг наад захын дээр дурьдсан асуудлыг өмгөөлөгч хүн бүр бодож санаж явах хэрэгтэй. Үйлчлүүлэгчийнхээ сэтгэл хангалуун байх нөхцөлийг хуулийн хүрээнд бүрдүүлэх нь өмгөөлөгчийн журамт үүрэг. Чанартай, сэтгэл ханамжтай алив үйлчилгээнд мөнгө төлөх нь зах зээлийн хууль юм шүү.

Өмгөөллийг ашиг, мөнгөөр илэрхийлж харвал тэр хүний ажил хууль бус ашиг сонирхолыг бий болгоод зогсохгүй түүн лүү чиглэсэн арга, хэрэгслийг сэтгэж таарна.

Тиймээс өмгөөлөгчийн ажил нинжин сэтгэл, хүн чанар тулгуурлан бусдын аврал эрсэн сэтгэлийг мэргэжлийн ур чадвараараа ариусгаж байх тавилантай, түүндээ бусдаас материаллаг болон материаллаг бус урам авч тэтгэгдэж байдаг хэмээн би боддог. Тэр бол миний мэргэжлийн үйл.

★ ★ ★

ГЭРЭЭСЛЭЛ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн
нотариатч Р.ОНОНЧИМЭГ

Нотариатаар гэрчлэгддэг үйлдлүүдийн дундаас гэрээслэл нь харьцангуй цөөн хийгддэг боловч цаашид нийгмийн харилцаагаа дагаад өргөжих нь зайлшгүй болж байгаа юм.

Монгол Улсын Иргэний хууль, Нотариатын тухай хууль, Нотариатын үйлдэл эрхлэн хийх зааварт гэрээслэлийн тухай ойлголт, нотариатч гэрээслэлийг хэрхэн гэрчлэх тухай асуудлыг зохицуулж өгсөн байдаг. Одоо практикт дээрхи хууль тогтоомжуудыг баримтлан нотариатчид гэрээслэлийг гэрчилж байгаа болно.

Энэхүү нийтлэлдээ ОХУ-ын хууль тогтоомжид гэрээслэлийн талаар хэрхэн зохицуулж өгснийг өөрийн орны хууль тогтоомжуудтай харьцуулж үзэх замаар бичсэнээ та бүхэнд толилуулж байна.

Гэрээслэлийн ерөнхий агуулга

Иргэний хуулийн 523 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэн нас барахдаа өөрийн эд хөрөнгөө гэрээслэл үйлдэх замаар захиран зарцуулж болно. Иргэн гэрээслэл үйлдэх үедээ эрх зүйн бүрэн чадамжтай байх ёстой төдийгүй гэрээслэлээ өөрөө биечлэн үйлдэх ёстой. Гэрээслэлийг төлөөлөгчөөр дамжуулан үйлдэж болохгүй. Гэрээслэлээр зөвхөн нэг иргэн өөрийн эд хөрөнгөө захиран зарцуулах ба гэрээслэлийг хоёр болон түүнээс дээш олон тооны иргэд үйлдэж болохгүй. Гэрээслэл гэдэг өв нээснээс хойш эрх үүргийг бий болгож байгаа нэг талын хэлцэл юм.

Гэрээслэл гэдгийг иргэн нас барахдаа өөрийн эд хөрөнгийг өөрөө захиран зарцуулж байгаа

үйлдэл гэж тодорхойлж болно. Захиран зарцуулах гэдэг эд юмсын өмчлөгчийн бүрэн эрх, тодруулбал өөрийгөө нас барсны дараа түүний эд хөрөнгийг хэрхэн яаж хуваарилах, эд хөрөнгийг нь хувь заяаг хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлох эрх, эрх чөлөө юм. Гэрээслэгчийг гэрээслэл бичихэд хэн ч хөндлөнгөөс нь нөлөөлөх эрхгүй. Гэрээслэлийг бичгээр хийх бөгөөд Нотариатын болон Иргэний хуульд заасан бусад этгээдээр гэрчлүүлсэн байх шаардлагатай.

Гэрээслэгчийг амьд байх хугацаанд гэрээслэл гэрээслэгч болон өв залгамжлагчдын хооронд ямар чхэн үүргийн харилцааг бий болгодоггүй.

Гэрээслэл бол эрх зүйн үр дагаварт хүрэхийн тулд чиглэсэн нэг этгээдийн үйлдлийн үр дүн юм. Гэрээслэгч эрх зүйн бүрэн чадамжтай ямар ч иргэн байж болно. Эрх зүйн бүрэн чадамж гэдэг нь иргэний эрхийг өөрийн үйлдлээр олж авах түүнийг хэрэгжүүлэх, өөртөө иргэний үүргийг бий болгох, түүнийг биелүүлэх чадвар юм. Иймээс гэрээслэлийг эрх зүйн чадамжгүй, эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай мөн холбогдох байгууллагын шийдвэрээр эрх зүйн чадамжгүй тооцогдсон иргэн хийж болохгүй.

Бага насны хүүхэд гэрээслэл үйлдэхийг зөвшөөрдөггүй. Жишээлбэл: ОХУ-ын хууль зүйн ном, зохиолд насанд хүрээгүй иргэн /14-18 насны/ гэрээслэл үйлдэх боломжтой эсэх тухай асуудал маргаантай байдаг. Насанд хүрээгүй иргэн өөрт ногдох эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийг зөвхөн түүний эцэг эх, асран хамгаалагч, эсвэл харгалзан

дамжигчийн зөвшөөрлөөр хийж болно гэж заасан байдаг нь гэрээслэлийн хувьд бас хэрэглэгддэг. Гэтэл гэрээслэлд зөвхөн гэрээслэгчийн өөрийн хувийн хүсэл зориг хэн нэгний нөлөөнд авталгүйгээр чөлөөтэй бүрэн дүүрэн тодорхой тусгагдсан байх шаардлагатай. Үүний зэрэгцээ 18 нас хүрээгүй иргэн өөрийн хийж байгаа гэрээслэлийн мөн чанарыг бүрэн ухамсарлахгүй байж болох талтай. Энэ бүхнээс 18 нас хүрээгүй иргэнд гэрээслэл үйлдэх эрх олгох ёсгүй гэдэг дүгнэлтийг хийдэг байна.

Хууль зүй, тооцоо хэргийн сайдын 2003 онд баталсан “Нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар”-ын 4.9.5 дахь хэсэгт “Гэрээслэгч нь гэрээслэл үйлдэх үедээ ухаан санаа саруул, өөрийн хийж байгаа үйлдлийг бүрэн гүйцэд ойлгох чадвартай байсныг нотолсон эмчийн магадлагааг үндэслэн нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч түүний гэрээслэлийг гэрчлэх бөгөөд энэ нь эрүүл мэндийн шалтгаанаар бусдын асрамжинд байгаа гэрээслэгчид нэгэн адил чадамгаар” гэсэн заалтыг маш сайн анхаарч гэрээслэгчийн эрх зүйн бүрэн чадамжийг эргэлзээ байхгүй тогтоосон байх шаардлагатай. Учир нь өвлүүлэгч өөрийн эд хөрөнгийг өөрийн үзэмжээр гэрээслэх эрхээ хэрэгжүүлсэн өвлөх эрхтэй холбоотой маргааныг шүүхээр хянан хэлэлцэх явцад гэрээслэл бичиж байх үед өвлүүлэгчийн сэтгэхүйн байдал ямар байсан асуудал хөндөгддөг байна. Иймээс нотариатч гэрээслэлийг гэрчлэхдээ дээрхи заалтыг ягштал биелүүлэх хэрэгтэй юм.

Гэрээслэгч гэрээслэлээ өөрөө биечлэн үйлдэх ёстой. Ямар ч тохиолдолд гэрээслэлийг төлөөлөгчөөр дамжуулан үйлдэж болохгүй өөрөөр хэлбэл хэн нэгэнд итгэмжлэл өгөөд түүгээр дамжуулж гэрээслэл үйлдэж болохгүй. Мөн хэд хэдэн этгээдийн нэрийн өмнөөс нэг гэрээслэл үйлдэж болохгүй бөгөөд гэрээслэлийг өөр, өөрийн нэрийн өмнөөс тус тусдаа үйлдэнэ.

Гэрээслэгч урьд нь бичсэн гэрээслэлээ хэдийд ч цуцлах, өөрчлөх болон шинээр гэрээслэл бичиж болно. Энэ тохиолдолд гэрээслэгч ингэж гэрээслэлээ өөрчлөх, цуцлах болсон шалтгаанаа дурдах албагүй байж болно. Үүгээр гэрээслэл нэг талын хэлцэл болохыг давхар нотолж байна.

Гэрээслэгч гэрээслэлдээ өөрийн бүх өвлөгчийн өв залгамжлах эрхийг хасах эсвэл үүнийг хязгаарлаж болно. Мөн тэрээр гэрээслэлдээ өөрийн бүх хөрөнгөө эсвэл түүний зарим хэсгийг хуулиар хууль ёсны өвлөгчийн хүрээнд орсон, ороогүй ямар ч этгээдэд дурын хувиар хуваарилан үлдээх, тусгай гэрээслэлийн даалгавар үйлдэх зэргийг тусгаж болно.

Гэрээслэлд хэд хэдэн өвлүүлэгчийг зааж байгаа тохиолдолд тэдэнд өвлөгдөх эд хөрөнгийн хувь хэмжээг тодорхой зааж өгсөн байх шаардлагатай. Жишээлбэл: тэнцүү хэмжээтэй, хадгаламжийн 1/2 хувь, байшингийн 1/4 гэх мэт.

Хэрвээ гэрээслэгч байшин өвлүүлж байгаа бол өвлөгчдийн хувь хэмжээг зааж өгөхөөс гадна байшингийн яг аль хэсгийг хэн эзэмших вэ гэдгийг зааж өгч болно. /Жишээ нь, байшингийн 1дүгээр давхарыг хүүдээ, 2дугаар давхарыг охиндоо г.м./ Энэ нь өвлөгчдийн хооронд гарч болох маргаанаас урьдчилан сэргийлж байгаа явдал юм.

Гэрээслэгч өөрийн эд хөрөнгөө ямар этгээдэд, ямар хувь хэмжээгээр өвлүүлэх, ямар өвлөгчийн өвлөх эрхийг хасах мөн гэрээслэлдээ ямар үүрэг биелүүлэхийг даалгах, урьд өмнө бичсэн гэрээслэлээ өөрчлөх, хүчингүй болгох зэрэг асуудлыг өөрийн үзэмжээр шийдэх эрхтэй. Гэрээслэгч хэн нэгэнд гэрээслэл бичсэн эсэх, гэрээслэлийн агуулга, түүнийг өөрчилсөн эсвэл цуцалсан тухай мэдэгдэх үүрэггүй. Гэрээслэлээр дараах этгээдийг өвлөгчөөр зааж болно.

Хууль ёсны өвлөгчид, энэ тохиолдолд гэрээслэгч хуульд

заасан өвлөгчдийн дарааллыг баримтлахгүй байж болно. Өөрөөр хэлбэл эхний дарааллын өвлөгчид байхад гурав дахь дарааллын өвлөгчид өөрийн эд хөрөнгөө гэрээслэж болно.

Хууль ёсны өвлөгчид байгаа эсэхээс үл хамааран хуулиар хууль ёсны өвлөгчдийн хүрээнд ороогүй бусад иргэд

Өв нээгдэх үед татан буугдаагүй үйл ажиллагаагаа явуулж байгаа хуулийн этгээд

Төр байж болно.

Гэрээслэлийн агуулга гэрээслэгчийн дараах зүйлүүдийн аль нэгнээс бүрдэж болно. Үүнд:

1. Өөрийн хууль ёсны өвлөгчдийн өвлөх эрхийг хасах заалт. Өвлөх эрхийг дараах хоёр хэлбэрээр хасаж болно.

A. өвлүүлэгч өвлөх эрхийг нь хасаж байгаа этгээдүүдийн нэрийг шууд заах

B. Аль нэг өвлөгчийн талаар гэрээслэлд дурдахгүй өнгөрөх

Энэ хоёр хэлбэр нь хоёр өөр эрх зүйн үр дагаврыг үүсгэж байдаг. Эхний тохиолдолд гэрээслэлээр бүх эд хөрөнгөө эсвэл түүний хэсгийг өвлүүлж байна уу гэдгээс үл хамааран нэр заасан өвлөгч өвлөх эрхээ бүр мөсөн алдаж байна.

Харин гэрээслэлээр эд хөрөнгийн зарим хэсгийн хувь заяаг шийдэж байгаа тохиолдолд өвлөх эрхээ бүрмөсөн алдаж байна. Харин гэрээслэлээр эд хөрөнгийн зарим хэсгийн хувь заяаг шийдэж байгаа бол гэрээслэггүй үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өвлөгчид хувааж авах бөгөөд эдгээр өвлөгчдийн тоонд энэ өвлөгч орж болно.

2. Өвлөгчдийн хэн нэгэнд болон бүгдэд нь нийгмийн ашиг тустай ямар нэгэн үйлдэл хийхийг үүрэг болгосон заалт

3. Өв нээгдэх үед хууль ёсны өвлөгч нас барсан тохиолдолд өөр өвлөгчийг заасан заалт зэрэг болно.

Гэрээслэлийг ямар нэгэн нөхцөл зааж үйлдэж болно. Өөрөөр хэлбэл өвлөгч тодорхой насаид хүрсэн байх, эсвэл ямар нэгэн нөхцлийг биелүүлсэн тохиолдолд өвийг хүлээж авч болно гэсэн нөхцлийг зааж өгч болно. Гэвч энэ зааж байгаа нөхцөл ямар нэгэн хэмжээ хязгааргүй, иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн байж болохгүй.

Эдгээрээс гадна гэрээслэгч гэрээслэлдээ өөр бусад зүйлийг тусгах эрхтэй. Тухайлбал, гэрээслэлийн биелэлтийг хангуулах зорилгоор гэрээслэл биелүүлэгчийг томилж болно.

Гэрээслэлийн эрх чөлөө нь хууль ёсоор өвлөгчдэд зайлшгүй оногдох хувь хэмжээ буюу Иргэний хуулийн 522.3 дахь хэсгээр хязгаарлагдаж байдаг. Өөрөөр хэлбэл Иргэний хуулиар зайлшгүй хувь оногдох өвлөгчдийн эрх ашгийг зөрчсөн гэрээслэл эдгээр өвлөгчид зайлшгүй оногдох хувь хэмжээний хувьд хүчин төгөлдөр бүр байна. Үүнийг нотариатч гэрээслэгчид сануулах хэрэгтэй юм.

Өвлүүлэгч өөрийн эд хөрөнгөө хоёр буюу түүнээс дээш өвлөгчид гэрээслэсэн, гэхдээ ямар хувь хэмжээгээр авах эсвэл гэрээслэж байгаа эд хөрөнгийн ямар хэсэг нь аль өвлөгчид очих тухай заагаагүй бол эд хөрөнгийг өвлөгчдөд тэнцүү хэмжээгээр гэрээслэсэнд тооцно.

Гэрээслэлд үл хуваагдах эд юмсыг (зориулалтыг нь өөрчлөхгүйгээр биетээр хувааж үл болох эд юмс) биетээр эсгэцлэн өвлүүлэхээр гэрээслэлд заасан бол энэ нь уг гэрээслэлийг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болохгүй. Энэ тохиолдолд уг эд юмсыг тухайн хэсгийн үнийн дүнгийн хэмжээтэй тэнцэх хувиар гэрээслэсэн гэж тооцно

Гэрээслэлийг гэрчилсэн нотариат эсвэл гэрээслэлийг гэрчилсэн хуулинд заасан бусад этгээд, орчуулагч, гэрээслэл биелүүлэгч, гэрч, мөн гэрээслэгчийн өмнөөс гэрээслэлд гарын үсэг зурсан этгээд өв нээгдэхээс

өмнө гэрээслэлийн агуулга, түүнийг үйлдсэн, өөрчилсөн эсвэл цуцалсан талаарх мэдээллийг бусдад задруулах эрхгүй. Харин гэрээслэгчийн хувьд ийм шаардлага тавигдаагүй байна. Өөрөөр хэлбэл өөрийн үйлдсэн гэрээслэлийн талаарх мэдээллээ тараах эсэх нь түүний эрхийн асуудал юм.

ОХУ-д гэрээслэлийн нууц хадгалах журмыг зөрчсөн тохиолдолд гэрээслэгч нууц задруулсан этгээдээс эдийн бус хохирлыг /сэтгэл санааны хохирлыг/ арилгуулахыг шаардах, түүнээс гадна Иргэний хуульд заасан иргэний эрхийг хамгаалах бусад аргыг ашиглаж болдог байна.

1. Гэрээслэлийн хэлбэр, түүнийг үйлдэх журам

Гэрээслэлийг бичгээр хийж, үйлдсэн газар, он, сар, өдрийг зааж, нотариатаар, гэрээслэл хийсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ.

Нотариат гэрээслэлийг хууль ёсны дагуу хийгдсэн гэдгийг шалгаж, нотариатын тамга, баталгааны тэмдэг дарж гэрчилнэ. Гэрээслэлд гэрээслэгчийн овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа хаягийг тодорхой нарийн зааж өгсөн байхаас гадна өвлөгчдийн нэр /хэрэв иргэн бол түүний овог нэр, хуулийн этгээд бол түүний бүтэн нэр/-ийг бүрэн бичсэн байх шаардлагатай.

Дараах тохиолдолд нотариатаар гэрчлүүлсний нэг адил үзнэ.

Цэргийн албан хаагчийн гэрээслэлийг түүний алба хааж байгаа цэргийн ангийн удирдлага гэрчилсэн.

Хорих газар хоригдож байгаа буюу ажиллаж байгаа иргэний гэрээслэлийг хорих ангийн дарга гэрчилсэн.

Хөлөг онгоцонд зорчиж яваа иргэн болон багийн гишүүдийн гэрээслэлийг уг хөлөг онгоцны ахмад гэрчилсэн

Гэрээслэлийг бичгээр хийх, түүнийг гэрчлүүлэх тухай

шаардлагыг зөрчвөл энэ нь уг гэрээслэлийг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болно.

ОХУ-д гэрээслэлийг ангийн бичгэн хэлбэрээр үйлдэхийг зарим гарцаагүй тохиолдолд зөвшөөрдөг байна. Тухайлбал, гэнэтийн нөхцөл байдлын улмаас амь насанд аюул тулгараад байгаа нөхцөлд Иргэний хуулийн дагуу гэрээслэлийг үйлдэх боломжгүй бол өөрийн эд хөрөнгийг хэрхэх тухай сүүлчийн хүсэл зоригөө ангийн бичгэн хэлбэрээр илэрхийлж болно.

Гэнэтийн нөхцөл байдал нь бодитойгоор бий болсон, иргэний амь насанд бодитой аюулыг учруулсан нөхцөл байдлыг хэлнэ. Хууль тогтоогчид энэхүү аюул хэний буруугаар үүссэн, өөрөөр хэлбэл тухайн иргэний өөрийн буруу юу эсвэл түүний буруугаар бус бодитойгоор үүссэн гэдгийг ялган заагаж тогтоогоогүй байна. Энэ тохиолдолд хамгийн гол нь тухайн иргэний амь насанд учирч байгаа аюул бодитой байх ёстой, мөн түүнээс гадна тухайн иргэн энэ нөхцөл байдлын улмаас нотариат болон хуульд заасан гэрээслэл гэрчлэх эрх бүхий этгээдэд хандах боломжгүй байх ёстой.

Ийнхүү энгийн бичгэн хэлбэрээр гэрээслэлийг хийхдээ гэрээслэгч хоёр гэрчийг байлцуулан, сайн дураараа өөрийн гараар бичсэн байх шаардлагатай.

Хэрвээ гэрээслэгч гэнэтийн нөхцөл байдал дуусгавар болсноос хойш нэг сарын хугацаанд ОХУ-ын Иргэний хуульд заасан бусад ямар нэгэн хэлбэрээр гэрээслэл бичих боломжоо хэрэгжүүлээгүй бол гэнэтийн нөхцөл байдалд хийгдсэн гэрээслэл хууль зүйн хүчин чадлаа алдана. Гэнэтийн нөхцөл байдалд хийгдсэн гэрээслэлийг зөвхөн шүүх зохих этгээдийн хүсэлтийн дагуу уг гэрээслэл гэнэтийн нөхцөл байдалд хийгдсэн гэдгийг баталгаажуулсан тохиолдолд биелүүлнэ.

Нотариатын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу

гэрээслэл гэрчлэхэд гэрч оролцуулж болохгүй. Үүнд:

1. тухайн нотариатчийн байнгын үйлчлүүлэгч
2. насанд хүрээгүй
3. эрх зүйн чадамжгүй этгээд
4. бичиг үсэг мэддэггүй
5. монгол хэл мэддэггүй

Харин ОХУ-д гэрээслэлийг бичих, гэрчлэх, түүнд гарын үсэг зурах эсвэл гэрээслэлийг нотариатад дамжуулж байгаа тохиолдолд гэрч оролцож байгаа бол дор дурьдсан этгээдүүд гэрчээр оролцох болон гэрээслэгчийн оронд гэрээслэлд гарын үсэг зурж болдоггүй байна. Үүнд:

- Нотариат эсвэл гэрээслэл гэрчлэх эрх бүхий өөр этгээд
- Уг гэрээслэлээр эд хөрөнгө өвлөж байгаа этгээд, эсвэл уг гэрээслэлээр өвлөх эрх нь хасагдаж байгаа этгээд, тэдгээрийн гэр бүл, үр хүүхэд, эцэг эх
- Эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд
- Бичиг үсэг мэдэхгүй этгээд
- Ямар нэгэн эд эрхтний согогийн улмаас болж байгаа үйл явдлыг бүрэн ухаарах чадваргүй этгээд
- Гэрээслэл үйлдэж байгаа хэлийг бүрэн дүүрэн хангалттай эзэмшээгүй этгээд

Гэрч эдгээр шаардлагыг хангаагүй бол гэрээслэлийг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болно.

Нотариатаар гэрчлэгдсэн гэрээслэлийг гэрээслэгч өөрөө эсвэл түүний хэлсний дагуу нотариат бичсэн байх шаардлагатай. Гэрээслэлийг бичихэд техник хэрэгсэл /компьютер, бичгийн машин г.м./ ашиглаж болно.

Гэрээслэлийг гэрээслэгчийн хэлсний дагуу нотариат бичиж байгаа тохиолдолд гэрээслэгч гэрээслэлд гарын үсэг зурахаас өмнө нотариатын дэргэд бүгдийг

нь уншиж танилцах ёстой. Ийнхүү гэрээслэлийг уншиж танилцах явцад нотариатаас ямар нэг үг, өгүүлбэрийн утга саваа, эрх зүйн ач холбогдлыг тодруулж болно.

Хэрвээ гэрээслэгч гэрээслэлээ өөрөө уншиж чадахгүй бол нотариат гэрээслэлийг уншиж танилцуулж, яагаад гэрээслэгч өөрөө уншиж чадахгүй байсан шалтгааныг дурьдаж энэ тухай гэрээслэлийн дор бичнэ.

Манайд огт байхгүй гэрээслэлийн бас нэг төрлийг сонирхуулъя.

ОХУ-ын Иргэний хуулийн 1126 дугаар зүйлд хаалттай гэрээслэлийг нотариатаар гэрчлэх тусгай журмыг заасан байна. Хаалттай гэрээслэл гэдэг нь нотариат боловч бусад этгээдэд үзүүлэлгүйгээр үйлдсэн гэрээслэл юм. Гэрээслэлийн энэ төрлийн гол давуу тал нь түүний нууцыг чанд хадгалж байгаа явдал юм. Хаалттай гэрээслэлийг гэрээслэгч өөрөө бичиж, түүнд өөрөө гарын үсэг зурсан байх шаардлагатай. Хэрэв энэ шаардлагыг биелүүлээгүй бол энэ нь уг гэрээслэлийг хүчин төгөлдөр бусад тооцоо үндэслэл болно. Гэрээслэгч дугтуйнд хийж наасан хаалттай гэрээслэлийг хоёр гэрчийн дэргэд нотариатад өгөх ба энэ хоёр гэрч дугтуйн дээр гарын үсэг зурна. Гэрчүүдийн гарын үсэг зурсан дугтуйг нотариатын дэргэд өөр дугтуйнд хийж тамга тэмдэг дарах ба энэ дугтуй дээр нотариат хаалттай гэрээслэлийг хийж байгаа гэрээслэгчийн тухай, энэ гэрээслэлийг хүлээж авсан он, сар өдөр, газар, гэрч тус бүрийн овог нэр, оршин суугаа хаяг зэргийн тухай тэмдэглэгээ хийнэ.

Нотариат гэрээслэгчээс хаалттай гэрээслэл хүлээж авахдаа түүнд хаалттай гэрээслэлийг өөрөө бичиж, өөрөө гарын үсэг зурсан байх шаардлагатай, мөн зайлшгүй ногдох хувийн тухай тайлбарлан хэлж энэ тухай тэмдэглэгээг хоёр дахь дугтуйн дээр хийнэ. Үүнээс гадна нотариат хаалттай гэрээслэл хүлээж авсаныг батлах

гэрчилгээг гэрээслэгчид өгнө. Гэрээслэгчийг нас барснаас хойш сонирхогч этгээд (энэ нь өөрийгөө өвлөгч байж болно гэж таамаглаж байгаа иргэн эсвэл хууль ёсны өвлөгч байж болно) нотариатад хаалттай гэрээслэл үйлдсэн гэрээслэгч нас барсан тухай гэрчилгээг гаргаж өгнө.

Нотариат энэ гэрчилгээг өгснөөс хойш 15 хоногоос хэтрүүлэлгүйгээр хоёроос доошгүй гэрч болон хууль ёсны өвлөгчдөөс гэрээслэлийг задлахад байхыг хүссэн этгээдийн дэргэд гэрээслэлтэй дугтуйг нээнэ. Дугтуйг нээсний дараа нотариат түүний доторх гэрээслэлийн агуулгыг шууд уншиж танилцуулж, гэрээслэлтэй дугтуйг нээсэн, гэрээслэлийг уншиж танилцуулсан тухай протокол хөтлөх ба уг протоколд гэрч болон нотариат гарын үсэг зурна. Гэрээслэлийн эх хувь нотариат дээр хадгалагдана. Өвлөгчид нотариатаар гэрчлэгдсэн хуулбарыг өгнө.

Хэрвээ гэрээслэлтэй дугтуйг нээх, түүнийг танилцуулахад өвлөгч оролцоогүй бол гэрээслэл болон протоколын эх хувь өвлөгчийг иртэл нотариат дээр хадгалагдана.

2. Гэрээслэлийн даалгавар

Монгол улсын хууль тогтоомжид гэрээслэлийн даалгаврын талаар огт дурьдаагүй байдаг бол ОХУ-д нилээд дэлгэрэнгүй байдлаар зохицуулсан байдаг.

Гэрээслэгч өөрийн бүхий л эд хөрөнгө /хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө/, тэр дундаа ирээдүйд худалдаж авах эд хөрөнгийг захиран зарцуулах агуулгатай гэрээслэлийг үйлдэж болно. Хамгийн чухал нь эдгээр эд хөрөнгө гэрээслэгчийг нас барах өдөр түүнийх байх ёстой. Гэвч нотариат өвлөх эрхийн бичгийг олгоходоо холбогдох нотлох баримтыг шаардах замаар өвлөгдөж байгаа эд хөрөнгө, түүний байгаа газрыг шалгадаг. Өв нээгдэж гэрээслэлийг танилцуулах үед зарим нэг эд хөрөнгө алга болох эсвэл бүр эсрэгээр шинэ эд хөрөнгө

нэмэгдэх бүрэн боломжтой.

Гэрээслэлд өвлөгчийг томилох, өөр өвлөгчийг давхар томилох

Гэрээслэгч гэрээслэлдээ нэг болон хэд хэдэн өвлөгчийг зааж өөрийн эд хөрөнгөө өвлүүлж болно. Эдгээр өвлөгчид хууль ёсны өвлөгчийн хүрээнд орсон ч байж болно, ороогүй ч байж болно. Гэрээслэгч гэрээслэлдээ өв нээгдэхээс өмнө, эсвэл түүний гэрээслэлдээ заасан өвлөгч гэрээслэгчтэй нэгэн зэрэг нас барсан, эсвэл өв нээгдсэнээс хойш өвлөгч өвийг хүлээж авч чадалгүй нас барсан тохиолдолд, эсвэл өвлөгч өөр ямар нэгэн шалтгаанаар өвийг хүлээж аваагүй зэрэг тохиолдолд түүний хувийг өвлөх өөр өвлөгчийг давхар томилж болно. Гэрээслэгч гэрээслэлдээ өөр өвлөгчийг давхар томилох эдгээр нөхцлөөс бүгдийг нь эсвэл аль нэгийг зааж болно. Түүнээс гадна гэрээслэгч хэдэн ч этгээдийг өөр өвлөгчөөр давхар томилж болно.

Гэрээслэлийн даалгавар. ОХУ-ын Иргэний хуулийн 1128 дугаар зүйлийн дагуу гэрээслэгч банкна дахь мөнгөн хадгаламж эсвэл банкны өөр дансанд байгаа мөнгөө Иргэний хуулийн 1124-1127 дугаар зүйлд заасны дагуу өөрийн үзмэжээр гэрээслэх эсвэл тухайн данс байгаа банкны салбарт гэрээслэлийн даалгаврыг бичгээр хийх замаар өвлүүлж болно. Банкны дансан дахь мөнгөн хадгаламжийн хувьд ийм гэрээслэлийн даалгавар нь нотариатаар гэрчлэгдсэн гэрээслэлийн адил хүчин чадалтай. Банкна дахь мөнгөн хадгаламжийн гэрээслэлийн даалгаварт гэрээслэгч түүнийг үйлдсэн он сарыг тавьж, өөрөө гарын үсэг зурах ёстой ба түүнээс гадна энэ нь үйлчлүүлэгчийн даалгаврыг биелүүлэх эрх бүхий банкны ажилтнаар гэрчлэгдсэн байх ёстой 2002 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор банкна дахь мөнгөн хадгаламжийн гэрээслэлийн даалгавар үйлдэх журмыг тодорхойлсон байна. Энэ журмыг иргэдийн мөнгөн хадгаламж нээх, бусад

мөнгөн гүйлгээ хийх эрхтэй бусад санхүүгийн байгууллагуудад хэрэглэнэ.

Гэрээслэлд заасан нийгэмд ашиг тустай үйлдэл хийх тухай үүрэг /Завещательное возложение /

Гэрээслэгч нь хууль ёсны өвлөгч буюу өөр этгээд эсхүл нийтийн тусын тулд гэрээслэлээр өвлөгчид аливаа үүрэг хүлээлгэх эрхтэй. /Иргэний хуулийн 524 дүгээр зүйл/

ОХУ-д гэрээслэгч өөрийн гэрийн тэжээмэл амьтныг харж хандаж тэжээх, хяналт тавихыг нэг буюу хэд хэдэн өвлөгчид үүрэг болгох эрхтэй.

Хэрвээ гэрээслэлд өөрөөр заагаагүй бол гэрээслэл биелүүлэгч, өвлөгчдийн хэн нэг болон сонирхогч этгээд гэрээслэлд заасан нийгэмд ашиг тустай үйлдэл хийх тухай үүргийг биелүүлэхийг шүүхийн журмаар шаардах эрхтэй байдаг байна.

3. Гэрээслэлийг хүчингүй болгох, өөрчлөх, биелүүлэх

Гэрээслэгч нь Иргэний хуулийн 525 дугаар зүйлд заасны дагуу өөрийн хийсэн гэрээслэлийг хэдий ч хүчингүй болгох эсвэл өөрчлөх эрхтэй бөгөөд яагаад хүчингүй болгох, өөрчлөх болсны шалтгааныг заахгүй байж болно.

Гэрээслэлийг хүчингүй болгох гэдэг нь урьд өмнө хийсэн гэрээслэлийг хүчингүй болгох тухай бичгээр хийж, нотариатаар гэрчилгдсэн байхыг хэлж байгаа юм.

Гэрээслэлийг өөрчлөх гэдэг нь гэрээслэлийг бүхэлд нь өөрчлөхгүйгээр түүний зарим нэг заалтыг өөрчлөнө гэсэн үг ба гэрээслэлийн өөрчлөлтийг бас бичгээр хийж, нотариатаар баталгаажуулах шаардлагатай.

Гэрээслэлийг үйлдэхэд цаг хугацаа, орон зайн ямар нэг хязгаарлалтыг хууль тогтоомжоор тусгаагүй байна. Гэрээслэлийг хэдэн ч удаа бичиж болох ба гэрээслэгч өөрийн бүх эд хөрөнгийг эсвэл түүний тодорхой нэг эд зүйлсийг гэрээслэж болно.

Мөн гэрээслэлээрээ өвийн эд хөрөнгийг дахин хуваарилах эрхтэй.

Гэрээслэлийг хүчингүй болгох, өөрчлөхөд хэн нэгний зөвшөөрөл, тэр тусмаа гэрээслэлд өвлөгчөөр томилсон этгээдийн зөвшөөрлийг авах шаардлагагүй.

Гэрээслэгчийг үлдсэн эд хөрөнгийн хэсгийг хууль ёсны өвлөгчид өвлөн авна.

ОХУ-д гэрээслэгч өөрийн урьд өмнө хийсэн гэрээслэлээ шинэ гэрээслэл хийх замаар хүчингүй болгохоос гадна гэрээслэлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг тусад нь хийх замаар хүчингүй болгож болдог байна. Энэхүү мэдэгдлийг хуульд заасан гэрээслэлийн хэлбэр, түүнийг хийх журмын дагуу үйлдсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл бичгээр үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх шаардлагатай. Мэдэгдлийг хоёр хувь үйлдэх ба нэг хувь нь нотариатад үлдэж, нөгөө хувийг гэрээслэлийг хүчингүй болгож байгаа этгээд авна. Хэрвээ гэрээслэлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг өөр нотариатаар гэрчлүүлсэн бол гэрээслэгч энэ мэдэгдлийг гэрээслэл гэрчилсэн нотариатад илгээнэ. Хэрвээ гэрээслэгч хүсэлт гаргавал гэрээслэлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг гэрчилж байгаа нотариат уг мэдэгдлийг холбогдох нотариатад илгээх ажлыг хийж болно.

Гэрээслэлд үг үсгийн алдаа гаргасан эсвэл гэрээслэлийг үйлдэх, гарын үсэг зурах эсвэл түүнийг гэрчлэх журмыг маш бага зэрэг зөрчсөн нь гэрээслэгчийн хүсэл зоригийн илэрхийллийг ойлгоход нөлөөлөхгүй байна гэж шүүх тогтоовол эдгээр нь уг гэрээслэлийг хүчин төгөлдөр бусад тооцож үндэслэл болохгүй.

Гэрээслэлийг бүхэлд нь хүчин төгөлдөр бусад тооцохоос гадна түүний зарим нэг зүйл заалтыг хүчин төгөлдөр бусад тооцож болно. Энэ тохиолдолд хүчин төгөлдөр бусад тооцогдож байгаа зүйл заалт нь гэрээслэлийн бусад

үлдсэн заалтуудыг хөндөөгүй байх шаардлагатай.

Гэрээслэл хүчин төгөлдөр бусад тооцогдсон ч гэсэн уг гэрээслэлд заасан өвлөгч хууль болон өөр бусад хүчин төгөлдөр гэрээслэлийн үндсэн дээр гэрээслэгчийн эд хөрөнгийг өвлөх эрхтэй.

Гэрээслэлийг биелүүлэх. Монгол улсын Иргэний хуулийн 526 дугаар зүйлийн дагуу гэрээслэл биелүүлэхийг гэрээслэлээр томилогдсон өвлөгчид даалгана. Гэрээслэгч нь гэрээслэл биелүүлэгчээр өөр этгээдийг томилж болно. Гэрээслэл биелүүлэгч нь даалгасан үүргийг биелүүлэхийг зөвшөөрснөө баталж, гэрээслэлд гарын үсэг зурах буюу энэ тухай баримт бичиг үйлдэж, гэрээслэлд хавсаргаснаар уг даалгаврыг гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

Гэрээслэл биелүүлэгч түүнийг биелүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй бөгөөд түүнийг биелүүлэх, өвлөгчдөд эд хөрөнгийг эрхлэн удирдах, хамгаалахад гарсан зайлшгүй зардалаа өвлөгчдөд хөрөнгөөс гаргуулан авах эрхтэй. Манайд гэрээслэл биелүүлэх талаар зөвхөн дээрхи заалт байдаг.

Харин ОХУ-д энэ талаар нилээд дэлгэрэнгүй, тодорхой заасан байна.

Гэрээслэл биелүүлэгч нь өвлөгч байхаас гадна өөр этгээдийг томилж болдог байна.

- Гэрээслэл биелүүлэгчийг дараах тохиолдолд томилж болно.

- өвийн эд хөрөнгийг хуваарилах үед өвлөгчдийн хооронд гарч болозшгүй маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор
- хэрвээ бага насны болон эрх зүйн чадамжгүй өвлөгч байгаа бол
- өөрөө бие даан гэрээслэл биелүүлэх боломжгүй хувд өвчтэй өвлөгч байгаа бол
- хэрвээ гэрээслэлийг нөхцөл

зааж хийсэн бол

- д. хэрвээ өвийн эд хөрөнгийг хамгаалах, эрхлэн удирдах шаардлагатай бол гэрээслэл биелүүлэгчийг томилж болно.

Өв нээгдсэнээс хойш гэрээслэл биелүүлэгчид даалгасан үүргийг биелүүлэхэд саад болсон нөхцөл байдал бий болбол гэрээслэл биелүүлэгчийн өөрийн хүсэлт эсвэл өвлөгчийн хүсэлтээр шүүх түүнийг үүргээс чөлөөлж болно. Ийнхүү гэрээслэгчийн даалгасан үүргийг биелүүлэх боломжгүй байх нөхцөл байдал нь жишээлбэл, гэрээслэл биелүүлэгчийн өвчин, оршин суугаа газраасаа нүүсэн зэрэг байж болно. Ямар нэгэн шалтгаангүйгээр гэрээслэлийг биелүүлэхээс татгалзаж болохгүй. Учир нь гэрээслэл биелүүлэгч гэрээслэгчийн хамгийн сүүлийн хүсэл зоригтой холбоотой бөгөөд гэрээслэгч өөрийн хүсэл зоригийг энэ хүн биелүүлнэ гэдэг итгэлтэйгээр гэрээслэлээ үйлдэж, үүнийг ч гэрээслэл биелүүлэгч зөвшөөрсөн байдаг.

Хэрвээ гэрээслэгч биелүүлэгч бодит шалтгааны улмаас өөрийн үүргийг биелүүлж чадахгүй тохиолдолд гэрээслэлээр томилогдсон өвлөгч эсвэл хууль ёсны өвлөгч гэрээслэгчийг бие даан биелүүлэх үүрэгтэй.

Гэрээслэл биелүүлэгчийн эрх түүнийг биелүүлэгчээр томилсон гэрээслэл дээр үндэслэсэн байдаг.

Нотариат гэрээслэл биелүүлэгчид гэрээслэлийн гэрчилгээг олгоно. Уг гэрээслэлийн гэрчилгээнд гэрээслэл, түүнийг гэрчилсэн тухай заахаас гадна гэрээслэл биелүүлэгчийг зааж түүний эрх тодорхой бичсэн байна.

- Хэрвээ гэрээслэлд өөрөөр заагаагүй бол гэрээслэл биелүүлэгч гэрээслэлийг биелүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээ, тэр дундаа:

- гэрээслэгчийн гэрээслэлд заасан эсвэл хуульд заасан хувь хэмжээний дагуу өвлөгдөх эд хөрөнгө өвлөгчид шилжүүлэх

- Өвлөгчдийн ашиг сонирхолын үүднээс өвлөгдөх эд хөрөнгийг эрхлэн удирдах, хамгаалах арга хэмжээг өөрөө бие даан эсвэл нотариатын туслажтайгаар авна.

Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалахтай холбогдоод гэрээслэл биелүүлэгч

- гэрээслэлээр томилогдсон бүх өвлөгч мөн хуулиар зайлшгүй хувь ногдох этгээдэд өв нээгдсэн тухай мэдэгдэх
- өвлөгдөх эд хөрөнгийг бүртгэх./үүнд мөнгөн хадгаламж орно/
- өвлөгч тус бүрийн хувь хэмжээг тогтоох
- өвлөгдөх эд хөрөнгөөс зайлшгүй ногдох хувийг ялгаж хуваарилах үүрэгтэй.

Өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ эрх зүй, техник, зохион байгуулалтын шинжтэй байж болно. Эрх зүйн арга хэмжээнд жишээ нь, хэрвээ аль нэг өвлөгчид түүнд ногдоогүй эд хөрөнгө байвал түүнийг буцааж өгөхийг шаардах, хэрвээ эд хөрөнгө өөр хотод байгаа бол уг эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах тухай хүсэлтийг нотариатад гаргах зэрэг орно. Техникийн арга хэмжээнд жишээ нь, төмөр хаалга хийх, хаалганы цоож солих, дохиолол тавих зэрэг хамаарна. Харин зохион байгуулалтын арга хэмжээ гэдэгт өвлөгдөх эд хөрөнгийн бүртгэл хийх зэрэг орно. Гэрээслэл биелүүлэгч өвлөгдөх эд хөрөнгийг өөрөө эрхлэн удирдаж болно эсвэл эд хөрөнгийг эрхлэн удирдах талаар өөр этгээдтэй (өвлөгч эсвэл өөр иргэн байж болно) гэрээ байгуулж болно. Гэрээслэл биелүүлэгч, эд хөрөнгийн эрхлэн удирдах гэрээ байгуулсан этгээдийн үйлдэл өвлөгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байх ёстой.

- гэрээслэгчийн авах ёстой гэхдээ амьд байх хугацаандаа ямар нэгэн шалтгааны улмаас авч чадаагүй мөнгөн төлбөр

тухайлбал, цалин эсвэл түүнтэй адилтгах орлого (тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын тэтгэмж), амь нас эрүүл мэндэд учруулсан хохирлын төлбөр зэргийг авч, өвлөгчид дамжуулах

- Гэрээслэлийн даалгаврыг биелүүлэх, өвлөгчдөөс гэрээслэлийн татгалзал эсвэл гэрээслэлийн даалгаврыг биелүүлэхийг шаардах үүрэгтэй. Гэрээслэл биелүүлэгч гэрээслэл биелүүлэхтэй холбоотой ажлыг өөрийн нэрийн өмнөөс хийх эрхтэй.

Гэрээслэл биелүүлэгч гэрээслэл биелүүлэхтэй холбогдон гарсан зайлшгүй зардлыг өвлөгдөх эд хөрөнгөнөөс гаргуулан авах, түүнээс гадна гэрээслэлд заасан бол өвлөгдөх эд хөрөнгөнөөс урамшуулал авах эрхтэй. Гэрээслэл биелүүлэгч урамшуулалын зөвхөн өвлөгчид өвийг хүлээн авснаас хойш авч болно.

Гэрээслэл биелүүлэгч гэрээслэлийг биелүүлэхгүй эсвэл хангалтгүй биелүүлсэн тохиолдолд ОХУ-ын Иргэний хуулийн 25 дугаар бүлэг "Үүрэг зөрчсөнөөс хүлээх хариуцлага"-ын хэм хэмжээний дагуу хариуцлага хүлээнэ.

* * *

АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ (ALIN) ҮЙЛ АЖИЛЛАГАА

Солонгосын хууль тогтоомжийн хүрээлэнгийн Эрх зүйн
мэдээллийн төвийн захирал СОН ХИ ДҮ

Мастер төлөвлөгөө

Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний (ALIN)¹ төслийн гол зорилго нь Азийн орнуудын хууль тогтоомжтой холбоотой материал болон судалгааны дүн, шүүхийн шийдвэр болон эрх зүйн бусад мэдээллийг хүний нөөцийн болон оюуны нэгдсэн сүлжээ байгуулах замаар бүрдүүлэх, хөтлөх, зохион байгуулах үүрэг бүхий агентлагуудаас эрхэлж буй дээрх төрлийн мэдээлэл болон холбогдох судлаачдийг харилцан солилцоход чиглэдэг.

Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI) нь Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний төслийн шаардлага, ач холбогдлыг хүлээн зөвшөөрч 2002 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр төслийн мастер төлөвлөгөөг боловсруулж баталсан. Төслийн үйл ажиллагаанд Азийн орнуудын томоохон их сургууль, коллеж, судалгааны хүрээлэн болон засгийн газрын агентлагуудыг оролцуулах зорилгоор KLRI нь 2003-2005 онд Ази хоорондын эрх зүйн мэдээллийн сүлжээг байгуулах 3 жилийн төлөвлөгөөг эхний жилд Зүүн-Хойд Ази руу, 2 дахь жилд Зүүн-Өмнөд Ази руу, 3 дахь жилд Баруун Ази болон хуучин ЗХУ-ын орнуудад төвлөрүүлэн ажиллаж байна.

ALIN-ий түнш байгууллагууд

ALIN нь богино хугацаанд нягт хамтран ажилладаг нэлээд олон түнш байгууллагатай болжээ.

2004 оны 10 дугаар сарын байдлаар ALIN-ий түншээр БНХАУ-ын Улс төрийн ухаан, эрх

зүйн Их сургууль болон Зүүн Хятадын Улс төр, эрх зүйн Их сургууль, Индонези Улсын Гажа Мадагийн Их сургууль, Солонгос Улсын Гадаад улс судлалын Ханкукийн Их сургууль, Күүк Миний Их сургууль, KLRI, Солонгосын Их сургууль, Сөүлийн Их сургууль, Монгол Улсын Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв, Филиппиний Их сургуулийн Хууль зүйн коллеж, Тайваны Үндэсний Их сургуулийн Хууль зүйн коллеж, Мэдээлэл үйлдвэрлэлийн хүрээлэнгийн Шинжлэх ухаан, технологийн эрх зүйн төв болон Тайландын Чулалонкорны Их сургууль зэрэг 7 үндэстний 13 байгууллага нэгдсэнийс гадна Японы Васедагийн Их сургуулийн Харьцуулсан эрх зүйн хүрээлэн болон Сингапурын Үндэсний Их сургуулийн Хууль зүйн факультет ажиглагчаар оролцож байна.

Судалгааны үйл ажиллагаа

Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах болон сэтгүүл хэвлэн гаргах гэж ангилж болно.

ALIN нь 2003 онд үйл ажиллагаагаа эхэлснээс хойш олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж байна. 2003 онд "Хятадын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тулгамдсан асуудлууд" сэдвээр Хятадын эрх зүйн тогтолцооны талаар форум болон ALIN-ийг үүсгэн байгуулах талаар "Зүүн-Хойд Азийн орнуудын эрх

зүйн мэдээллийн төлөв байдал болон ALIN-ий цаашдын чиг хандлага" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. 2004 онд "Өмнөд, Хойд Солонгос болон Монгол Улсын эрх зүйн тогтолцооны өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт Солонгос-Монголын хамтарсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болон 11 дүгээр сард Гадаад улс судлалын Ханжук Их сургуультай хамтран Зүүн-Хойд Азийн орнуудын эрх зүй, заншлын талаар олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулаад байна.

Эрдэм шинжилгээний сэтгүүлийн тухайд, Солонгос хэл дээр "Азийн эрх зүй судлал" сэтгүүлийг хагас жил тутам гаргаж байгаа бөгөөд цаашид ч гаргахаар төлөвлөж байна. Түүнчлэн англи хэл дээр "Азийн эрх зүйн тойм" сэтгүүлийг 2004 оны эцсээс анх хэвлэн гаргаж байна. Үүнийг зэрэгцээ Азийн орнуудын эрх зүйн тогтолцооны талаархи судалгааны тайлан болон тэдгээр орны хууль тогтоомж, дүрэм, журмын орчуулгыг хэвлэн нийтлүүлдэг юм.

ALIN-ий веб хуудас

ALIN-ий төслөөс өнөөг хүртэл хэрэгжүүлсэн үйл ажиллагааны чухал хэсгийн нэг нь 2004 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөтөлсөн веб хуудас бөгөөд, тус төсөл үйл ажиллагаагаа онлайн хэлбэрээр явуулдаг юм. Веб хуудасны хаяг маань www.e-alin.org.

Веб хуудас нь 2 хэсэгт хуваагддаг.

Нэг нь ALIN-ий үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулах ALIN-ий хэрэг эрхлэх газрын homepage, нөгөө нь ALIN-ий түншүүдийн тус тусын дэд

¹ Редакторын тэмдэглэл: Энэ хэсэгт Солонгосын хууль тогтоомжийн судалгааны хүрээлэнгээс хэрэгжүүлж буй Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээний төслийн үйл ажиллагаа, үндсэн чиглэлийн тухай өгүүлнэ.

homepage байх бөгөөд хариуцах ажилтнууд танилцуулга, судалгааны тайлан, холбогдох материалыг уг хуудаст оруулдаг.

Хэдийгээр жижиг боловч веб хуудас маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Үндсэн үүргийнхээ хувьд:

Нэгдүгээрт, "Мэдээ" гэсэн хэсэгт ALIN-ий болон түншүүд, тэдгээрийн үйл ажиллагааны талаархи хамгийн сүүлийн үеийн мэдээллийг байрлуулдаг.

Хоёрдугаарт, "Нөөц" гэсэн хэсгээс ALIN-ий бие даасан түншүүд судалгааны тайлан, эрдэм шинжилгээний сэтгүүлүүд болон бусад нийтлэлийг татаж авахаас гадна тэдгээрийг хэвлэж авах, хайлт хийх боломжийг хэрэглэгчдэд бүрдүүлнэ. Тухайлбал, веб хуудас маань тухайн материалын бичигдсэн хэлнээс үл шалтгаалан PDF хэлбэр рүү автоматаар хөрвүүлж, хадгалахаар хийгдсэн тул эдгээр материалыг Acrobat Reader программыг өөрийн компьютерт суулгасан тохiolдолд хайх, хэвлэх боломжтой юм.

Гуравдугаарт, "Линк" гэсэн хэсэг нь тухайн хэрэглэгчийг ALIN болон түншийн хууль тогтоомж, дүрэм, журам, шүүхийн прецедент, судалгааны материал зэргийн тухай мэдээлэлтэй цаг хэмнэж, маш хурдтайгаар холбож өгнө.

Дөрөвдүгээрт, "Форум" гэсэн хэсэг нь түнш байгууллага бүрийн эрдэмтдэд тухайлсан сэдвээр (жишээлбэл, байгаль орчин, зохиогчийн эрх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомж) онлайн хэлэлцүүлэг болон хамтарсан судалгаа хийхэд тус болох юм. Эцэст нь, "Онлайн уулзалт" гэсэн хэсэг нь хэрэглэгчид урьдчилан цаг тохирч шууд арилцах боломж олгодог.

ALIN-ий үйл ажиллагааны тайлангийн эцэст хэлэхэд ирэх жил Та бүхний хамтын ажиллагааны дүнд ALIN илүү өндөр түвшинд хүрнэ гэж найдаж байна.

Хөгжлийн үе

Огноо	Үйл явдал
2002.4.26	KLRI ALIN-ий Ma0стер төлөвлөгөөг батлав.
2003.6.18	Сөүлийн Их сургууль ALIN-д нэгдэв.
2003.6.20	KLRI болон Дэлхийн эдийн засгийн эрх зүйн судалгааны төвийн санхүүжилтээр "Хятадын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тулгамдсан асуудлууд" сэдэвт Хятадын эрх зүйн тогтолцооны талаархи форум болов.
2003.7.15	Солонгосын Их сургууль ALIN-д нэгдэв.
2003.8.9	Тайваны Үндэсний Их сургуулийн Хууль зүйн коллеж ALIN-д нэгдэв.
2003.9.3	KLRI Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээг үүсгэн байгуулсан "Зүүн- Хойд Азийн улсуудын эрх зүйн мэдээллийн төлөв байдал болон ALIN-ий цаашдын чиг хандлага" сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
2003.9.4	Монгол Улсын Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв ALIN-д нэгдэв.
2003.11.6	Күүк Миний Их сургууль ALIN-д нэгдэв.
2004.1.27	Тайваны Эрх зүйн мэдээллийн солилцоо болон хамтарсан судалгааны мэдээлэл үйлдвэрлэлийн хүрээлэн ALIN-д нэгдэв.
2004.4.1	ALIN-ий веб хуудас ажиллаж эхлэв.
2004.6.15	Гадаад улс судлалын Ханкүкийн Их сургууль ALIN-д нэгдэв.
2004.6.23	Хятадын Улс төрийн ухаан, эрх зүйн Их сургууль ALIN-д нэгдэв.
2004.7.9	Монгол Улсын ХЗҮТ, KLRI болон Күүк Миний Их сургуулийн хамтарсан санхүүжилтээр "Өмнөд, Хойд Солонгос болон Монгол улсын эрх зүйн тогтолцооны өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт Солонгос-Монголын Олон улсын бага хурал зохиов.
2004.8.29	Зүүн Хятадын Улс төр, эрх зүйн Их сургууль ALIN-д нэгдэв.
2004.9.3	Филиппиний Их сургуулийн Хууль зүйн коллеж ALIN-д нэгдэв.
2004.9.6	Чулалонкорны Их сургууль ALIN-д нэгдэв.
2004.9.8	Гажа Мадагийн Их сургууль ALIN-д нэгдэв.

Англи хэлнээс орчуулсан Ч.Нарантуяа
(Хууль зүйн үндэсний төвийн эрдэм шинжилгээний ажилтан)

* * *

"ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" СЭТГҮҮЛИЙН 2004 ОНЫ НИЙТЛЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Сэдвийн нэр	Зохиогчийн нэр, эрхэлсэн ажил	Нийтлэгдсэн дугаар
Төрийн байгуулалтын хууль тогтоомж			
1.	Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс	Б. Чимид / ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор /	№ 1 (04)
2	Дэлхийн зарим орны үндсэн хууль дахь спортын зохицуулалт	Б.Бат-Эрдэнэ / "Аварга" дээд сургуулийн захирал, докторант /	№ 1 (04)
3	Украины үндсэн хуулийн шүүх	Э.Лхагвасүрэн /Үндсэн хуулийн цэцийн ажилтан /	№ 1 (04)
4	Үндсэн хуулийн хөгжлийг судлахад шинэ хандлага нэн чухал	Б. Чимид /ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор /	№ 2 (05)
5	Хууль зүйн нэр томъёог оновчтой болгох, зөв хэрэглэх асуудал	С. Гэрэлмаа / ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрхлэгч /	№ 1 (04)
6	ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх-Шүүх эрх мэдлийн хамгийн дээд зэргэмжийн шүүх болох нь	Э. Лхагвасүрэн /Үндсэн хуулийн цэцийн ажилтан /	№ 1 (04)
7	Монгол Улсын эрх зүйн тогтолцоо: Өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага	С. Төмөр /УИХ-ын гишүүн асан, Хууль зүйн доктор, профессор/	№ 3 (06)
8	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд анхаарах нь	Б. Цогням /Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн шүүхийн сургагч багш/	№ 3(06)
9	Хууль зүйн нэр томъёоны талаархи зарим асуудал	Д. Баянбилэг /ХЗҮТ-ийн мэдээлэл, сурталчилгааны төвийн дарга /	№ 3(06)
10	Захиргааны шүүх нь хүний нэгдсэн эрхийг хамгаалах үндсэн баталгаа болох нь	Г.Банзрагч /ХБНГУ-ын Байротын Их сургуулийн докторант /	№ 3(06)
11	Ардчилсан нийгэм, улс төрийн плюрализм	Ш. Цогтоо /МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор, дэд профессор/	№ 4(07)
12	Бидний сонгох, сонгогдох эрх	С.Гэрэлмаа /ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрхлэгч/	№ 4(07)
13	Бүгд Найрамдах Беларусь улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай	Э.Лхагвасүрэн /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	№ 4(07)
Иргэний хууль тогтоомж			
1	Иргэний эрх зүйн харилцаан дахь төлөөлөл	Ц. Оюунчимэг / Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, докторант	№ 1(04)
2	Хөршийн эрх	Б. Гэрэл / МУИС-ийн магистрант /	№ 1(04)
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хугацааны эрх зүйн зохицуулалт	П. Баттогтох / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№ 1(04)

6	Монгол Улсын газрын хууль тогтоомжийн түүхэн хөгжил	Н.Отгончимэг / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант /	№2(05)
7	Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ	Д.Цолмон /ХЗҮТ-ийн секторын эрхлэгч, Удирдлагын академийн ахлах багш	№2(05)
8	Өөртөө туслах эрхийн мөн чанар, онцлог	Т.Мэндсайхан / ХЗҮТ-ийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч, доктор /	№2(05)
9	Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх	Д.Отгончимэг / ХЗДХЯ-ны ахлах мэргэжилтэн /	№2(05)
10	"Нэр, нэр төр, элдэр хүнд, ажил хэргийн нэр хүндийн хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа нь	Л.Бямбаа / Нийслэлийн шүүхийн шүүгч /	№2(05)
11	Төлөөлөл	Ч.Амгалан / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№3(06)
12	Иргэний хэргийг давж заалдах шатаар хянах ажиллагаа	Д.Хуяг / МУИС-ийн ХЗС-ийн багш, докторант /	№4(07)
13	Татварын хуулийг хэрэглэж буй практикийн зарим асуудал	А.Доржготов / Улсын дээд шүүхийн шүүгч	№4(07)

Шүүх эрх мэдэл

1	Шүүгчийн ёс зүй	Ж.Амарсанаа / ХЗҮТ-ийн захирал, академич /	№1(04)
2	Шүүхийн шийтгэх тогтоолын үндэслэл ба шүүхээс гарах дүгнэлт	Д.Баярсайхан / Улсын дээд шүүхийн шүүгч /	№1 (04)
3	Гаалийн хууль тогтоомжийг зөв хэрэглэх асуудал	О.Зандраа / Улсын дээд шүүхийн шүүгч /	№2(05)
4	Фидуцийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал	П.Цэцгээ / Улсын дээд шүүхийн судалгааны төвийн захирал /	№2(05)
5	Захиргааны хэргийн шүүх: харьцуулсан судалгаа	Н.Отгончимэг /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант /	№ 2(05)
6	Шүүгчийн ёс зүйн байдлын судалгаа	Д.Золзаяа /ШУА –ийн философи социологийн эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан /	№2(05)
7	Шүүхийн эрх зүй дэх үнэний асуудал	Ц.Амарсайхан /Улсын дээд шүүхийн шүүгч /	№3(06)
8	Шүүх засаглал: онол практикийн зарим асуудал	Ц.Амарсайхан /Улсын дээд шүүхийн шүүгч /	№4(07)

Прокурорын хяналт

1	Мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналтын зарим асуудал	Ё.Сагсай / Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор /	№1(04)
2	Олон улсын эрүүгийн шүүхийн үйл ажиллагаанд прокурорын гүйцэтгэх үүрэг	Б.Цэрэнбалтав / Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх /	№1(04)

3	Мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүрэг, бүрэн эрх	Т.Сүхбаатар / Улсын ерөнхий прокурорын газрын туслах, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга.	№2(05)
4	Хуульчийн ба прокурорын ёс зүй	Б.Цэрэнбалтав / Улсын ерөнхий прокурорын орлогч /	№3(06)

Олон улсын эрх зүй, Харьцуулсан эрх зүй

1	Олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжил, хандлага, Монгол улсын оролцоо	Ж.Энхсайхан / Олон улсын эрүүгийн шүүхийг дэмжих үндэсний эвслийн зөвлөх, хууль зүйн доктор	№1(04)
2	Олон улсын шинжтэй иргэний хэргийг шүүхээр шийдвэрлэх нь	Т.Мэндсайхан / МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор, хууль зүйн доктор	№1(04)
3	Консулын хийх Нотариатын үйлдэл	А.Төмөр / Гадаад хэргийн яамны мэргэжилтэн /	№1(04)
4	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай олон улсын эрх зүй ба гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хууль	Ч.Нарантуяа / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№2(05)
	Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц ба "Монгол улсын олон улсын гэрээний тухай хууль"	С.Должин / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№2(05)
6	Жишиг эрх зүйн тухай ойлголт	Б.Гүнбилэг / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№3(06)
7	Эвтаниц буюу өвчтөн хүсэлтээрээ үхэх эрхийн тухай	П.Баяр / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№3(06)
8	Хууль зүйн шинжлэх ухаанд харьцуулсан эрх зүйн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг	Н.Отгончимэг / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№4(07)
9	Оролмаанууд төрөлх эх орон казахстандаа эргэж ирсэн нь	Галия Сармурзина / Казахстаны Кайнерийн их сургуулийн доцент /	№4(07)

Криминологи

1	Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилт	С.Жанцан / ШУА-ийн Бага чуулганы гишүүн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор /	№1(04)
2	Гэмт хэргийн улмаас учрах оюун санааны гэм хорын асуудал	Ц.Одгэрэл / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№1(04)
3	Хүүхэд эмэгтэйчүүдийг хил дамжуулан худалдах асуудал ба хүний эрх	Г.Уранцхоож / Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн /	№1(04)
4	Монгол улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлийн зарим асуудал	Д.Зүмбэрэллхам / ХЗҮТ-ийн секторын эрхлэгч, доктор, профессор /	№2(05)
5	Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлж байгаа практик	Б.Билэгсайхан / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№3(06)

6	Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шалтгаан ,нөхцөл, тэмцэх арга зам	Ц.Цэлмэг / “Шихихутаг” Хууль зүйн дээд сургуулийн багш /	№4(07)
7	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарим хугацаа,түүний тухай ойлголт	Ц.Одончимэг / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№4(07)
8	Полиграфийн түүхэн хөгжил, түүнийг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах арга зам	Г.Батчимэг / ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтны туслах /	№4(07)

Эрх зүйн үйлчилгээ


1	Ардчилсан нийгэмд өмгөөллийн эзлэх байр суурь	Б.Ганбаатар / Монголын өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч /	№1(04)
2	Нотариатчдад өгөх зөвлөмж	Н.Отгонжаргал / Монголын Нотариатчдын танхимийн мэдээллийн албаны ажилтан /	№1(04)
3	Оюуны өмчийн эрхийн нэр томъёоны дагалга	Ю.Энхтүвшин / Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /	№1(04)
4	Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгч мэтгэлцээний нэг тал болох нь	Я.Нямжав / МӨХ-ны гишүүн , өмгөөлөгч /	№2(05)
5	Хуулийн зөвлөгчийн эрх зүйн байдлын зарим асуудал	П.Баттогтох /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№2(05)
6	Нотариатчдад өгөх зөвлөмж	П.Уянга / Монголын Нотариатчдын танхимийн ажилтан /	№2(05)
7	Оюуны өмчийн эрхийн нэр	Ю.Энхтүвшин / Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /	№2(05)
8	Өмгөөлөгчийн ёс зүйн зарчим	Н.Сосорбарам / МӨХ-ны Сахилгын хорооны дарга /	№3(06)
9	Тайван жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал	Д.Оросоо /ХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан /	№3(06)
10	Гарын үзүүрийн ажил биш	Н.Алтанцэцэг / Монголын Нотариатчдын танхимийн удирдах зөвлөлийн гишүүн /	№3(06)
11	Санаж бодсоноо л хэлье	Д.Тогтохжаргал /Ахмад өмгөөлөгч /	№4(07)
12	Иргэд газраа өмчилж авахад бүрдүүлэх баримт бичиг	С.Наранцэцэг / Нийслэлийн Хан-Уул дүүргийн нотариатч /	№4(07)

Мэдээ мэдээлэл

1	Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ ба Хууль зүйн үндэсний төв (Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээг бий болгох болон удирдан явуулах түр хэлэлцээр)	№4(07)
2	Норвегичууд Монголын өмгөөлөгчдөд оюуны хөрөнгө оруулалт хийнэ.	№4(07)
3	Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал	№2(05)
4	Америкийн Баарын холбооны “Азийн эрх зүйн санаачлага төсөл”	№2(05)

2005 ОНЫ ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА.

Тус төвөөс эрхлэн гаргадаг ном, сонин, сэтгүүл -
Таны өдөр тутмын ажил амьдралын хөтөч!



Хууль дээдлэх ёс

----- Сэтгүүл -----

Улиралд 1 удаа


Үнэ 2100 төг, индекс:14279

Хууль зүйн мэдээ

----- Сонин -----

Улиралд 6 удаа

Үнэ:1800 төг, индекс:11197



Хууль зүйн мэдээлэл

----- Сэтгүүл -----

Улиралд 6 удаа

Үнэ: 3000 төг, индекс: 14195

РЕДАКЦЫН ХАЯГ:

УТАС:

Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг
Сүхбаатарын гудамж

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн индекс-14279
322094, ФАКС: 322094, 315789,